



USAID
FROM THE AMERICAN PEOPLE



The Asia Foundation



ХУУЛЬ ЗҮЙН
ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН

АВЛИГА, АЛБАН ТУШААЛЫН ГЭМТ ХЭРЭГ

Хуульчдад зориулсан гарын авлага



АНУ-ЫН АЗИЙН САН



The Asia Foundation



ХУУЛЬ ЗҮЙН
ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН

АВЛИГА, АЛБАН ТУШААЛЫН ГЭМТ ХЭРЭГ

(ХУУЛЬЧДАД ЗОРИУЛСАН ГАРЫН АВЛАГА)

УЛААНБААТАР ХОТ
2014 ОН

Энэхүү гарын авлагыг АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлаг (ОУХА)-аас үзүүлсэн Америкийн ард түмний дэмжлэгтэйгээр бүтээсэн болно.

Гарын авлагыг Хууль зүйн үндэсний хүрээлэн, АНУ-ын Азийн сан хамтран бүтээсэн бөгөөд АНУ-ын Засгийн газар болон ОУХА-ийн үзэл бодлыг илэрхийлээгүй болохыг анхаарна уу.

Зохиогчид:

*Б.Батзориг-Тахарын Ерөнхий газрын дэд дарга, хууль зүйн доктор (Ph.D) **IV бүлэг***

*Ц.Цэлмэг-Хууль Зүйн Үндэсний Хүрээлэнгийн Сургалтын төвийн эрхлэгч, доктор (Ph.D) **V бүлэг***

*Г.Оюунболд-Хууль Зүйн Яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын хэлтсийн дарга **III бүлэг***

*Б.Одонгэрэл-Хууль Зүйн Үндэсний Хүрээлэнгийн Бодлогын ахлах судлаач **I бүлэг***

*Б.Мөнхдорж-ХСИС-ийн Шинжлэх ухаан, технологийн газрын Цагдаа судлалын төвийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан **II бүлэг***

Эмхэтгэсэн:	Д.Цэцэгдарь
Хянасан:	Ц.Цэлмэг
Хэвлэлийн эхийг:	Б.Цэрэнлхам
Хэвлэлийн хуудас:	18.83 хх
Хэвлэсэн газар	Хууль зүйн үндэсний хүрээлэн

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

АТГ	- Авлигатай Тэмцэх Газар
ЗГ	- Засгийн Газар
ЕНБД	- Ерөнхий Нарийн Бичгийн Дарга
НҮБ	- Нэгдсэн Үндэсний Байгууллага
ОУБ	- Олон Улсын Байгууллага
УДШ	- Улсын Дээд Шүүх
УЕП	- Улсын Ерөнхий Прокурор
УИХ	- Улсын Их Хурал
ТББ	- Төрийн Бус Байгууллага
ТЕГ	- Тагнуулын Ерөнхий Газар
ЭБШ хууль	- Эрүүгийн Байцаан Шийтгэх Хууль
ЦЕГ	- Цагдаагийн Ерөнхий Газар

ГАРЧИГ

ӨМНӨХ ҮГ	7
I БҮЛЭГ. АВЛИГЫН ЭСРЭГ ҮНДЭСНИЙ БОЛОН ОЛОН УЛСЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ	
1.1. Авлигын эсрэг олон улсын эрх зүйн хэм хэмжээ	9
1.2. Авлигын эсрэг НҮБ-ын Конвенци	16
1.3. НҮБ-ын Авлигын эсрэг конвенцид үндэсний хууль тогтоомжийг нийцүүлэх нь	23
1.4. Авлигатай тэмцэж буй гадаадын зарим орны туршлагаас	27
II БҮЛЭГ. МОНГОЛ УЛС ДАХЬ АВЛИГА, АЛБАН ТУШААЛЫН ГЭМТ ХЭРГИЙН ШАЛТГААН, НӨХЦӨЛ	
2.1. Монгол Улс дахь авлига, албан тушаалын гэмт хэргийн өнөөгийн байдал	53
2.2. Авлига, албан тушаалын гэмт хэргийн шалтгаан, нөхцөл	62
2.3. Авлига, албан тушаалын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх асуудал	72
2.4. Авлигаас урьдчилан сэргийлэх олон улсын туршлага, харьцуулсан судалгаа	76
III БҮЛЭГ. АВЛИГА, АЛБАН ТУШААЛЫН ГЭМТ ХЭРГИЙН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ХАНДЛАГА	
3.1. Нийтийн албан тушаалтанд хээл хахууль өгөх, авах гэмт хэрэг	88
3.2. Гадаад улсын нийтийн албан тушаалтан болон олон улсын байгууллагын албан тушаалтанд хахууль өгөх үйлдлийг гэмт хэрэгт тооцох	102
3.3. Эд хөрөнгийг хууль бусаар завших гэмт хэрэг	107
3.4. Хуулийн этгээдэд хариуцлага хүлээлгэх	112
3.5. Нөлөөгөөр наймаалцах болон хууль бусаар хөрөнгөжихийг гэмт хэрэгт тооцох	116
3.6. Хувийн хэвшил дэх хээл хахуулийг гэмт хэрэгт тооцох	119

IV БҮЛЭГ. АВЛИГА, АЛБАН ТУШААЛЫН ГЭМТ ХЭРГИЙГ ШАЛГАХ АЖИЛЛАГАА

4.1. Албан тушаалын гэмт хэргийн талаарх гомдол, мэдээлэл хүлээн авах, бүртгэх ажиллагаа	121
4.2. Байцаалт явуулах тактик, арга зүй	123
4.3. Үзлэг, нэгжлэх явуулах тактик, арга зүй	128
4.4. Шинжилгээ хийх, шинжилгээнд томилоход анхаарах асуудал	132
4.5. Албан тушаалын гэмт хэргийг мөрдөхөд анхаарах зарим асуудал	136
4.6. Хээл хахуулийн гэмт хэргийг шалгах ажиллагаа	143

V БҮЛЭГ. АВЛИГА, АЛБАН ТУШААЛЫН ГЭМТ ХЭРГИЙГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААН ДАХЬ ПРОКУРОРЫН ОРОЛЦОО

5.1. Авлигын гэмт хэргийг мөрдөн байцаах, прокурорын хяналтанд анхаарвал зохих асуудал	159
5.2. Прокурорын хяналтын мөн чанар, харьцуулсан судалгаа	163
5.3. Авлигын гэмт хэргийг шүүхээр хянан шийдвэрлэхэд прокурорын оролцоо, мэтгэлцэх зарчмын хэрэгжилт	166
5.4. Авлигын гэмт хэргийг шүүн таслах ажиллагааны онцлог	174
5.5. Авлигын хэргийг мөрдөн шалгах, түүнд прокурорын хяналт тавих үр дүнтэй арга хэрэгсэл	181

ӨМНӨХ ҮГ

Монгол Улсад авлигын эсрэг болон ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх хуулиуд батлагдаж, авлигатай тэмцэх үндэсний хууль тогтоомжоо олон улсын хэм хэмжээнд үе шаттай нийцүүлэн хэрэгжүүлэх, төрийн үйлчилгээг иргэдэд шуурхай, ил тод нээлттэй хүргэх, хүнд суртал, чирэгдлийг арилгах чиглэлээр урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлж буй арга хэмжээний үр дүнд авлигын индексээр дэлхийн 185 орноос 83 дугаар байранд орсон¹ нь өмнөх жилүүдээс урагшилсан эерэг үр дүн харагдаж байна.

Гэвч авлигын индексийн үзүүлэлт, түүний олон нийтийн санал асуулгын дүн, авлига, албан тушаалын гэмт хэргийн талаарх өргөдөл, гомдол, мэдээлэл, эрүүгийн хэрэг үүсгэн шалгасан, шүүхээр шийдвэрлэгдсэн байдал, чиг хандлагаас үзэхэд авлигатай хийх тэмцэл, урьдчилан сэргийлэлтийн талаар бодитой үр дүн төдийлөн харагдахгүй байна.

Авлига нь улс орны хөгжлийг боомилж хэдхэн бусармаг этгээд хагартал баяжиж улс орны баялгийг цөлмөх боломж олгодог, баян ядуугийн ялгааг туйлд нь хүргэдэг, иргэдийн төрд итгэх итгэлийг бууруулдаг, үндэсний баялгийн тэгш хувиарлалтыг алдагдуулдаг зэрэг олон сөрөг үр дагаврыг дагуулдаг.

Манай орны нийт баялгийн 90 гаруй хувийг хүн амын 2 хувь эзэмшиж, үлдсэн 98 хувь нь нийт баялгийн 10 хүрэхгүй хувийг эзэмшиж байгаа, иргэдийн төрд итгэх итгэл алдарсаар байгаа нь авлига газар авсаныг харуулах үзүүлэлт юм.

Иргэдийн дунд явуулсан судалгаагаар² төрийн албан хаагчдын 70 орчим хувь нь авлигад өртөмтгий, тэр дундаа хээл хахууль, авлигатай тэмцэх ёстой шүүх, хууль сахиулах байгууллагууд нь хамгийн их авлигад өртөгдсөн газруудын эхний 10-д жагсаж байгаа нь авлигатай хийх тэмцэл ямар хэцүүг харуулна.

Өнгөрсөн жилүүдэд Монгол Улс авлигатай тэмцэх хууль эрх зүйн орчныг бүрдүүлж, Авлигатай тэмцэх газрыг (цаашид АТГ гэх) байгуулсан нь сайшаалтай боловч иргэдийн хууль эрх зүйн ухамсар, мэдлэгийг дээшлүүлэх, сэтгэлгээг өөрчлөх, цахим төрийн үйлчилгээг бүрэн нэвтрүүлэх, төрийн зарим чиг үүргийг хувийн болон нийтийн эрх зүйн субъектэд шилжүүлэх зэрэг ажлыг хийхгүй цаг алдсаар байгаатай холбоотой.

Шүүхийн шинэчлэлийн хүрээнд шүүх төдийгүй Прокурорын байгууллагын бүтэц, тогтолцоо, хэргийн харъяаллыг өөрчилж 2014 оноос авлигын хэргийг урьд нь зөвхөн Нийслэлийн прокурорын газарт харъяалал тогтоон хянадаг байсан бол 2014 оны 3 сараас орон нутгийн прокурор хянадаг болж байна.

Энэ нь орон нутгийн прокурорын газарт ажиллаж байгаа прокуророос авлигын гэмт хэргийн шийдвэрлэлтэнд хяналт тавих тодорхой мэдлэг

¹ 2013 оны индекс. 2012 онд 94-д байсан

² 2011-2013 онд АНУ-ын Азийн сангийн захиалгаар явуулсан судалгааны дүнгээс

чадвар, аргачлал шаардахаас гадна бусдын нөлөөнд автахгүй байх, өндөр хариуцлагатай байхыг шаардана.

Авлигатай тэмцэх газрын хувьд ч үйл ажиллагааны цар хүрээ нь өргөжиж Авлигатай тэмцэх ерөнхий газар болж, орон нутагт салбараа байгуулах болж байгаа зэрэг өөрчлөлтийн нөхцөлд энэхүү гарын авлага хэвлэгдэж байгаа нь цагаа олсон явдал болжээ.

Дараагийн удаад хууль тогтоомжид нэмэлт өөрчлөлт оруулах замаар шинжлэх ухааны дэвшлийг ашиглаж төрийн бүх албан хаагчийг полиграфийн тестээр шалгаж (*та авлига авсан уу гэсэн нэг л асуулт тавина, аппаратын дүгнэлтийн магадлал 95 хувьтай*) зэрэг заасан албан хаагчдыг чөлөөлөх, шинээр төрийн албанд ороход ч тестийн дүгнэлтийг харгалздаг АНУ болон бусад улсын авлигатай тэмцдэг туршлагыг нэвтрүүлэх шаардлага байна.

Бидний толилуулж байгаа энэхүү гарын авлагын зорилго нь хуульч, хууль сахиулагчдын авлига, албан тушаалын гэмт хэргийн талаарх мэдлэгийг дээшлүүлэх, энэ төрлийн гэмт хэргийг илрүүлэх, шалгаж шийдвэрлэх чадварыг нэмэгдүүлэх, зөв хандлага тогтооход оршино.

Авлигын эсрэг үндэсний болон олон улсын эрх зүйн зохицуулалт, Монгол Улс дахь авлига, албан тушаалын гэмт хэргийн өнөөгийн байдал, шалтгаан нөхцөл, авлига, албан тушаалын гэмт хэргийн эрх зүйн зохицуулалтын хандлага, түүнийг шалгах тактик ажиллагаа, арга зүй, хянан шийдвэрлэх ажиллагаан дахь прокурорын оролцоо зэрэг өргөн хүрээг хамарсанаараа уг гарын авлага нь иж бүрэн шинжтэй болсон гэж редакторын зүгээс үзэж байна.

Та бүхнийг авлига хэмээх хорт үзэгдлээс хол байж, эх орныхоо хөгжилд хувь нэмрээ оруулна гэдэгт итгэж байна.

Сайн үйлс дэлгэрэх болтугай!

Редактор

Хууль зүйн доктор (Ph.D) Ц.Цэлмэг

I БҮЛЭГ. АВЛИГЫН ЭСРЭГ ҮНДЭСНИЙ БОЛОН ОЛОН УЛСЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

1.1. АВЛИГЫН ЭСРЭГ ОЛОН УЛСЫН ЭРХ ЗҮЙН ХЭМ ХЭМЖЭЭ

Дэлхийн улс үндэстнүүдийн түүх, хэл соёл, зан заншил, эрх зүйн хэм хэмжээ өөр хоорондоо харилцан адилгүй учраас авлигатай тэмцэх талаар дэлхий нийтийн нэгдсэн нэг загвар гарган авахад хүндрэлтэй боловч олон улсын эрх зүйн хэм хэмжээ нь улс орнуудад жишиг болгон хэрэглэгдэж байдаг. Түүнчлэн авлигын талаар тодорхойлолтыг янз бүрээр тодорхойлохоос гадна авлигын тодорхой гэмт үйлдлүүд болох хээл хахууль авах өгөх, эрх мэдлээ урвуулах, төсвийн хөрөнгийг хууль бусаар зарцуулах зэрэг нь улс орон бүрийн эрх зүйн зохицуулалтад өөр өөрөөр тусган хуульчилж байна.

Тухайлбал, энгийнээр тодорхойлоход авлига нь төрийн эрх мэдлээ хувийн эрх ашигт урвуулан ашиглахыг хэлдэг³ бол НҮБ-ын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, Эрүүгийн шүүн таслах байгууллагын тодорхойлолтоор авлига нь *өөрт болон бусдад зүй бус давуу эрх олгохын тулд албан үүргээ хэрэгжүүлж байгаа нийтийн болон хувийн албан хаагчид аливаа дүрэм, журам, стандартаа зөрчихийг ятган өглөг барьц өгөх болон бусад үйлдэл хийх юм*. Тэгвэл Source Book-ийн хүрээнд авлигыг тодорхойлохдоо *төрийн албан тушаалтан (улс төрчид эсвэл төрийн албан хаагчид) албан тушаалаа урвуулан ашиглаж хууль бусаар хувьдаа эсвэл ойр дотны хүмүүстээ ашиг хонжоо олохыг хэлнэ*⁴ гэсэн байдаг.

Академик түвшинд мөн авлигын талаар олон янз тодорхойлолтууд байдаг. Тухайлбал, Лафрее болон Моррис нарын тодорхойлсноор: *Нийтийн албан тушаалтан өөртөө болон гуравдагч этгээдэд шударга ёсоор олдох боломжгүй баялаг, нөөц болон бусад давуу байдлыг олгох үүднээс албан ёсны хууль тогтоомж /эрх зүй/, эсхүл хэм хэмжээг зөрчиж байгаа хууль бус үйлдэл* гэсэн бол авлигын эсрэг үйл ажиллагаа явуулж байгаа Германд төвтэй Транспаренси Интернейшнл⁵ байгууллага авлигыг товч байдлаар *“авлига бол нийтийн эрх мэдлийг хувийн ашиг сонирхолд ашиглах”* гэжээ.

Авлигыг дээрх байдлаар өөр өөрөөр тодорхойлсон байдаг бол авлигын гэмт хэргийг олон улсын эх сурвалжид дараах байдлаар тодорхойлсон⁶.

1. НҮБ-ын Авлигын эсрэг конвенцид гэмт хэргийн төрлүүдийг зааж өгсөн. Үүнд: Төрийн албан хаагчийн хээл хахуулийн гэмт хэрэг, гадаадын төрийн албан хаагч болон олон улсын байгууллагын албан хаагчийн хээл хахуулийн гэмт хэрэг, хууль бус аргаар мөнгө олох гэмт хэрэг, төрийн албан хаагч эд хөрөнгө шамшигдуулах, завших, шүүн таслах ажиллагаанд

³Жереми Поуп, Авлигын эсрэг сурвалж бичиг, 2003., 32 дахь тал.

⁴Мөн тэнд

⁵Энэхүү ТББ нь дэлхийд 100 салбартай, Интерпол, Дэлхийн банк гэх мэт олон ОУ-ын түвшний байгууллагуудтай хамтран ажилладаг.

⁶Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын Авлигын эсрэг олон улсын стандартын тайлбар, 2008, 30-р хуудас.

саад учруулах, шахалт үзүүлэн худалдаа хийх, үүрэг зөрчих, хууль бусаар хөрөнгөжих, хувийн сектор дахь хээл хахуулийн гэмт хэрэг г.м

2. Европын зөвлөлийн Авлигын гэмт хэргийн эрүүгийн конвенцид гэмт хэргийн хүрээ хязгаарыг зааж өгсөн. Уг конвенцийн II бүлэгт дотоод болон гадаадын төрийн албан хаагчийн идэвхитэй, идэвхигүй хээл хахуулийн гэмт хэрэг, хувийн сектор дахь хээл хахуулийн гэмт хэрэг болон шахалт үзүүлэн худалдаа хийх гэмт хэргүүдийг тусгасан. Европын зөвлөлийн конвенцид заасан бүх гэмт хэргүүд нь албадлагын гэмт хэргүүд юм.

3. Гадаадын төрийн албан хаагчдын олон улсын бизнесийн хэлцэл дэх хээл хахуулийн гэмт хэрэгтэй тэмцэх тухай Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын конвенц /Хээл хахуулийн эсрэг Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын конвенц/-ийн I зүйлд гадаадын төрийн албан хаагчдын олон улсын бизнесийн хэлцэл дэх хээл хахуулийн гэмт хэргүүдийг зааж өгсөн.

Дээр дурьдсан конвенциуд нь өөрөө шууд хэрэгжих шинж багатай бөгөөд конвенциудад заасан шаардлагуудыг тусгасан дотоодын хууль тогтоомжийг батлахыг улсуудаас шаарддаг. Өөрөөр хэлбэл эдгээр конвенциудыг хэрэгжүүлэхийн тулд улс орнууд хууль тогтоомждоо тухайн стандартуудыг хэрхэн тусгах вэ гэдгийг тодорхойлох ёстой.

Түүнчлэн авлигын эсрэг авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээнүүд нь улс орнуудын хувьд нийтээр хүлээн зөвшөөрөгдөх түгээмэл механизм байх боломжтой. Иймд НҮБ болон Европын Холбоо, Олон улсын Эдийн Засаг, Хамтын ажиллагааны нийгэмлэг зэрэг олон улсын байгууллагууд авлигатай тэмцэх дэлхийн жишиг стандартыг тогтоож олон улсын гэрээ, конвенциудад нэгдэн ажиллахыг уриалсаар байгаа.

Ингэж олон улсын болон улс үндэстний зүгээс авлига, хээл хахуулийн гэмт хэрэгтэй эрчимтэй тэмцэж байгаа ч авлига өсөн нэмэгдсээр байгаа нь улс орны ядуурал зэрэг олон шалтгаантай холбоотой юм.⁷

Жишээлбэл, БНХАУ-ын үндэсний хянан шалгах товчооны тайланд дурьдсанаар ядууралтай тэмцэхэд зориулсан төсвийн хөрөнгийн 1/5-ийг авлига идэж байна гэжээ.⁸

Авлигатай тэмцэх ажиллагааг олон улсын хамтын ажиллагааны хүчээр шийдвэрлэхийг улс орнууд илүүд үзэх болсноор үндэсний хууль тогтоомжоор зохицуулдаг байсан хувь хүний эрх, гэмт хэрэгтэй тэмцэх зэрэг ажиллагааг олон улсын эрх зүйгээр зохицуулах хүсэл эрмэлзлэлийн үүднээс Авлигын эсрэг НҮБ-ын конвенц нь 1990-ээд оноос хойш олон улсын түвшинд авлигатай тэмцэх талаар хийгдсэн институтын болон эрх зүйн шинжтэй олон үр дүнтэй, бодитой алхмуудыг нэгтгэсэн баримт бичиг болж батлагдсан билээ. Энэхүү конвенцийг НҮБ-ын ЕНБД Бан Ги Мүн “Авлигатай тэмцэх дэлхийн хамгийн хүчтэй зэвсэг” гэж томъёолсон, авлигын эсрэг олон улсын болон бүс нутгийн дараах гэрээнүүдийг улс орнууд дагаж мөрдөж авлигатай тэмцэх арга хандлагыг тодорхойлж байна.

⁷ Жереми Поуп, Авлигын эсрэг сурвалж бичиг, УБ, 2003, 31 дэх тал.

⁸ Мөн тэнд.

- 2003.10.31-ны 58/4 тоот тогтоолоор батлагдсан **Авлигын эсрэг НҮБ-ын конвенц**;
- Америк тивийн улсуудын байгууллагаас 1996.03.29-нд баталсан **Авлигын эсрэг Америк тив улсуудын конвенц**;
- Европын холбооны Зөвлөлөөс 1997.05.26-нд баталсан **Европын Холбооны болон түүний гишүүн орны албан тушаалтанд хамаарах авлигын эсрэг конвенц**;
- Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагаас 1997.11.21-нд баталсан **Олон улсын бизнесийн хэлэлцээрт гадаадын төрийн албан хаагчийг хахуульдахтай тэмцэх тухай конвенц**;
- Европын зөвлөлийн Сайд нарын хорооноос 1999.01.27-нд баталсан **Авлигын талаарх эрүүгийн эрх зүйн тухай конвенц**;
- Европын зөвлөлийн Сайд нарын хорооноос 1999.11.4-нд баталсан **Авлигын эсрэг иргэний эрх зүйн тухай конвенц**;
- Африкийн холбооны төр, засгийн тэргүүнүүдийн 2003.7.12-нд баталсан **Авлигаас урьдчилан сэргийлэх түүнтэй тэмцэх тухай Африкийн холбооны конвенц**;
- НҮБ-аас 2003.9.29-нд баталсан **Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ-ын конвенц**.

Авлигын эсрэг Америк тив улсуудын конвенц

Энэхүү конвенц нь 1996 онд Венесуел улсын Каракас хотноо батлагдсан ба авлигын олон төрлийг тодорхойлж, хөгжиж байгаа болон хөгжсөн орнуудад ажиглагдсан түүний олон шинжүүдийг агуулсан төдийгүй улс хоорондын авлигын эсрэг тэмцэх хамтын ажиллагааг хөнгөвчлөх, дэмжих хэрэгцээг ухамсарласан анхны хууль зүйн зэвсэг болсон юм. Энэхүү конвенцийн зорилго нь:

- Оролцогч улсуудын авлигатай тэмцэх, илрүүлэх, шийтгэх, ул үндсийг арилгах хэрэгцээтэй механизмыг хөгжүүлэх, өргөжүүлэх болон дэмжих;
- Төрийн албан хаагч нийтийн үйлчилгээнд чиг үүргээ хэрэгжүүлэх явцдаа чиг үүрэгтэйгээ холбоотойгоор авлигад автах явдлыг арилгах, тэрхүү үйлдлийг илрүүлэх, шийтгэх, түүнээс хамгаалах үйл ажиллагааг үр дүнтэй арга хэрэгслээр хангах байдлаар оролцогч улсуудын хоорондын хамтын ажиллагааг журамлах, хөнгөвчлөх болон дэмжих.

Энэхүү конвенц нь авлигын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэрэгслийн цогц бүрдлийг бий болгох, авлигын тодорхой үйлдлүүд болох үндэстэн дамнасан хээл хахууль, хууль бусаар баяжих зэргийг гэмт хэрэгт тооцох явцыг тодорхой болгох, оролцогч улсуудын хоорондын хамтын ажиллагааг өргөжүүлэх буюу 2 талт эрх зүйн туслалцаа, техникийн хамтын ажиллагаа, хэрэгтэн шилжүүлэх, авлигын гэмт хэрэг үйлдэгдэхэд хэрэглэгдсэн болон гэмт хэргийн улмаас бий болсон хөрөнгийг хураан авах, борлуулах, хадгалах, мөрдөх, таньж олуулах үйл ажиллагааны талаар цуврал заалтуудыг агуулах зэргийг багтаасан 28 зүйл бүхий конвенц юм.

Энэхүү Америк тив улсуудын авлигын эсрэг конвенцид одоогоор хойд болон өмнөд Америкийн 30 гаруй улс гарын үсгээ зурж нэгдэн орсон байдаг.

1. Европын хамтын нийгэмлэг болон Европын холбооны гишүүн орны албан тушаалтанд хамаарах авлигын эсрэг конвенц

Европын холбооны хурлаар 1997 онд баталсан тус конвенц нь Европын Холбооны гэрээн дээр үндэслэгдсэн ба Европын хамтын нийгэмлэг болон Европын холбооны гишүүн орны албан тушаалтанд хамаарах авлигын эсрэг баримт бичиг юм.

Тус конвенцоор Европын Холбооны гишүүн орны төрийн албан тушаалтныг авлигад өртөхтэй тэмцэх, гишүүн улсуудын хоорондын шүүхийн хамтын ажиллагааг өргөжүүлэх асуудлыг өргөн авч үзсэн. Конвенцийн үндсэн дээр гишүүн улс бүр идэвхгүй болон идэвхтэй авлигын гэмт үйлдэл үйлдэж байгаа албан тушаалтанд эрүүгийн хариуцлага ноогдуулахаар шаардлагатай арга хэмжээг авах ёстой байна. Түүнчлэн конвенцийн дагуу авлигын ноцтой хэргүүдийн хувьд тухайн этгээдийн эрх чөлөөг хязгаарлах мөн хэрэгтэнг холбогдох улсад шилжүүлэн өгөх зэрэг заалтууд байдаг.

Олон улсын бизнесийн хэлэлцээрт гадаадын төрийн албан хаагчийг хахуульдахтай тэмцэх тухай конвенц

Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (OECD)-аас 1997 онд батлагдан гарсан энэхүү конвенц нь олон улсын бизнесийн хэлэлцээрт гадаадын төрийн албан хаагчийг хахуульдахыг гэмт хэрэгт тооцох эрх зүйн дагаж мөрдөх стандартыг тогтоож өгсөн мөн түүний эсрэг үр нөлөөтэй арга хэмжээ авахыг уриалсан олон улсын баримт бичиг юм.

Тус конвенц нь хээл хахууль авах, өгөх үйл явцын “нийлүүлэгч тал”-д гол анхаарлыг хандуулсан анхны олон улсын гэрээ бөгөөд Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын гишүүн 34 орон гишүүн бус 6 орон болох Аргентин, Бразил, Болгар, Колумб, ОХУ, Өмнөд Африк зэрэг нийт 38 улс энэ конвенцид нэгдэн орсон бол БНХАУ, Энэтхэг, Индонез зэрэг улс нэгдэн ороогүй байна.

Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага нь 1948 онд байгуулагдсан бөгөөд эхэн үедээ Европын орнууд гишүүнчлэлтэй байсан бол 1961 оноос гишүүнчлэлийг Европын холбооны орнуудаар хязгаарлахгүй болжээ. Тус байгууллагын авлигын эсрэг бүлэг жил бүр хуралдаж татварын болон санхүүгийн бодлогын талаар хэлэлцдэг.

Тус конвенцийн хэрэгжилттэй холбоотойгоор 2009 онд Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын Хээл хахуулийн эсрэг зөвлөмжийг гаргасан ба 40 улс хүлээн зөвшөөрсөн. Тус 40 улсын төлөөлөгчдөөс бүрдсэн Ажлын хэсэг конвенцийн болон зөвлөмжийн хэрэгжилт түүнийг мөрдүүлж буй тал дээр хяналт тавих ба 4 жилд 1 удаа Парис хотноо хуралддаг байна.

Хээл хахуулийн эсрэг конвенцийн⁹ I зүйлд тодорхойлсоноор “олон улсын бизнесийн хэлцэл дэх гадаадын төрийн албан хаагчийн хахууль”-ийг “олон улсын бизнесийн харилцаанд зүй бус давуу тал олж авах зорилгоор гадаадын төрийн албан хаагчаар захиргааны шийдвэр гаргуулах, хууль ёсны албан үүргээ гүйцэтгэхээс нь татгалзуулахын тулд мөнгө, санхүүжилтыг шууд болон шууд бусаар өгөх буюу тийнхүү өгөхөөр санал болгох, амлах, үйлдэл” гэжээ.

Гадаадын иргэдийн оролцсон хээл хахуулийн хэрэг нь ихэвчлэн томоохон авлигын хэрэг байдаг ба өндөр түвшний, улс төрийн томоохон албан тушаалтнуудтай холбоотой авлигын онцгой хэлбэр гэж үзэж болно.

Түүнчлэн конвенцийн VI зүйлд зааснаар мэргэжлийн үйл ажиллагааны аливаа хязгаарлалт нь гадаадын албан тушаалтны авлигын хэргийг мөрдөн шалгах, түүнд хяналт тавих тохиромжтой цаг хугацааг хязгаарлах ёсгүй гэсэн байдаг.

Европын Холбооны авлигын эсрэг эрүүгийн эрх зүйн конвенц

Европын Холбооны Зөвлөлийн Сайд нарын хорооноос 1999 онд баталсан Авлигын эсрэг эрүүгийн эрхийн конвенц нь дотоодын болон гадаад орны төрийн албан тушаалтанд ямар нэг хэлбэрээр өглөг, шан харамж өгөхийг хориглодог.

Тус конвенцийг Европын Холбооны улс төдийгүй АНУ, Канад, Япон зэрэг улсууд хүлээн зөвшөөрсөн ба одоогийн байдлаар буюу 2013 оны байдлаар дэлхийн 34 улс соёрхон баталж 7 улс гарын үсэг зуржээ.¹⁰

Европын Холбооны авлигын эсрэг иргэний эрх зүйн конвенц

Европын Холбооны авлигын эсрэг иргэний эрх зүйн конвенц нь авлигын чиглэлээр иргэний эрх зүйн олон улсын нийтлэг журмыг тодорхойлохыг хичээсэн анхны оролдлого юм. Тухайлбал, авлигын улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэх зэргээр иргэний хариуцлагыг хүлээлгэх нөхцөл байдлыг оруулсан байдаг.

Тус конвенцид Авлигын эсрэг улс орнуудын тусгай групп мониторинг хийх асуудлыг 1999 онд эхлүүлсэн бөгөөд Европын Зөвлөлөөр хянагдсан авлигын эсрэг хэд хэдэн арга хэрэгслийг бий болгожээ. Үүнд: техникийн туслалцааны хөтөлбөр байдаг.¹¹

Иргэний эрх зүйн авлигын конвенцид авлигыг тодорхойлохдоо “энэхүү конвенцийн зорилгоор авлига нь хээл хахууль болон ямар нэгэн давуу талыг шууд болон шууд бусаар шаардах, санал болгох, өгөх болон хүлээн авах үйлдлийг хэлэх ба ингэснээр тэрхүү авлигыг хүлээн авагч нь өөрийн албан үүргийг гуйвуулан хууль бусаар бусдад давуу байдлыг олгох үйлдэл байдаг”.¹²

⁹www.oecd.org/corruption

¹⁰ Нэгдэн орсон улсуудын жагсаалтыг доорх сайтаас үзнэ үү. <http://conventions.coe.int/Treaty/Commun/ChercheSig.asp?NT=174&CM=&DF=&CL=ENG>

¹¹http://archive.transparency.org/global_priorities/international_conventions/conventions_instruments/coe_civil_law#sthash.NbXfWPdP.dpuf

¹² Авлигын эсрэг Иргэний эрх зүйн конвенцийн 2 дугаар зүйл.

Мөн тус конвенцийн 3 дугаар зүйлд авлигын гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэх эрхийг заасан ба бодит хохирол, олох байсан ашиг орлого түүнчлэн мөнгөн бус хохирлыг нөхөн төлүүлнэ гэжээ.

Авлигаас урьдчилан сэргийлэх түүнтэй тэмцэх Африкийн Холбооны конвенц

2003 онд Африкийн холбооноос баталсан Авлигаас урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх тухай конвенц Африкийн холбооны орнуудын удирдах хурлаар батлагдсан. Тус конвенцийн зорилго нь оролцогч улсуудад дараах 3 асуудлыг үүрэг болгосон байна:

1. Урьдчилан сэргийлэх арга хэмжээ: Төрийн болон хувийн салбарт авлигаас урьдчилан сэргийлэх арга хэмжээний стандарт, арга зам, механизмын өргөн заалтуудыг агуулсан. Түүнчлэн, мэдээлэлд хүрэх шаардлага, мэдээлэгчийн хамгаалалт, улс төрийн намын санхүүгийн ил тод байдал, иргэний нийгмийн оролцоо гэх мэт зүйлийг тодорхой заажээ. Авлигын эсрэг үндэсний хэмжээний бие даасан байгууллага байгуулах түүний үйл ажиллагааг өргөжүүлэхийг шаардсан байна.

2. Гэмт хэрэгт тооцох: Африкийн Холбооны конвенц нь хууль бусаар баяжих зэрэг тодорхой гэмт үйлдлүүдийг өргөн хүрээнд гэмт хэрэгт тооцохыг үүрэг болгожээ. Мөн хувийн хэвшлийн зүгээс авлигад холбогдохыг гэмт хэрэгт тооцох тухай заалт байдаг.

3. Олон улсын хамтын ажиллагаа: Конвенцид олон улсын хамтын ажиллагааны цар хүрээг тодорхойлж, Африк тив улсуудын хоёр талт хууль сахиулах туслалцааг өргөжүүлэх, эд хөрөнгө хураан авах зэрэг ажиллагааг гүйцэтгэх талаар заажээ.

Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ-ын конвенц

НҮБ-ын Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг конвенц нь ҮДЗБГХ-ийн талаар олон улсын хэмжээнд мөрдөгдөж байгаа гол баримт бичиг бөгөөд уг конвенцоор ҮДЗБГХ-ийн үр нөлөөнд зэвсэгт мөргөлдөөн болон өөр төрлийн хүчирхийллийг дагуулсан сөргөлдөөнийг бий болгох, авлигын сүлжээг бий болгох, терроризмын үндэс суурийг бүрэлдүүлэх зэрэг хор уршиг байгааг тодорхойлжээ.

2013 оны байдлаар уг конвенцид 176 улс орон¹³ нэгдэж орсон байгаа нь ҮДЗБГХ-ийн тухай ойлголт дээр дэлхийн ихэнх улс орон санал нэгдсэнийг илтгэж байна.

Монгол Улс уг конвенцид 2008 онд нэгдэн орсон ба энэ конвенц нь зохион байгуулалттай гэмт хэргийн асуудлыг авч үзсэн цорын ганц олон улсын конвенц юм.

ҮДЗБГХ-ийн эсрэг конвенц нь ҮДЗБГХ-тэй илүү үр дүнтэйгээр урьдчилан сэргийлж, тэмцэхийн тулд хамтын ажиллагааг хөхүүлэн дэмжих

¹³ UN Treaty Collection, *UN Convention against Transnational Organized Crime*. http://treaties.un.org/Pages/ViewDetails.aspx?src=TREATY&mtdsg_no=XVIII-12&chapter=18&lang=en

үндсэн зорилгыг агуулж байдаг¹⁴ бөгөөд үүгээрээ ҮДЗБГХ-тэй тэмцэх гэсэн олон улсын хүсэл эрмэлзлэлийн илэрхийлэл болсон юм.

ҮДЗБГХ-ийн эсрэг конвенциор “зохион байгуулалттай гэмт бүлэглэл” гэдгийг нэг эсхүл хэд хэдэн гэмт хэрэг үйлдэх зорилгоор тохиролцон, шууд буюу шууд бус хэлбэрээр санхүүгийн эсхүл бусад материаллаг ашиг олохоор тодорхой хугацаанд байгуулагдсан, гурав буюу түүнээс дээш тооны бүлэг этгээдийг хэлнэ¹⁵ гэжээ.

Энэ байдлаар ҮДЗБГХ гэдгийг шууд тодорхойлоогүй нь дэлхийн, бүс нутгийн хэмжээнд эсвэл дотоодод шинээр үүсэж болох гэмт хэрэгт конвенцийн үйлчлэлийн хүрээг хязгаарлахгүй байх зорилготой байжээ.¹⁶

Ихэнх гэмт бүлэглэлүүд нь 3 ба түүнээс дээш гишүүдтэй хамтран ажиллаж, тодорхой хугацаанд оршин тогтнож байдаг тул зохион байгуулалттай гэмт бүлэглэлийн гол тодорхойлогч хүчин зүйл нь ашиг олох зорилготойгоор хүнд төрлийн гэмт хэрэг үйлдэх явдал болно.¹⁷ Хүнд гэмт хэрэг гэдэгт дөрвөөс доошгүй жилийн хугацаагаар хорих буюу онц хүнд ял оногдуулах гэмт хэргүүдийг¹⁸ авч үзнэ гэжээ.

Ийнхүү ҮДЗБГХ-ийн эсрэг конвенцийн үйлчлэх хүрээ доорхи гэмт хэргүүд үндэстэн дамнасан шинж чанартай болон зохион байгуулалттай гэмт бүлэглэл үйлдсэн бол дараах байдлаар тодорхойлогдсон байна. Үүнд:

1. Конвенцийн 5, 6, 8 болон 23 дугаар зүйлд тодорхойлсон гэмт хэргүүд;¹⁹

2. Конвенцийн II зүйлийн нэр томъёонд тусгагдсан дөрвөөс доошгүй жилийн хугацаагаар хорих буюу онц хүнд ял оногдуулах гэмт хэргүүд болно.

ҮДЗБГХ-ийн эсрэг конвенцийн 5 дугаар зүйлд зохион байгуулалттай гэмт бүлэглэлд оролцох, 6 дугаар зүйлд гэмт хэргээс олсон ашиг орлогыг угаах (мөнгө угаах), 8 дугаар зүйлд авлига болон 23 дугаар зүйлд шүүх үйл ажиллагаанд саад тотгор учруулах зэрэг гэмт хэргүүдийг заасан тул эдгээр төрлийн гэмт хэргүүд нь үндэстэн дамнасан байдлаар үйлдэгдэж, зохион байгуулалттай гэмт бүлэглэл үйлдсэн бол конвенц үйлчлэнэ. Өөрөөр хэлбэл, тус конвенцид нэгдэн орсон улс орнууд эдгээр төрлийн гэмт хэргүүдийг заавал эрүүгийн хууль тогтоомжиндоо тусгах, тэмцэх үүрэг амлалтуудыг хүлээдэг байна.

ҮДЗБГХ-ийн эсрэг конвенциор дээрхи гэмт хэрэг нь дараах тохиолдолд үндэстэн дамнасан шинж чанартай байхаар заасан байна. Үүнд:

1. Зохион байгуулалттай гэмт хэрэг нэгээс олон улсад үйлдэгдсэн;

2. Нэг улсад үйлдэгдсэн боловч гэмт хэрэг үйлдэх үе шатны

¹⁴НҮБ-ын Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг конвенцийн 1 дүгээр зүйл.

¹⁵ НҮБ-ын Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг конвенцийн 2 дугаар зүйлийн “а” хэсэг.

¹⁶ UN Office on Drugs and Crime website: “Organized Crime” <https://www.unodc.org/unodc/en/organized-crime>

¹⁷ Мөн тэнд.

¹⁸ НҮБ-ын Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг конвенцийн 2. “b” хэсэг.

¹⁹ НҮБ-ын Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг конвенцийн 3.1

бэлтгэх, завдах, төлөвлөх, удирдах буюу хянах үндсэн хэсгийг өөр улсад гүйцэтгэсэн;

3. Нэг улсад үйлдэгдсэн, гэхдээ нэгээс олон улсад гэмт хэргийн үйл ажиллагаа явуулдаг зохион байгуулалттай гэмт бүлэглэл оролцсон;

4. Нэг улсад үйлдэгдсэн, гэхдээ бодит үр дагавар нь нөгөө улсад илэрсэн²⁰ зэрэг болно.

Дээрх байдлаар үндэстэн дамнасан шинж чанарыг тодорхойлсон нь өргөн утга агуулгыг хамарч, улс орнуудын хувьд аль болох олон талт хамтын ажиллагааг бүрдүүлэх нөхцөл боломжийг бий болгож байна.

ҮДЗБГХ-ийн эсрэг конвенциор 5, 6, 8 болон 23 дугаар зүйлд тодорхойлсон гэмт хэргүүд, дөрвөөс доошгүй жилийн хугацаагаар хорих буюу онц хүнд ял оногдуулах гэмт хэргүүд болон материаллаг ашиг олох зорилгыг хангасан тохиолдолд үндэстэн дамнасан гэсэн шинжийг нэг бол үндэстэн дамнасан гэмт байгууллага байх, үндэстэн дамнасан гэмт үйлдэл хийх эсвэл гэмт үйлдлийн үр дагавар нь үндэстэн дамнасан байх зэргээр хангаж болно.²¹ Мөн түүнчлэн ҮДЗБГХ-ийн эсрэг конвенцид нэгдэн орсоноороо улс орнууд эрх зүйн туслалцаа үзүүлэх, ялтан шилжүүлэх зэрэг асуудлаар шинэ эрх зүйн орчин бүрэлдэж байгаа бөгөөд хууль сахиулах байгууллагуудын хамтын ажиллагаа нэмэгдэх боломжийг олгож байгаа болно.²²

Гишүүн улс орнууд зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх үндэсний байгууллагуудын чадавхийг бэхжүүлэх зорилгоор сургалт, техникийн туслалцаа үзүүлэх үүрэг амлалт өгч байдаг байна.²³

1.2. АВЛИГЫН ЭСРЭГ НҮБ-ЫН КОНВЕНЦ

НҮБ-ын Ерөнхий Ассамблей 2000.12.04-ний 55/61 тоот тогтоолд “Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ-ын конвенциос тусдаа авлигын эсрэг олон улсын бие даасан эрх зүйн баримт бичиг боловсруулах нь чухал байгаа”-г дурьдаж НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх газрын дэргэд авлигын эсрэг олон улсын баримт бичгийн төсөл боловсруулах түр хороог томилсон байна.

Тус хороо нь 2002.1.31-нээс 2003.10.1-ний хооронд 7 удаа хэлэлцэж, зөвшилцөн Авлигын эсрэг НҮБ-ын конвенцийн төслийн эцсийн найруулгыг боловсруулсаныг Ерөнхий Ассамблей 2003.10.31-нд 58/4 тоот тогтоолоор тус конвенцийг баталжээ.

Конвенцид гарын үсэг зурах тухай ОУБХ-г зохион байгуулах тухай Мексик Улсын Засгийн газрын санаачлагыг Ерөнхий Ассамблей зөвшөөрч 2003.12. 9-11-ний өдрүүдэд Мексикийн Мерида хотноо зохион байгуулсан. Авлигын эсрэг НҮБ-ын конвенцид Эквадор Улс тус нэгдэж 30 дахь гишүүн

²⁰ Мөн тэнд үзэх

²¹ James Cockayne, “Transnational Organized Crime: Multilateral Responses to a Rising Threat”, p.2.

²² НҮБ-ын Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг конвенцийн 17, 18, 26 дугаар зүйл

²³ Мөн тэнд

орон болсон 2005 онд хүчин төгөлдөр болсон. Энэхүү баримт бичигт жил бүрийн 12 сарын 9-ны өдрийг Дэлхий нийтээр “авлигын эсрэг өдөр” болгон зарласан байдаг. Тус конвенцид 2013 оны байдлаар дэлхийн 168 орон нэгдэн орж 140 улс гарын үсэг зурсан ба 10-аад улс ямар нэгэн байдлаар нэгдэн орсон боловч гарын үсэг зураагүй байна.²⁴

Конвенц нь авлигаас урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэхэд чиглэсэн хэм хэмжээг тогтоосон 8 бүлэг, 71 зүйлтэй олон улсын эрх зүйн томоохон баримт бичиг юм. Үндсэн хэсгүүд нь урьдчилан сэргийлэх арга хэмжээ, эрүүгийн эрх зүйн зохицуулалт /материаллаг болон хэрэгжүүлэх зохицуулалт/, иргэний эрх зүйн зохицуулалт, олон улсын хамтын ажиллагаа болон техникийн тусламж зэрэг юм. Конвенцийн заалтууд дор дурдсан агуулгатай:

- Конвенцид нэгдэн орсон улс өөрийн хууль тогтоомжид заавал тусгаж хуульчлах заалт;
- Конвенцид нэгдэн орсон улс өөрийн хууль тогтоомжид тусгахыг эрмэлзэх заалт ;
- Нэмэлт зүйл, заалтууд багтжээ.

Конвенцийн удиртгал хэсэгт:

- Авлига нь нийгмийн тогтвортой, аюулгүй байдалд бэрхшээл, аюул занал учруулж улмаар ардчиллын тогтолцооны болон ёс зүйн үнэт зүйлс, шударга ёсыг сулруулж, тогтвортой хөгжил, хууль дээдлэх ёсонд хохирол учруулахуйц болж байгаа;
- Авлига нь бусад гэмт хэрэг, ялангуяа зохион байгуулалттай гэмт хэрэг, мөнгө угаах зэрэг эдийн засгийн гэмт хэрэгтэй холбоотой байдаг;
- Авлигын хэрэг нь улсын нөөц баялгийн үлэмж хэсгийг бүрдүүлэхүйц их хэмжээний хөрөнгөтэй холбоотой бөгөөд тухайн улсын улс төрийн тогтвортой байдал, тогтвортой хөгжилд заналхийлж байдаг;
- Авлига нь үндэсний асуудал байхаа больж бүх улсын нийгэм, эдийн засагт нөлөөлөх үндэстэн дамнасан үзэгдэл болсон;
- Эд баялгийг хууль бусаар олж авах нь ардчилсан тогтолцоо, үндэсний эдийн засаг, хууль дээдлэх ёсонд хохирол учруулж байна гэж тодорхойлсон байна.

Тус конвенцийн зорилгыг авлигаас илүү үр ашигтай бөгөөд үр дүнтэйгээр урьдчилан сэргийлж, тэмцэх арга хэмжээг дэмжиж, бэхжүүлэх, авлигаас урьдчилан сэргийлж, тэмцэх, тухайлбал хөрөнгө буцааж олгох талаар олон улсын хамтын ажиллагаа, техникийн туслалцааг хөгжүүлэх, хөнгөвчлөх, дэмжих болон төрийн хэрэг, төрийн эд хөрөнгийн шударга, хариуцлагатай, зохистой удирдлагыг дэмжихэд оршино гэжээ.

Монгол Улс тус конвенцид 2005.04.29-нд нэгдэн орж, 2005.10.27-нд УИХ соёрхон баталсан, конвенцийг соёрхон баталсан тухай батламж жуух бичгийг 2006.01.11-нд НҮБ-ын ЕНБД-д хадгалуулахаар хүргүүлж, 2006.02.10-наас эхлэн дотоодын хууль, тогтоомжийн нэгэн адил хүчин

²⁴ Тоон мэдээг <http://www.unodc.org/unodc/en/treaties/CAC/signatories.html> сайтаас авч ашиглав. 2013 оны 10 сар.

төгөлдөр үйлчилж эхэлсэн. Ингэснээр манай улс тухайн олон улсын гэрээг даган мөрдөх, түүний хэрэгжилтийг хангахад хүчин чармайлт тавих үүргийг олон улсын өмнө албан ёсоор хүлээсэн билээ. Аливаа улс нэгдэн орсон олон улсын гэрээний хэрэгжилтийг дараах механизмаар хангадаг байна.

- Олон улсын баталгаа бий болгох;
- Олон улсын хяналт бий болгох;
- Олон улсын албадлага хэрэглэх;
- Мэдээлэл, итгэлцлийн тогтолцоо бий болгох.

НҮБ нь конвенцийн хэрэгжилтийг дэмжих, хянах үүднээс тус конвенцийн гишүүн орнуудад зөвлөмж өгөх, түүнчлэн хүлээсэн үүргээ биелүүлээгүй болон тухайн гэрээнд заасан үйлдэл, эс үйлдлийг зөрчсөн этгээдэд хариуцлага хүлээлгэх зэргээр энэхүү конвенцийг хэрэгжүүлэх талаар тодорхой арга хэмжээг явуулдаг. Тухайлбал, конвенцийн хэрэгжилтийг дэмжих, хяналт тавих зорилгоор бага хурлын III чуулган 2009 онд Катарын Доха хотноо зохион байгуулагдсан ба тус чуулганаар конвенцийг хэрэгжүүлэхэд түүнд оролцогч улсуудад дэмжлэг үзүүлэхэд чиглэгдсэн “Конвенцийн хэрэгжилтийг хянах аргачлал”-ыг баталсан байна. НҮБ-аас 2010 онд Монгол Улсад конвенцийн III, IV бүлгийн хэрэгжилтийн талаар ирүүлсэн зөвлөмжид эдгээр бүлгийн хэрэгжилтийг үнэлж Монгол Улс тус конвенцийн хэрэгжилтийн талаар цаашид авах арга хэмжээг зөвлөжээ.

Үнэлгээг хийхдээ Монгол Улсаас ирүүлсэн өөрийн үнэлгээний дэлгэрэнгүй тайлан, “Конвенцийн хэрэгжилтийг хянах аргачлалд заасны дагуу ирүүлсэн нэмэлт мэдээллүүд дээр тулгуурласан.Зөвлөмжид *гэмт хэрэгт тооцох ба хууль сахиулах, олон улсын хамтын ажиллагаа* гэсэн үндсэн 2 асуудлаар дараах асуудлыг тусгасан байна.

Нэг. Гэмт хэрэгт тооцох ба хууль сахиулах

1.1. Эрүүгийн гэмт хэрэгт тооцох

Монгол Улс хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомждоо олон улсын стандартад нийцүүлсэн нэмэлт, өөрчлөлт оруулах талаар идэвх зүтгэлтэй ажиллаж байгааг тэмдэглэхийн зэрэгцээ, үнэлгээний багийнхан Монгол Улсыг дараах арга хэмжээг авахыг зөвлөсөн байна. Үүнд:

1) Хээл хахуулийн гэмт хэрэгтэй холбоотой хуулийн зүйл, заалтдаа нэмэлт, өөрчлөлт оруулж, хээл хахуулийн гэмт хэргийг зүйлчлэхдээ төрийн албан хаагч албан тушаалын чиг үүргээ хэрэгжүүлэхтэй холбоотойгоор болон албан тушаалын чиг үүргээсээ гадуур үйлдсэн үйлдлүүдийг ялгаж зүйлчилж байгаа ялгааг арилгах;

2) Хээл хахуулийн идэвхгүй хэлбэрийг тогтоосон хууль тогтоомждоо нэмэлт, өөрчлөлт оруулж, төрийн албан хаагч нь хээл хахууль өгөхийг шаардах үйлдлийг гэмт хэрэгт тооцох;

3) Хээл хахуулийн идэвхтэй ба идэвхгүй хэлбэрүүдэд ногдуулах ял шийтгэлийг боловсронгуй болгох, хээл хахуулийн хэргийн талаар иргэдийн мэдээлэл өгөх идэвх санаачлагыг дэмжих, төрийн албан хаагчийн зүгээс

хээл хахууль нэхэх, шаардах явдлыг арилгахын тулд хээл хахууль авах үйлдэлд хээл хахууль өгөхөөс илүү хатуу ял шийтгэл ногдуулдаг болох;

4) Монгол Улсын Эрүүгийн хууль дахь хээл хахуулийн гэмт хэрэгт мөрдөн байцаалт явуулах босгыг бууруулсанаар АТГ-ын шалгах хээл хахуулийн хэргийн харьяаллыг боловсронгуй болгох юм.

5) Гадаадын болон Олон улсын байгууллагын албан тушаалтны хээл хахуулийн идэвхтэй ба идэвхгүй хэлбэрийг гэмт хэрэгт тооцох чиглэлээр тодорхой хууль тогтоомж гаргаж батлах;

6) Гадаадын болон Олон улсын байгууллагын албан тушаалтны хээл хахуулийн идэвхгүй хэлбэр, эрх нөлөөгөө урвуулан ашиглах гэмт хэргийн идэвхтэй ба идэвхгүй хэлбэр, хувийн хэвшлийн хээл хахуулийн хэргийг тус тус гэмт хэрэгт тооцох;

7) Хууль бусаар баяжих явдлыг гэмт хэрэгт тооцох;

8) Албан үүргээ урвуулан ашиглах гэмт хэргийн хохирлын зүйлд тавигдах хязгаар босгыг тогтоож өгсөн учраас тэр хязгаараас доогуур хохирлын зүйл бүхий үйлдэл нь гэмт хэрэгт тооцогдолгүй захиргааны шугамаар шийдвэрлэгддэг тул энэхүү хязгаар босгыг арилгах нь зүйтэй.

1.2. Хууль сахиулах

Хууль сахиулах байгууллагууд авлигын гэмт хэргийн чиглэлээр хамтын ажиллагаагаа бэхжүүлэхэд Монгол Улс дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэх нь зүйтэй.

1) Монгол Улсын хуулиар төрийн зарим албан тушаалтнуудад олгогдсон бүрэн эрх, хууль зүйн халдашгүй байдал зэрэг нь тэдгээрийн албан үүргээ биелүүлэхэд нь зайлшгүй шаардагдах халдашгүй байдлынх нь хамгаалалт гэдэг утгаасаа хэтэрсэн эсэхэд үнэлгээ өгөх.

2) Гэрч, шинжээч, хохирогчийг хамгаалах тухай хууль баталж, хэрэгжүүлэх, хууль батлагдах хүртэлх завсрын хугацаанд эмзэг ангиллын гэрчүүдэд зохих хамгаалалт үзүүлэх арга ажиллагаагаа үргэлжлүүлэн хэрэгжүүлэх, хууль сахиулах байгууллагын анхаарлыг хандуулах²⁵.

3) Авлигын эсрэг НҮБ-ын конвенцийн 23 дугаар зүйлд заасны дагуу мөнгө угаах гэмт хэргийн эсрэг хуулийнхаа хувийг НҮБ-ын ЕНБД-д хүргүүлэх.

4) Авлигатай тэмцэх газрын салбарыг 21 аймагт байгуулах²⁶.

5) АТГ-ын салбар нэгжүүд байгуулагдах хүртэлх завсрын хугацаанд авлигын гэмт хэргийг цагдаагийн байгууллагаар мөрдөн шалгуулах бололцоог судлах.

6) АТГ нь харьцангуй шинэ тутам байгуулагдсан байгууллага, Монгол Улсад 160 гаруй мянга орчим төрийн албан хаагч байдаг гэж тооцоолон тус байгууллагын үйл ажиллагааны амжилтыг баталгаажуулахын тулд улс

²⁵ Зөвлөмжийн тус хэсгийг хангасан зохицуулалт болох "Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль" 2013 онд батлагдсан.

²⁶ Төсөв хөрөнгийн хувьд боломжгүй байгаатай холбоотой энэ хэсгийн заалтыг хангаж чадаагүй байгаа авлигатай тэмцэх ажиллагаанд зарим хүндрэлийг учруулсаар байна.

төрийн дэмжлэг болон ялангуяа мөрдөн байцаагч, урьдчилан сэргийлэх ажил хариуцсан ажилтнуудад зориулсан менежментийн тусгай сургалт зохион байгуулах зэрэг чадавхи сайжруулах арга хэмжээ нэн чухал юм.

7) Авлигын эсрэг НҮБ-ын конвенцод заагдсан бүх гэмт хэргүүдийг харьяалан мөрдөн шалгах бүрэн эрхийг Авлигатай тэмцэх газарт олгох. Үүнд ялангуяа суурь гэмт хэрэг нь авлигын гэмт хэрэг байх мөнгө угаах болон эд хөрөнгө завших гэмт хэрэг, түүнчлэн сонгуультай холбоотой авлигын гэмт хэргийн мөрдөн шалгах эрхийг АТГ-д өгөх хэрэгтэй.

8) АТГ-ын үйл ажиллагаанд улс төр, бизнес болон бусад сонирхлын нөлөөг бууруулах зорилгоор тус байгууллагын үйл ажиллагаанд хууль бусаар нөлөөлөх гэмт үйлдэлд эрүүгийн хариуцлага хүлээлгэдэг болох.

9) Хэргийн шийдвэрлэлт болон ял ногдуулах үйл явцад тавигдах хяналтыг сайжруулах зорилгоор бүх төрлийн хууль сахиулах байгууллагуудыг хамруулан холбосон нэгдмэл мэдээллийн сан байгуулах²⁷.

10) Монгол Улсын Эрүүгийн хуулийн дагуу авлигатай холбоотой гэмт хэрэг нь эрүүгийн гэмт хэрэгт тооцогдож, эрүүгийн шүүхээр хянан хэлэлцэгдэж, шийдвэрлэгдэхээр заагдсны дагуу энэхүү зохицуулалтад нийцүүлэн авлигын гэмт хэргийн чиглэлээр мэргэшсэн шүүгч нараас бүрдсэн авлигын гэмт хэргийн дагнасан тусгай шүүхийг байгуулах.

11) Төрийн албан тушаалтны халдашгүй эрх дархыг түдгэлзүүлэх, цуцлах хүсэлтэд хариу өгөөгүй тохиолдолд уг асуудлыг шийдвэрлэх арга хэрэгслийг бий болгох, энэ төрлийн шийдвэрийг сэжигтэн этгээдээс хараат бус этгээд гаргах талаар зохицуулалт хийх.

12) ЭБШ хуулийн 144, 163 дугаар зүйлүүдэд эрүүгийн хэрэгт байцаалт, мэдүүлэг өгч байгаа хохирогч, гэрч нь хавтаст хэрэгт заавал гарын үсэг зурж байх тухай заалтад нэмэлт, өөрчлөлт оруулах.

13) Гэмт хэргийн талаар мэдээлэгчдийн эрхийг хамгаалах тухай тодорхой хууль тогтоомж гаргах.

14) Улс төрийн нам болон мэдээллийн эрх чөлөөний тухай хууль тогтоомжийг батлан гаргах.

15) Сонгуулийн хуульд байгаа улс төрийн намуудад тогтоосон хэмжээнээс илүү хандив өгсөн тухай мэдээллийг шаардах тухай заалтыг эргэж харах.

16) Төрийн албан хаагчийн хөрөнгө, орлогын мэдүүлгийг хүлээн авах, дүн шинжилгээ хийх, мэдүүлэгт дурдагдсан мэдээллийг шалгах, мэдүүлгийг АТГ-т шилжүүлэхтэй холбоотой хууль зүйн тусгай эрх хэмжээг эрх бүхий төрийн байгууллагуудад олгох асуудлыг анхааралдаа авах

17) Хөрөнгө, орлогын мэдүүлгээ гаргах журмыг зөрчсөн тохиолдолд нуун дарагдуулсан хөрөнгийг хураан авах гэх мэт илүү, хатуу чанд хариуцлага тооцдог болох талаар бодолцох

18) УИХ-ын дэргэд Санхүүгийн тайлангийн хороо, Хөрөнгө оруулалтын хороог байгуулах, түүнчлэн төрийн яамдуудад дотоодын аудитын албадыг байгуулах талаар арга хэмжээ авах хэрэгтэй байна.

²⁷ХЗЯ-аас уг ажлыг санаачлан эхлүүлсэн бөгөөд тодорхой ажлуудыг гүйцэтгэж байна.

Хоёр. Олон улсын хамтын ажиллагаа

2.1. Гэмт хэрэгтэнг шилжүүлэх

Авлигын эсрэг НҮБ-ын конвенцийн сонгон хэрэглэх заалтуудтай холбоотойгоор Монгол Улс дотоодын хууль тогтоомжоо боловсронгуй болгохын тулд дараахь арга хэмжээг авах нь зүйтэй.

1) Хэрэгтэн шилжүүлэх үйл ажиллагааг хурдавчлах, нотлох баримттай холбоотой ажиллагааг хялбаршуулах арга хэмжээг хэрэгжүүлэх.

2) Тухайн этгээдийг хүйс, үндэс угсаа, шашин шүтлэг, арьсны өнгө, улс төрийн итгэл үнэмшил болон үүнтэй холбоотой бусад шалтгаанаар яллах зорилгоор шилжүүлэн авах хүсэлт гаргасан гэж үзэх хангалттай үндэслэл байгаа тохиолдолд хүсэлтийг хүлээн авахаас татгалзах.

2.2. Ял шийтгүүлсэн этгээдийг шилжүүлэх тухай

Авлигын эсрэг НҮБ-ын конвенцийн сонгон хэрэглэх заалттай холбогдуулан Монгол Улс дотоодын хууль тогтоомжоо боловсронгуй болгох талаар дараахь арга хэмжээ авах нь зүйтэй.

1) Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааг шилжүүлэх боломж, түүнийг зохицуулах бодлого, хууль тогтоомжийг батлах

2.3. Эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх

Монгол Улс дараахь зорилгоор холбогдох арга хэмжээ авах нь зүйтэй гэж зөвлөж байна.

1) Хүсэлтэд хэргийн мөрдөн байцаах, яллах, шүүн таслах ажиллагааны нөхцөл байдал, мөн чанар болон асуудлыг хариуцаж буй эрх бүхий байгууллагын нэр, чиг үүргийн талаар тодорхой тусгасан байх.

2) Мэдээллээр хангах, нотлох баримт, шинжээчийн дүгнэлт, хэрэгт холбогдох бичиг баримт, тэмдэглэл хүргүүлэх, гэмт хэргийн замаар олсон ашиг орлогыг илрүүлэн тогтоох, гэмт хэргийн замаар олсон ашиг орлогыг нь битүүмжлэх, алдагдсан эд хөрөнгийг эргүүлэн олж авах зэрэг эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх боломжийг баталгаажуулах.

3) ЭрхзүйнхарилцантуслалцааньМонголУлсынхууль,мөрдөнбайцаах. шүүн таслах ажиллагааны зарчимд нийцсэн байхыг баталгаажуулах

4) Эрх зүйн туслалцаа үзүүлэх хүсэлтийг хүлээн авахаас татгалзах буюу түүнийг биелүүлэх ажиллагааг хойшлуулах тухай шийдвэр гаргахаас өмнө хүсэлт гаргагч талтай албан ёсоор урьдчилан зөвлөлдөх.

5) Эрх зүйн харилцан туслалцааны хүсэлт гаргагч талын хүсэлтийн дагуу нотлох баримтыг гаргаж өгөхөөр зөвшөөрсөн гэрч, шинжээч болон бусад хүмүүсийг хүсэлт гаргагч улсын нутаг дэвсгэр дээр мөрдөн шалгагдах, яллагдах, байцаан шийтгэх ажиллагаанд татагдан оролцох зэргээс хамгаалсан баталгааг бий болгох.

6) Хүлээн авсан мэдээллийн нууцыг хамгаалах, эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэхэд Монгол Улсын Банкны тухай хууль дахь банкны нууцлалын тухай заалт нь бэрхшээл учруулахгүй байх.

7) Нотлох баримт, мэдээллийг ямар зорилгоор хайж байгаагаа мэдээлэх тухай тусгай журмын заалтыг хэрэгжүүлэн, нотлох баримтыг зөвхөн тухайн зорилгоор хэрэглэх.

8) Авлигын эсрэг НҮБ-ын конвенцийн 46.14-д заасны дагуу Монгол Улсад ямар хэлийг албан ёсны хэлээр хүлээн зөвшөөрөх тухайгаа НҮБ-ын ЕНБД-д мэдэгдэх ёстой.

9) Авлигын эсрэг НҮБ-ын конвенцийг эрх зүйн харилцан туслалцааны хууль зүйн үндэслэл болгон хэрэглэх, энэ тухайгаа НҮБ-ын ЕНБД-д мэдэгдэх.

10) Авлигын эсрэг НҮБ-ын конвенцын 46.10-д заасны дагуу мэдүүлэг өгөх, эсвэл таньж олуулах ажиллагаанд оролцох болон нотлох баримт цуглуулахад туслалцаа үзүүлэх зорилгоор тодорхой этгээдийг Монгол Улсаас гадаад руу, эсвэл гадаадаас Монгол Улс руу шилжүүлэх боломжийг хангасан эрх зүйн тогтолцоо бий болгох.

11) Мэдүүлэг өгөх этгээд өөрийн биеээр ирэх боломжгүй, эсвэл татгалзаж байгаа тохиолдолд видео /дүрс бичлэгийн/ ярилцлагын хэлбэрээр мэдүүлэг өгөхийг зөвшөөрөх.

12) Олон нийтэд нээлттэй бус мэдээлэл, бичиг баримт, тайлангийн хуулбарыг хүсэлт гаргагч талд шилжүүлэн өгөх эрхийг мөрдөн байцаагч, прокурор, шүүгчдэд олгосон хуулийн тодорхой заалтыг боловсруулж батлах хэрэгтэй.

13) Эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх хүсэлтийг биелүүлэх цаг хугацааны хязгаарыг тогтоосон практикийн бичиг баримтыг бий болгох.

2.4. Хууль сахиулах байгууллагын хамтын ажиллагаа

Монгол Улс дараахь зорилгоор зохих арга хэмжээ авах хэрэгтэй.

1) Авлигын эсрэг НҮБ-ын конвенцын 48 дугаар зүйлийн дагуу хууль сахиулах байгууллагын хамтын ажиллагааг өргөжүүлэх. Үүнд: Авлигын эсрэг НҮБ-ын конвенцид заасан гэмт хэргийг үйлдэхэд ашигласан арга, хэрэгсэлтэй холбоотой мэдээлэл солилцох гэх мэт.

2) Монгол Улсын болон гадаадын хууль сахиулах байгууллагуудыг шууд хамтран ажиллах боломжоор хангах.

2.5. Хамтарсан мөрдөн байцаалт ба мөрдөн байцаалтын тусгай арга

Авлигын эсрэг НҮБ-ын конвенцийн сонгон хэрэглэх заалтуудын хувьд Монгол Улс хууль тогтоомжоо боловсронгуй болгох зорилгоор дараахь арга хэмжээг авах хэрэгтэй.

1) Мөрдөн байцаалтын тусгай арга техник хэрэглэх тухай гэрээ, хэлэлцээр байгуулах, эсвэл гэрээ, хэлэлцээрүүдэд орох, олон улсын түвшинд уг ажиллагааг явуулахад тусгай ажиллагааны зардлыг хэн хариуцах талаар гэрээ хэлэлцээрт зааж өгсөн байх.

2) Ийм гэрээ, хэлэлцээр байгуулаагүй тохиолдолд зөвхөн тухайн хэрэгт холбогдуулан мөрдөн байцаалтын тусгай арга хэрэглэх тухай хэлэлцээр хийхийг зөвшөөрөх.

2.6. Сургалт, техникийн туслалцаа

Авлигын эсрэг НҮБ-ын конвенцийн талаар цаашид сургалт явуулах нь хууль сахиулах, шүүх байгууллагын ажилтнуудад чухал ач холбогдолтой. Эрх бүхий этгээд, жишээлбэл, Гадаад харилцааны яам нь олон улсын шинжээчидтэй харилцан зөвлөлдсөний үндсэн дээр зохих яам, агентлаг дээр сургалт зохион байгуулахад шаардагдах арга хэмжээг авах.

Авлигын эсрэг НҮБ-ын конвенцийг гэмт хэрэгтэн шилжүүлэхэд эрх зүйн үндэслэл болгон ашиглах тухай Засгийн газрын санаачлагаар зохион байгуулсан сургалт нь шилдэг туршлагын жишээ мөн. Уг конвенцийн монгол хэл дээрх албан ёсны орчуулга нь алдаа ихтэй байгаа учраас түүнийг ашиглахад хүндрэлтэй байгааг харгалзан үзэж Гадаад харилцааны яам нь монгол хэл рүү орчуулах шийдвэр гаргах, Хууль зүйн яам туслалцаа үзүүлэх хэрэгтэй.

Монгол Улс Авлигын эсрэг НҮБ-ын конвенцын III, IV бүлгүүдийн олон тооны заалтуудыг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн өргөн хэмжээний техникийн туслалцаа авах хүсэлт гаргасан. Хамгийн их давтагдаж байгаа техникийн хүсэлтийн төрөл нь эрх зүйн зөвлөгөө, шилдэг туршлагаас суралцах болон авлигын эсрэг мэргэшсэн шинжээчийг газар дээр нь урьж ирүүлэх зэрэг болно гэсэн байна.

1.3. НҮБ-ЫН АВЛИГЫН ЭСРЭГ КОНВЕНЦИД ҮНДЭСНИЙ ХУУЛЬ ТОГТООМЖИД НИЙЦҮҮЛЭХ НЬ

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх асуудалд төрөөс оновчтой зохицуулсан эрх зүйн зохицуулалт шаардлагатай бөгөөд Монгол Улсад авлигатай тэмцэх эрх зүйн эх сурвалж зохистой хангагдснаар бид авлигыг бууруулж чадна. Авлигын гэмт хэргийн олон улсын эх сурвалжид дээр өгүүлсэн олон улсын гэрээ болон бүс нутгийн бусад конвенциуд хамаарна.

Үндсэн гол эх сурвалж бол НҮБ-ын Авлигын эсрэг конвенци юм. Монгол Улс олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, зарчмыг баримталж энхийг эрхэмлэсэн гадаад бодлого явуулна гэж хуульчилсан төдийгүй олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ гэсэн байдаг.

Түүнчлэн Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчлэх тухай Үндсэн хуулиндаа заасан.

Иймд Монгол Улс нэгдэн орсон НҮБ-ын Авлигын эсрэг конвенцийг дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчлэх эрх зүйн боломжийг олгох төдийгүй тус конвенцийн заалтад үндэсний хууль тогтоомжийг нийцүүлэх хэрэгцээ шаардлага байсаар байна.

Монгол Улс 2006 онд тус конвенцид нэгдэн орсон ба конвенцийн үзэл баримтлалд нийцүүлсэн Авлигын эсрэг хуулийг батлан гаргаж, үүний дагуу АТГ-г бөгөөд авлигын эсрэг үндэсний гол эх сурвалжид Авлигын эсрэг хууль, Эрүүгийн хууль, Эрүүгийн байцаан шийтгэх хууль, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль зэрэг багтдаг.

Үндэсний хууль тогтоомжийг тус Конвенцид нийцүүлэхтэй холбоотойгоор манай улс сүүлийн жилүүдэд зарим зүйлүүдийг хийж байгаа нэг жишээ бол авлигыг илчлэхэд хувь нэмрээ оруулж, хууль сахиулах байгууллагатай хамтран ажилласан хүмүүсийг хамгаалах явдал юм.

Монгол Улс 2013.07.05-нд гэмт хэрэг хянан шийдвэрлэх явцад гэрч, хохирогчийн амь нас, эрүүл мэндийг хамгаалах, тэднийг мэдээллээр хангах, дэмжлэг, туслалцаа үзүүлэх эрх зүйн үндсийг тогтоох зорилт бүхий Гэрч хохирогчийг хамгаалах тухай хуулийг баталсан нь конвенцид заасан гэрч, шинжээч, хохирогч (32 дугаар зүйл), мэдээлэгч этгээдийг хамгаалах (33 дугаар зүйл) талаар шаардлагатай бүх талын арга хэмжээ, түүний дотор тухайн хүмүүсийг шилжүүлэн суурьшуулах, хувийн мэдээллийг нь нууцлах, биечилсэн хамгаалалтад авах, мэдүүлгийг дүрс бичлэг, холбооны хэрэгслээр дамжуулан авах зэрэг аргыг хэрэглэх ёстой заалтыг хангасан гэж үзэх боломжтой.

Мөн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 5 дахь хэсэгт цагдаагийн байгууллага мэдээллийн нууцыг чанд хадгалж, шаардлагатай бол мэдээлэгчийн аюулгүй байдлыг хангах арга хэмжээ авах үүрэгтэйг ерөнхий байдлаар, мөн Авлигын эсрэг хуульд “өөрийн үйл ажиллагаанд туслалцаа үзүүлсэн гэрч, бусад этгээдийг шаардлагатай тохиолдолд цагдаагийн байгууллагын хамгаалалтад авахуулах” тухай заасан байдаг. Авлигатай тэмцэх үйл хэрэгт олон нийтийн дэмжлэг туслалцаа авах явдал тэдний аюулгүй байдлын баталгааг төрөөс хангах асуудалтай салшгүй холбоотой нь ойлгомжтой юм.

Энэхүү Конвенцид анхаарал татсан бас нэг чухал асуудал бол авлигатай тэмцэх тусгай байгууллага юм. Авлигын эсрэг Конвенцид авлигатай тэмцэх талаар зарим байгууллага, бүтэцтэй байх үүргийг оролцогч улсуудад хүлээлгэсэн байна.

Үүнд авлигаас урьдчилан сэргийлэх байгууллага хууль сахиулах замаар авлигатай тэмцэх тусгай байгууллага, мөнгө угааж буй сэжиг бүхий мэдээллийг цуглуулах, шинжлэх, түгээх зорилго бүхий үндэсний төв болох санхүүгийн шуурхай мэдээллийн нэгжийг буй болгох шаардлыг заасан байдаг.

Манай улсын Авлигын эсрэг хуулийн IY бүлэгт Авлигатай тэмцэх байгууллага шинээр байгуулж түүнд авлигатай бүх хэлбэрээр тэмцэх чиг үүргийг хамааруулсан нь тус Конвенцийн шаардлагыг хангах, үндэсний хэмжээнд хэрэгжүүлэхэд чиглэгдсэн чухал арга хэмжээ боллоо.

Гэсэн хэдий ч Монгол Улс үндэсний хууль тогтоомжоо Авлигын эсрэг конвенцид нийцүүлэх үүднээс хэрэгжүүлэх шаардлагатай дараах асуудлууд байна.

1. Авлигын хүрээг тус Конвенцид манай дотоодын хууль тогтоомжоос өргөн авч үзжээ. Манай улсад авлигыг зөвхөн төрийн албан хаагчийн үйлдэлд хамааруулж хуульчилсан байдаг бол Конвенцид төрийн албанаас гадна хувийн хэвшил дэх авлигыг хамааруулж нийгмийн бүх хүрээг багтаасан байна.

Монгол Улсын Төрийн албаны тухай хуульд “Төрийн албан тушаалыг эрхэлж, бүрэн эрхээ хэрэгжүүлсний төлөө төрөөс цалин авч, ажиллах нөхцөл, баталгаагаар хангагдан ажиллаж байгаа этгээдийг төрийн албан хаагч гэнэ” (11.1) гэж тодорхойлсон.

Эрүүгийн хуульд хээл хахуулийн субъект нь зөвхөн удирдах албан тушаалтан байхаар хязгаарлагдмал хүрээнд хуульчилсан байдаг бол Авлигын эсрэг конвенцид “оролцогч улсын хууль тогтоох, гүйцэтгэх, захиргааны буюу шүүхийн байгууллагад байнга буюу сонгогдсон, цалинтай буюу цалингүй ажилладаг хүмүүс, төрийн байгууллага буюу улсын үйлдвэрийн газарт төрийн чиг үүрэг гүйцэтгэдэг, эсхүл төрийн үйлчилгээ үзүүлдэг хүмүүсийг албан тушаалаас нь үл хамааран” төрийн албан хаагч гэж үзэж авлигын субъектэд хамааруулснаас гадна тэдгээрийн тус бүрд нь дэлгэрэнгүй тайлбар хийсэн байна.

Энэ нь авлигын үйлдлийн төлөө хариуцлага хүлээх ёстой субъектүүдийн талаар эргэлзээгүй, нэг мөр ойлголттойгоор хууль тогтоомжийг дагаж мөрдөхөд ихээхэн чухал ач холбогдолтой. Одоогийн үйлчилж байгаа манай хууль тогтоомжид эдгээр субъектүүдийг хэт явцуу тусгасан нь авлигатай хийх тэмцэл нийтийг хамарч чадахгүй байхын нэг шалтгаан болж мэдэх юм.

Харин УИХ-д өргөн баригдсан Гэмт хэргийн тухай хуулийн төсөлд төрийн албан тушаалтан гэсэн нэр томъёоноос татгалзан нийтийн албан тушаалтан, гадаад улсын төрийн албан тушаалтан, ОУБ-ын албан тушаалтан түүнчлэн хууль, тогтоомж, дүрэм, журам, заавар, гэрээгээр үүрэг хүлээсэн хүн зэрэг авлигын гэмт хэргийн субъектын хүрээг өргөжүүлсэн байна.²⁸

2. Авлигын гэмт хэрэг үйлдснийх нь төлөө хуулийн этгээд хариуцлага хүлээх явдлыг оролцогч улс хангах ёстой гэдгийг тус Конвенцид зааж, тэрхүү хариуцлага нь эрүүгийн, иргэний, захиргааны аль ч хэлбэрээр байж болохыг тодотгожээ.

Хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх тухай НҮБ-ын үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг конвенц, авлигын эсрэг НҮБ-ын конвенц, гадаадын төрийн албан тушаалтны хээл хахуультай тэмцэх эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын конвенц, авлигын талаарх европын консулын Эрүүгийн хуулийн конвенц, гэмт хэргээс үүдсэн мөнгө угаах, нэгжлэг хийх, эд хөрөнгө хураах, улсын орлого болгох болон терроризмыг санхүүжүүлэх европын КОНСУЛЫН КОНВЕНЦ зэрэг олон улсын эх сурвалжид заасан байна.

²⁸ Гэмт хэргийн тухай хуулийн төслийн 22.1-22.13-г үзнэ үү.

Энэ бол авлигатай тэмцэх хүрээ зөвхөн хүмүүсээр хязгаарлагдахгүй, хуулийн этгээдэд ч ийнхүү нэгэн адил хамруулж байгаа нь нийгэмд авлигын хариуцлагаас ангид орших нэг ч субъект байх учиргүй гэдгийг нотлон харуулж байна. Хуулийн этгээдэд гэмт үйлдлийн төлөө эрүүгийн хариуцлага хүлээлгэх тухай өнөөг хүртэл манай хууль тогтоомжид тусгагдаагүй байгаа. Гэмт хэргийн тухай хуулийн төсөлд хуулийн этгээдийг эрүүгийн хариуцлагад татаж ял оногдуулах заалтыг оруулж ирэхээр тусгасан нь сайшаалтай.

3. Авлигын үйлдэлд хамаарах хээл хахууль авах, өгөх гэмт хэргийг үндэсний төрийн албан хаагчийг хахуульдах (15 дугаар зүйл), гадаадын төрийн албан хаагч болон олон улсын байгууллагын албан хаагчийг хахуульдах (16 дугаар зүйл), хувийн хэвшлийн аж ахуйн нэгжийн ажилтныг хахуульдах (21 дүгээр зүйл) хэмээн тус Конвенцид ангилан заасан байна.

Мөн ямар нэгэн үйлдэл хийсэн, эсхүл хийгээгүйн төлөө шууд болон шууд бусаар ашиг хонжоо, давуу байдал олгохыг санал болгох, амлах, өгөх, ямар нэгэн үйлдэл хийсний, эсхүл хийгээгүйн төлөө хууль бус ашиг хонжоо, давуу байдал олгохыг шууд болон шууд бусаар гүйх буюу хүлээн авах үйлдлүүд авлигад хамаарна гэдгийг тодорхойлжээ. Үүнийг Эрүүгийн хууль зэрэг үндэсний хууль тогтоомжтой харьцуулбал өргөн хүрээний үйлдлийг хамарсан байна. Тухайлбал, манай улсын Эрүүгийн хуульд хээл хахуулийн гэмт хэргийн бүрэлдэхүүн хээл хахуулийг өгсөн, авсанаар төгсөхөөр заасан нь энэхүү Конвенцийн тодорхойлолтод тусгагдсан шаардлагыг хангахгүй байгаа юм. Мөн хээл хахуулийн гэмт хэргээс гадна төрийн албан хаагч: эд хөрөнгө завших, урвуугаар ашиглах, зохион байгуулалттай болон бусад аргаар ашиглах (17 дугаар зүйл), нөлөөлөх (18 дугаар зүйл), хууль бусаар хөрөнгөжих (20 дугаар зүйл), гэмт хэргээс олсон мөнгийг угаах (23 дугаар зүйл), хууль бус хөрөнгийг нуун дарагдуулах (24 дүгээр зүйл), авлигын хэргийг шүүн таслах ажиллагаанд саад учруулах (25 дугаар зүйл) зэрэг үйлдлийг авлигын хүрээнд хамаарах гэмт хэрэгт тооцож, хэрэг тус бүрийг тодорхойлсон нь энэ талаарх үндэсний хууль тогтоомжтай харьцуулахад илүү тодорхой, хамрах цар хүрээний хувьд ч илүү байгаа юм.

Иймд конвенци ба эрүүгийн хууль тогтоомжийн харьцуулсан судалгааг нямбай хийж нийцүүлэхэд чиглэгдсэн арга хэмжээ авах шаардлагатай юм.

Ялангуяа хууль бусаар хөрөнгөжих гэсэн зүйлд төрийн албан хаагч хөрөнгөө их хэмжээгээр нэмэгдсэнийг түүний хууль ёсны орлого гэдгийг үндэслэлтэйгээр тайлбарлаж чадаагүйг хууль бусаар хөрөнгөжсөн гэмт хэрэгт тооцох болсон.

4. Авлигатай тэмцэхэд нийгмийн оролцоог хангах үүднээс хувь хүн, иргэний нийгэм, төрийн бус байгууллага зэрэг төрийн бус оролцоог хөхиүлэн дэмжих, олон нийтийн дунд сурталчилгаа явуулах, дунд болон их дээд сургууль зэрэг боловсролын байгууллагын хөтөлбөрт тусган хэрэгжүүлэх, авлигатай холбоотой мэдээллийг эрэн сурвалжлах, хүлээн авах, нийтлэх, тараан дэлгэрүүлэх эрх чөлөөг хүндэтгэх, хөхиүлэн дэмжих, хамгаалахад уг конвенци ихээхэн ач холбогдол өгчээ.

Үүнд эдгээр ажиллагааг явуулах боломж олгоод зогсохгүй, тэдгээрийг хөхиүлэн дэмжих арга хэмжээг зориуд авч, шаардлагатай бол энэ үйл хэрэгт зориглон оролцсон олон нийтийн төлөөллийг хамгаалах шаардлага тавигдаж байна.

2002 онд баталсан Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрт авлигатай тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх ажиллагаанд нийгмийн оролцоог нэмэгдүүлэх, ялангуяа иргэд, олон нийт, хэвлэл мэдээллийн хэрэгслийн үүргийг хүчтэй болгох хөшүүрэг, механизмыг буй болгох талаар тусгасан байх ба чухамхүү тэр хөшүүрэг, механизм нь дээр дурьдсан “хөхиүлэн дэмжих, хамгаалах” явдал гэдгийг анхааралдаа авч, арга замуудыг нь тодорхой болгож, үүнд чиглэгдсэн бодитой алхам хийх хэрэгтэй байна.

Бүх шатны боловсролын байгууллагын сургалтын хөтөлбөрт авлигатай тэмцэх арга зүйн талаар тусгах асуудлыг тухайн салбарын хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх шаардлагатай болж байна.

1.4. АВЛИГАТАЙ ТЭМЦЭЖ БУЙ ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ТУРШЛАГААС

Дэлхийн банкны судалгаагаар авлигын улмаас учирсан хохирол жил бүр 1.0 триллион америк доллараар хэмжигддэг бөгөөд аль ч оронд зайлшгүй зохицуулалт хийх шаардлагатай нийгмийн сөрөг үзэгдэлд тооцогдож байна.

Улс үндэстэн болгон харилцан адилгүй шалтгаан, арга хандлагаар авлигын эсрэг тэмцэж ирсэн хэдий ч хүн төрөлхтний нийтээр “ардчилал” ба “даяаршил” гэсэн үндсэн хоёр хүчин зүйлсийн нөлөөгөөр авлигын эсрэг эрчимтэй тэмцэлд оржээ гэж Америкийн криминологич Крис Эскридж үзжээ.²⁹

Ардчиллын хэв загварууд улс орон бүрт адилгүй ч ардчиллын нийтлэг үнэт зүйлс нь эрх зүйт ёс тогтсон байх, эрх чөлөө хангагдсан, ард иргэдийн төрийг удирдах үйл хэрэгт оролцох оролцоо, ил тод байдал өндөр байх явдал бөгөөд эдгээр үнэт зүйлс нь нийгэмд авлига, хээл хахууль оршин тогтнох үндсийг үгүй хийдэг.

Гэхдээ орчин үеийн ардчилсан нийгэмд авлига бат суурьтайгаар оршсоор байгааг АНУ-д дуулиан тарьсан Енроны хэрэг, түүнчлэн Бернард Мэрдоффын пирамид тогтолцооны хэрэг зэрэг авлигын гэмт хэргээс харж болно. Түүнчлэн сүүлийн хэдэн жилд дэлхий дахиныг хамарсан эдийн засгийн эрчимтэй өсөлт өрнөсөн ч глобалчлал улс орнуудад авлигын өргөн сүлжээг нээж өглөө. Олон улсын эдийн засгийн харилцаанд чөлөөтэй оролцохын тулд хөгжиж байгаа орнууд гадны хөрөнгө оруулалтыг татах шаардлага байнга тулгардаг.

Үүний тулд нийтэд чиглэсэн төрийн захирамж, шийдвэрүүд нь зохистой, ил тод байх ёстой. Хэрвээ авлига, хээл хахууль байхгүй бол ямар ч бизнес хэвийн явагдах учиртай боловч авлига үгээр хэлэмгүй өндөр зардал чирэгдэл гаргаж, олон улсын худалдаа, глобалчлалын эдийн засаг дахь эерэг талыг харлуулах чадалтай байдаг.

Гадаадын зарим орны авлигын талаарх хууль тогтоомжийн болон түүнтэй тэмцэж буй арга хандлагын харьцуулахдаа авлигатай тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлд амжилт олж байгаа болон зарим шинэлэг туршлагыг нэвтрүүлж буй улсуудыг сонгосон.

²⁹ Крис Эскридж, 21 дүгээр зууны авлигын гэмт хэрэг өгүүлэлээс, 2012 он.

Тухайлбал, Транспаренси интернэшнл ОУБ-с жил бүр хийдэг Авлигын төсөөллийн индексийг (Corruption Perception Index) харгалзан Сингапур, Эстони, Япон, ХБНГУ зэрэг улс мөн авлига өндөр Украин улсыг авч үзлээ. Сэдвийн энэ хэсэгт *улс орнуудын авлигын үзүүлэлт, авлигын эсрэг хууль тогтоомж, авлигатай тэмцэх байгууллага, авлигын эсрэг хэрэгжүүлж байгаа стратеги, бодлого* гэсэн үндсэн асуудлуудыг хамарсан.

Гадаадын орнуудад авлигатай тэмцэх чиг үүрэг бүхий байгууллагаар дамжуулан төрийн бодлогоо хэрэгжүүлдэг.

НҮБ-ын Авлигын эсрэг Конвенцид авлигын эсрэг дараах хоёр төрлийн байгууллага байхаар зохицуулсан. Үүнд:

1. Авлигаас урьдчилан сэргийлэх нэг буюу хэд хэдэн байгууллага;
2. Хууль сахиулах байдлаар авлигатай тэмцэх дагнасан нэг буюу хэд хэдэн байгууллага

Эдгээр байгууллага нь дараах нийтлэг чиг үүрэгтэй байдаг. Үүнд:

- **бодлого боловсруулах, судалгаа хийх, хянах, зохицуулан холбох чиг үүрэг** – авлигын чиг хандлага, түвшин, авлигын эсрэг арга хэмжээний үр нөлөөг үнэлэх чиглэлээр судалгаа хийх, улмаар авлигын эсрэг стратеги, үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх арга хэмжээнд мониторинг хийж, хамтран ажиллах; олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлэх;
- **авлигаас урьдчилан сэргийлэх чиг үүрэг**- олон нийтийн байгууллагын ёс зүйг сайжруулах, нийтийн албаны дүрэм журам, хориг хязгаарлалтын талаар тодорхой арга хэмжээ боловсруулах, хэрэгжүүлэх, тэр дундаа ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, нийтийн албан тушаалтан хөрөнгө орлогын мэдүүлгээ зарлах, үнэн бодитой болохыг нь нотлох, олон нийтэд нээлттэй болгох;
- **соён гэгээрүүлэх, ухамсрын түвшинг дээшлүүлэх чиг үүрэг**- олон нийт, эрдэм шинжилгээний байгууллага, төрийн албан хаагчдад зориулан боловсролын хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэх; олон нийтийн ухамсрыг дээшлүүлэх компанид ажил зохион байгуулах; өргөн хүрээнд хэвлэл мэдээллийн байгууллага, ТББ, бизнесийн хүрээнийхэн, олон нийттэй хамтран ажиллах.

Харьцуулан үзвэл одоогоор дэлхий дээр авлигын чиглэлээр дагнасан байгууллагын 3 ялгаатай загвар байна. Тэдгээр нь:

- Хууль сахиулах эрх мэдэлтэй, урьдчилан сэргийлэх чиг үүрэг бүхий нэгдсэн, хамтын зорилго бүхий байгууллага;
- Хууль сахиулах агентлаг, хэлтэс, нэгж;
- Урьдчилан сэргийлэх, бодлого боловсруулах, зохицуулан холбох (кординаци хийх) байгууллага³⁰ юм.

³⁰ OECD, Specialised Anti-Corruption Institutions, Review of Models: Anti-Corruption Network for Eastern Europe and Central Asia, 2008, p.11

Эхнийх нь урьдчилан сэргийлэх талаар бодлого боловсруулах, дүн шинжилгээ хийх, техникийн туслалцаа үзүүлэх болон олон нийтэд зориулан үйл ажиллагаа, арга хэмжээ зохион байгуулах (мэдээлэл түгээх гэх мэтээр), хяналт тавих, мөрдөн байцаалт явуулах зэрэг авлигыг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх асуудлаар голлон ажилладаг бие даасан байгууллагын загвар юм.

Үндсэндээ энэ загварыг төлөөлж чадах 2 байгууллага байдаг нь *Сингапур улсын Авлигын хэргийг Мөрдөх Алба (Corrupt Practices Investigation Bureau)*, *Хонгконгын Авлигын эсрэг Хараат бус комисс (Independent Commission against Corruption)* юм.

Мөн энэ загварт Литвийн Мөрдөн байцаах Тусгай алба, Латвийн Авлигаас урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх товчоо, Австралийн Авлигын эсрэг хараат бус комисс, Ботсваны Авлига болон эдийн засгийн гэмт хэргийн асуудал хариуцсан захиргаа, Угандагийн Засгийн газрын ерөнхий мөрдөн байцаагч зэрэг байгууллага багтдаг. Өмнөд Солонгос, Тайланд, Аргентин, Эквадорт эдгээртэй ижил төстэй байгууллага байдаг.

Хоёрдох нь авлигыг илрүүлэх, мөрдөн байцаах, яллах чиг үүрэг нэг байгууллагад төвлөрсөн энэ хандлага нь баруун Европод түгээмэл байдаг.

Тухайлбал, Норвегийн Эдийн засгийн болон хүрээлэн буй орчны гэмт хэргийг Мөрдөн шалгах, ял оногдуулах үндэсний байгууллага, Испанийн Авлигатай холбоотой эдийн засгийн гэмт хэрэгтэй тэмцэх тусгай прокурорын газар, Хорватын Авлига болон зохион байгуулалттай гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, тэмцэх газар, Бельгийн Авлигатай тэмцэх төв газар, Румыний Авлигын эсрэг үндэсний захиргаа, Унгарын Прокурорын Мөрдөн байцаах төв газар зэрэг болно.

Мөн энэ загвар нь хууль сахиулах байгууллагын харъяанд авлигыг илрүүлэх, мөрдөн шалгах нарийвчилсан харъяалал бүхий дотоодын мөрдөн байцаах байгууллагуудад хэрэглэгдэх боломжтой. Үүний тод жишээ нь ХБНГУ-ын Дотоодын мөрдөн байцаах газар юм.

Гуравдахь нь авлигаас урьдчилан сэргийлэх нэг буюу хэд хэдэн чиг үүрэгтэй байгууллага. Энэ хүрээнд авлигын эрсдэл, боломжит шийдвэрлэх арга замын талаар судалгаа, дүн шинжилгээ хийх, бодлого боловсруулах, зохицуулан холбох, сургалт зохион байгуулах, зөвлөгөө өгөх үйл ажиллагаа явуулдаг.

Ийм төрлийн байгууллагууд нь ихэнх тохиолдолд хууль сахиулах эрх мэдэлгүй байдаг. Гэхдээ төрийн албан хаагчдын хөрөнгө орлогын мэдүүлгийг хянадаг байгууллагууд нууц мэдээллийг ашиглах нэвтрэх эрхтэй.

Францад Авлигаас урьдчилан сэргийлэх төв алба, Албанид Авлигын эсрэг Мониторингийн бүлэг, Малтад Авлигын эсрэг байнгын комисс, Серб, Монтенегрод Авлигын эсрэг агентлаг, АНУ-д Засгийн газрын ёс зүйн газар, Энэтхэгт Сонор сэрэмжийн төв комисс, Филиппинд Омбудсманы газар, Болгарт Авлигатай тэмцэх үйл ажиллагааг зохицуулан холбох комисс байдаг.

Авлигын эсрэг байгууллагад тавигдах нэг чухал стандарт нь урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, мөрдөн байцаах гэсэн 3 чиг үүргийг адил тэнцүү хэрэгжүүлэх явдал байдаг.

Гэхдээ практикт харилцан адилгүй бөгөөд эдгээр чиг үүргийг бүхэлд нь хэрэгжүүлдэг Латвийн Авлигаас урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх товчоо, Литвийн Мөрдөн байцаах тусгай алба, Польшийн Авлигын эсрэг төв алба байхад мөрдөн байцаах, урьдчилан сэргийлэх гэсэн 2 чиг үүрэг хэрэгжүүлдэг Австрийн Холбооны Дотоод хэргийн товчоо, нэг чиг үүргийг хэрэгжүүлдэг Германы Дотоодын мөрдөн байцаалтын газар, Францын Авлигын эсрэг төв бригад, Словенийн Авлигаас урьдчилан сэргийлэх комисс байна³¹.

Сингапур

Сингапур улс нь 2012 оны Авлигын төсөөллийн индекс (цаашид “АТИ” гэх)-д V байр эзэлсэнээрээ³² Ази тивд авлигын зөрчлийн хамгийн бага үзүүлэлттэй оронд тооцогдож байна. НҮБ-ын Авлигын эсрэг конвенци болон Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг конвенцийг соёрхон баталсан.

Азийн хөгжлийн банк, Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын Ази Номхон далайн бүс нутгийн сүлжээний гишүүн орон³³ ба авлига нь Сингапурыг Британийн колони байх үед хурцаар тавигдаж 1871 онд Эрүүгийн хуулиар анх гэмт хэрэгт тооцох болсон байна³⁴.

Тус улсад авлигыг гэмт хэрэг, зөрчилд тооцсон 2 гол хууль байдаг нь Авлигаас урьдчилан сэргийлэх тухай хууль (1993) болон Гэмт хэргийн тухай хууль (2003) бөгөөд Авлигаас урьдчилан сэргийлэх тухай хуульд тодорхойлсоноор “авлига” гэдэгт идэвхтэй болон идэвхгүй (өгөх, амлах, санал болгох) хэлбэрийг тооцохоор заасан байна. Үүнд:

а) Мөнгө, аливаа бэлэг сэлт, зээл, хураамж, шагнал, шимтгэл / commission/, үнэт цаас болон хөдлөх, үл хөдлөх бусад эд хөрөнгийн эрх;

б) Албан газар, хөдөлмөр эрхлэлт, гэрээ;

с) аливаа зээл, үүрэг, өрийг бүхэлд нь болон хэсэгчлэн барагдуулах, чөлөөлөх, хөнгөлөх, хэрэгсэхгүй болгох;

д) үүссэн буюу үүсээгүй сахилгын, эрүүгийн процесс, хүлээх хариуцлага, төлбөрийн чадваргүй байдлаас хамгаалах, аливаа эрх, албаны эрх, үүргээ гүйцэтгэх буюу гүйцэтгэхээс татгалзахад чиглэсэн бусад үйлчилгээ, дэмжлэг тусалцаа, давуу байдал;

е) эдгээрийн хүрээнд авлига өгөхөөр амлах, үүрэг хүлээх, санал болгох³⁵.

Түүнчлэн хувийн салбарт 100,000 доллараар торгох, 5 жил хүртэл хугацаагаар хорих; нийтийн салбарт 100,000 хүртэл доллараар торгох

³¹ European Partners against Corruption, Anti-Corruption Working Group, Common standards and Best Practice for Anti-Corruption agencies, 2008, p.10

³² <http://www.transparency.org/cpi2012/results>

³³ Norton Rose Group, Anti-corruption Laws in Asia Pacific, 2011, p.59

³⁴ Jon S.T.Quah, Anti-Corruption agencies in four Asian countries: A comparative analysis, 2007, p.75

³⁵ Сингапур улсын Авлигаас урьдчилан сэргийлэх тухай хууль, 1-р хэсэг, 2-р зүйл

буюу 7 жил хүртэл хугацаагаар хорино. Авлига өгсөн, авсан аль алиныг гэмт хэрэгт тооцох ба ижил ял шийтгэлтэй байдаг байна. Хорих, торгохоос гадна авсан, өгсөн авлигаа бүрэн хэмжээгээр төлөхийг шүүхээс үүрэг болгодог бөгөөд авлигын замаар олж авсан эд хөрөнгийн хураан авна.

Гэмт хэргийн субъект нь хувь хүн болон хуулийн этгээд байдаг. Одоогийн байдлаар мэдээлэгчийг хамгаалах хууль батлаагүй ч Авлигаас урьдчилан сэргийлэх тухай хуульдаа мэдээлэгчийн нэрийг нууцлах талаар заасан³⁶.

Гэхдээ дараах нөхцөлд нэрээ нууцлах эрх үйлчлэхгүй. Үүнд:

1. Мэдээлэгчийг ил гаргахгүйгээр шударга ёс хэрэгжихгүй гэж үзвэл;
2. Мэдүүлэгч өөрөө мэдүүлгийнхээ үнэн, худал эсэхэд эргэлзэж байвал.

Өөрийн мэдээлсэн хууль бус үйл ажиллагаанд оролцсон мэдээлэгчийг хамгаалах, оногдуулах ялыг хөнгөрүүлэх талаар тодорхой зохицуулалт байхгүй. Ийм тохиолдолд мэдээлэгчид арай хөнгөн ял оногдуулах эсхүл торгох эсэх нь шүүхийн үзэмжийн асуудал байдаг нь мэдээлэгчийн сэдэлтээс тодорхой хэмжээгээр хамааралтай.

Авлигын хэргийг Мөрдөн Шалгах Алба (Corruption Practices Investigation Bureau)

Эрх зүйн үндсийг Авлигаас урьдчилан сэргийлэх тухай хуулийн 241-р бүлэгт заасан. Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээнд үйл ажиллагаа явуулах ба Ерөнхий сайдад үйл ажиллагаагаа шууд тайлагнана.

Даргыг Засгийн газар эсхүл Засгийн газрын нийтлэг эрх мэдлийн хүрээнд үйл ажиллагаа явуулдаг Сайдын санал болгосны үндсэн дээр улсын Ерөнхийлөгч томилно. Дэд даргыг мөн Ерөнхийлөгч томилох ба дарга, бусад удирдах албан тушаалтан, тусгай мөрдөн байцаагч нь нийтийн албан тушаалтанд тооцогдоно.

Хувийн болон нийтийн секторт авлигаас урьдчилан сэргийлэх, мөрдөн шалгах, баривчлах эрх хэмжээтэй. Шийтгэл оноох эрх хэмжээгүй, мөрдөн байцаалт явуулсаны дараа прокурорт хэргийг шилжүүлнэ. Үндсэн гурван чиг үүрэгтэй. Үүнд:

- а) нийтийн болон хувийн сектор дахь авлигын хэргийн талаарх гомдлыг хүлээн авч, мөрдөн шалгах;
- б) нийтийн албан тушаалтнуудын авлигын шинжтэй албан тушаалын болон хууль зөрчсөн гэмт хэргийг мөрдөн шалгах;
- с) авлигыг бууруулахын тулд нийтийн албан дахь практик, процедурыг шалгах замаар авлигаас урьдчилан сэргийлэх.

Мөрдөх Албаны дарга болон дэд даргыг Засгийн газар аль эсхүл Засгийн газрын нийтлэг эрх мэдлийн хүрээнд үйл ажиллагаа явуулж байгаа Сайдын санал болгосны үндсэн дээр Ерөнхийлөгч томилно³⁷. Үйл ажиллагаагаа Ерөнхий сайдад тайлагнадаг, мөрдөх албаны дарга болон бусад албан

³⁶ Ажил олгогчийнхоо хууль бус үйлдлийг илчилсэн ажилтныг хамгаалах

³⁷ Авлигаас урьдчилан сэргийлэх тухай хууль (The Prevention of Corruption Act, 1960), 3. 2 дахь хэсэг

тушаалтан нийтийн албан тушаалтанд тооцогдоно³⁸.

Харьцангуй цомхон бүтэцтэй буюу 80 орчим ажилтантай, зохион байгуулалтын бүтцийн хувьд 3 хэлтэстэй. Үүнд:

- А. Үйл ажиллагаа хариуцсан хэлтэс;
- В. Дотоод асуудал хариуцсан хэлтэс;
- С. Мөрдөн байцаах хэлтэс.

Мөрдөн байцаах хэлтэс нь тус Мөрдөх албаны гол чиг үүргийг гүйцэтгэдэг. Нийтийн болон хувийн сектор дахь авлигын хэргээр дагнасан дотоод 2 нэгжтэй. Хэрэгт бүрэн мөрдөн байцаалт явуулсан тухай илтгэлийг холбогдох нотлох баримтын хамтаар прокурорт шилжүүлнэ. Авлигаас урьдчилан сэргийлэх тухай хуулийн дагуу прокурорын бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр яллах үйл ажиллагаа явагдахгүй.

Сингапур улсын Авлигын эсрэг стратеги 4 тулгуур баганад суурилдаг. Үүнд:

- А. Үр дүнтэй Авлигын эсрэг хууль тогтоомж;
- В. Үр дүнтэй Хууль сахиулах ажиллагаа (Бие даасан Авлигын эсрэг байгууллага, Авлигын хэргийг Мөрдөн шалгах Алба);
- С. Үр дүнтэй шүүн таслах ажиллагаа (Хараат бус шүүх);
- Д. Үр дүнтэй удирдлага (Хариуцлагатай Нийтийн алба)³⁹.

А. Сингапурт Авлигатай тэмцэх чиглэлд 2 гол хууль байна. Эхнийх нь Авлигаас урьдчилан сэргийлэх тухай хууль (авлигын үндсэн зөрчил болон хууль сахиулах байгууллага (Авлигын хэргийг Мөрдөн шалгах Алба)-ын эрх хэмжээг заасан, хоёрдахь нь Авлига, Мансууруулах бодисын худалдаалах болон бусад онц ноцтой гэмт хэргийн тухай хууль (гэмт хэргийн замаар олсон орлогыг хураан авах) юм.

Авлигаас урьдчилан сэргийлэх тухай хууль нь дараах онцлог зохицуулалттай. Үүнд:

- Авлигын хэргийг Мөрдөн шалгах албанд нийтийн болон хувийн сектор дахь авлигыг мөрдөн шалгах (авлига өгсөн, авсан) эрх олгосон;
- Презумци бүхий заалт агуулсан. Нийтийн албан тушаалтан авлига авсан эсэхийг тогтоох үед презумцийн асуудал гарч ирдэг. Энэ нь шүүхэд авлигын хэрэгт буруутгагдан дуудагдаж байгаа этгээд авлига аваагүй гэдгээ тайлбарлах үүрэгтэй гэсэн утга илэрхийлдэг. Хэрвээ хангалттай тайлбарлаж чадахгүй бол авлига авсан гэж үзнэ. Гэхдээ тухай этгээдэд шийтгэл оноох нь презумциас шууд хамаарахгүй ч хэргийг байдлыг бүрэн нотлоход нэмэлт нөхцөл болох боломжтой;
- Авлига авсан этгээд нь авлига өгсөн этгээдэд буцаан өгөх боломжгүй байсан ч гэм буруутайд тооцогдоно;
- Заншлын хэм хэмжээг хэрэглэхийг хориглосон. Жишээлбэл, Хятадын

³⁸Авлигаас урьдчилан сэргийлэх тухай хууль, 4-р зүйл

³⁹ OECD, Specialized Anti-corruption Institutions: Review of Models (Anti-Corruption Network for Eastern Europe and Central Asia), 2008, p.56

Шинэ жилээр улаан уут өгөх, авах. Хэн ч улаан уутаар нуун далдалсан авлигыг сайн санааны үүднээс өгч байгаа мөнгө, хууль бус зүйл огт биш гэж шүүхийн өмнө мэдүүлэх, өршөөл эрэх боломжгүй. Эхний үед Авлигын хэргийг Мөрдөн шалгах алба Хятадын шинэ жилээр завгүй ажилладаг байсан бол эдүгээ идэвхтэй арга хэмжээ авсны хүчинд авлига авсанаа өнгөлөн далдлах байдлаар баяр ёслолыг тохиолдуулан ашиглах оролдлого харьцангуй багассан байна.

- Торгох буюу хорих ял оногдуулахаас гадна авсан авлигаа бүрэн хэмжээгээр төлөхийг шүүхээс гэм буруутай этгээдэд даалгах шийдвэр гаргахыг зөвшөөрсөн. Хэрвээ 1 сая долларын авлига авсан этгээд яг тийм хэмжээний мөнгө буцаан өгнө, энэ нь гэмт этгээд авлигын замаар ямар ч ашиг хүртэх эрхгүй гэсэн зарчмыг илэрхийлдэг;
- Аливаа этгээд авлигын хэрэг үйлдсэн нь тогтоогдвол иргэний эрх зүйн өрийн журмаар гаргуулан авч болно. Тодорхой тохиолдлыг дурьдвал, Үндэстэн дамнасан корпорацийн удирдах албан тушаалтан бусадтай гэрээ байгуулсанахаа төлөө хахууль авсан хэрэгт буруутгагдаж 10 жилийн хорих ял, авсан авлигатайгаа тэнцэх 300,000 долларыг төлөх шийтгэл авсан. Ял оноосны дараагаар үндэстэн дамнасан корпораци Авлигаас урьдчилан сэргийлэх тухай хуулийн дагуу удирдах албан тушаалтнаас авлигад авсан мөнгийг гаргуулан авахаар иргэний нэхэмжлэл гаргасан байна. Удирдах албан тушаалтан авлига авсны төлөө *төрөөс нэгэнт ял оноосон, иймээс үндэстэн дамнасан корпорацийн нэхэмжилсэн мөнгийг төлөх ёсгүй, энэ нь нэг гэмт хэрэгт 2 удаа шийтгэж байгаа хэрэг* хэмээн үзэж давж заалдах шатны шүүхэд гомдол гаргажээ. Гэхдээ шүүх гомдлыг хэрэгсэхгүй болгосон бөгөөд шийдвэртээ *нэг хэрэгт давхар эрүүгийн хариуцлага хүлээж байгаа хэрэг биш, эрх зүй өөрөө үүнийг хүлээн зөвшөөрсөн юм* гэж тайлбарласан байна⁴⁰;
- Сингапур улсын иргэн тус улсын хилийн гадна авлигын хэрэг үйлдсэн бол ял шийтгэл оноох, ингэхдээ тухайн хэргийг Сингапурт үйлдсэний адилаар шийдвэрлэх боломжтой.

В. Авлигын хэргийг Мөрдөн шалгах алба нь тус улсад авлигын хэрэгт мөрдөн байцаалт явуулдаг цорын ганц байгууллага юм. Бусад хууль сахиулах байгууллага авлигын талаар мэдээлэл, өргөдөл, гомдол хүлээн авсан тохиолдолд Мөрдөн шалгах албанд шилжүүлнэ.

Үйл ажиллагааны хараат бус байдал нь Үндсэн хуулиар баталгаажсан ба энэ нь Ерөнхий сайд өөрийн харъяанд ажилладаг албан тушаалтан, сайд болон өөрийн эсрэг авлигын хэргийн мөрдөн байцаалт явуулахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авсан бол Ерөнхий сайдыг мөрдөн байцаахыг Мөрдөн шалгах албаны даргад Ерөнхийлөгч зөвшөөрөх байдлаар тодорхойлогдоно⁴¹.

С. Авлигын хэргийн шүүх хуралдааныг нээлттэй явуулдаг нь шүүх эрх мэдлийн ил тод байдлын нэг илэрхийлэл болдог бөгөөд шүүх хуралдааны процессыг мэдэх боломжийг олон нийтэд олгодог байна.

⁴⁰ Koh Teck Hin, National Anti-Corruption strategy: The Singapore Experience, 2011, p.97

⁴¹ Мөн тэнд

Шийдвэрийг баримтжуулах нь олон нийтийн хараа хяналтан дор явагддаг бөгөөд давж заалдах эрх нээлттэй.

D. Нийтийн салбар дахь урьдчилан сэргийлэх болон захиргааны арга хэмжээ- авлигатай хууль зүйн арга хэрэгслээр тэмцээд зогсохгүй Засгийн газраас захиргааны шинжтэй тодорхой арга хэмжээ авдаг.

Нийтийн албан тушаалтны зан үйлийг зохицуулахын тулд хатуу дүрэм, журам тогтоодог байна. Нийтийн албан тушаалтан нь албаны үүрэгтэй өндөр ёс зүйтэй хандаж дараах стандартыг мөрдөнө. Үүнд:

- Ажил хэргийн харилцаатай этгээдээс мөнгө зээлэхгүй байх;
- Төлөөгүй өр, төлбөр нь сарын цалингаас 3 дахин их байж болохгүй;
- Хувийн ашиг сонирхлын үүднээс албаны мэдээллийг ашиглахгүй байх;
- Анх албан тушаалд томилогдсон үеийн болон түүнээс хойших жил бүр хөрөнгө орлогын мэдүүлгээ зарлаж байх;
- Зөвшөөрөлгүйгээр бизнесийн үйл ажиллагаа эрхлэх, хагас цагаар ажиллахгүй байх.

Авлигатай тэмцэх хүрээнд хууль сахиулах, хууль тогтоомжийн, шүүхийн захиргааны арга хэмжээ авахад чиглэсэн стратеги 1959 онд Сингапур улсыг тусгаар тогтнолоо зарласнаас хойш нэг жилийн дараа батлагдсан.

Авлигатай тэмцэх чиглэлд Сингапур улс амжилт олж байгаа шалтгаан нь төвөгтэй захиргааны процедурыг оновчтой болгоход урт хугацаанд анхаарал хандуулах замаар авлигын болзошгүй эрсдэлийг бууруулах, хүнд суртлыг халахад чиглэсэн засгийн газрын бодлого юм.

Мөн авлига өгсөн, авсан гэм буруутай этгээдэд ижил хэмжээний шийтгэл оноодогтой холбоотой. Торгох, хорихоос үл хамааран авлигын хэрэг үйлдсэн этгээд шүүхийн шийдвэрээр авсан авлигаа бүрэн буцааж, авлигын замаар олж авсан эд хөрөнгийг хураан авдаг⁴². Шаардлагатай үед холбогдох нэмэлт, өөрчлөлтийг оруулж болох уян хатан эрх зүйн орчинтой.

Хонконг

2012 оны АТИ-т 14-р байрт орсон⁴³, БНХАУ-ын Засгийн газар НҮБ-ын Авлигын эсрэг конвенц болон Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн конвенцид нэгдэн орсон нь Хонконгод хэрэглэгдэнэ. Азийн Хөгжлийн банк, Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын Ази Номхон далайн орнуудын Авлигын эсрэг санаачлагийн гишүүн орон. Авлига нь мөн Сингапурын нэгэн адил Хонконгийг Британийн колони байх үеэс ноцтой асуудалд тооцож байсан бөгөөд Авлигаас урьдчилан сэргийлэх тухай хууль нь эрх зүйн гол эх сурвалж юм. Нийтийн болон хувийн салбар дахь авлигын асуудлыг зохицуулна. Хуулийн зохицуулалт нь нийтийн болон хувийн салбарыг хамарна.

⁴² UNDP, Institutional Arrangements to Combat Corruption: A Comparative Study, 2005, p.80

⁴³ <http://www.transparency.org/cpi2012/results>

Нийтийн салбарт дараах тохиолдолд авлигын гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцогдоно. Үүнд:

- Гүйцэтгэх эрх мэдлийн тэргүүн (Хонконгийн Тусгай захиргааны бүсийн захирагч)-ийн зөвшөөрөлгүйгээр албан хаагч аливаа “ашигт зүйл” авах буюу авахаар шахаж шаардах;
- Гүйцэтгэх эрх мэдлийн тэргүүний харъяанд ажилладаг нийтийн албан тушаалтанд албан үүргийнх нь хувьд хамаарах үйлдлийг хийлгэх, хийлгэхээс татгалзуулах зорилгоор Хонконгийн нутаг дэвсгэрт болон нутаг дэвсгэрийн гадна оршин суудаг этгээд хууль ёсны эрх, хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр “ашиг” санал болгох;
- Хонконгийн нутаг дэвсгэрт болон нутаг дэвсгэрийн гадна оршин суудаг гүйцэтгэх эрх мэдлийн тэргүүний харъяанд ажилладаг нийтийн албан тушаалтан өөрийн албан үүрэгт хамаарах үйлдлийг хийх, хийхээс татгалзах зорилгоор хууль ёсны эрх, хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр авлига авсан буюу авахаар шахаж шаардах.

Хувийн салбарт хууль ёсны эрхгүй буюу хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр⁴⁴ дараах үйлдлийг хийсэн тохиолдолд авлига гэж үзнэ. Үүнд:

- Итгэмжлэгчийн үйл ажиллагаа, бизнестэй холбоотой аливаа үйлдэл хийхээс татгалзуулах, гүйцэтгэх зорилгоор итгэмжлэгчийн зөвшөөрөлгүйгээр төлөөлөгчид “ашиг” санал болгох;
- Төлөөлөгч болохынхоо хувьд итгэмжлэгчийн үйл ажиллагаа, бизнестэй холбоотой аливаа үйлдэл хийхээс татгалзуулах, гүйцэтгэх зорилгоор “ашиг” авахаар шахаж шаардах, авах⁴⁵.

Ялын хэмжээ нь 100,000-1,000,000 Хонконг доллараар торгох, 10 жил хүртэл хугацаагаар хорих ял оногдуулах ба Авлигаас урьдчилан сэргийлэх тухай хуульд мэдээлэгчийн нэрийг нууцлах асуудлыг баталгаажуулсан байна. Гэхдээ дараах тохиолдолд нэрээ нууцлах эрх хэрэгжихгүй. Үүнд:

1. Шүүх мэдээлэгчийг ил болгохгүйгээр шударга ёс хэрэгжихгүй гэж үзсэн;
 2. Мэдээлэгч зориуд худал мэдүүлэг өгсөн буюу өгсөн мэдүүлгээ буруу гэж үзсэн;
 3. Мэдээлэгч шүүх хуралдаанд гэрчээр дуудагдсан бол.
- Тус хуулийн дагуу оногдуулах ялыг хөнгөлөх үндэслэл болохгүй.

Авлигын эсрэг Хараат бус комисс (Independent Commission against Corruption, ICAC)

1974 онд Авлигын эсрэг Хараат бус комиссын тухай хуулийг баталснаар байгуулагдсан. Авлигын хэргийг мөрдөн шалгах, урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх зорилгыг хослуулах чиг үүрэгтэй бие даасан хууль сахиулах байгуулах юм.

⁴⁴ Хууль ёсны эрх (lawful authority), хүндэтгэн үзэх шалтгаан (reasonable excuse)-ыг Авлигаас урьдчилан сэргийлэх тухай хуульд тодорхойлоогүй бөгөөд практикт хэрэглэх, тайлбарлахад төвөгтэй. Тухайн тодорхой тохиолдлоос хамаарах шинжтэй.

⁴⁵ Авлигаас урьдчилан сэргийлэх тухай хууль, 9-р зүйл

Үйл ажиллагаагаа Хонгконгийн Тусгай захиргааны бүсийн тэргүүнд тайлагнана. Холбогдох хууль тогтоомжийн дагуу авлигын хэрэг үйлдсэн гэх үндэслэл бүхий сэжиг байгаа тохиолдолд сануулга өгөхгүйгээр баривчлах эрхтэй.

Бүтцийн тухайд Комиссарын газар, Захиргааны алба, Үйл ажиллагааны, Авлигаас урьдчилан сэргийлэх, Олон нийтийн харилцааны гэсэн хэлтэстэй.

Мөн гишүүдийг нь Хонгконгийн Засгийн газрын тэргүүнээс томилдог Авлигын асуудлаар зөвлөх хороо, Үйл ажиллагааг хянан зохицуулах хороо, Авлигаас урьдчилан сэргийлэх талаар зөвлөх хороо, Олон нийтийн харилцааны талаар иргэдэд зөвлөх хороодтой.

Үйл ажиллагааны хэлтэс нь авлигатай холбоотой гомдлыг хүлээн авч, шалган үзсэний үндсэн дээр мөрдөнө. Авлигаас урьдчилан сэргийлэх хэлтэс нь авлигыг бууруулах үүднээс төрийн болон олон нийтийн байгууллагын үйл ажиллагаа, дотоод журмыг хянан шалгах, хүсэлтийн дагуу хувийн байгууллагуудад авлигаас сэргийлэх талаар зөвлөгөө өгнө. Олон нийтийн харилцааны хэлтэс нь авлигаас сэргийлэх талаар олон нийтийг соён гэгээрүүлэх, авлигатай тэмцэхэд олон нийтийн дэмжлэгийг нэгтгэх чиглэлд үйл ажиллагаа явуулна. Одоогийн байдлаар 1 200 ажилтантай байна⁴⁶.

2012 онд 5 182 хэрэг (үүний 2 335 нь сонгуультай холбоотой хэрэг байна) шинээр мөрдөн шалгасан нь өмнөх оныхтой харьцуулахад 47 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Эдгээрээс 4 962 хэргийг бүрэн шалгаж дуусчээ⁴⁷.

Мөрдөн байцаах үйл ажиллагаа явуулах үндсэн чиг үүрэгтэй байгууллага болохын хувьд ямар нэгэн санкц, шийтгэл оногдуулах эрхгүй.

Мөрдөн байцаалт явуулж дууссаны дараагаар Хууль зүйн департамтад шилжүүлнэ, уг департамент шүүн таслах ажиллагаа явуулахад хангалттай нотлох баримт байгаа, олон нийтийн ашиг сонирхлын дагуу яллах нь зүйтэй гэж үзсэн нөхцөлд шүүх рүү шилжүүлнэ⁴⁸. Практикт голлон явуулдаг үйл ажиллагаанууд

- Гомдол хүлээн авах
- Авлигын хэрэгт мөрдөн байцаалт явуулах

Албан ёсны цахим хаяг болох www.icac.org.hk-аас гадна Хонгконгийн Ёс зүйн хөгжлийн төвийн www.icac.org.hk/hkedc, www.icac.org.hk/teensland, Ёс зүйн боловсролын www.icac.org.hk/мeцaхим хаягуудаар мэдээлэл түгээдэг.

⁴⁶ http://www.icac.org.hk/en/about_icac/os/index.html

⁴⁷ Annual Report 2012 Independent Commission Against Corruption Hong Kong Special Administrative Region

⁴⁸ Norton Rose Group, Anti-corruption Laws in Asia Pacific, 2011, p.33

Япон

Япон улс 2012 оны АТИ-т 17-р байр эзэлсэн⁴⁹ ба НҮБ-ын Авлигын эсрэг конвенцид гарын үсэг зурсан боловч хараахан соёрхон батлаагүй. Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын Олон улсын бизнесийн хэлцэлд Гадаадын төрийн албан тушаалтны авлигатай тэмцэх тухай конвенцийг соёрхон баталсан.

Авлигын эсрэг хоёр гол хууль байдаг нь Шударга бус өрсөлдөөнөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон Гэмт хэргийн тухай хууль юм. Шударга бус өрсөлдөөнөөс урьдчилан сэргийлэх тухай хууль нь гадаадын нийтийн албан тушаалтанд, Гэмт хэргийн тухай хууль нь дотоодын нийтийн албан тушаалтанд тус тус хамаарна.

Мөн Үндэсний нийтийн албаны ёс зүйн тухай хууль нь хоёрдогч эх сурвалжид тооцогддог бөгөөд үндэсний нийтийн албанд баримталбал зохих үндсэн хэм хэмжээг тогтоосон байна. Тус хуулийн дагуу Үндэсний нийтийн албаны ёс зүйн дүрмийг 2000 онд баталсан. Шударга бус өрсөлдөөнөөс урьдчилан сэргийлэх тухай хууль нь нутаг дэвсгэрийн гадна үйлчлэх хүчин чадалтай.

Зөвхөн нийтийн албан дахь авлигын асуудлыг Гэмт хэргийн тухай хууль тогтоомжоор зохицуулдаг. Гэхдээ Компанийн тухай хуулиар компанийн захирал, аудитор авлига өгөх, тэдгээрээс авлига авах; хувьцаа эзэмшигчийн эрх хэрэгжүүлэхтэй холбоотойгоор авлига өгөх, авах; мөн түүнтэй холбоотойгоор компанийн болон түүний охин компанийн зардалд захирал, аудиторос ашиг авах зэрэг тохиолдлуудад шийтгэл оноодог. Хувь хүний хувьд оногдуулах ял нь:

- *Дотоодын төрийн албан тушаалтанд авлига өгсөн бол 3 хүртэл жилийн хугацаатайгаар хорих буюу 2.5 сая хүртэл иенээр торгох;*
- *Гадаадын төрийн албан тушаалтанд авлига өгсөн бол 5 жил хүртэл хугацаагаар хорих буюу 5 сая хүртэл иенээр торгох гэсэн заалттай бол*

Хуулийн этгээдийн хувьд:

- *Дотоодын нийтийн албан тушаалтанд авлига өгсөн бол хувь хүнийхтэй адилхан ял оногдуулах;*
- *гадаадын төрийн албан тушаалтанд авлига өгсөн тохиолдолд 300 сая хүртэл иенээр торгох гэсэн ял шийтгэлийг оногдуулдаг.*

Гэмт хэргийн тухай хууль 25 дугаар бүлэгт авлигын гэмт хэргийг хуульчилсан байна. Үүнд:

Хээл хахууль авах, өгөх гэсэн хүсэлтийг хүлээн авах

(1) Нийтийн албан тушаалтан өөрийн албан үүрэгтэй холбоотойгоор авлига авсан, авлига авахаар шахаж шаардсан, амласан бол 5 жилээс ихгүй хугацаагаар; хүсэлтийн хариуд үйлдэл хийхээр албан ёсоор тохиролцсон бол 7 жил хүртэл хугацаагаар тус тус хорих ял оногдуулна.

⁴⁹ <http://www.transparency.org/cpi2012/results>

(2) Нийтийн албан тушаалтнаас томилогдсон этгээд хүсэлтийн хариуд үйлдэл хийхийн тулд гэрээгээр хүлээсэн үүрэгтэй холбоотойгоор авлига авсан, авахаар шахаж шаардсан буюу амласан бол 5 жил хүртэл хугацаагаар хорих ял оногдуулна⁵⁰.

Хүсэлтийн хариуд үйлдэл хийхээр тохиролцсон нийтийн албан тушаалтан албан үүрэгтэйгээ холбоотойгоор гуравдагч этгээдийг авлига өгөхөд хүргэсэн, гуравдагч этгээдээс авлига өгөхийг шахаж шаардсан буюу амлалт авсан бол 5 жил хүртэл хугацаагаар ажил хийлгэж хорих ял оногдуулна⁵¹.

Хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар авлига авах, албан тушаалаасаа чөлөөлөгдсөний дараа авлига авах

(1) Нийтийн албан тушаалтан өмнө дурдсан 2 гэмт хэргийг үйлдэж, улмаар үүргээ хууль бусаар гүйцэтгэсэн буюу гүйцэтгэхээс татгалзсан бол 1 жил хүртэл хугацаагаар ажил хийлгэж хорих ял оногдуулна.

(2) Нийтийн албан тушаалтан албаны үүргээ хууль бусаар гүйцэтгэх буюу гүйцэтгэхээс татгалзах байдлаар авлига авсан, авахаар шахаж шаардсан, амласан, гуравдагч этгээдийг авлига өгөх байдалд хүргэсэн буюу гуравдагч этгээдээс авлига өгөхийг шахаж шаардсан, амласан бол адил ял оногдуулна.

(3) Нийтийн албан тушаалаас чөлөөлөгдсөн этгээд хүсэлтийн хариуд хууль бусаар үүрэг гүйцэтгэх буюу гүйцэтгэхээс татгалзахаар авлига авсан, авахаар шахаж шаардсан, амласан бол 5 жил хүртэл хугацаагаар ажил хийлгэж хорих ял оногдуулна⁵².

А. Нөлөөлөл үзүүлэх зорилгоор авлига авах

Нийтийн албан тушаалтан хүсэлтийн хариуд хууль бусаар албан үүргээ гүйцэтгэх буюу гүйцэтгэхээс татгалзахад хүргэхээр өөр албан тушаалтанд дарамт үзүүлсэн буюу дарамт үзүүлэхээр тохиролцож авлига авсан, авахаар шахаж шаардсан, амласан бол 5 жил хүртэл хугацаагаар ажил хийлгэж хорих ял оногдуулна⁵³.

В. Хураан авах, тэнцэх мөнгөн дүнг хуримтлуулах

Гэмт хэрэгтэн болон гуравдагч этгээдээс мэдсээр байж авлига авсан бол хураан авна. Авлигыг бүхэлд нь буюу хэсэгчлэн хураан авах боломжгүй бол тэнцэх мөнгөн дүнг хуримтлуулна.

С. Авлига өгөх: авлига өгсөн, өгөхөөр санал болгосон буюу амласан бол 3 хүртэл жилийн хугацаатайгаар хорих буюу 2,500,000 хүртэл иенээр торгох ял оногдуулна.

Гадаадын төрийн албан тушаалтан

Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын Олон улсын бизнесийн хэлцэлд авлигатай тэмцэх тухай конвенцийг соёрхон батласны дараагаар 1998 онд Шударга бус өрсөлдөөнөөс урьдчилан сэргийлэх тухай

⁵⁰ Гэмт хэргийн тухай хууль, 197-р зүйл

⁵¹ Мөн тэнд

⁵² Гэмт хэргийн тухай хууль, 197-3 зүйл

⁵³ Мөн тэнд

хуульд нэмэлт өөрчлөлт оруулан гадаадын төрийн албан тушаалтныг авлигын гэмт хэргийг шинээр хуульчилсан байна.

Тус хуулиар олон улсын арилжааны хэлцэлтэй холбоотой бизнесийн үйл ажиллагаанаас ашиг олохын тулд албан үүрэгтэй нь холбоотой үйлдэл хийлгэх болон үйлдэл хийхээс татгалзуулах, уг албан үүрэгтэй холбоотой үйлдэл хийх буюу үйлдэл хийхээс татгалзуулахаар өөр гадаадын төрийн албан тушаалтанд нөлөөлөхөд албан тушаалын байдлыг нь ашиглах зорилгоор гадаадын төрийн албан тушаалтанд мөнгө болон бусад давуу тал олгох, санал болгох, амлахыг хориглосон⁵⁴.

Гадаадын төрийн албан тушаалтан гэдэгт:

а) гадаадын төрийн болон орон нутгийн захиргаанд төрийн алба хашиж байгаа;

б) нийтийн ашиг сонирхол бүхий тусгай ажил хэргийг явуулахын тулд гадаадын хуулийн дагуу байгуулагдсан аж ахуйн нэгжид ажиллаж байгаа;

с) олон улсын байгууллага (бүрэн эрхт улсын засгийн газар болон засгийн газар хоорондын олон улсын байгууллагаас үүсгэн байгуулсан)-ын нийтийн албанд ажиллаж байгаа;

д) гадаадын төрийн болон орон нутгийн захиргаа, ОУБ-ын бүрэн эрхийн хүрээнд үйл ажиллагаа явуулж байгаа буюу тэдгээр байгууллагыг төлөөлж байгаа этгээд хамаарна гэжээ.

2004 онд Мэдээлэгчийг хамгаалах тухай хууль баталж дараах хамгаалалт олгосон байна. Үүнд:

- Мэдээлэгчийн нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгосныг хүчингүй болгох (нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгосон нь мэдээлсэн үр дүн бол);
- Ажилтны гэрээг цуцласныг хүчингүй болгох (гэрээг цуцласан нь мэдээлсэний үр дүн бол);
- Албан тушаал, цалин бууруулах зэрэг хохиролтой байдлаар хандахыг хориглох (ийнхүү хандсан нь мэдээлэл өгсний үр дүн бол). Нэрээ нууцлах эрх мэдээлэгчид олгоогүй боловч нэмэлт, өөрчлөлт оруулахаар хэлэлцэж байна.

Үндэсний Нийтийн Албаны Ёс зүйн тухай хуулиар Үндэсний нийтийн албаны зөвлөлийг байгуулсан. Тусхуулийн 10-38 дугаар зүйлд байгууллагын эрх зүйн байдлыг тодорхойлжээ. Авлигын эсрэг мөрдөн шалгалт явуулах, сахилгын шийтгэл оногдуулах эрх хэмжээтэй. Дарга болон зөвлөлийн 4 гишүүнээс бүрдэнэ. Өндөр ёс суртахуунтай, албан тушаалтны үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотой ёс зүйг сахих шударга чанартай, хуулийн болон нийгмийн зохих мэдлэг, туршлагатай этгээдүүдийн дотроос Парламентийн зөвшөөрөлтэйгээр дарга, зөвлөлийн гишүүдийг Засгийн газраас томилно.

Зөвлөлийн нэг гишүүнийг Үндэсний Боловсон хүчний байгууллагын комиссаруудын дотроос Засгийн газар томилно. Дарга, зөвлөлийн гишүүний бүрэн эрхийн хугацаа 4 жил байх ба дахин сонгогдож болно⁵⁵.

⁵⁴ Шударга бус өрсөлдөөнөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, 18-р зүйл

⁵⁵ Үндэсний Нийтийн Албаны Ёс зүйн тухай хууль, 15-р зүйлийн 4 дэх хэсэг

Украин

2012 оны АТИ-т 144 дүгээр байр эзэлсэн буюу доогуур үзүүлэлттэй Украин улс нь НҮБ-ын Авлигын эсрэг конвенцид 2003 онд гарын үсэг зурж, 2006 онд соёрхон баталж 2010 онд гишүүн орон болсон.

Европын зөвлөлийн авлигын гэмт хэргийн эрүүгийн хуулийн конвенцийг 2006 онд соёрхон батлаж 2010 оноос хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн. Хээл хахуулийн эсрэг Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын конвенцийн гишүүн биш боловч Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын байгуулсан Зүүн Европ болон Төв Азийн Авлигын эсрэг сүлжээнд оролцдог бөгөөд Хээл хахуулийн эсрэг Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын конвенц зэрэг олон улсын стандартуудад үндэслэсэн Истанбулын Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөнд⁵⁶ хяналт тавьдаг улс юм.

Эрүүгийн хариуцлага: Украин улсын хууль тогтоомжид авлигын гэмт хэргийг өргөн хүрээтэйгээр тусгасан нь Украин улс дахь авлигын гэмт хэрэг болон олон улсын стандартуудыг зөрүүтэй болгосон. Авлигын эсрэг улсуудын нийгэмлэг болон Авлигын эсрэг сүлжээ нь уг асуудлыг хянаад дараах дутагдлуудыг илрүүлсэн:

Украин улсын нийт хууль тогтоомжинд заасан авлигын гэмт хэргүүд	Украин улсын нийт хууль тогтоомжоос илэрсэн дутагдлууд
Хээл хахуулийн гэмт хэргүүд	
- Идэвхигүй хээл хахууль /Эрүүгийн хуулийн 368, 368.3.3, 368.4.3-р зүйл/ - Идэвхитэй хээл хахууль /Эрүүгийн хуулийн 368.3, 368.4, 369-р зүйл/	- Хээл хахууль өгөх, авахаар амлах, шаардах, хээл хахууль өгөх, авах санал эсхүл амлалтыг хүлээж авах нь төгссөн гэмт хэрэг - Эд хөрөнгийн бус ашигтай талууд - Гуравдагч этгээдээс хээл хахууль өгөх, авах болон гуравдагч этгээдийн ашиг - Хээл хахуулийн гэмт хэргийн хариуцлагын үр нөлөө, тэгш байдал болон хориглох шинж - Хуулийн этгээдийн хариуцлага

⁵⁶ Авлигын эсрэг сүлжээ нь Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын хээл хахуулийн гэмт хэрэг дээрх ажлын хэсгийн олон улсын харилцааны бодлогын хүрээнд хэрэгжүүлдэг бүс нутгийн хөтөлбөрүүдийн нэг юм. Авлигын эсрэг сүлжээ нь Украин улсыг оролцуулан Зүүн Европ болон Төв Азид оршдог 23 улсаас бүрдэнэ. Истанбулын үйл ажиллагааны төлөвлөгөө нь сайн дурын байгууллага бөгөөд Украин улсыг оролцуулан Авлигын эсрэг сүлжээний 8 улсаас бүрддэг. Истанбулын үйл ажиллагааны төлөвлөгөө нь авлигын эсрэг хууль тогтоомжийн тогтвортой тэгш хяналтын үйл ажиллагаа болон авлигын гэмт хэрэг гардаг газар нутгуудад хууль хэрэгжүүлэх байгууллагаар хангадаг. Истанбулын үйл ажиллагааны төлөвлөгөөн дор 2010 онд батлагдсан хүчин төгөлдөр Украин улсын хяналтын 2-р үе шатны тайлан.

Бусад авлигын гэмт хэргүүд	
• Мөнгө угаах гэмт хэрэг /Эрүүгийн хуулийн 209, 209.1-р зүйл/ • Хууль бус аргаар мөнгө олох гэмт хэрэг, мөрийн болон хувийн секторын эд хөрөнгө шамшигдуулах, завших гэмт хэрэг /191-р зүйл/ • Шахалт үзүүлэн худалдаа хийх /Эрүүгийн хуулийн 369.2-р зүйл/ • Шүүн таслах ажиллагаанд саад учруулах /376-р зүйл/ • Байгууллагын журам зөрчих, албан тушаалын эрх мэдлээ хэтрүүлэх /364, 364.1, 365, 365.1, 365.2-р зүйл/ • Санаатайгаар нуун дарагдуулах/ Эрүүгийн хуулийн 396-р зүйл/ • Хууль бусаар хөрөнгөжих /368.2/	• Мөнгө угаах гэмт хэрэг үйлдсэн хуулийн этгээдийн хариуцлага • Хууль бусаар хөрөнгөжих /Энэ гэмт хэрэг нь НҮБ-ын Авлигын эсрэг конвенцийн 20-р зүйлд байхгүй./ • Байгууллагын журам зөрчих гэмт хэрэг /Энэ гэмт хэрэг нь хувь хүн ашиг олох гэсэн шинжийг агуулаагүй бөгөөд үл ялгагдах байдлаар илэрхийлсэн/

Захиргааны хариуцлага

Олон улсын арга хэрэгслүүд нь авлигын үйлдэлд эрүүгийн гэмт хэргийн нэгэн адил прокурорын хяналт тавихыг шаарддаг тул 1995 оноос хойш Украин улс нь хуучнаар ЗХУ байсан зарим улсууд шиг авлигын гэмт хэргийн захиргааны болон эрүүгийн хариуцлагын зэрэгцээ тогтолцоотой болсон.

Мөн Эрүүгийн хуулиндаа тухайн гэмт хэргүүдийг тусгасан бөгөөд Украин улсын авлигын гэмт хэрэгтэй тэмцэх хуулинд захиргааны болон засан хүмүүжүүлэх ял шийтгэл бүхий “Төрийн үүрэг гүйцэтгэх эрх бүхий албан тушаалтан материаллаг ашиг, үйлчилгээ, эрх мэдэл, бусад давуу талыг хууль бусаар олж авах” гэмт хэргийг оруулсан.

Авлигын эрүүгийн хэрэг болон захиргааны зөрчлийн хоорондын ялгарах гол шинж нь тухайн гэмт хэргүүдийн нийгэмд учруулах аюулын хэр хэмжээ боловч практикт үүнийг тодорхойлоход хүндрэлтэй байдаг. Эрүүгийн үйл ажиллагаа нь баталгааны өндөр түвшин болон илүү төвөгтэй үйл ажиллагааг шаарддаг бөгөөд гэмт хэрэгтэнд хүнд хариуцлага оногдуулдаг тул хууль хэрэгжүүлэгч эсхүл дотоодын мөрдөн шалгах эрх бүхий албан тушаалтнууд илүү хөнгөн захиргааны хариуцлагыг оногдуулах хандлагатай байдаг.

2011 онд Авлигын гэмт хэргийн хариуцлагатай холбоотойгоор хууль тогтоомжид шинэчлэлт хийсний дараа одоог хүртэл Украин улсын хуулиар авлигын гэмт хэрэг дээр захиргааны болон эрүүгийн хариуцлага оногдуулдаг болсон. Жишээ нь: Захиргааны гэмт хэргийн хуулийн 172.3-р зүйлд “Давуу тал бий болгох тухай санал болгох, өгөх” гэж заасан бол Эрүүгийн хуулийн 369-р зүйлд “Хээл хахууль санал болгох, өгөх” гэж заасан байна.

Хариуцлага, хураан авах болон халдашгүй байдал

Оногдуулах хариуцлагын хувьд олон улсын авлигын эсрэг конвенцуудад тухайн хариуцлага үр дүнтэй, тэгш болон хориглох шинж бүхий байхыг шаардсан ерөнхий стандартыг тусгасан. Украин улсын тодорхой дутагдлуудыг илрүүлсэн Авлигын эсрэг сүлжээний хяналт нь хээл

хахуулийн гэмт хэргийн хариуцлага нь хэтэрхий сул байгааг онцолсон⁵⁷.

2011 онд танилцуулагдсан нэмэлтүүд нь энд хамаарахгүй бөгөөд хээл хахуулийн зарим гэмт хэргүүдийн хариуцлагыг багасгасан. Идэвхитэй болон идэвхигүй хээл хахуулийн үндсэн гэмт хэргүүдэд шоронд хоригдох ял шийтгэл байхгүй.

Энэ нь Европын зөвлөлийн конвенцийн 19-р зүйлд “хариуцлага нь үр дүнтэй, тэгш, хориглох шинж бүхий байна, үүнд эрх чөлөөг хасах төрлийн ял шийтгэлтэй байх бөгөөд тухайн улсын хуулийг зөрчсөн гэмт хэрэгтнийг шилжүүлэн өгөх явдлыг нэмэгдүүлэх зорилготой байна” гэсэн заалтыг зөрчдөг.

Үүнээс гадна зарим авлигын гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааны хязгаарлалт нь – идэвхигүй хээл хахуулийн үндсэн гэмт хэргийнх 2 жил /368.1-р зүйл/, идэвхитэй хээл хахуулийн үндсэн гэмт хэргийнх 3 жил /369.1-р зүйл/ - үлдсэн гэмт хэргийнх хэтэрхий бага байдаг.

Олон улсын бүхий л конвенцууд тэдгээрт нэгдэж орсон улсуудыг хээл хахууль, хээл хахуулийн үйл ажиллагаа болон тухайн үйл ажиллагаанд тохирох хөрөнгийн үнийг хураан авах чадвартай байхыг шаарддаг.

Украин улсын хураан авах хүчин төгөлдөр арга ажиллагаа нь хязгаарлагдмал бөгөөд бүх авлигын гэмт хэрэг дээр болон авлигатай холбогдох гэмт хэргүүд дээр хураан авах үйл ажиллагааг хэрэгжүүлэх боломжоор хангаагүй байдаг.

Уг боломж нь хэдийгээр “Хураан авах үйл ажиллагааг явуулах процесс ажиллагааг сайжруулах эрүүгийн болон эрүүгийн процессийн хуулийн нэмэлт” хуулийн төсөлд тусгагдсан боловч уг төслийг 2009 оноос хойш парламент хойшлуулсаар байна.

Халдашгүй байдлын хувьд Авлигын эсрэг НҮБ-ын конвенц нь халдашгүй байдал болон шалгагдах шаардлагатай авлигын гэмт хэргийг үр дүнтэйгээр мөрдөн шалгах, прокурорын хяналт тавих болон шүүхээр шийдвэрлэх боломжийг тэнцвэртэйгээр хангадаг.

Хамгийн сайн практик нь эдгээр олон улсын стандартууд, төрөлхийн шинжээр үүрэгжсэн халдашгүй байдалд нийцүүлэх, зөвхөн албан хаагчийн хүлээсэн үүргээ хэрэгжүүлэх үйлдэлд нь хандах болон хөөн хэлэлцэх хугацааг хязгаарлах, зайлшгүй шалтгаанаар халдашгүй байдалд халдах үйл ажиллагааг үр дүнтэй байлгахыг зөвлөдөг. Хөөн хэлэлцэх хугацааны тухай хуулинд халдашгүй байдлын тухай заагаагүй.

Украинд халдашгүй байдлыг баталгаажуулах ямар ч арга хэмжээ авагдаагүйг тэмдэглэх хэрэгтэй бөгөөд төрийн дээд түвшний албан хаагчийн хэргийг мөрдөн шалгах, прокурорын хяналт тавих үйл ажиллагаанд халдашгүй байдлыг урьдчилан хамгаалдаггүй, бусад халдашгүй байдал туйлын бөгөөд үүрэгжээгүй байдаг ба халдашгүй байдалд халдах үйл ажиллагаа нь хангалттай үр дүнтэй, тодорхой биш байдаг.

⁵⁷Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага /Авлигын эсрэг сүлжээ, Истанбулын үйл ажиллагааны төлөвлөгөөнөөс 2010 онд батласан Украин улсын хяналтын тайлангийн 2-р үе шат, хуудас 33.

Хуулийн шинэтгэлийг үргэлжлүүлэх

2011 онд “Авлигын эсрэг, авлигаас урьдчилан сэргийлэх зарчим” болон “Авлигын гэмт хэргийн хариуцлагатай холбогдох хэд хэдэн хууль тогтоомжийн актуудын нэмэлт”-ийг батласан бөгөөд эдгээр нь 2011 онд хүчин төгөлдөр болсон.

Тэдгээр эрх зүйн актууд нь Украин дахь эрүүгийн хууль тогтоомжийн хэд хэдэн чухал өөрчлөлтүүдийг танилцуулсан юм. Үүнд нь: шахалт үзүүлэн худалдаа хийх, хууль бусаар хөрөнгөжих гэмт хэрэг, идэвхитэй болон идэвхигүй хээл хахуулийн гэмт хэргийн хариуцлагын өөрчлөлтүүдэд олон улсын стандартуудыг бүтнээр нь тусгасан.

Гэхдээ Украины авлигын гэмт хэрэгт хууль зүйн дутагдлууд үлдэж байгаа учраас улс нь эцсийн эцэст хууль тогтоомжоо шинэчлэх, олон улсын стандартуудыг дагаж мөрдөх шаардлагатай.

Энэ нь Украины хууль тогтоомжийн хэм хэмжээ болгох ёстой, бусад улс орнуудын дагаж мөрддөг, хуулийн хяналтын байгууллага /MLA/ болон олон улсын хамтын ажиллагааны бусад хүсэлтүүдийн үндэслэл болгон хэрэглэдэг олон улсын стандартуудыг ухамсарлаж ойлгосон мөрдөн байцаагч болон прокуроруудад ихээхэн ач холбогдолтой юм.

Холбооны бүгд найрамдах Герман улс

ХБНГУ нь 2012 оны АТИ-т 13-р байр эзэлсэн байна⁵⁸. 1999 онд Герман улс Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын Олон улсын бизнесийн хэлцэлд гадаадын төрийн албан тушаалтны авлигатай тэмцэх тухай конвенцийг соёрхон баталж, НҮБ-ын Авлигын эсрэг конвенцид гарын үсэг зурсан (2005 онд хүчин төгөлдөр болсон). Эрх зүйн гол эх сурвалж нь Гэмт хэргийн тухай хууль юм.

Хуулийн 331-338 дугаар зүйлд нийтийн албан дахь авлига, 299-302 дугаар зүйлд бизнесийн хэлцэл дэх авлига, 108-198 дүгээр зүйлд сонгуулийн авлигын талаар тусгасан. Европын холбооны болон бусад гадаадын төрийн албан тушаалтан, шүүгчийн тухайд Европын холбооны Авлигын эсрэг хууль болон Олон улсын авлигатай тэмцэх тухай хууль үйлчилдэг.

Германы авлигын эсрэг хууль тогтоомж нь нийтийн болон хувийн секторыг хамардаг.

А. Дотоодын болон гадаадын нийтийн албан тушаалтан

Нийтийн албан тушаалтан гэдэгт төрийн албан хаагч, шүүгч, өөр бусад байдлаар нийтийн албан ёсны чиг үүрэг гүйцэтгэдэг буюу нийтийн эрх бүхий байгууллагад ажиллахаар томилогдсон эсхүл нийтийн захиргааны үйлчилгээ үзүүлэхээр бүрэн эрх олгогдсон хувь хүн хамаарна.

Иймээс Германы авлигын эсрэг хууль тогтоомжоор төв болон мужийн захиргааны чиг үүрэг гүйцэтгэдэг этгээдээс гадна бусад нийтийн эрх зүйн субъект, тухайлбал төрийн аж ахуйн нэгж, их сургууль, эмнэлэг, нийтийн тээврийн компани мөн гадаадын төрийн албан тушаалтан, шүүгч, цэрэг байх боломжтой.

⁵⁸ Мөн тэнд

В. Ажилтан, бизнесийн агент

АНУ-ын авлигын эсрэг зохицуулалттай адилгүйгээр компанид ажилладаг этгээдэд хэрэглэгдэнэ. Арилжааны практик гэдэгт тодорхой хугацаатай ашгийн төлөө бүх үйл ажиллагаа жишээлбэл, компани, бие даасан мэргэжлийн алба, олон нийтийн болон хувийн нөхөрлөл, ашгийн төлөө олон нийтийн компани зэргийг ойлгоно. Эрүүгийн хариуцлагыг оруулахгүйгээр компани нь ажилтныхаа гаргасан зөрчлийг хариуцна.

С. Төлөөлөгч: гэдэгт холбооны, мужийн, орон нутгийн парламентын гишүүн, Европын парламентын гишүүн хамаарна. Сонгуулийн үеэр сонгогчдод авлига өгөхийг хориглодог.

Үндсэндээ идэвхтэй (авлига авах), идэвхгүй (авлига авах) авлигын аль алиныг хамарсан. Ганц онцгой тохиолдол байдаг нь Европын холбооны бус төрийн албан тушаалтны оролцоотой авлигын гэмт хэрэгт зөвхөн идэвхтэй авлигыг хориглодог.

Арилжааны практикт буюу хувийн секторт ашиг өгөх, авахыг хориглодог. Ашиг нь хууль бус зорилгоор бий болсон давуу байдал юм. Энэ нь тухайн этгээдийн санхүүгийн, эрх зүйн, хувийн нөхцөл байдлыг дээшлүүлэх зорилготой эдийн болон эдийн бус давуу байдлаар тодорхойлогдоно.

Үүнд албан тушаал дэвшихэд чиглэсэн бэлэг, ашгийн талаар зөвлөгөө өгөх гэрээ, хөнгөлөлт, хангамж, дэмжлэг, бүр бэлгийн харьцаа хүртэл орно. Цаашлаад хөнгөлөлт бүхий төлбөр Германы хуулиар авлигад тооцогддог, төлбөрийн хэлбэртэй авлига нь хэрэгжсэн байна. Гэхдээ бага хэмжээний заншил болсон зорилгын хувьд шийдвэр гаргах процесст нөлөөлөх боломжгүй харандаа, үзэг өгөх, аяга кофе уух зэрэг тохиолдол хамаарахгүй.

Нийтийн албан дахь авлига: Германы авлигын эсрэг хууль тогтоомжоор албан үүрэгтэйн холбогдуулан өөрийн болон бусдын эрх ашгийн төлөө авлига өгөх (өгөх, өгөхөөр санал болгох, амлах), авах (авахаар шаардах, зөвшөөрөх, хүлээн авах)-ыг нийтийн албан тушаалтанд хориглосон байна.

Бизнесийн үйл ажиллагаан дахь авлига: Бизнесийн үйл ажиллагаа / хэлцэл/-нд өөрийн эсхүл бусдын эрх ашгийн төлөө ажилтан болон агентад авлига өгөх, авахыг хориглодог.

Сонгуулийн авлига: Саналыг худалдах, худалдан авах, тодорхой асуудлаар санал өгөх болон санал өгөхгүйн төлөө бэлэг, ашиг өгөх, авахыг хориглодог.

Хариуцлагын асуудал

Хувь хүнд торгох, хорих шийтгэл оногдуулах ба ялын дээд хэмжээ 10 жил байна. Нийтийн албаны авлигын хэрэгт торгох буюу 3 жил хүртэл хугацаагаар хорих, онц хүнд тохиолдолд 10 жил хүртэл хугацаагаар хорих; бизнесийн хэлцэл дэх авлигад торгох, 3 жил хүртэл хугацаагаар хорих, онц хүнд тохиолдолд 5 жил хүртэл хугацаагаар хорих; сонгуулийн авлигын хэрэгт торгох буюу 5 жил хүртэл хугацаагаар хорих ял тус тус оногдуулна.

Германд хуулийн этгээд гэмт хэргийн эрх зүйн субъектэд тооцогддоггүй ч компанийн төлөөлөгч, ажилтны үйлдсэн авлигын хэрэгт Германы Захиргааны зөрчлийн тухай хуулиар 1 сая хүртэл еврогоор торгох шийтгэл оногдуулдаг. Үүнээс гадна тухайн авлигаар дамжин компанийн олсон орлогыг хураадаг.

Германы парламентаас батласан нэмэлт, өөрчлөлтөөр компанид оногдуулах торгуулийн хэмжээ 10 сая хүртэл евро байхаар тогтоосон байна. Германы авлигын эсрэг хууль тогтоомжийг хэрэглэх хүрээ:

- а) Герман улсын нутаг дэвсгэрт үйлдэгдсэн;
- б) Герман улсын эсрэг Герман улсын нутаг дэвсгэрийн гадна үйлдэгдсэн;
- в) Германы иргэн Герман улсын нутаг дэвсгэрийн гадна үйлдэгдсэн тохиолдолд хэрэглэгдэнэ.

Европын холбооны Авлигын эсрэг хууль нь Европын Холбооны болон гишүүн орнуудын нийтийн албан тушаалтан, шүүгчийн үйлдсэн идэвхгүй авлигын хэрэгт үйлчилнэ.

Дотоодын Мөрдөн байцаалтын газар (*Dezernat Interne Ermittlungen* (D.I.E.), Department of Internal Investigations) нь Дотоод хэргийн яамны эрхлэх асуудлын хүрээнд үйл ажиллагаа явуулдаг бөгөөд цагдаа, бусад бүтцээс бие даасан шинжтэй.

Нийтийн захиргааны түвшинд цагдаагийн зүй бус үйлдэл, авлига болон хувийн секторын хүрээн дэх авлигын хэргийг мөрдөн шалгадаг.

Эстони улс

Одоогоор дагнасан авлигын эсрэг байгууллага байхгүй. Хууль зүйн яам авлигын эсрэг бодлогыг зохицуулан холбох чиг үүргийг хэрэгжүүлдэг. Хууль сахиулах байгууллагад Прокурорын газар, Цагдаагийн болон Хилийн гварди, Аюулгүй байдал хариуцсан Цагдаагийн газар, Цагдаагийн болон Хилийн гвардийн харъяа Санхүүгийн тагнуулын хэлтэс орно.

Германы Засгийн газар авлигаас урьдчилан сэргийлэх, ил тод байдлыг бий болгох зорилгоор 3 түвшинд Авлигын эсрэг Германы хөгжлийн бодлого үйл ажиллагаа явуулж байна.

А. Олон улсын хэмжээнд координаци хийх (зохицуулан холбох)

а) НҮБ, Дэлхийн банк, Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын идэвхтэй оролцоотойгоор Германы Засгийн газар олон улсын авлигын эсрэг стандартыг тогтоох, дагаж мөрдөхөд анхааран ажилладаг. Энэ хүрээнд авлигад өртсөн үйлдвэрлэл, салбарт ил тод байдал бий болгохыг зоридог.

б) Герман улсын Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн яам нь НҮБ-ын Авлигын эсрэг конвенцийг соёрхон батлаж, хэрэгжүүлэхэд түншлэгч орнууддаа туслалцаа үзүүлэх зорилготой.

в) Мөн тус яам байгалийн нөөц ихтэй орнуудад авлига тэргүүлэх чиг хандлагатай байгааг анхааралдаа авч тэдгээр орны авлигад ихээр өртсөн

салбаруудад ил тод байдлыг дээшлүүлэхэд олон улсын идэвх санаачлагыг дэмжинэ.

В. Германы 2 талт хамтын ажиллагаагаар дамжуулан хувь нэмэр оруулах.

Түншлэгч орнуудын төрийн албыг авлигаас ангижруулах, олон нийтийн хэрэгцээ шаардлагад нийцсэн ил тод, үр нөлөөтэй, уян хатан нийтийн захиргааг бий болгоход туслалцаа үзүүлдэг.

Одоогийн байдлаар Германы Техникийн Хамтын ажиллагааны байгууллага дэлхий даяар 70 гаруй нийтийн салбарын шинэчлэлийн төсөл хөтөлбөрт санхүүжилт олгоод байна. Эдгээр төсөл хөтөлбөр нь нэгдмэл стандарт тогтоох, үр дүнтэй хүний нөөцийн удирдлага бий болгох, олон нийтийн санхүүгийн тогтолцоог бүрдүүлэхэд чиглэсэн. Сонор сэрэмжтэй иргэний нийгэм авлигатай тэмцэхэд амин чухал хүчин зүйл болдогийг анхааралдаа авч хөгжиж буй орнуудад, олон улсын түвшинд, мөн Герман, Европд энэ чиглэлээр санаачлага гаргаж ажилладаг.

С. Герман улсын хэмжээнд авлигаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах

Германы төрийн албаны талаарх хууль тогтоомжид Германы нийтийн албан тушаалтнуудыг төвийг сахисан, нэгдмэл байх талаар заасан.

Холбооны бүх эрх бүхий байгууллага Холбооны захиргаанд Авлигаас урьдчилан сэргийлэх тухай Засгийн газрын удирдамжийг дагаж мөрдөнө.

Эстони

Эстони улс 2012 оны Авлигын төсөөллийн индекст 32-р байр эзэлсэн⁵⁹ нь хуучин социалист тогтолцоонд хамаарч байсан улсуудын хувьд хамгийн бага үзүүлэлт юм. 2010 онд НҮБ-ын Авлигын эсрэг конвенцид нэгдэн орж, нэгдэн орсон тухай баримт бичгийг ЕНБД-д хадгалуулсан байна.

Эрх зүйн гол эх сурвалж нь Гэмт хэргийн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Мөнгө угаах гэмт хэрэг болон Терроризмыг санхүүжүүлэхийн эсрэг хууль байна.

Гэмт хэргийн тухай хуулиар нийтийн албан тушаалтны идэвхтэй, идэвхгүй хэлбэрийн авлигыг гэмт хэрэгт тооцсон байна. Дараах үйлдлийг Гэмт хэргийн тухай хуулиар авлигын гэмт хэрэгт тооцсон байна. Үүнд:

А. Авлига авах⁶⁰

Аливаа этгээдийн тусын тулд эд хөрөнгө, ашиг авахаар тохиролцсон буюу хүлээн зөвшөөрч хариуд нь Албан тушаалын давуу байдлаа ашиглан хууль бус үйлдэл, эс үйлдэл хийх буюу тийм үйлдэл, эс үйлдэл хийх үндэслэлтэй этгээдэд 1-5 жилийн хорих ял оногдуулна. Энэ гэмт хэргийг

а) өмнө нь авлига авсан этгээд;

б) шахаж шаардах замаар авсан;

⁵⁹ Мөн тэнд.

⁶⁰ Гэмт хэргийн тухай хууль, 294-р зүйл.

с) бүлэглэн үйлдсэн их хэмжээгээр үйлдсэн;

д) онц ноцтой үр дагавартайгаар үйлдсэн бол 2-10 жил хүртэл хугацаагаар хорхи ял оногдуулна.

а) хэсэгт заасан гэмт хэргийг хуулийн этгээд үйлдсэн бол мөнгөн шийтгэл оногдуулна.

б) хэсэгт заасан гэмт хэргийг хуулийн этгээд үйлдсэн бол мөнгөн шийтгэл эсхүл албадан татан буулгах шийтгэл оногдуулна.

Энэ хэсэгт заасан гэмт хэрэгт шүүх хуулийн 83-р зүйлийн дагуу гэмт хэргийн замаар олсон орлого, эд хөрөнгийг хураана.

*Б. Авлига авахаар тохиролцох*⁶¹ - мөнгөн торгууль эсхүл 1 жил хүртэл хорих ял оногдуулна.

Энэ гэмт хэргийг өмнө нь авлига авахаар тохиролцож байсан этгээд үйлдсэн (давтан), албан тушаалын давуу байдлаа ашиглах байдлаар үйлдсэн бол мөнгөн шийтгэл эсхүл 3 жил хүртэл хугацаагаар хорих ял оногдуулна.

Г. Авлига өгөхөөр санаачлах

Авлига өгөхөөр санаачилсан бол мөнгөн шийтгэл эсхүл 1 жил хүртэл хугацаагаар хорих ял оногдуулна. Энэ гэмт хэргийг өмнө нь авлига авахаар тохиролцож байсан этгээд үйлдсэн; албан тушаалын давуу байдлаа ашиглаж үйлдсэн бол мөнгөн шийтгэл эсхүл 3 жил хүртэл хугацаагаар хорих ял оногдуулна. Хуулийн этгээд үйлдсэн бол мөнгөн шийтгэл оногдуулна.

Д. Авлига өгөх: Авлига өгсөн буюу өгөхөөр амласан бол 1-5 жилийн хугацаатай хорих ял оногдуулна. Энэ гэмт хэргийг

а) өмнө нь авлига өгч байсан этгээд үйлдсэн;

б) Бүлэглэн үйлдсэн;

с) Их хэмжээгээр өгсөн;

д) Онц ноцтой үр дагавартай бол 2-10 жилийн хугацаатай хорих ял оногдуулна.

а)-д заасан гэмт хэргийг хуулийн этгээд үйлдсэн бол мөнгөн шийтгэл оногдуулна.

б)-д заасан гэмт хэргийг хуулийн этгээд үйлдсэн бол мөнгөн шийтгэл эсхүл албадан татан буулгах шийтгэл оногдуулна.

Эстониин мэдээлэгчийг хамгаалах тухай хууль тогтоомж нь үндсэндээ нийтийн салбарт чиглэдэг. Нийтийн албан тушаалтан аливаа авлигын үйл ажиллагааны талаар мэдсэн бол байгууллагынхаа дарга, Аюулгүй байдлын Цагдаагийн зөвлөл, Прокурорын газарт мэдэгдэх үүрэгтэй⁶². Эрүүгийн шүүх хуралдаанд гэрчээр оролцох зайлшгүй шаардлагатайгаас бусад тохиолдолд нэрээ нууцлах эрхтэй.

⁶¹Гэмт хэргийн тухай хууль, 295-р зүйл

⁶²Авлигын эсрэг хууль, 23-р зүйл

Нэрээ нууцлах баталгаанаас өөр мэдээлэгчийг хамгаалах шууд зохицуулалт байхгүй. Мэдээлэгчийг өргөн хүрээнд хамгаалах заалт Авлигын эсрэг шинэ хуулийн төсөлд оруулахаар хэлэлцэж байна.

Хувийн болон ашгийн бус секторт авлигаас урьдчилан сэргийлэх ба ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, нийтийн салбарт ажиллагчдын авлигын эсрэг хандлага, ёс зүйг бэхжүүлэх гэсэн 2 хүрээнд авлигатай тэмцэх үндэсний стратеги боловсруулсан байдаг.

Хувийн сектор, өрсөлдөөний салбар дахь авлигаас урьдчилан сэргийлэх, аж ахуйн салбарт авлигын талаар ухамсар, ёс зүйг дээшлүүлэх, ашгийн бус салбарт авлигаас урьдчилан сэргийлэх гэсэн эхний шатны хүрээнд дараах арга хэмжээ авна. Үүнд:

Нэгдүгээрт, өрсөлдөөний гэмт хэрэгт эрүүгийн шүүн таслах ажиллагаа явуулах чадавхийг сайжруулах, авлигын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх. Энэ хүрээнд 1. Уян хатан хөтөлбөр боловсруулах, өрсөлдөөний гэмт хэргийг хянан шийдвэрлэх процессыг эхлүүлэх зарчмын талаар тохиролцох, процессийн ажиллагаа явуулах эрхтэй Өрсөлдөөний байгууллагын прокурор, албан хаагчдад зориулсан сургалт зохион байгуулах,

Хоёрдугаарт, ашгийн бус салбарт авлигын эрсдлийг бууруулах.

Энэ хүрээнд ашгийн бус байгууллагын санхүүжилтийн болон хэвлэн нийтлэх тогтолцооны талаар зөвшилцөх, ашгийн бус байгууллага улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжилт авахад тухайн байгууллага нь Ёс зүйн дүрэмтэй байх бөгөөд Ёс зүйн дүрэмтэйгээ нийцүүлэн шалгуурыг хангаж ажиллах.

Гуравдугаарт, Европын холбооны бүтцийн сангуудаас хүлээн авсан нөөцийг ашиглахад ашгийн бус байгууллага хяналт тавих. Энэ хүрээнд иргэний нийгмийг төлөөлж буй Засгийн газрын бус байгууллага бүтцийн шинжтэй туслалцаа үзүүлж байгаа тохиолдолд мониторинг хийхэд оролцох.

Дөрөвдүгээрт, бизнесийн салбарт авлигын талаар ухамсар, ёс зүйн түвшинг дээшлүүлэх.

Энэ хүрээнд мөрдөн шалгах сэтгүүл зүйг дэмжих зорилтын хүрээнд бизнес эрхлэгчдэд зориулсан цуврал семинар зохион байгуулах, тухайлбал, Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын авлигын эсрэг конвенцид туссан зарчмын талаар мэдээлэл өгөх гэх мэт, уян хатан хөтөлбөрөөр бизнес эрхлэгчдэд мэдээлэл өгөх, жишээлбэл, олон улсын бага хурал зохион байгуулах, сэтгүүлчдийг сургах, хэвлэл мэдээллийн салбар дахь авлигын асуудалд дүн шинжилгээ хийх, хувийн сектор дахь, авлига, залилан мэхлэх хэргийн тархацын талаар зураглал үйлдэх.

Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, нийтийн салбарт ажиллагчдын авлигын эсрэг хандлага, ёс зүйг бэхжүүлэх ажлын хүрээнд:

1. Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх;

1.1. Хориглох замаар ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх;

1.2. Гэм хорын талаар мэдээлэл хийх;

1.3. Эдийн засгийн ашиг сонирхлыг зарлах.

2. Ёс зүйн сургалт зохион байгуулах, судалгааны материал тараах

3. Нийтийн албаны ёс зүйн зөвлөлийн үйл ажиллагааг хүртээлжтэй явуулах.

Нэгдүгээрт, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх эрх зүйн орчин бий болгох.

Энэ хүрээнд ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх нэмэлт зохицуулалт, эдийн засгийн ашиг сонирхлыг зарлах талаар шинэ журам агуулсан Авлигын эсрэг хууль боловсруулах, эдийн засгийн ашиг сонирхлыг зарлах мэдээллийн сан бүрдүүлэх.

Хоёрдугаарт, нийтийн салбарт ажиллагсдын авлигын талаарх ухамсар, ёс зүйн түвшинг дээшлүүлэх. Энэ хүрээнд Эстони улсын нөхцөл байдалд суурилсан дүрс бичлэг нэмж оруулах, хэрэгт дүн шинжилгээ хийх, ашиг сонирхлын зөрчилтэй холбоотой хэргүүдийг нэмэх байдлаар мэдээллийн санг шинэчлэх.

Мөн тус улс дахь ашиг сонирхлын зөрчилтэй холбоотой гарын авлага боловсруулах, танилцуулах, түгээн тараах (korruptsioon.ee; avalikteenistus.ee;aktiva.ee зэрэг цахим хаягуудаар), нийтийн салбарт ажиллагсдын ялгаатай бүлгүүдэд ёс зүйн сургалт зохион байгуулах.

Гуравдугаарт, авлигын болон ёс зүйн талаар судалгаа хийх. Энэ хүрээнд Эстони улс дахь авлигын түвшингийн болон албан тушаалтны үүрэг, хандлагын талаар тодорхой давтамжит судалгаа хийх, нийтийн болон хувийн салбарын байгууллагыг зураглах байдлаар мэдээллэгчийг хамгаалах хэрэгцээ шаардлага, тохиромжтой байдлын талаар дүн шинжилгээ хийх.

Засгийн газрын 2011-2015 оны Үйл ажиллагааны хөтөлбөрт шинэ Авлигын эсрэг стратеги батлахаар тусгасны дагуу Эстонийн Засгийн газар 2013.10.03-ны өдөр Авлигын эсрэг стратеги хөтөлбөр (2013-2020)-ийг шинээр батлажээ⁶³. Энэ нь 2004-2008, 2008-2012 онуудад батлагдаж байсан өмнөх стратегүүдийн үргэлжлэл юм.

Үндсэндээ авлигын талаар олон нийтийн ухамсрыг дээшлүүлэх, нийтийн салбар дахь шийдвэр, үйл ажиллагааны ил тод байдлыг сайжруулах, авлигын хэргийг мөрдөн шалгах ажиллагааг дэмжих, чанаржуулахад голлон чиглэсэн байна. Стратеги нь бүтцийн хувьд удиртгал хэсэг, нэр томъёоны тодорхойлолт, нөхцөл байдлын талаарх судалгаа, зорилго, авах арга хэмжээ, стратегийг хэрэгжүүлэх, үнэлэх асуудал гэсэн нийт 7 хэсгээс бүрдэнэ.

Нөхцөл байдлын үнэлгээний хэсэгт зааснаар 2008 онд буюу стратеги хэрэгжиж эхлэхэд 274 авлигын хэрэг бүртгэгдэж байсан бол 2012 онд буюу стратеги хэрэгжиж дуусахад 161 авлигын хэрэг бүртгэгдсэн байна.

Боловсролын байгууллагад авлига өссөн үзүүлэлттэй гарсан. Бүртгэгдсэн гэмт хэргийн статистикаас харахад нэг этгээд хэдэн хэдэн удаа

⁶³ www.baltictimes.com/news/articles/33530/

авлигын хэрэг үйлдсэн байгаа нь мөрдөн шалгах байгууллагын чадавхи сул байгааг илэрхийлж байна. Стратегийн хүрээнд дараах зорилготой тавьжээ. Үүнд:

- Авлигын талаарх ухамсарыг сайжруулах;
- Шийдвэр, үйл ажиллагаан дахь ил тод байдлыг дэмжих;
- Мөрдөн шалгах байгууллагын чадавхийг хөгжүүлэх;
- Үндэсний аюулгүй байдлыг аюулд оруулж болох авлигын эрсдлээс урьдчилан сэргийлэх.

Стратегийг Эстони улсад олон улсын байгууллага (Авлигын эсрэг улсуудын бүлэг/ GRECO, Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага /OECD, НҮБ, Транспаренси Интернэшнл/-аас өгсөн үнэлгээ, зөвлөмж болон Эстони дахь авлигын асуудал: 3 зорилтот бүлгийн судалгаа”⁶⁴-ны үндсэн дээр үнэлжээ.

Америкийн Нэгдсэн улс

1970-аад оны үед Америкт төвтэй 500 орчим компаниуд гадаад орнуудын албан тушаалтнуудад авлига өгсөн нь илэрсэн нь 1977 онд АНУ-ын Конгрессийг Гадаад авлигын хуулийг батлахад хүргэжээ.⁶⁵

Энэхүү хууль нь авлигыг олон улсын түвшний асуудал болсныг анхлан гаргаж ирсэн. Америкийн авлигын эсрэг хууль тогтоомж 1990-ээд оны эхэн үед олон үндэстнийг хамарсан элемент агуулах болсон төдийгүй ерөнхийлөгч асан Билл Клинтон том гүрний бодлогоор дэлхийн бусад орнуудыг энэ загварын авлигын эсрэг хууль тогтоомж батлахыг, түүнчлэн Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагатай авлигын эсрэг үйл ажиллагаанд нягт хамтран ажиллахыг уриалах боллоо. НҮБ 1990-ээд оны эхэнд авлигын эсрэг үйл хэрэгт нэгдэж одоог хүртэл олон улсын авлигын эсрэг хурал чуулганыг тогтмол дэмжин ажиллаж байна.

АНУ-д хувийн болон нийтийн салбар дахь авлигатай хэрхэн үр дүнтэй тэмцэх талаар хоёр хандлага байна. *Мотивацийн стратеги* – энэ төрлийн гэмт хэрэг үйлдэх сэдлийг бууруулах.

Ситуацийн стратеги – авлига хөгжих орчин нөхцлийг хаахын тулд орчин нөхцлийг өөрчлөх.

Өдгөө зонхилж байгаа хоёр мотивацийн стратеги зонхилж байгаа нь авлигад хүлээлгэх хариуцлагыг нэмэгдүүлж, хууль ёсны үйл ажиллагааг урамшуулахад чиглэнэ.

- Авлигын хариуцлагыг нэмэгдүүлэх.

Авлига өгөх авахад хүлээлгэх хариуцлагыг өндөрсгөх арга нь уламжлалт ял шийтгэлийн онолд тулгуурласан хандлага юм. Авлигын хэмжээ их, хүлээлгэх хариуцлага түүнээс бага байх тохиолдолд ялын бодит ач холбогдол бага байна. Энэ тохиолдолд хүмүүсийн зан үйлд нөлөөлөх нөлөөлөл ямар байх нь ойгомжтой билээ.

⁶⁴ Эстонийн Хууль зүйн яамнаас хийдэг бодлогын судалгаа

⁶⁵Мөн тэнд.

Хэрэв зан үйлд нөлөөлөхийг зорьвол нэгэнт авлигын хэмжээнд нөлөөлж чадахгүй ч харин ял шийтгэлийг тодорхой, оновчтой үр нөлөөтэй, цээрлүүлэх хандлагатай болгож болно. Гэхдээ уламжлалт ял шийтгэлийн хандлагаар ял шийтгэлийг нэмэгдүүллээ гээд ялын үр нөлөө адил түвшинд нэмэгдэхгүй.

Үнэхээр хариуцлагыг нэмэгдүүлж авлигын гэмт хэргийг бууруулахын тулд зохицуулах, хянах чиг үүрэг бүхий агентлагийн эрх хэмжээ, хяналтын далайц, хүрээг нэмэгдүүлэх, олон нийтийн ил тод байдлыг бэхжүүлэх, төрийн байгууллагын бүхий л үйл ажиллагааг ерөнхийд нь нээлттэй болгох, хэвлэлийн эрх чөлөөг тунхаглах төдий биш бодитоор дэмжих зэрэг арга хэмжээг авсны дүнд бодит үр дүнд хүрч болно.

• Албан хаагчдын орчин нөхцлийг сайжруулах.

Ялангуяа төрийн албан хаагчдын цалин хөлс бага байдаг хөгжиж байгаа оронд төрийн албан хаагчдын цалин хөлсийг нэмэгдүүлэх нь авлигын хүрээ хязгаарыг багасгах ач холбогдолтой гэж үзсээр ирсэн билээ. Цалин, хөдөлмөрийн хөлс бага байдаг төрийн албан хаагч авлигад өртөмтгий байх нь төдий л гайхмаар хэрэг биш билээ.

Ажлын байрны нөхцөл, хөдөлмөрийн хөлсийг хэмжээгээр сайжруулах нь авлигын коэффициентийг бууруулахад чухал нөлөөтэй байх нь ойлгомжтой.

Гэвч тулгамдаж байгаа асуудал бол хөгжиж байгаа орнуудад цалин хөлс, ажиллах нөхцлийг өндөр түвшинд байлгах хангалттай нөөц баялаг дутагддаг.

Хэрэв тийм хэмжээний хөрөнгийг төрийн албан хаагчдын цалин хөлсөнд зарцуулбал гэмт хэрэгтэй ямар хөрөнгөөрөө тэмцэх билээ дээ? Ер нь харахад төр, компаниуд, иргэд зүгээр л зөв шалтгааны учир зөв үйлдлийг хийж байх нь хамгийн зохистой билээ.

Зүй ёс, шударга үнэн, тэгш байдал оршин тогтнох эсэх нь эцэстээ хүмүүс ямар нэг албадлагагүйгээр өөрийн ухамсраар эдгээр үнэт зүйлсийг өөрийн үйл ажиллагаандаа баримтлахаас хамаардаг. Бага орлоготой төрийн албан хаагчдын цалин хөлсийг нэмэгдүүлэх нь авлигаын хүрээ хязгаарыг багасгах ач холбогдолтой.

Авлигын гэмт хэрэгт холбогдсон хүмүүсийн зарим хэсэг нь баян чинээлэг, эд хөрөнгөтэй байх нь бий бөгөөд тэрхүү эд баялгаа өсгөн нэмэгдүүлэх, эрх мэдлээ өргөжүүлэхийн тулд ихэвчлэн гэмт хэрэг үйлдсэн байдаг.

Энэ төрлийн албан хаагчдын цалин хөлсийг хичнээн нэмэгдүүлээд авлигатай хийх тэмцэлд төдийлөн нөлөө үзүүлэхгүй гэдэг нь тодорхой. Эндээс гарч байгаа санаа бол төрийн албаны цалингийн цэсний доод шугаманд байгаа төрийн албан хаагчдын цалинг нэмэгдүүлэх нь авлигыг бүр мөсөн утгаж үгүй болгохгүй юмаа гэхэд бууруулах ач холбогдолтой байж болох талтай.

Дараагийн авч үзэх арга хэмжээнүүд нь ситуацийн страгеги байх ба энэ арга хэмжээ нь авлига цэцэглэн хөгжих боломжгүй орчин нөхцлийг бүрдүүлэхэд чиглэдэг.

Зүйрлэж хэлбэл намаг, шаврыг хатаах аргаар тэнд байгаа ялаа, шумуул зэрэг шавьжийг өсөн төлжих боломжийг таслан зогсоохтой адил юм.

Энэ стратеги нь хэд хэдэн талтай. 1/ Төрийн оролцоо өндөр байх /төрийн монополь/ нөхцөлд цөөн төрийн албан хаагч их хэмжээний нийтийн ажил үйлчилгээ, эд баялгийг ямар ч хяналтгүйгээр өөрийн дураар зарцуулах, эд хөрөнгө олж авах нөхцлийг бүрдүүлдэг.

Энэ нь зүгээр л олон нийтийг авлигад хөтлөж байгаа нөхцөл юм. Хэт нүсэр, ээдрээ төвөгтэй, ойлгомжгүй төрийн зохицуулалт нь төрийн албан хаагчдад шууд төрийн албан хаагчдад монополь давуу байдлыг олгож байдаг. Харин эсрэгээр нээлттэй ил тод байдалтай, шударга өрсөлдөөнтэй, үр дүнтэй, ухаалаг зохицуулалттай газар авлигын түвшин бага байна.

Ситуационал хандлагын авлигыг бууруулах өөр нэг стратеги бол өмнө дурдсанчлан засаглалын ардчилсан хэлбэрт чиглэх явдал юм. Ардчилал өндөр хөгжсөн газарт авлига орших боломж байдаг бөгөөд Монтинола, Джакман нарын 2002 онд явуулсан 66 орныг хамруулан явуулсан судалгаагаар ардчилсан дэглэмд шилжсэн орнуудад анх авлига өсөх хандлагатай байдаг байна. Энэ байдал ардчилал хөгжлийн шатандаа байгаа үед өндөр хэвээр үргэлжилбэл тухайн улсын ардчиллын төлөө хийсэн хүчин чармайлт талаар болох байдал ажиглагдсан байна.

Харин хэрэв ардчиллын хүчин чармайлт энэ байдлыг тэсвэрлэж үлдэж чадвал цаашид авлигаын түвшин цаг хугацааны эрхээр буурах хандлага ажиглагджээ. Эцэст нь хэлэхэд төрийн хэлбэр, байгуулал онц чухал биш, харин нээлттэй, ил тод байдал чухал.

II БҮЛЭГ. МОНГОЛ УЛС ДАХЬ АВЛИГА, АЛБАН ТУШААЛЫН ГЭМТ ХЭРГИЙН ШАЛТГААН, НӨХЦӨЛ

2.1. МОНГОЛ УЛС ДАХЬ АВЛИГА, АЛБАН ТУШААЛЫН ГЭМТ ХЭРГИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Дэлхийн улс орнууд авлига, албан тушаалын гэмт хэрэгтэй олон янзын арга замаар тэмцэж байна. Барууны ардчилсан орнууд төрийн албаны ёс зүйн дүрэм, ёс зүйн компанит ажил, сургалт, иргэдийн эрхийн тунхаглал болон засаг захиргааны нэгжийн түвшинд хяналтын ба тайлагнах механизмыг төлөвшүүлж, үйл ажиллагааг нь ил тод болгох зэрэг арга хэмжээ авч байна.

Монгол Улс авлигын эсрэг конвенцид нэгдэн орж, соёрхон баталсан, улмаар авлигын эсрэг хууль баталж, тусгайлан байгууллага байгуулж, нийтийн болон хувийн ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль гарган, олон талт хэлбэрээр авлигатай тэмцэж байгаагийн дүнд ахиц дэвшилд хүрч байна.

Авлига нь эрт дээр үеэс улбаатай, эртний зарим нэг улсын мөхөх гол шалтгааны нэг болсон байдаг. Авлига нь дээрэм, аллага зэрэгтэй адил дуулиан шуугианаар илэрхийлэгдэж айдас түгшүүр илэрхий төрүүлдэггүй боловч нам жим, нууц далд байдлаар нийгэмд хүрээгээ тэлж бүх салбарыг хамруулан хор хөнөөлөө түгээдэг аюултай үзэгдэл билээ. АТГ-ын сүүлийн 7 жилийн хугацаанд шалгасан албан тушаалын гэмт хэргийн улмаас 256.5 тэрбум төгрөгийн эд материалы хохирол учирч, түүний зөвхөн 6.6 хувийг нөхөн төлүүлжээ. Авлигад тодорхой хохирогч гэж байхгүй, түүний дам хохирогч нь нийгэм, төр байдаг, нийгэм нь хүмүүсийн олонлог учраас энэ нийгэмд амьдарч байгаа хүмүүс нийтээрээ авлигын гэмт хэргийн хохирогч болдог.

Хээл хахууль өгсөн, авсан хүмүүс нь аль алиныхаа эрх ашгийг гүйцэлдүүлсэн учраас илрэх магадлал маш бага байдаг нь энэ төрлийн гэмт хэрэг нуугдмал байх шалтгаан болдог. Авлига ийм байдлаар нийгэмд газар авч эхэлдэг бөгөөд ужгирвал түүний хор нөлөөнөөс ангид үлдэх нийгмийн салбар байдаггүй онцлогтой. Улс төр, эдийн засаг, оюун санааны бүх хүрээнд үүрлэж, тогтолцооны шинжтэй болсон авлига тухайн улсын үндэсний аюулгүй байдлын баталгааг алдагдуулах аюултай. Авлига улс төрийн хүрээнд үүрлэх нь улсын хөгжлийн бодлогыг алдагдуулж түүнээс үүдсэн бусад олон талын таагүй үр дагаврыг үүсгэдэг.⁶⁶

Авлигын хор хөнөөл нийгмийн оюун санааг хүчтэй хордуулж шударга ёсыг ганхуулдаг нь нэн хортой бөгөөд эргэж эрүүлжүүлэн сэргээхэд маш урт хугацаа, хүчин чармайлт шаарддаг. Нийгэмд авлига газар авч сэргэлэн ухаантай хүүхэд сургуульд сурч чадахгүй, эрдэм чадалтай хүн түүнийхээ ид хавыг үзүүлэх албан тушаалд томилогдох найдваргүй, ердийн амьжиргаандаа шаардагдах аливаа зөвшөөрөл, шийдвэрийг танил тал,

⁶⁶ Авлигын гэмт явдал. ХЗҮХ. УБ хот, 2010 он, 9 дэх тал

хээл хахуульгүйгээр хөөцөлдөөд нэмэргүй, өөрөөр хэлбэл, алхам тутамд нь авлига шаарддаг болсон бол нийгмийн гишүүд эхлээд цочирлон бухимдаж байснаа сүүлдээ энэ байдал даамжрахын хэрээр цөхөрч дасан зохицохоос өөр аргагүй байдалд хүрнэ.

Энэхүү дасан зохицох шатанд сайн муугийн тухай нийгмийн ёс суртахууны үнэлэмж өөрчлөгдөж, авлигадаж ажил бүтээхийг ердийн зүйлд тооцох, авлигачдыг нийгэмдээ сайн зохицон амьдарч чадаж байгаа сэргэлэн хүмүүс гэж даган дуурайх, шударга хүнийг тохуурхан гадуурхах зэрэг нь авлига хавтгайрсаны хожуу үеийн шинж тэмдэг юм.

Авлига хэмээх нь шударга бус аргаар, хууль зөрчиж өөрийн болон бусдын өмч хөрөнгийг арвижуулах арга гэгддэг. Авлигадах нь хээл хахууль авах, албаны нууцыг задруулах зэрэг хэлбэрээр илэрнэ. Монгол хэлний тайдбар тольд “ёсон бусаар шунаж авсан эд юм” хэмээн тайлбарласан байдаг.

Авлига гэж “Итгэж хүлээлгэсэн эрх мэдлийг хувийн ашиг хонжоо олоход урвуулан ашиглах явдал”⁶⁷ бөгөөд авлига нь хээл хахууль, шан харамжийн шинжтэй үйлдлүүдийг хамарсан өргөн хүрээтэй ойлголт. Өөрөөр хэлбэл, авлига гэдгийг төрийн болон хувийн хэвшлийн албан хаагч өөрт нь итгэж олгосон эрх хэмжээ буюу албан тушаалын байдлаа тухайн албаны эрх ашгийн эсрэг хувийн ашиг сонирхолдоо урвуулан ашиглаж хийвэл зохих үүргээс татгалзах, эсхүл хийхийг хориглосон үйлдлийг хийх зүй бус үзэгдлийг ойлгодог. Албан хаагч түүнд амласан, санал болгосон, эсхүл өгсөн буюу өгөхөөр амласан эдийн болон эдийн бус ашгийн нөлөөнд автан хариуцсан албаныхаа ашиг сонирхлыг худалдан урваж байгаа үйлдлийг авлига юм.

Өнөөгийн байдал: Авлигатай тэмцэх газрын 2013 оны судалгаанаас харахад авлигын индексийг 0.65, авлигын цар хүрээний нэгдсэн үзүүлэлт 0.74 гарч, шинжээчдийн төсөөллийн үнэлгээ 0.8 буюу олон нийт, шинжээчдийн төсөөллийн дунджаар тэдний 80 хувь нь Монгол Улсад авлига түгээмэл байна⁶⁸ гэжээ. Байдал ийм байхад жилд цөөн тооны авлигын хэргийг илрүүлэн шалгаж, хариуцлага тооцож байгаа нь энэ төрлийн гэмт хэрэг нуугдмал байна гэж үзэж болохоор байна.

Авлигатай тэмцэх газар нь хүний эрх, эрх чөлөөг дээдлэн, хуульч шуурхай ажиллагааг эрхэмлэж, авлигын гэмт хэргийн илрүүлэлт, мөрдөн байцаалтын үр дүнг нэмэгдүүлэх гэсэн үндсэн зорилтыг хэрэгжүүлэн үйл ажиллагаагаа явуулдаг. Гомдол, мэдээлэл хүлээн авах зааврын дагуу иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас тус газарт /амаар, бичгээр, шуудангаар, утсаар, интернетээр, биечлэн/ ирүүлсэн гомдол, мэдээллийг хүлээн авах, тэдэнд мэргэжлийн зөвлөгөө өгөх ажлыг гүйцэтгэдэг.


АТГ нь⁶⁹ Эрүүгийн хуулийн тусгай ангийн 263-р зүйл /Төрийн албан тушаалтан, албаны эрх мэдлээ урвуулах/, 264-р зүйл /Төрийн албан тушаалтан, албаны эрх мэдлээ хэтрүүлэх/, 265-р зүйл /Төрийн бус байгууллагын албан тушаалын байдлаа урвуулах/, 266 дүгээр зүйл /Төрийн бус байгууллагын албан тушаалын байдлаа хэтрүүлэх/, 268 дугаар зүйл

⁶⁷ Transparency international. Дэлхий нийтийн авлигын тайлан. 2007 он.

⁶⁸ АТГ-ын судалгааны тайлан, <http://iaac.mn/>-аас

⁶⁹ ЭБШХ-ийн 27 дугаар зүйлийн 27.3-д заалт

/Хээл хахууль авах/, 269 дүгээр зүйл /хээл хахууль өгөх/, 270 дугаар зүйл /Хээл хахуульд зуучлах/, 270¹ дүгээр зүйл /Хууль бусаар баяжих/, 273 дугаар зүйл /Төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах/ гэмт хэргийг харъяалан шалгадаг.



2013 онд Мөрдөн шалгах хэлтэст 970 гомдол, мэдээлэл хүлээн авснаас “Гомдол, мэдээллийн нэгдсэн бүртгэл”-д гэмт хэргийн шинжтэй 422 гомдол, мэдээлэл бүртгэгдсэн нь 2012 оны мөн үетэй харьцуулахад 18.2 хувиар өссөн⁷⁰.

Авлига, албан тушаалын гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийн агуулга нь:


- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасан журам;
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль;
- Төсвийн тухай хууль;
- Газрын болон Ашигт малтмалын талаарх хууль тогтоомж;
- Барилга байгууламж барих ашиглалтанд өгөх талаарх хууль тогтоомж;
- Албантушаал, ажилмэргэжил, сургууль зэргийн сонгон шалгаруулалтын журам;
- Тусгай зөвшөөрлийн талаарх хууль тогтоомжийг тус тус зөрчсөн;
- Санхүүгийн анхан шатны баримтыг хуурамчаар үйлдэх, хуурамч баримт бичиг үйлдэх, хуурамч гэрээ хэлцлээр халхавчлах;
- Бусдад давуу байдал бий болгосон, хясан боогдуулсан;
- Хээл, хахууль авах, өгөх;

⁷⁰www.iaac.mn, мэдээллийн хуудаснаас

- Хандив, буцалтгүй тусламжаар ирсэн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулсан, завшсан, үрэгдүүлсэн;
- Албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа ашиглан бусдын хөрөнгийг завшиж үрэгдүүлсэн буюу тийм бололцоог бусдад олгосон гэх үндэслэлүүд байна.

2013 онд урьд оны үлдэгдэл 5 гомдол, мэдээлэл, шинээр хүлээн авсан 422 нийт 427 гомдол, мэдээллийг шалгаж 58 гомдол, мэдээлэл буюу 13.5 хувьд эрүүгийн хэрэг үүсгэж, 176 гомдол, мэдээлэлд эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзах санал гаргаж 152 гомдол, мэдээлэл харьяаллын дагуу шилжүүлж, 6 гомдол мэдээллийг эрүүгийн хэрэг болон гомдол мэдээлэлд нэгтгэж шийдвэрлэсэн.

АТГ-аас шалгасан эрүүгийн хэрэг




АТГ-аас 2007-2013 онд нийт 2344 холбогдогчтой 1083 эрүүгийн хэрэг шалгажээ.


2007-2013 онд Мөрдөн байцаалт явуулсан эрүүгийн хэргүүдээс 287 буюу 26.5 хувийг яллах дүгнэлт үйлдүүлэхээр, 235 буюу 21.7 хувийг хэрэгсэхгүй болгох саналтайгаар, 186 буюу 17.2 хувийг харьяаллын дагуу шилжүүлж, 101 буюу 9.3 хувийг өөр эрүүгийн хэрэгт нэгтгэж, 44 буюу 4.1 хувийг Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 205 дугаар зүйлийг үндэслэн түдгэлзүүлж шийдвэрлэсэн бөгөөд 232 буюу 21.4 хувь нь ажиллагаанд

шалгагдаж байсан гэсэн статистик мэдээ гарчээ.

Эрүүгийн хэргийн шийдвэрлэлт. 2007-2013 он




Авлигатай тэмцэх газар 2008-2013 онд 237 холбогдогчтой 103 эрүүгийн хэргийг шалгаж, шүүхээр шийдвэрлүүлсэн байна⁷¹.




Шүүхээр шийдвэрлэгдсэн 237 хүний 36.3 хувь нь хорих, 19.8 хувь нь торгуулийн, 0.4 хувийг албадан ажил хийлгэх, 3.0 хувийг баривчлах ялаар тус тус шийтгэсэн ба 10.5 хувь нь өршөөлийн хуульд хамрагдсан, 11.0 хувь нь цагаатгасан, 13.1 хувийг ял тэнссэн, 4.6 хувийг эрүүгийн хариуцлагаас чөлөөлсөн байна.

⁷¹ АТГ-ын мэдээллээр




2007-2013 онд Эрүүгийн хэрэгт нийт 2344 хүн сэжигтэн, яллагдагчаар татагдан шалгагдсан (2013 онд өмнөх оны мөн үетэй харьцуулахад 36.5 хувиар өссөн байх) бөгөөд холбогдогчдыг албан тушаалын байдлаар авч үзвэл төрийн улс төрийн 7.2 хувь, төрийн захиргааны 19.8 хувь, төрийн тусгай 14.6 хувь, төрийн үйлчилгээний 14.2 хувь, энгийн буюу аж ахуйн нэгж, байгууллагын албан тушаалтан 43.0 хувийг эзэлжээ.


Эрүүгийн хэрэгт холбогдогчдын албан тушаалын ангилал. 2007-2013 он



Гэмт хэрэгт холбогдсон этгээдийн албан тушаалын онцлогийг доорх байдлаар үзүүлэв.




2007-2013 онд шалгасан эрүүгийн хэргийн зүйлчлэл /Шалгасан хэргийн төрөл/



АТГ-аас ЭБШХ-ийн 26, 27 дугаар зүйлд заасан харьяаллын дагуу дээрх эрүүгийн хэргийг шалгажээ. АТГ-аас шалгасан эрүүгийн хэрэг, Бүртгэгдсэн⁷² Албан тушаалын гэмт хэргийн харьцуулалт

⁷² ЦЕГ-ын Мэдээлэл, судалгааны төвийн мэдээллээр



Үндэсний статистикийн хорооноос зөвшөөрсөний дагуу ХЗДХЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2010.01.01-ний өдрийн 01 тоот тушаалаар батлагдсан “Гэмт хэргийн тоо бүртгэлийн маягт, гэмт хэргийн статистик мэдээний маягт”, “Гэмт хэргийн тоо бүртгэлийн маягт нөхөх заавар”, ЦЕГ-ын даргын 2009.12.24-ний 636 дугаар тушаалаар батлагдсан “Монгол Улсад бүртгэгдсэн гэмт хэргийн тоо бүртгэлийн заавар”-ын дагуу Монгол Улсад бүртгэгдсэн албан тушаалын гэмт хэргийг ЦЕГ-ын Мэдээлэл, судалгааны төв дээр нэгтгэн төвлөрүүлж, улсын хэмжээний статистик мэдээ гардаг. Бүртгэгдсэн гэмт хэрэг, шалгасан эрүүгийн хэрэг зарчмын хувьд зөрүүтэй гарсан байна.

АТГ, ТЕГ, ЦЕГ, Улсын ерөнхий прокурорын дэргэдэх Мөрдөн байцаах албаны даргын хамтарсан 2010.04.28-ны 43/223/82/21 тоот тушаалаар баталсан “Гэмт хэргийн тоо бүртгэлийн маягтыг нөхөх, мэдээллийн санд оруулах журам” мөрдөгдөж байна. Энэхүү журмаар АТГ, ТЕГ, УЕП-ын дэргэдэх Мөрдөн байцаах албанд шалгагдаж буй эрүүгийн хэргийг Монгол Улсын хэмжээний гэмт хэргийн тоо бүртгэлд оруулах, улмаар Үндэсний статистикийн хороонд хүргэгддэг, улсын хэмжээний албан ёсны статистик мэдээнд тусдаг юм. Иймд эдгээр байгууллагууд бүртгэгдсэн гэмт хэргээ ЦЕГ-ын мэдээллийн санд тухай бүр цаг хугацаанд оруулах шаардлага байна.

Прокурорын байгууллагын судалгаа:


АТГ-ын шалгасан албан тушаалын гэмт хэрэгт Нийслэлийн прокурорын газраас харъяалан хяналт тавьдаг байсныг 2014 оноос эхлэн өөрчилж орон нутгийн прокурор хяналт тавьдаг болсон. Сүүлийн 3 жилийн байдлаар Нийслэлийн прокурорын газраас хяналт тавьсан албан тушаалын гэмт хэргээс прокурор яллах дүгнэлт үйлдэж шүүхэд шилжүүлсэн болон хэрэгсэхгүй болгосон хэргийг судалж үзэхэд Нийслэлийн прокурорын газар албан тушаалын гэмт хэргээс эрүү үүсгэн шалгасан 114 хэргийг хуульд заасан үндэслэлээр хэрэгсэхгүй болгож, 61 хэрэгт яллах дүгнэлт үйлдэн шүүхэд шилжүүлжээ.

Дээрх судалгаанаас үзэхэд сүүлийн 3 жилд хяналт тавьж, хэрэгсэхгүй болгосон албан тушаалын гэмт хэргийн тоо яллах дүгнэлт үйлдэж шүүхэд

шилжүүлсэн хэргийнхээ тооноос 1.9 дахин их байгаа нь хэдийгээр хэргийг хуульд заасан үндэслэлээр хэрэгсэхгүй болгосон ч гэсэн тухайн хэргийг бүрэн гүйцэд илрүүлж шалгах талаар ямар ч алдаа дутагдалгүй ажилласан гэж хэлэх үндэслэл төдийлөн байхгүй гэж үзэж болно.

Монгол Улсын хэмжээнд 2013 онд хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулсан 108380 хэргийн 518 буюу 0,4 хувь нь авлига, албан тушаалын гэмт хэрэг байх бөгөөд үүний 96 буюу 18,4 %-д яллах дүгнэлт үйлдүүлсэн, 66,9 хувийг хэрэгсэхгүй болгожээ. Эдгээр хэргийн улмаас 40 гаруй тэрбум төгрөгийн шууд хохирол учирсанаас мөрдөн байцаалтын явцад 2.5 тэрбум төгрөгийг нөхөн төлүүлсэн, 15.2 тэрбум төгрөгийн эд хөрөнгийг битүүмжилсэн байна.

Улсын Дээд Шүүхийн Судалгааны төвийн мэдээллээр⁷³ авлига, албан тушаалын анхан шатны шүүхээр шийдвэрлэгдсэн байдлыг авч үзье. Доорх графикаас харахад авлига, албан тушаалын гэмт хэргийн шүүхээр шийдвэрлэлт нэмэгдэх хандлага байна.



2013 онд яллах дүгнэлт үйлдүүлэхээр шилжүүлсэн 33 шүүгдэгчид холбогдох 11 хэрэг шүүхээр шийдвэрлэгдэж 26 шүүгдэгчийг гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцон 12 шүүгдэгчийг хорих ялаар, 5 шүүгдэгчийг торгох ялаар, 1 шүүгдэгчийг баривчлах ялаар, 2 шүүгдэгчийг тодорхой ажил, албан тушаал эрхлэх нэмэгдэл ялаар шийтгэж, хорих ял оногдуулсан 8 шүүгдэгчийн ялыг тэнссэн. Харин 7 шүүгдэгчид холбогдох 2 хэргийг хэрэгсэхгүй болгожээ.

Авлига, албан тушаалын гэмт хэргийн өнөөгийн байдал дээрх байдлаар илэрхийлэгдэн гарч байна. Мөн авлигын индексийн судалгаагаар авлига, албан тушаалын гэмт хэргийн өнөөгийн нөхцөл байдал харагдаж байна. Энэ төрлийн гэмт хэргийн илрүүлэлт, шийдвэрлэлт хангалтгүй байгаа цаашид энэ төрлийн гэмт хэргийн илрүүлэлт, шийдвэрлэлт нэмэгдэх судалгаанаас дүгнэгдэж байна.

⁷³ 2013 оны мэдээлэл Шүүхийн ерөнхий зөвлөлийн мэдээллээр

2.2. АВЛИГА, АЛБАН ТУШААЛЫН ГЭМТ ХЭРГИЙН ШАЛТГААН, НӨХЦӨЛ

Авлига, албан тушаалын гэмт хэргийн шалтгааныг авч үзэхийн тулд “шалтгаан”, “нөхцөл”, “нөхцөл байдал”, “хүчин зүйл”⁷⁴ гэсэн ойлголтыг авч үзье. Шалтгаан бол үр дагавар буюу үйлдлийг төрүүлдэг. Шалтгаан, нөхцөл хоёрыг тодорхой үзэгдлийн хувьд авч үзвэл нэг төрлийн ойлголт биш, эсрэг тэсрэг ойлголт ч биш юм. Шалтгаан, нөхцөл хоёрын хооронд давхцаж байгаа шинж байхын зэрэгцээ ялгаа заавал байдаг. Гэмт явдлын шалтгаанд түүнийг бий болоход хүргэсэн нийгмийн үзэгдэл, үйл явцууд хамаардаг байна.⁷⁵

Шалтгаан, нөхцөлийг судлахын зэрэгцээ “хүчин зүйл” гэсэн ойлголт бий. Хүчин зүйл бол гэмт явдлын гаралтад эерэг болон сөрөг нөлөө үзүүлж болно. Гэмт явдлын гаралтад нөлөөлөх нөхцөл байдал нь шалтгаан, нөхцөл, хүчин зүйл хэмээх ойлголтуудаас өөр бөгөөд гэмт хэрэг үйлдэхэд нөхцөлдүүлсэн тодорхой тохироог хэлдэг байна. Иймд гэмт явдлын шалтгааны түгээмэл шинжийн тухай авч үзэхээс, тодорхой нэг тохиолдлын тухай ярих боломжгүй юм. Гэмт явдлын шалтгааныг ерөнхий ба тодорхой шалтгаан гэж ангилдаг.

Сүүлийн 10 жилийн судалгаагаар 200 мянган гэмт хэрэг үйлдэгдэж, 16 мянган хүн нас барсан, 75 мянган хүн эрүүл мэндээрээ хохирч, нийт 380 тэрбум төгрөгийн хохирол төр засаг, иргэдэд учирсан. Криминологийн онолын ойлголтод үндэслэн, улс орны нийгэм, эдийн засаг, ялангуяа гэмт хэрэг, захиргааны зөрчлийн статистик мэдээлэл, судалгаа, тайлан, бусад баримтад түшиглэн Монгол Улс дахь гэмт явдлын шалтгааныг *ерөнхий болон тодорхой шалтгаан нөхцөл* гэж доор байдлаар бүлэглэн, авч үзэж болох юм⁷⁶.

⁷⁴ Н.Жанцан, Криминологи, 50-р тал

⁷⁵ Н.Жанцан, Криминологи, УБ хот, 2004 он, 44-46-р тал

⁷⁶ ЦЕГ-ын МСТ, Монгол Улс дахь 2010 оны гэмт хэргийн байдал, шалтгаан нөхцөл, 2011, 89-р тал

Нэг. Ерөнхий шалтгаан нөхцөлд:

1. Ажилгүйдэл
2. Хүн амын төвлөрөл их
3. Ядуурал, орлогын эх үүсвэргүй, амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой иргэд их байна
4. Архидан согтуурал, согтууруулах ундааны үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ хэтэрхий их, хяналтгүй байгаа байдал
5. Шударга бус байдал газар авсан
6. Хууль тогтоомжийн хэрэгжилт хангалтгүй
7. Нийгмийн үнэт зүйлсийн үнэлэмж өөрчлөгдсөн
8. Оюун санааны эрх чөлөө нь ёс суртахууны доголдолд хүргэсэн
9. Миний эрх гэх боловч бусдын эрхийг үл хүндэтгэх байдал нийтлэг болсон
10. Амар хялбар аргаар мөнгө олж амьдрах хүсэл эрмэлзэл
11. Иргэдийн эрх зүйн боловсрол, мэдлэг дутмаг
12. Аливаа асуудлыг хурдан, амар хялбар аргаар хууль бусаар шийдвэрлэх хандлагад бий болсон
13. Хүмүүсийн стресс бухимдал их болсон
14. Байгалийн баялаг дагаж, ашигт малтмалын хайгуул хийх, олборлох, ашиглах үйл ажиллагаа идэвхижсэн
15. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын үр дүн, түүний үнэлэмж хангалтгүй
16. Гэмт хэрэг үйлдэгдэж болзошгүй газрууд, орон гэргүй, тэнэмэл иргэдэд төрийн захиргааны байгууллагаас тавих халамж, дэмжлэг туслалцаа дутмаг
17. Хууль тогтоомжийг сурталчлах, мэдээлэх, таниулах ажил хангалтгүй
18. Галт зэвсгийн бүртгэл, ашиглалтад тавих хяналт сул
19. Хорихоос суллагдсан хүмүүсийг нийгэмшүүлэх тогтолцоо байхгүй
20. Бүртгэл, хяналтын нэгдсэн тогтолцоо байхгүй
21. Төрийн байгууллагуудын дотоодын хяналт, шалгалт суларсан
22. Хэвлэлийн эрх чөлөө, хууль бус зар сурталчилгаа
23. Даяаршил, ялангуяа мэдээллийн нээлттэй байдал, хүртээмж сайжирсан
24. Аялал жуулчлал хөгжиж, хүмүүсийн хөдөлгөөн идэвхижсэн
25. Нийгэм дэх нээлттэй байдлыг дагасан сөрөг зан үйл
26. Инфляци, мөнгөний ханш уналт

Хоёр. Тодорхой шалтгаан нөхцөлд:

1. Хувь хүний ухамсар, ёс зүйн төлөвшил
2. Хүмүүжлийн доголдол
3. Хар амиа хичээх үзэл
4. Хүмүүс бие биеэ үл хүндэтгэх байдал
5. Өшөө хонзон, атаа жөтөө
6. Дээрэнгүй зан авир
7. Бусдын нөлөөнд автах
8. Гэр бүлийн хүчирхийлэл
9. Хүүхдэд тавих анхаарал, халамж сул
10. Нийгэм, хамт олон, гэр бүлийн өмнө хүлээх үүрэг, хариуцлагаа ухамсарладаггүй
11. Иргэдийн сонор сэрэмж, анхаарал болгоомжгүй байдал
12. Эд хөрөнгийн хадгалалт, хамгаалалт муу
13. Малаа хариулга, маллагаагүй орхих
14. Бараа, бүтээгдэхүүн, түүхий эдийн үнийн өсөлт
15. Жолоочийн ур чадвар, хууль, дүрмийн мэдлэг муу
16. Замын хөдөлгөөнд оролцогчдын хууль, дүрмээ баримтлах, хэрэгжүүлэх явдал хангалтгүй
17. Замын орчин, нөхцөл стандартын шаардлага хангаагүй
18. Тээврийн хэрэгслийн тооны өсөлт, замын багтаамж, нэвтрүүлэх чадвар муу
19. Бүрэн бус тээврийн хэрэгсэл
20. Бэлгийн гаж зуршил, сонирхол
21. Хохирогчийн буруутай үйлдэл
22. Биеэ хамгаалах чадваргүй байдал
23. Садар самуун явдал, биеэ үнэлэлт
24. Хил, гаалийн хяналт шалгалт сул
25. Хувь хүний стресс, уур бухимдал
26. Интернэт өдөр тутмын хэрэглээ болсон

Монгол Улс дахь гэмт явдлын гаралтад сөргөөр нөлөөлж буй зарим хүчин зүйлсийн нэг болох шударга бус байдал, албан тушаалын гэмт хэргийн шалтгаан нөхцөлийн талаар дурьдая.

Шударга бус байдал: Нийгэмд шударга бус явдал түгээмэл болж, төрийн болон хувийн хэвшил, нийгмийн харилцаанд бүхэлдээ шударга бус байдлыг хүлээн зөвшөөрөх хандлага бий болжээ. Хүмүүс албандаа

эзний ёсоор хандах, албан үүргээ шударгаар хийж гүйцэтгэхээсээ илүүтэй тухайн албан тушаалын давуу байдлыг ашиглан, хөрөнгөжих тухай бодож, зөвхөн мөнгөний төлөө амьдрах сэтгэхүй давамгайлах болсон нь хууль бус үйлдлийн өдөөгч хүчин зүйл болж байна.

Авлигын эсрэг хуулийн 18.1.3-т заасны дагуу Монгол Улсын Авлигатай тэмцэх газар (АТГ) авлигын хэлбэр, цар хүрээ, шалтгааныг 2 жил тутам судлан авлигын индексийг тооцон олон нийтэд мэдээлэх чиг үүргийг хэрэгжүүлдэг.

“Авлигын индекс” гэдэгт тодорхой нутаг дэвсгэр (аймаг, нийслэл), төрийн захиргааны байгууллага (яам, агентлаг) дахь авлигын цар хүрээ, хэлбэр, шалтгааныг тодорхойлох тоон болон чанарын үзүүлэлтүүдийн нийлбэр цогц бөгөөд тухайн байгууллагын авилгын эрсдэлийн үнэлгээг хийхдээ: олон нийт, шинжээчдийн төсөөллийн судалгаа болон байгууллагын авлигын эрсдлийн үнэлгээний судалгааг явуулж дүнг нэгтгэх, мэдээллийг холбогдох хууль хяналтын байгууллага болон АТГ-ын холбогдох хэлтсээс хүлээн авч баримтын судалгааг хийх; холбогдох мэдээллийг шалгаж нэгтгэн, авлигын цар хүрээ, хэлбэрийн үзүүлэлтүүдийг тооцох; авлигын цар хүрээ, хэлбэрийн нэгдсэн үзүүлэлтүүдийг тооцох; авлигад нөлөөлж буй шалтгааныг тодорхойлох; авлигын индексийн өөрчлөлт, бүрэлдэхүүн хэсэгт дүн шинжилгээ хийх зэргээр авлигын цар хүрээ, хэлбэрийн үзүүлэлтүүдийг нэгтгэн авлигын индексийг тооцдог.

Монгол Улсын 21 аймаг, нийслэл, 330 сум, 9 дүүргийн оршин суугчдыг төлөөлсөн 4000 иргэд, бизнес эрхлэгчид; төрийн захиргааны болон нутгийн захиргаа, өөрөө удирдах байгууллагын ажилтан, албан хаагчдыг төлөөлсөн төрийн 2000 албан хаагч; төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллага, хувийн хэвшил зэрэг холбогдох бүх төлөөллийн 352 шинжээчдийн буюу нийт 6352 хүний үзэл бодлыг тусгасан байна.

Авлигыг 0 (авлигад автсан)-ээс 1 (огт авлигагүй) хүртэлх тоон үзүүлэлтээр илэрхийлдэг. Өөрөөр хэлбэл, авлигын индекс⁷⁷ нь 0-1 хүртэлх утгыг авах бөгөөд индексийн утга 1-д ойртох тусам авлига багасч байна гэж үздэг. Монгол Улсын Авлигын индекс 2013 оны байдлаар 0.65 гарсан нь 2011 оныхоос 0.02 пунктээр өссөн эерэг дүнтэй гарсан ч өндөр байна. Өөрөөр хэлбэл, шударга бус байдлын түвшинг илэрхийлж байна.

2013 оны судалгаанаас харахад шинжээчдийн төсөөллийн үнэлгээ 0.8 буюу олон нийт, шинжээчдийн төсөөллийн дунджаар тэдний 80 хувь нь Монгол Улсад авлига түгээмэл байна⁷⁸ гэжээ. Байдал ийм байхад жилд маш цөөн тооны авлигын гэмт хэргийг илрүүлэн шалгаж, хариуцлага тооцож байгаа нь энэ төрлийн гэмт хэрэг нуугдмал байна гэж үзэж болохоор байна.

Авлигын түвшин өндөр байгаа нь төрийн үйл ажиллагаа нь улс төрийн намын нөлөөнөөс ихээхэн хамааралтай, томилгоог улс төрийн намын нөлөөгөөр мэдлэг, чадвар, туршлагыг үл харгалзан албан хаагчдыг томилдгоос ажилдаа хариуцлагагүй хандах, хүнд суртал гарган, хээл хахуулиар асуудлыг шийдвэрлэх, тэр хэмжээгээр авлигатай тэмцэх үйл

⁷⁷ Авлига хэмээх сөрөг үзэгдлийн цар хүрээ, хэлбэр, шалтгааныг тодорхойлох тоон болон чанарын үзүүлэлтүүдийн нийлбэр цогцыг авлигын индекс гэж ойлгоно.

⁷⁸ АТГ-ын судалгааны тайлан, <http://iaac.mn/-aac>

ажиллагаа нь үр ашиггүй болж, шагнал урамшуулал, томилгоо нь бодитой бус байдаг нь авлигын түвшин өсөх шалтгаан болж байна гэж дүгнэжээ.

Иргэд, олон нийт, төрийн бус байгууллагаас төрийн холбогдох албан тушаалтан, байгууллагуудад хандаж тодорхой асуудлаар шүүмжлэлтэй хандаж байгаа нь сайшаалтай. Гэвч улс төр, хувь хүн, бүлэг хүмүүс, байгууллагын эрх ашиг, сонирхлоос үүдсэн шударга бус байдал, хийрхэл, нэг нэгэндээ сайн хүн болох гэсэн шаардлагууд гарч байгаа нь нийгмийг бухимдуулж байна. Сонгуулийг угтсан жагсаал цуглаан, сургалт, сурталчилгаа, хурал зөвлөгөөн хийх, мөн нэгнийгээ гүтгэсэн, доромжилсон, “өөрийгөө зөвтгөж, бусдыг буруутгасан” зүй зохисгүй үйлдлүүд байсаар байна. Энэ нь улс орныг, иргэдийг шударга, эвтэй байх нөхцөлийг алдагдуулж “улс төржсөн иргэдтэй улс” болоход хүргэж байна.

Авлигын индексийн судалгааны Шинжээчдийн болон Олон нийтийн төсөөллийн судалгаанд оролцогч шинжээч, иргэд, төрийн албан хаагч, бизнес эрхлэгчдээс Монгол Улсад авлига үүсгэж буй шалтгаан нөхцөлийг асуухад дараах шалтгааныг гол гэж нэрлэсэн байна⁷⁹. Авлигын шалтгаан нөхцөл, шинжээчдийн болон олон нийтийн төсөөллийн судалгаа /хамгийн их нэрлэсэн шалтгаан нөхцөлөөр/

Шинжээч	Иргэд	Төрийн албан хаагч	Бизнес эрхлэгч
Улс төрийн нөлөө их	Улс төрийн нөлөө их	Улс төрийн нөлөө их	Улс төрийн нөлөө их
Ашиг сонирхлын зөрчил их	Ашиг сонирхлын зөрчил их	Ашиг сонирхлын зөрчил их	Ашиг сонирхлын зөрчил их
Төрийн албан хаагчдын цалин, орлого бага	Цалин, орлого бага	Төрийн албан хаагчдын цалин, орлого бага	Цалин, орлого бага
Эрх зүйн зохицуулалт, хуулийн хэрэгжилт сул	Эрх зүйн зохицуулалт, хуулийн хэрэгжилт сул	Эрх зүйн зохицуулалт, хуулийн хэрэгжилт сул	Эрх зүйн зохицуулалт, хуулийн хэрэгжилт сул
Хүмүүсийн сэтгэлгээ, ухамсрын түвшин муу, ёс зүйгүй байдал	Ажлаа хурдан бүтээхийн тулд	Хүмүүсийн сэтгэлгээ, ухамсрын түвшин муу, ёс зүйгүй байдал	Хүмүүсийн сэтгэлгээ, ухамсрын түвшин муу, ёс зүйгүй байдал
Хариуцлага тооцдоггүй, хөндлөнгийн хяналт сул	Ажилгүйдэл, ядуурал	Ажилгүйдэл, ядуурал	Төрийн үйлчилгээний хүртээмж муу

Шинжээч, иргэд, төрийн албан хаагч, бизнес эрхлэгчдийн үзсэнээр улс төрийн нөлөө их, ашиг сонирхлын зөрчил үүсэх магадлал өндөр, төрийн албан хаагчдын цалин, орлого бага, эрх зүйн зохицуулалт, хуулийн хэрэгжилт сул байгаа нь Монгол Улсад авлига үүсэхэд хамгийн ихээр нөлөөлж буй гол шалтгаан гэж дүгнэж болохоор байна.

Түүнчлэн шинжээч, төрийн албан хаагч, бизнес эрхлэгчдийн үзэж байгаагаар хүмүүсийн сэтгэлгээ, ухамсрын түвшин муу, ёс зүйгүй байдал нь авлига үүсэх шалтгааны бас нэг гол нөхцөл болохыг харууллаа. Авлига үүсэхэд хамгийн ихээр нөлөөлж буй шалтгааныг шинжээчид хариуцлага

⁷⁹Авлигын индексийн 2013 оны судалгааны тайлан, www.iaac.mn

тооцдоггүй, хөндлөнгийн хяналт сул явдал гэж дүгнэсэн.

Харин иргэд, төрийн албан хаагчид ажилгүйдэл болон ядуурал, бизнес эрхлэгчид төрийн үйлчилгээний хүртээмж муу байгаа нь авлига үүсэх шалтгаан болж байна гэж үзсэн байна.

Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд заасан бүтцийн дагуу Засгийн газрын гишүүдийн эрхлэх асуудлын хүрээний салбарын авлигад өртөх эрсдэл, авлигын индексийг тооцон гаргажээ. Авлигын индекс болон авлигад өртөх эрсдэл /Засгийн газрын гишүүдийн эрхлэх асуудлын хүрээгээр, 2013 онд/



2013 оны байдлаар Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын (0.44), Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын эрхлэх асуудлын (0.42), Үйлдвэр, хөдөө аж ахуйн эрхлэх асуудлын (0.38), Барилга, хот байгуулалтын сайдын эрхлэх асуудлын (0.38), Зам, тээврийн сайдын эрхлэх асуудлын (0.37) салбарууд авлигад өртөх эрсдэл өндөртэй гарчээ.

Хөдөлмөрийн сайдын эрхлэх асуудлын (0.28), Гадаад харилцааны сайдын эрхлэх асуудлын болон Хууль зүйн сайдын эрхлэх асуудлын салбарууд тус бүр (0.30), Эрчим хүчний сайдын болон Эдийн засгийн хөгжлийн сайдын эрхлэх асуудлын салбарууд тус бүр (0.32) үнэлгээ авсан нь бусад салбартай харьцуулахад авлигад өртөх эрсдэл бага байгааг судалгааны дүн харуулж байна.

Мөн нийгмийн ёс суртахууны төлөвшил, хувь хүний хүмүүжил, хүнлэг харилцаа хөндөгдөнө. Хувь хүний зөв хүмүүжил, хүнлэг зан төлөв гээгдэж, нийгмийн бүхий л харилцаанд хууль зөрчих явдал түгээмэл болж, хүмүүсийн ухамсар, сэтгэхүйд хууль бусаар хөлжих, амар, хялбар аргаар амь зуух сэтгэлгээ төлөвшиж байгаа нь гэмт явдлын шалтгаан болж байна.

Иргэд эрх чөлөөт байдлыг дураар авирлах гэж ойлгон, нийгмийн өмнө хүлээх үүрэг, хариуцлагаа ухамсарлахгүй байна. Хууль тогтоомжийг иргэдийн олонх нь үл ойшоох хандлага бий болжээ.

Хүн амын, ялангуяа хүүхэд, залуучуудын боловсрол, хүмүүжил, эрүүл мэндэд анхаарч, ажил, мэргэжилтэй болгохын зэрэгцээ төрийн хууль тогтоомжийг хүндэтгэн, дагаж биелүүлэхухамсар, сэтгэлгээтэй “зөв хүн”

болгон төлөвшүүлэхэд төрийн оролцоог нэмэгдүүлэх хэрэгтэй байна.

Өнгөрсөн хугацаанд төр, засгаас авлигатай тэмцэх зорилгоор удаа дараа хууль болон бодлогын бусад баримт бичиг батлан гаргаж, хэрэгжүүлж ирсэн нь зарим үр дүнгээ өгч байна. Тухайлбал, олон улсын *Transparency International* байгууллагаас тогтмол гаргадаг *Corruption Perception Index* 2013 оны байдлаар Монгол Улсыг авлигын түвшингээр 180 гаруй улсаас 83-д орсон нь анхаарал татаж байна. 2011 онд 120-р байрт орж байсан бол 2013 онд 83-р байрт орж, амжилтаа ахиулжээ.



Авлигын төрөл, хэлбэр нь олон янз бөгөөд хээл хахууль, шан харамж, бэлэг, ах дүүс, найзархаг харьцаа, зүй бусаар тал өгөх, хөнгөлөлт үзүүлэх, авлигын лоббизм, протекционизм, фаворотизм, улс төрийн зорилгоор нууц хандив цуглуулах, албан тушаал амлаж сонгуульд хандив цуглуулах, өмч хувьчлал, дуудлага худалдаа, үнэт цаасны зах зээл дэх луйвар, үндэслэлгүй гаалийн болон татварын хөнгөлөлт үзүүлэх зэрэг урьдчилан төлөвлөгдөж зохион байгуулагдсан хор уршгаар их хэлбэрүүд тархмал байна.

Авлигын шинжтэй гэмт хэрэг нь хээл хахууль авах, өгөх, зуучлах, эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулан ашиглах, эрх мэдлээ хэтрүүлэх, түүнчлэн бизнесийн хүрээний авилга зэрэг олон хэлбэртэй.

Авлига, албан тушаал, хүнд суртал, ил тод байдлын талаар нэлээд олон тоонысудалгааны ажлууд хийгдсэн байдаг. Монгол Улсын авлигын талаар дараах төсөөлөл хийж болохоор байна.

- Авилга төрийн албаны бүхий л салаа мөчирт өргөн тархасны дотор улс төрийн хүрээнд, ялангуяа улс төрөөр дамжин төрийн өндөр албан тушаалд хүрэгсэдийн дунд авлига цэцэглэсэн байна.

- Улс төрийн хүрээн дэх бизнесийн бүлэглэлийн ашиг сонирхлын зөрчил, сонгуулийн болон намын санхүүжилт, сонгуулийн тогтолцооны авлигад үзүүлэх нөлөө маш хүчтэй хэвээр байна.

- Төрийн үйл ажиллагааны хараат бус байдал алдагдаж улс төрийн

намуудаас хараат болсны гадна “төр данхайж”, улсын төсөвт захиргааны гэгдэх зардлын эзлэх хэмжээ, хувийн жин өсөн нэмэгдэхийн хэрээр төрийн байгууллагын үйл ажиллагааны ил тод байдал алдагдаж, иргэдэд үзүүлэх үйлчилгээний чанар улам муудаж байна. Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачлан эхлүүлж буй Ухаалаг төрийн үзэл баримтлалтай уялдуулан авч үзэх нь зүйтэй.

- Олон нийт улс төрийн намын дараа авлигад хамгийн ихээр автсан байгууллагаар цагдаа, газрын алба, шүүх, мэргэжлийн хяналт, татвар зэрэг байгууллагыг ээлжлэн нэрлэж байна.

- Олон нийт авлига авах олон арга, хэлбэрийг судалгаанд дурдсан боловч эдгээрээс ямар нэг зөвшөөрөл олгох, төрийн албанд ажилд орох, тендерт оролцох буюу төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа, үйлчилгээ худалдан авах сонгон шалгаруулалтыг онцлон нэрлэсэн байна.

- Авлигыг “ажлаа хурдан бүтээх чухал хэрэгсэл”, “авлига нь нийгэмд байх зүйл, заавал муу үр дагавартай байх ёсгүй”, “тийм ч гаж үзэгдэл биш” гэх зэргээр төсөөлөх явдал нийгэмд төлөвшиж тогтсон байна.

- Иргэдийн дийлэнхи нь “Монголд авлига нийтлэг үзэгдэл” гэж үзсэн хэвээр байна.

- Авлигаас урьдчилан сэргийлэх хамгийн чухал гурван арга хэмжээнд “хатуу чанга шийтгэл ногдуулах”, “хууль эрх зүйн орчинг сайжруулах” болон “төрийн алба хаагчдын цалинг нэмэгдүүлэх” гэж үзжээ.

- Авилгатай тэмцэх газарт итгэл буурсан ч иргэд авлигын эсрэг тэмцлийг тэргүүлэх гол байгууллага нь мөн гэж үзсэн хэвээр байна.

- Газрын алба, уул уурхайн салбарыг авлигад хамгийн их автсан гэж үзсэн хэвээр байгаа бөгөөд улс төрийн намуудын үнэлгээ муудаж байгаа нь улс төрийн хүрээнд авилга өсөн нэмэгдсээр байгааг илтгэж байна.

- Эмч, цагдаа, багш, зөвшөөрөл олгодог, бүртгэл явуулдаг захиргааны ажилтан гэх мэт анхан шатны нэгж-хүн төвтэй, иргэдэд үйлчилгээ үзүүлэх чиг үүрэг бүхий төрийн алба хаагчдад авлига өгөх явдал их байна гэж тэмдэглэжээ.

Шалтгаан, нөхцөл:

А. Төрийн байгууллага, аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны эрх зүйн орчин, дотоод үйл ажиллагаатай холбоотой шалтгаан, нөхцөл

- Байгууллагын дотоод үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалт хангалтгүй
- Хяналт тавих, хариуцлага тооцох тогтолцоо оновчтой бус
- Төсвийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналт сул
- Удирдлагын хууль бус шийдвэр, үүрэг даалгавар
- Тендэр зарлах, шалгаруулах, дүгнэх, мэдээлэх ажиллагаан дахь хууль бус хандлага
- Төрийн байгууллагуудын ажлын уялдаа холбоо сул

Б. Хувь хүнээс үүдэлтэй шалтгаан, нөхцөл

- Төрийн албан хаагчдын ашиг сонирхлын зөрчил
- Хууль, эрх зүйн мэдлэг сул байдал
- Улс төр, бизнесийн хүрээний нөлөөлөлд автах, албаны эрх мэдлээ урвуулах, хэтрүүлэх
- Төрийн албаны сонгон шалгаруулалт, томилгооны дутагдал
- Төрийн албан хаагчдын ёс зүйгүй байдал

ЭРҮҮГИЙН ХУУЛИЙГ ГЭМТ ХЭРГИЙН ТУХАЙ ХУУЛЬ БОЛГОН ШИНЭЧЛЭХ АСУУДЛЫН ХҮРЭЭНД ХИЙХ ДҮГНЭЛТ:

Эрүүгийн хуулийг 2002 онд баталснаас хойш цаг үеийн тухайн нөхцөл байдал, шаардлагаас шалтгаалан уг хуульд хэд хэдэн удаа нэмэлт, өөрчлөлт оруулсан байна. Эдгээр нэмэлт, өөрчлөлтүүд нь хохирлын хэмжээ болон гэмт хэрэгт тооцох нөхцөл байдал /гипотези/-ийг тодорхой болгох, шинэ гэмт хэргийн бүрэлдэхүүнийг хуульчлах, олон улсын гэрээ, конвенцид нэгдэн орсон түүнчлэн өөр бусад хууль шинээр батлагдсан, зарим хуульд өөрчлөлт орсонтой холбоотойгоор оржээ⁸⁰.

Ийнхүү Эрүүгийн хуулийг баталж мөрдсөнөөс хойшх хугацаанд зарим нэмэлт, өөрчлөлтийг оруулсан нь тухайн эрх зүйн харилцааны тогтвортой байдалд сөргөөр нөлөөлж байна гэж үзжээ.

Улсын Их Хурлын 2012 оны 37 дугаар тогтоолоор батлагдсан Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрт ардчилсан нийгмийн үнэт зүйл, зарчим, улс орны хөгжлийн шаардлагад нийцсэн, урьдчилан сэргийлэх, хариуцлага тооцох чадавхтай эрүүгийн хууль тогтоомжийн тогтолцоог бүрдүүлж, ялын бодлогыг оновчтой үр нөлөөтэй, олон сонголттой болгохоор заасантай нийцүүлэх, Эрүүгийн хуульд заасан зарим гэмт хэргийн хохирлын хэмжээг тодорхой болгох, ойлгомжгүй буюу оновчгүй хэрэглэсэн зарим нэр томъёог залруулах, олон улсын гэрээ, конвенцид нийцүүлэх талаар нарийн судлан үзсэний үндсэн дээр Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулга болох Гэмт хэргийн тухай хуулийн төслийг боловсруулж, УИХ-д өргөн баригдаад байна.

Гэмт хэргийн тухай хуулийн төслийн 22 дугаар бүлэгт “**Авлигын гэмт хэрэг**” гэж томъёолон, нийт 13 гэмт хэргийг шинээр томъёолжээ. Үүнд:

- 1.1. Эрх мэдлийг урвуулан ашиглах
- 1.2. Албан тушаалтан бусдад хууль бусаар нөлөөлөх
- 1.3. Гадаад улсын төрийн албан тушаалтан, олон улсын байгууллагын албан тушаалтан эрх мэдлийг урвуулан ашиглах
- 1.4. Үндэслэлгүйгээр хөрөнгөжих
- 1.5. Хахууль авах
- 1.6. Хахууль өгөх

⁸⁰ <http://www.moj.gov.mn/>

- 1.7. Хууль бусаар шан харамж авах
- 1.8. Төрийн өмч, төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах
- 1.9. Төрийн өмчийн төсвийн бус хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах
- 1.10. Төрийн өмчийн эд хөрөнгийг хууль бусаар захиран зарцуулах, завших
- 1.11. Улсын нөөцийг хууль бусаар зарцуулах
- 1.12. Албан тушаалтны нэрийг ашиглах
- 1.13. Хуулийн этгээдийн эрх мэдлийг урвуулан ашиглах зэрэг болно.

Гэмт хэргийн тухай хуулийн төсөлд туссан харьцуулалт

Эрүүгийн хуульд (12 гэмт хэрэг) АЛБАН ТУШААЛЫН ГЭМТ ХЭРЭГ	Гэмт хэргийн тухай хуулийн төсөлд (13 гэмт хэрэг) АВЛИГЫН ГЭМТ ХЭРЭГ
•Төрийн албан тушаалтан албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдла урвуулах •Төрийн албан тушаалтан эрх мэдлээ хэтрүүлэх •Төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн албан тушаалтан эрх мэдлээ урвуулах •Төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн албан тушаалтан эрх мэдлээ хэтрүүлэх •Албан тушаалтны нэр барих •Хээл хахууль өгөх •Хээл хахуульд зуучлах •Хууль бусаар хөрөнгөжих •Албан тушаалтан хуурамч баримт бичиг үйлдэх •Албан тушаалтан албан үүрэгтээ хайнга хандах •Төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах	•Эрх мэдлийг урвуулан ашиглах •Албан тушаалтан бусдад хууль бусаар нөлөөлөх •Гадаад улсын төрийн албан тушаалтан, олон улсын байгууллагын албан тушаалтан эрх мэдлийг урвуулан ашиглах •Үндэслэлгүйгээр хөрөнгөжих •Хахууль авах •Хахууль өгөх •Хууль бусаар шан харамж авах •Төрийн өмч, төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах •Төрийн өмчийн төсвийн бус хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах •Төрийн өмчийн эд хөрөнгийг хууль бусаар захиран зарцуулах, завших •Улсын нөөцийг хууль бусаар зарцуулах •Албан тушаалтны нэрийг ашиглах •Хуулийн этгээдийн эрх мэдлийг урвуулан ашиглах

Эрүүгийн хуулийг Гэмт хэргийн тухай хууль болгоход албан тушаалын гэмт хэргийн талаарх онцлог өөрчлөлт шинэчлэлт:

- Эрүүгийн хуулийг онол дээр тулгуурлан, мэтгэлцэх зарчмын үндсэн дээр хэрэглэх боломжийг нээж өгсөн гэж болно.
- Албан тушаалтан гэх явцуу нэр томъёоноос “Авлигын” гэмт хэрэг болгосон.
- Авлигын эсрэг конвенцийн заалттай нийцүүлсэн
- Төрийн албан тушаалтан нь “нийтийн албан тушаалтан” болсон.
- Ихэнх гэмт хэрэг “хэлбэрийн бүрэлдэхүүнтэй” болсон.
- Хээл хахуульд зуучлахыг хассан.

- Төрийн өмчит, хуулийн этгээдийн хяналтыг сайн оруулсан.
- Хууль бусаар баяжих-үндэслэлгүйгээр хөрөнгөжих болсон.
- Гадаад улсын төрийн албан тушаалтан, олон улсын байгууллагын албан тушаалтан эрх мэдлийг урвуулан ашиглах, Хууль бусаар шан харамж авах, Төсвийн бус хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах, Улсын нөөцийг хууль бусаар зарцуулах, Хуулийн этгээдийн эрх мэдлийг урвуулан ашиглах гэмт хэрэг шинээр нэмэгдсэн.
- Ялын төрөл, өөрчлөлт
- Хөрөнгө, орлогыг хураах
- Нийтийн албанд томилогдох, сонгогдох эрхийг тодорхой хугацаагаар хязгаарлах, эсхүл хасах
- Тодорхой хугацаагаар нийтэд тусгай ажил хийлгэх
- 7-60 сая хүртэл төгрөгөөр торгох
- 1-8 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэхээр туссан.
- Хор уршиг хохирол-Албан тушаалтан бусдад хууль бусаар нөлөөлөх. 50 сая төгрөгөөс дээш бол.
- Хэргийн хүнд, хөнгөнөөр ангилалгүй болгосон.
- Нийтийн албан тушаалтан-Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 4.1-д заасан этгээдийг.
- Хахууль өгөх-Конвенцитай уялдуулан, 2 нөхцөлөөр тусгасан.

Эрүүгийн хуулийг шинэчилсэн Гэмт хэргийн тухай хуулийн төслөөр **авлигын гэмт хэргийн субъектын хүрээ өргөжих, хэлбэрийн бүрэлдэхүүнтэй болж байгаа учир авлигын гэмт хэрэг огцом нэмэгдэх магадлалтай.**

2.3. АВЛИГА, АЛБАН ТУШААЛЫН ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АСУУДАЛ

Монгол Улсад авлига, албан тушаалын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх асуудлыг дараах байдлаар урьдчилан тодорхойлж байна.

1. Авлигын эсрэг конвенцийг бүрэн хэрэгжүүлэх, үндэсний хууль тогтоомжоо нийцүүлэх, Конвенцийн хэрэгжилтийг хангах үүднээс 1996 онд Авлигын эсрэг хууль баталж, 2002 оноос 2010 он хүртэл Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр хэрэгжүүлсэн, 2005 онд НҮБ-ын Авлигын эсрэг конвенцийг Монгол Улсын хуулиар соёрхон баталсан, 2006, 2014 онд Авлигын эсрэг хуулийг шинэчилсэн, Авлигатай тэмцэх газар байгуулсан, 2012 онд Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль батлагдсанаас гадна Эрүүгийн болон Эрүүгийн байцаан шийтгэх хууль, бусад хууль тогтоомжид өөрчлөлт оруулж ирсэнээс үзэхэд конвенци тодорхой хэмжээнд хэрэгжиж байна. Эдгээр өөрчлөлт, шинэчлэлт нь конвенцийн заалтууд бүрэн утгаараа хэрэгжихгүй байдал байсаар байна.

2. Авлигатай тэмцэх үндэсний стратегий баталж, мөрдүүлэх, Монгол Улсад авлига бодитой оршиж, төрд итгэх олон түмний итгэлийг алдагдуулан, улс төр, эдийн засгийн шинэтгэлд бэрхшээл учруулж, улмаар үндэсний аюулгүй байдалд заналхийлэхэд хүргэж болзошгүй байдлыг харгалзан “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийг УИХ-ын 2002 оны 41-р тогтоолоор баталжээ.

Энэхүү хөтөлбөрийг 2002-2010 онд хоёр үе шаттай хэрэгжүүлэхээр төлөвлөж, авлигаас урьдчилан сэргийлэх эрх зүйн орчныг бий болгох, сонгуулийн тогтолцоо болон төрийн албыг боловсронгуй болгох, эдийн засгийг либералчлах, шүүх эрх мэдлийн хараат бус, бие даасан байдлыг хангах, авлигатай тэмцэх ажилд иргэний нийгмийн оролцоог дээшлүүлэх, гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагуудаас авах арга хэмжээ гэсэн үндсэн 7 чиглэлийн үйл ажиллагаа явуулахаар тусгажээ.

“Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр” хэрэгжүүлснээр хүрсэн үр дүн, олсон амжилт, гаргасан алдаа эндэгдлийг хараахан эцэслэн үнэлж дүгнээгүй байгаа ч Авлигатай тэмцэх тухай хууль /2006 он/-ийг баталж, авлигын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх, авлигаас урьдчилан сэргийлэх, авлигын гэмт хэргийг илрүүлэх үүрэг бүхий хараат бус, бие даасан байгууллага /2007 он/ бий болгож, төрийн улс төр, захиргаа, тусгай албан тушаалтан болон хуульд заасан бусад этгээд хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргах журам тогтоон хэвшүүлсэн зэрэг авлигатай тэмцэх бодитой алхамууд хийжээ.⁸¹

- Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд иргэдийг татан оролцуулах механизмыг тодорхой болгох.

- Авлига үүсэх нөхцөл боломжийг шууд болон шууд бусаар бүрдүүлж байгаа хууль эрх зүйн акт, дүрэм журмыг өөрчлөн шинэчлэх, хүчингүй болгох арга хэмжээ авч хэрэгжүүлэх.

- Байгууллагын авлигын эрсдлийг үнэлгээнд тулгуурлан авлигын эрсдлийг бууруулах, арилгах төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах.

- Газар зохион байгуулалт, ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох зэрэг судалгааны үр дүнгээр авлигад өртөмтгий салбараас гадна боловсрол, эрүүл мэндийн болон мэргэжлийн хяналт зэрэг сүүлийн үед авлигын индекс өндөртэй байгууллага-салбарт авлигаас сэргийлэх үр дүнтэй ажил зохион байгуулах.

- Зөвшөөрөл, лицензийн олон шат, дамжлагыг багасгах, чиргэдлийг арилгах талаар холбогдох хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах санал боловсруулах.

3. Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлыг улсын хэмжээнд өргөн далайцтай зохион байгуулах,

4. Монгол Улсад шударга ёсыг тогтоох үйл хэргийг төрийн болон хувийн хэвшлийн бүх шатанд хэрэгжүүлэх,

5. Авлига, хүнд суртал, ил тод байдлын талаар олон улсын болон

⁸¹ “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийн хяналт шинжилгээ, үнэлгээг эрдэм шинжилгээ, судалгааны байгууллага зэрэг сонирхлын зөрчил багатай байгууллага, баг хамтлагаар иргэний нийгмийн төлөөллийн өргөн оролцоотой гүйцэтгэх шаардлагатай.

дотоодын олон нийтийн байгууллагын судалгаа, авлигын индексийн судалгаанд үндэслэн урьдчилан сэргийлэх зорилтод үйл ажиллагааг төлөвлөн, хэрэгжүүлэх,

6. Төрийн алба хаагчдын хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө, орлогын мэдүүлэгт тавигч хяналтыг сайжруулах, Авлигын эсрэг хууль, Сонирхлын зөрчлийн хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан журмын дагуу ХАСХОМ-ийн бүрдүүлэлтийн үйл ажиллагааг буюу мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах, олон нийтэд мэдээлэх үйл ажиллагааг улсын хэмжээнд зохион байгуулдаг болох,

7. Авлига, албан тушаалын гэмт хэргийн талаарх гомдол, мэдээлэл, гэмт хэргийг шалгах бүтэц, зохион байгуулалтыг оновчтой төлөвлөх,

Өнөөдрийн байдлаар Монгол Улсад цагдаа, прокурорын дэргэдэх мөрдөх байцаах, тагнуул, авлигатай тэмцэх газар энэ харъяаллын дагуу гэмт хэрэг шалгаж байгаа боловч, тухайн эрүүгийн хэргийг шалгах явцад харъяаллын дагуу шилжүүлэх, улмаар авлигын гэмт хэрэг замхрах боломж бий болж байна. Э

8. Авлига, албан тушаалын гэмт хэрэгтэй үр дүнтэй тэмцэхийн тулд Эрүүгийн хуульд (Гэмт хэргийн тухай) конвенцийн заалтад нийцүүлэн, оновчтой зохицуулалтыг оруулж өгөх,

9. Улсын Дээд Шүүх, УЕПГ, АТГ, АНУ-ын Азийн сангийн “Засаглал, ил тод байдлыг дэмжих төсөл”-ийн захиалгаар авлига, албан тушаалын гэмт хэргийг мөрдөн шалгах, хянан шийдвэрлэх үйл ажиллагаанд эрүүгийн хууль тогтоомжийг хэрэглэж байгаа практикийг судлах зорилгоор явуулсан судалгааны тайланд тусгагдсан санал зөвлөмжийг хэрэгжүүлэх, Үүнд:

- Хууль эрх зүйн орчин бүрдсэн эсэх, Хуулийг нэг мөр ойлгож хэрэглэж байгаа эсэх, Мөрдөн шалгах, хянах, шүүхээр хянан шийдвэрлэхэд гарч буй алдаа, дутагдал, гэмт хэргийн шалтгаан, нөхцөл, цаашдын арга замыг тодорхойлох зорилгоор хийгдсэн.
- 2010-2013 оны эрүүгийн хэрэг шалгасан, шийдвэрлэсэн материалд 2013 онд явуулсан судалгааны үр дүн.
- Нийслэл, Дархан-Уул, Сэлэнгэ, Булган, Орхон, Дорноговь, Төв аймгийн Прокурор, шүүх, АТГ, УЕП-ын МБА-нд очиж судалсан байна.
- **77.6-85.9% нь** албан тушаалын гэмт хэргийг мөрдөн шалгах, хянан шийдвэрлэх эрх бүхийн байгууллагын үйл ажиллагаанд эрүүгийн хууль тогтоомжийн хэрэглээний чадамжийг **“Сайн биш”, “Сэтгэл дундур байна”** гэжээ.
- Албан тушаалын гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг бага бус байлгах, үлэмж хэмжээний хохирол учирсан бол хүнд ангилалд хамааруулах
- “Албан тушаалтан” гэдгийг нэгдсэн ойлголттой болгох.
- Албан тушаалын гэмт хэргүүдийг хэлбэрийн бүрэлдэхүүнтэй болгох, бодит хохирол учраагүй байдаг.

- Албан тушаалын гэмт хэрэгтэй тэмцэх мөрдөн байцаагч, прокурор, шүүгч нарыг мэргэшүүлэх, тогтвортой ажиллуулах.
- Мөрдөн шалгах, хянан шийдвэрлэх ажлын уялдаа холбоог хангах, хамтарсан сургалт хийх.
- Албан тушаалын гэмт хэрэг эцэслэн шийдэгдэхгүй, гадна нөлөө их байна.
- Мөрдөн шалгах аргачлал, механизмыг өөрчилж, шуурхай бэрхшээлгүй болгох.
- Хуулиар зөвшөөрөгдсөн ГА-ын үр дүнд олж тогтоосон баримт сэлтийг мөрдөн шалгах ажиллагаанд ашиглах, нотлох баримтын хэмжээнд үнэлэх, мөрдөн шалгах ажлыг стандарттай болгох.
- Албан тушаалын гэмт хэргийг хэрэгсэхгүй болгосон ч хохирол нөхөн төлүүлдэг механизм бий болгох.
- Хээл хахууль өгсөн, зуучилсан этгээд сайн дураараа хэргээ илчилсэн бол хариуцлагаас чөлөөлөхийг Эрүүгийн хуульд тусгах.
- Ялын бодлого хүндэдээгүй, ихэнхи нь хэрэгсэхгүй болж байна.
- Шүүх албан тушаалын гэмт хэргийг шийдвэрлэж чадахгүй байна. Нэгдмэл ойлголтгүйгээс шүүгчид өөр өөр шалтгаанаар хэргийг олон удаа буцааж байгаа тул албан тушаалын хэргийг шийдвэрлэж байгаа практикийг тусгайлан судалж, хамтарсан сургалт явуулах. Мөрдөн байцаагч нарыг мэргэшүүлэх.
- Хэргийн харъяаллаас шалтгаан мөрдөн байцаалтын шуурхай байдал алдагдаж байна.
- Албан тушаалын гэмт хэрэг, гомдлыг шалгах хугацааг уртасгах.
- Мөрдөн байцаах байгууллагууд нэгдсэн сүлжээтэй болох.
- Албан тушаалын гэмт хэргийн талаар Хуульчдын холбоотой хамтран сургалт хийх.
- Хуулийн этгээдийг гэмт хэргийн субъект болгох.
- Улс, үндэстэн дамнасан авлигын гэмт хэргийн талаар эрүүгийн хуульд жич зүйл хэсэг оруулах.
- Нэр нөлөөг нь ашиглах, ашиглуулах, спортын авлигын асуудлын зохицуулалтыг оруулах.
- Авлигын эсрэг хуульд хамаарах хуулийн этгээдийн хүрээг өргөжүүлэх.
- Ашиг сонирхлын зөрчлийн хэлбэрүүдийг нарийвчлан судлах шаардлагатай.
- Банкны нууцлал чухал боловч авлигын гэмт хэрэг илрүүлэхэд бэрхшээл учруулах үндэслэл болохгүй гэж үзэж, хуульд өөрчлөлт оруулах.
- Авлига, албан тушаалын гэмт хэргийн тогтоол магадлалыг олон

нийтэд ил тод, нээлттэй байлгах.

- Авлига, албан тушаалын гэмт хэргийн шалтгаан нөхцлийг мэргэшсэн шинжлэх ухааны байгууллага, эрдэмтэн судлаачдын оролцоотойгоор хамтран судалж урьдчилан сэргийлэх.
- Авлига, албан тушаалын гэмт хэргийг мөрдөн шалгах, хянан шийдвэрлэх үйл ажиллагаанд Эрүүгийн хууль тогтоомжийн заалтыг нэг мөр хэрэглэх, авлига, албан тушаалын гэмт хэрэгтэй тэмцэх эрх зүйн орчинг сайжруулах зэрэг болно.

2.4. АВЛИГААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА, ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

Олон улсад Авлигаас урьдчилан сэргийлэх хуулийн ач холбогдол болон тухайн зохицуулалтыг зөрчсөн мөн зөрчих үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, үндэстэн дамжсан корпорациуд, эсхүл хувь хүнтэй холбоотой далд эрсдэлийн тухай олон нийтийн мэдлэг, мэдээлэл улам бүр өргөжин тэлсээр байна.

АНУ-д Авлигаас урьдчилан сэргийлэх хуулийн хэрэгжилтийг чангаруулах талаар анхаарч байна. Тэр дундаас АНУ-тай харилцаа холбоо нь хязгаарлагдмал, тухайн улсаас гадуур үйл ажиллагаа эрхэлдэг томоохон корпорациудын эсрэг ажиллагаа ч мөн багтаж байна. Мөн Англи улсад сүүлийн жилүүдэд бүс нутгаас гадуурх өргөн цар хүрээтэй Авлигаас урьдчилан сэргийлэх хуулийг ч нэвтрүүлж байна. Зохицуулалтын агуулга болон хэрэгжилтийн өнөөгийн нөхцөл байдал нь улсуудын хувьд ялгаатай боловч ихэнх улсуудад илүү олон зохицуулалт болон илүү хатуу, чанга хэрэгжилтийг зорьсон тодорхой арга хэмжээнүүд хийгдэж байна.

Энэхүү судалгаа нь Зүүнд өмнөд Азийн бүс нутагт эрчимтэй дэлгэрч буй Авлигаас урьдчилан сэргийлэх хуулийн өнөөгийн нөхцөл байдлын ойлголтыг танилцуулах зорилготой билээ. Энэхүү судалгаанд олон аж ахуйн нэгжийн өнөөгийн байдал болон шаардлагад тохирсон төрөл бүрийн авлигаас урьдчилан сэргийлэх аргууд байгаагаас цөөн хэдэн жишээг дурьдая.

- Хянан магадлагаа /due diligence/. Энэхүү судалгаа нь компани худалдан авах, нэгтгэх /merger and acquisitions/ ажиллагаа, нэгдсэний дараах компанийн удирдлагад нэр дэвшихэд үйлчлэх Авлигаас урьдчилан сэргийлэх хуулийн ач холбогдлын тухай түүний агуулгыг таньж мэдэхэд ашиглаж болно.
- Бизнесийн хамтрагчид нэр дэвшигч. Энэхүү судалгаа нь аж ахуйн нэгж бусад улсуудын бизнесийн хамтрагчтай шинэ харилцаа тогтоох тохиолдолд хамтрагчийн байгаа нутаг дэвсгэр дээр явуулах үйл ажиллагаатай холбоотой нуугдмал эрсдлийн агуулгыг таньж мэдэхэд ашиглаж болно.
- Compliance program-ийн үр дагаврын дүгнэлт. Энэхүү судалгаа нь улс тус бүрийн бүс нутаг мөн дэлхий даяарх зөвшилцлийн хөтөлбөрийг боловсруулах шаардлага, боловсруулах аргыг дүгнэхэд ашиглаж

болно. Зөвшилцийн хөтөлбөрийн боловсруулалтыг дүгнэхэд юун түрүүнд аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа нь тухайн бүс нутгийн дүрэм, журамд нийцэж байгаа эсэхийг мэдэх шаардлагатай.

Энэхүү судалгаа нь тухайн улсын бүс нутгаас нэрсийн дарааллаар жагсааж улс бүрт тодорхой нөхцөлийг тавьсан. Эдгээр нөхцөл нь:

1. Засгийн газартай хамаарал бүхий этгээд болон гадаад улсын засгийн газартай холбоотой этгээдэд бэлэг өгөхийг хориглосон зохицуулалт байгаа эсэх;

2. “Засгийн газартай хамаарал бүхий этгээд”-ийн ойлголт;

3. Засгийн газартай хамаарал бүхий этгээдэд бэлэг сэлт өгөх, дайлж цайлах, аялалын зардалтай холбоотой зохицуулалт байгаа эсэх, хамрах хүрээ;

4. Хэрэгжилттэй холбоотой асуудал;

5. Сүүлийн үеийн хандлага гэсэн нөхцөлүүдийг хамаарч байна.

Мөн энэхүү судалгаа нь судалгааны зүйл болж буй улс бүрийн CPI оноо болон ранкийг оруулсан. CPI гэдэг нь Транспэрэнси интернэшнл олон улсын байгууллагаас нийтэлдэг Авилгын индекс (Corruption Perceptions Index) юм. Авилгын индексийн оноо нь 10-аас 0 хүртэл эрэмблэх бөгөөд 2011 онд Авилгын индексийн оноонд үндэслэж 183 улсын эрэмбийг гаргасан. Энэхүү судалгаа нь мөн судалгаанд багтаж буй улсууд нь хэлэлцэгч талууд болж буй гол олон улсын гэрээг багтаасан. Эдгээр гэрээ, конвенцийн тухай нэр томьёоны хэсэгт тайлбарласан.

Эдгээр улсуудын Авлигаас урьдчилан сэргийлэх хуультай холбоотой асуудал үүссэн тохиолдолд энэ судалгааны эцсийн бүлэгт бодит байдалд үндэслэсэн үнэн зөв мэдээллийг авах, эсхүл тохиромжтой тохиолдолд оршин байгаа газрын өмгөөлөгчдийн мэдээллийг авах боломжтой Жонес дэйгийн хариуцах хүмүүсийг нийтэлсэн байгаа. Мөн хууль тогтоомжтой холбоотой асуудал үүссэн тохиолдолд Жонес дэйгийн багаас тусламж хүсэх, үйлчилгээ авах боломжтой.

АВЛИГА, АЛБАН ТУШААЛЫН ГЭМТ ХЭРЭГ

Бүс нутаг		Зүүн Өмнөд Ази
Улс		Индонези
2011 CPI	Байр	100/183
	Оноо	3.0
Авилгатай холбоотой хууль, тогтоомж	Төрийн албан хаагчдын авилга	Авлигаас урьдчилан сэргийлэхтэй холбоотойгоор “Авлигын гэмт үйлдлийг таслан зогсоох тухай хууль” /1999 оны дугаар 31 дэх хууль, 2001 оны дугаар 20 болон 2006 оны дугаар 7 дэх хуулийн нэмэлт өөрчлөлт, “цаашид Авлигаас урьдчилан сэргийлэх хууль гэх” нь хээл хахууль өгсөн болон хахууль авагчийн аль алийг нь зохицуулдаг. Хээл хахууль өгөгч: Дор дурдсан тохиолдолд засгийн газрын байгууллагын албан хаагчид хандан ямар нэгэн зүйл бэлэглэх, түүнийг амласан этгээдэд ял онооно. - Төрийн албан хаагчийн үүргээ зөрчсөн үйлдэл, эс үйлдэл гаргах мөн түүгээр шалтагласан тохиолдолд 1-5 жилийн хорих ял, мөн 50-250 сая рупи торгох ял /Үйлдэл хийхийг шаардаагүй байх/ Тухайн албан тушаалтны эрх мэдэлтэй холбоотой тохиолдолд 3-аас дээшгүй жил хорих ял мөн 150 сая рупи торгох ял Хээл хахууль авагч: Төрийн албан хаагч мөн нийтийн ажил үүргийг гүйцэтгэдэг этгээд /мөн шүүгч/ нь дараах шалтгааныг мэдэх мөн эргэлзээтэйгээр бэлэг сэлт хүлээн авах, авахаар амласан тохиолдолд ял онооно. - Тухайн эрх мэдэл, албан тушаалаараа шалтагласан тохиолдолд 1-5 жил хүртэл хорих ял мөн 50-250 сая рупигээр торгох ял - Тухайн үүрэгтэй зөрчилдөх үйлдэл, эс үйлдэл /мөн шүүх хуралдааны шийдвэр/-д нөлөөлөхөд шалтгаан болсон тохиолдолд бүх насаар нь хорих ял, 4-өөс дээш 20 жил хүртэл хорих ял мөн 200 сая-с 1 тэрбум рупигээр торгох ял Улсад хохирол учруулах: Дор дурдсан үйлдлийн улмаас улсад эд хөрөнгийн болон эдийн засгийн хохирол учруулах нөхцөл үүсгэсэн этгээд нь хэн байхаас үл хамааран ял онооно. - Өөрөө мөн бусдыг ашиглан хууль бус үйлдэл хийвэл бүх насаар нь хорих ял, 4-с дээш 20 жил хүртэл хорих болон 200 сая рупигээр торгох ял - Ашиг олох зорилгоор эрх мэдлээ урвуулан, хэтрүүлэн ашигласан үйлдэлд бүх насаар нь хорих ял, мөн 1-с дээш 20 жил хүртэл хорих ял, эсхүл 500 сая рупигээр торгох ял Хуулийн этгээдэд хүлээлгэх хариуцлага: Авлигын үйлдлийг хуулийн этгээдийн захиалгаар мөн хуулийн этгээдийн төлөө явуулсан тохиолдолд тухайн хуулийн этгээд мөн албан тушаалтанд ял онооно. Жич: Авлигын үйлдлийн хэмжээ нь 5 сая рупид хүрээгүй тохиолдолд хорих ялын дээд хэмжээ нь 3 жил, торгох ялын дээд хэмжээ нь 50 сая рупигээс дээшгүй байна.
	Гадаад улсын төрийн албан хаагчийн хээл хахууль	2006 оны хуульд гадаад улсын төрийн албан хаагчийн хээл хахуулийг хориглох UNCAC-д нэгдэн орсон боловч түүнийг хэрэгжүүлэх хууль байгаагүйн улмаас гадаадын төрийн албан хаагчийн эсрэг хээл хахуулийг зогсоох ажил Индонез улсад боломжгүй гэмт хэрэг болоод байна. Индонезийн засгийн газар Авлигаас урьдчилан сэргийлэх хуулийн шинэчлэлийг зорьж, нийтэд танилцуулсан хуулийн төсөлд гадаадын төрийн албан хаагчийн хээл хахуулийг хориглосон зохицуулалт оруулсан боловч эцсийн төсөлд тухайн заалт нь байгаа эсэх, хуулийн төсөл нь их хуралд өргөн баригдсан эсэх нь тодорхойгүй байна.
	Иргэд хоорондын хээл хахууль	Индонез улсад иргэд хоорондын хээл хахуулийг хориглосон тусгайлсан хууль байхгүй. Гэвч Авлигаас урьдчилан сэргийлэх хуульд тайлбарласан “Засгийн газрын хамаарал бүхий этгээд мөн албан хаагч” гэгийг өргөн утгаар нь 1. Улсын хөрөнгө мөн бүс нутгийн хөрөнгөөс дэмжлэг авдаг хуулийн этгээд, 2. Улс мөн олон нийтээс хөрөнгө татан төвлөрүүлэх болон хөрөнгө оруулалт авдаг түүнээс бусад хуулийн этгээдийг багтааснаас олон тооны аж ахуйн нэгж нь хамаарах боломжтой.

Тодорхойлолт	Төрийн албан хаагч	Явцуу утгаараа төрийн албан хаагч /сонгогдсон, томилогдсон/ нийтийн ажлыг гүйцэтгэдэг этгээд болон цэргийн бие бүрэлдэхүүн, Авлигаас урьдчилан сэргийлэх хууль дэх "Засгийн газрын байгууллагын албан хаагч" нь 1. Улсын эд хөрөнгө мөн бүс нутгийн эд хөрөнгө, 2. Улсын эд хөрөнгө болон бүс нутгийн эд хөрөнгөөс дэмжлэг авдаг хуулийн этгээд 3. Улс мөн олон нийтээс хөрөнгө татан төвлөрүүлэх болон хөрөнгө оруулалт авдаг түүнээс бусад хуулийн этгээдийн аль нэгээс цалин, хөлс авдаг этгээдийг багтаана. Энэхүү тодорхойлолт нь зөвхөн төрийн өмчит аж ахуйн нэгжийн ажилтныг багтаасан бус импортын гаалийн албан татварын чөлөөлөлтийг эдэлж буй Индонезд хөрөнгө оруулалт хийж буй гадаадын хуулийн этгээд болон богино хугацааны мөнгө зээлүүлж буй банкыг мөн багтаан ойлгоно.
	Бэлгийн зүйл /бэлэг сэлт, цайллага/	Аялал зугаалга, цайллагатай холбоотой Авлигаас урьдчилан сэргийлэх хуульд шууд зохицуулаагүй боловч хүлээн авагчийн албан тушаалтай холбогдох мөн тухайн үйлдлийг хүлээн авсан тохиолдолд хээл хахууль гэж үзэх боломжтой. Тухайн бэлэг нь 10 сая рупигээс дээш үнэ бүхий зүйл байх тохиолдолд хүлээн авагч нь тухайн бэлгийг нь хээл хахууль биш байсан гэдгийг нотлох хариуцлага хүлээнэ. /10 сая рупи хүрэхгүй тохиолдолд прокурор нотлох хариуцлага хүлээнэ./ Бэлэг хүлээн авагч нь Авилгын үйлдлийг таслан зогсоох зөвлөл /КРК/-д мэдээлсэн тохиолдолд түүнийг хээл хахуульд тооцохгүй. КРК мэдээлэгч нь тухайн бэлгийг авч болох эсэхийг шийдвэрлэнэ.
Өнөөгийн нөхцөл байдал	Хэрэгжүүлэгч байгууллага	КРК нь 2002 оны дугаар 30 дэх хуульд үндэслэж байгуулагдсан бие даасан байгууллага бөгөөд улсад учирсан хохирол нь 1 тэрбум рупигээс дээш бол хууль хэрэгжүүлэгч байгууллага нь оролцож олон нийтэд анхааруулах, авилгын үйлдэлтэй холбоотой гэмт хэргийг мөрдөх, хэрэг үүсгэх эрхтэй. Түүнээс бага хохиролтой тохиолдолд цагдаа болон дүүргийн прокурорын газар мөрдөх ажиллагааг явуулах тохиолдол байдаг.
	Хэрэгжилттэй холбоотой асуудал	1. Дотоод мэдээлэгчийн хамгаалалт сул- Гэрч, хохирогчийг хамгаалах хууль /2006 оны дугаар 13 дэх хууль/ батлагдснаас үл хамааран дотоод мэдээлэгчид огт хамгаалалт байхгүй. Гэрч, хохирогчийг хамгаалах байгууллага 2006 онд хууль батлагдснаас хойш 2 жил байгуулагдалгүй, санхүүгийн дэмжлэггүй болсон. 2. КРК нь тусгайлан тогтоосон нөхцөлийг хангасан гэмт хэргийг л мөрдөн шалгах, хэрэг үүсгэх эрхтэй байдаг. 3. КРК нь санхүү болон хүн хүчний хувьд туйлын хангалтгүй байдаг.

Бүс нутаг		Зүүн Өмнөд Ази
Улс		Малайз улс
2011 CPI	Ранк	60/183
	Оноо	4.3
Төрийн албан хаагчдын хахууль	албан хээл	Авлигаас урьдчилан сэргийлэх гол хууль нь 2009 оны Авлигаас урьдчилан сэргийлэх зөвлөлийн хууль юм. Хээл хахууль өгөх: Нийтийн алба дахь төрийн албан хаагчид тухайн үйлдлийг явуулах эрх мэдэл, боломж байхгүй байсан тохиолдолд мөн тухайн үйлдлийг явуулах зорилгогүйгээр бэлэг хүлээн авсан эсэхээс үл хамааран тухайн төрийн албан хаагчид олон нийтийн байгууллага дахь шийдвэрт нөлөөлөхөөр санал өгөх, түдгэлзэх, үйлдэл, эс үйлдэл гаргуулах зэргээр шан харамж өгөх нь гэмт хэрэг болно. /ACCA 21-р зүйл./ Хээл хахууль авах: Дээр дурдсан үйлдэлд шан харамж авсан бол гэмт хэрэг болно. /ACCA 21-р зүйл./ Эрүүгийн хууль нь ACCA-г батлагдахаас өмнө байсан бөгөөд одоогийн нөхцөлд дээрхээс бусад улсын дотоод хээл хахуультай холбоотой гэмт хэрэгт үйлчилнэ. Хуулийн этгээдийн хариуцлага: ACCA-д "хүн" гэдэгт "хуулийн этгээдийн эрхтэй, эрхгүй нэгдэл"-ийг хамааруулж, Эрүүгийн хууль дахь "хуулийн этгээдийн эрхтэй, эрхгүй компани, байгууллага, бүлэг" зэргийг хамааруулах учир онолын хувьд хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх боломжтой.

АВЛИГА, АЛБАН ТУШААЛЫН ГЭМТ ХЭРЭГ

А в и л г а т а й холбоотой хууль, тогтоомж	Гадаад төрийн хаагчийн хахууль	улсын албан хээл	Хээл хахууль өгөх: Гадаадын төрийн албан хаагчийн улс мөн тухайн төрийн албан хаагчийн үйл ажиллагаа явуулж буй олон улсын байгууллагын үйл ажиллагааны шийдвэрт нөлөө үзүүлэх, үйлдэл, эс үйлдэл, тусгайлсан этгээдийн эрх ашит нийцсэн гэрээ байгуулах, байгуулахгүй байх, шан харамж, бэлэг сэлтийг өөрөө болон бусдаар дамжуулан өгөх, амлах зэрэг нь гэмт хэрэг болно. Хээл хахууль авах: Дээр дурдсан үйлдлийг эсэргээр нь төрийн албан хаагч ямар нэгэн шан харамж шаардах, авах, амлах, мөн авахаар оролдох зэрэг нь гэмт хэрэг болно. /АССА 22-р зүйл./ Хээл хахууль өгсөн, авсан этгээдүүдэд 20-с дээшгүй жил хорих болон хахуулийн үнийн дүнгийн хэмжээг 5 дахин нэмэгдүүлэн төлүүлэх, 10 мянган рингитын аль өндөр хэмжээний торгуулийг ногдуулна.
	Иргэд хоорондын хээл хахууль		АССА-д төрийн албан хаагчийн хээл хахууль болон иргэд хоорондын хээл хахуулийн аль алийг нь хориглосон байдаг. /АССА 16-р зүйл./
Тодорхойлолт	Төрийн хаагч	албан	Дотоод төрийн албан хаагчид ерөнхийд нь засгийн газрын байгууллага, парламент, мужийн их хурал, холбооны улсын шүүх, түүнээс бусад холбооны засгийн газрын байгууллага, мужийн засгийн газар, нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага, засгийн газраас талаас илүү хувийг нь эзэмшиж буй компани, бүртгэгдсэн холбоо болон үйлдвэрчний эвлэл гэсэн олон нийтийн байгууллагын гишүүд, албан хаагч, албан тушаалтан, ажилчид, мөн олон нийтийн хөрөнгөөс урамшуулал авч буй этгээд хамаарна. Гадаадын төрийн албан хаагчид ерөнхийд нь томилогдсон болон сонгогдсон эсэхээс үл хамааран гадаадын хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх мөн захиргааны албан үүргийг гүйцэтгэгч этгээд мөн олон улсын олон нийтийн байгууллагын төлөө үйл ажиллагаа явуулж буй этгээдүүд багтана.
	Бэлгийн /бэлэг цайллага/	зүйл сэлт,	“Бэлгийн зүйл”-ийн тодорхойлолт нь өргөн хүрээтэй ба эд хөрөнгөөр үнэлэгдэх эрх ашиг, түүнээс гадна үйлчилгээ болон ая тухтай нөхцөл мөн багтана. АССА-д хахуулийн хэмжээ маш бага байх тохиолдлыг хамаарахгүй байхаар зохицуулаагүй ч 1998 онд нийтийн үйлчилгээний хэлтсийн гаргасан нийтийн үйлчилгээн дэх бэлэг өгөх, авахтай холбоотой танилцуулгад бэлгийн зөвшөөрөгдөх хязгаарыг тогтоох, түүнд хүндэтгэлтэй хандах зөвшөөрлийн процессыг нарийвчилан зохицуулсан.
Өнөөгийн байдал	Хэрэгжүүлэгч байгууллага		Малайзын Авилгаас урьдчилан сэргийлэх зөвлөл /МАСС/ нь АССА болон Эрүүгийн хууль дахь авилгын гэмт хэргийг мөрдөн шалгах эрх хэмжээтэй. Түүнээс бусад Малайзын хууль хэрэгжүүлэгч байгууллага ч авилгын хэргийг мөрөх боловч тухайлбал санхүүгийн байгууллагатай холбоотой тусгайлан мөрдөн шалгах ажиллагааг зөвхөн МАСС-д зөвшөөрсөн. Прокурорын зөвшөөрлөөр МАСС нь авилгын гэмт хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэнэ.
	Хэрэгжилттэй холбоотой асуудал		2010 онд Дотоод мэдээлэлчийг хамгаалах хууль батлагдсан ч хуулийн хэрэгжүүлэх улс төрийн арга хэмжээ хангалтгүй байгаагаас төсөөлж байсан үр дүнд хүрэхгүй байна. - Сүүлийн үед Малайзад хоёр том улс төрийн намын хооронд засгийн эрхийн төлөөх тэмцэл өрнөж, Авилгаас урьдчилан сэргийлэх хуулийн хэрэгжилтийн ач холбогдлыг үгүйсгэж байна. - МАСС нь эрх баригч намд шууд захирагдаж байгаагаас МАСС-ийн хуулийг хэрэгжүүлэх нь зөөлөрч байна.

Бүс нутаг		Зүүн Өмнөд Ази
Улс		Мьянмарын холбооны бүгд найрамдах улс
2011 CPI	Ранк	180/183
	Оноо	1.5

Авлигатай холбоотой хууль, тогтоомж	Төрийн албан хаагчдын хээл хахууль	Авлигаас урьдчилан сэргийлэхтэй холбоотой гэмт хэргийг Авлигаас урьдчилан сэргийлэх хууль, Авлигаас урьдчилан сэргийлэх хуулийн нэмэлт өөрчлөлт болон Мьянмарын Эрүүгийн хууль гэсэн гол хуулиудаар зохицуулж байна. Үндсэндээ хээл хахуулийн зуучлагч болон хүлээн авагчид ял оногдуулдаг. Гэвч одоогийн Мьянмарын хууль тогтоомжид хахууль өгөх нь гэмт хэрэг биш юм. Хахууль авах: Нийтийн албанд ажилладаг этгээд мөн нийтийн албанд хамаарах боломжтой этгээд нь өөрөө мөн бусдын төлөө албан үүргээ гүйцэтгэхдээ үйлдэл, эс үйлдэл гаргаж, бэлэг сэлт /хуульд заасан шагнал, урамшууллаас бусад/ шаардах, авах, авахаар амлах явдал нь тухайн үйлдэл, эс үйлдэл бодитоор хэрэгжсэн эсэхээс үл хамааран гэмт хэрэг гэж үзэж 3-с дээшгүй жил хорих, торгох, түүнчлэн эдгээр ялыг давхар оногдуулж болно. Авилгын үйлдэлд зуучлах: Хэн ч авлигын үйлдэл мөн хууль бус аргаар нийтийн албанд хамаарах этгээдийг албан үүргээ гүйцэтгэхэд үйлдэл эсхүл эс үйлдэл, хэлбэрийн төдийгөөр ажил үүргийг гүйцэтгүүлэх, бэлэг сэлт өгөхийг шаардах, хүлээн авах, авахаар амлах, хохирол учруулах нь гэмт хэрэг бөгөөд 3-с дээшгүй жил хорих ял, торгох ялыг давхар оногдуулна. Энэ зүйлд заасан “хүн” гэдэг нь компани, байгууллага мөн бүлгийг багтаасан ойлголт ба хуулийн этгээдийн эрхтэй, эрхгүй үл хамаарна. Нийтийн албыг хэрэгжүүлэхтэй холбоотой эрх мэдлээ урвуулан ашиглах гэмт хэрэг: Нийтийн албыг хэрэгжүүлэгч этгээд нь дор дурдсан үйлдэлд шударга бус мөн залилах сэдэлээр оролцсон тохиолдолд гэмт хэрэг болно. Эрүүгийн хуулийн 161-р зүйл, 163-р зүйлд заасан гэмт хэргийг үйлдсэн тохиолдолд авилгын үйлдэл эсхүл хууль бус арга, албаны эрхээ урвуулан ашигласнаар эд хөрөнгө, мөнгөн хэлбэрийн ашиг олсон тохиолдолд нийтийн эрх ашгийг зөрчих шударга бус үйлдэл байгаа тохиолдолд мөн итгэмжлэгдсэн нийтийн хөрөнгийн тухай шударга бусаар эрхээ урвуулан ашигласан тохиолдол. Эдгээр тохиолдолд 7-с дээшгүй жил хорих ял болон эрх мэдлээ урвуулан ашигласан үйлдлийн улмаас олсон бүх ашгийг хураан авах ял онооно. Авлигын үнэлгээ: Нийтийн албанд хамаарах этгээд нь өөртөө мөн бусдын төлөө тухайн нийтийн албанд хамаарах этгээдээр мөн тухайн этгээдтэй холбоотой ажиллагаа, урьд өмнө нь худалдааны хамтрагч байсан эсхүл дараа нь бизнесийн харилцаанд оролцсон, оролцох гэж буй мөн оролцох төлөвлөгөөтэй байгаа этгээдээс тухайн харилцаанд үндэслэж хөрөнгө шаардах, хүлээн авах, хүлээн авахаар амлах нь гэмт хэрэг бөгөөд 2-с дээшгүй жил хорих ял оногдуулж торгох ялыг давхардуулан ногдуулна.
	Гадаад улсын төрийн албан хаагчийн хээл хахууль	Мьянмар улсад гадаадын засгийн газар мөн олон улсын байгууллагын ажилтан хээл хахуулийн гэмт хэргийн субъект болдоггүй.
	Иргэд хоорондын хээл хахууль	Иргэдийн хоорондох хээл хахуулийн асуудал гэмт хэрэг биш гэж үздэг.

Тодорхойлолт	Төрийн албан хаагч	Нийтийн албанд хамаарах этгээд нь Эрүүгийн хуульд /Эрүүгийн хуулийн 21-р зүйл/ тайлбарласантай адилаар Авилгаас урьдчилан сэргийлэх хуульд заасан байдаг. Нийтийн албанд хамаарах этгээд гэдэгт дараах этгээдүүд хамаарна. - Засгийн газартай гэрээний харилцаанд байгаа албан тушаалтан - Улсын хуурай болон усан замын цэрэг, агаарын довтолгооны цэрэг - Шүүгч, Шүүхийн албан хаагч - Шүүхийн иргэдийн төлөөлөгч, шүүхийн хөрөнгө хянагч, шүүхийн албан тушаалтан, мөн нийтийн албанд ажилдаг этгээдийг орлох зөвлөлийн гишүүд - Арбитрч, шүүгч мөн бусад харьяалах албадаас тодорхой нөхцөлтэйгээр итгэмжлэгдсэн этгээд - Хүнийг хорих, баривчлах эрхтэй албан тушаалтан - Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэгтэй холбоотой мэдээллээр хангах, гэмт этгээдийг шүүхийн шатанд хянах, нийтийн аюулгүй байдал, аюулгүй байдлыг хангах үүрэгтэй засгийн газрын албан хаагч - Захиргааны үйлчилгээг үзүүлэгч төрийн албан хаагч, түүний үүргийг гүйцэтгэхээр засгийн газраас урамшуулал авч буй төрийн албан хаагч - Засгийн газрын гишүүд - Эд хөрөнгө авах, шилжүүлэх, хариуцах, мөн түүнийг өсгөн нэмэгдүүлэх, судалгаа явуулах, шашны бүс нийтийн төлөөх зорилготой тосгон, хот мөн бүс нутагт татвар хураах, иргэдийн эрхийг хамгаалах материал боловсруулах, хадгалах үүрэгтэй этгээд - Сонгуульд нэр дэвшигчдийн бэлтгэл, хэвлэн нийтлэх, хариуцах эсхүл засварлах мөн сонгууль эсхүл сонгуулийн чиг үүргийг хэрэгжүүлэх эрхтэй этгээд “Засгийн газар” гэдэг нь Мянмарын аль нэг бүс нутгийн гүйцэтгэх засаглалыг хэрэгжүүлэх эрхтэй этгээдийг хэлнэ. “Төрийн албан хаагч” гэж нийтийн албанд хамаарах этгээд, парламентийн гишүүн болон засгийн газрын албан хаагчдыг багтаана.
	Бэлгийн зүйл /бэлэг сэлт, цайллага/	“Бэлэг” гэдгийг өргөн утгаар тодорхойлсон ба мөнгөн бэлэг болон мөнгөөр үнэлэгдэх үнэлгээ бүхий урамшууллаар хязгаарлагдахгүй. “Хуульд заасан урамшуулал” нь нийтийн албанд хамаарах этгээд нь хуульд нийцсэн шаардаж болох урамшууллаар хязгаарлагдахгүй, засгийн газраас зөвшөөрсөн бүх урамшууллыг багтаана.
Өнөөгийн нөхцөл байдал	Хэрэгжүүлэгч байгууллага	Хуульд Авлигаас урьдчилан сэргийлэхтэй холбоотой хууль тогтоомжийг хэрэгжүүлэх бие даасан байгууллага байхгүй. Авилгаас урьдчилан сэргийлэх хууль нь Эрүүгийн хуулийн 161-ээс 165-р зүйлд заасан гэмт хэргийг шалгах “Тусгай шүүгч”-ийг томилох эрхийг Ерөнхийлөгчид олгосон.
	Хэрэгжилттэй холбоотой асуудал	Одоо хэрэгжиж буй хуулийг хэрэгжүүлэх хариуцлагыг тусгай байгууллагад шилжүүлээгүй, хэрэгжилт нь олон нутаг болон төрийн цагдаагийн албан үүргийн хүрээнд хамаардаг.
	Сүүлийн үеийн хандлага	2012 онд Мянмарын төрийн мэдээлэл сэтгүүлд шинэ Авилгыг хориглох тухай хуулийн төслийг, 2012 онд Хээл хахуулийг хориглох тухай хуулийн төсөл хоёр танхимаар дэмжигдсэн тухай мэдээлсэн.

Бүс нутаг		Зүүн Өмнөд Ази
Улс		Филиппин Улс
2011 CPI	Байр	129/183
	Оноо	2.6

Авилгатай холбоотой хууль тогтоомж	Төрийн албан хаагчид холбоотой авилга	Филиппин улсад төрийн албан хаагчдыг Авилгаас урьдчилан сэргийлэхтэй холбоотой чухал зохицуулалт бол шинэчлэгдсэн Эрүүгийн хууль нь юм. (цаашид Эрүүгийн хууль гэх). Уг хууль нь төрийн албан хаагчдын авилга, албан тушаалаа урвуулан ашиглахтай холбоотой ойлголт болон ял шийтгэлийг тусгаж өгсөн бөгөөд төрийн албан хаагч болон ард иргэдэд нийтлэг үйлчилж байна. Мөн өөр нэг чухал зохицуулалт бол Авилга болон албан тушаал урвуулан ашиглахыг таслан зогсоох тухай Хууль 3019 юм. Энэ хуульд авилгын үйлдлийг нэг бүрчлэн зааж өгөөд, төрийн албан хаагч болон ард иргэдэд нийтлэг хэрэглэж байна. Уг хуульд дараах үйлдлийг хориглосон: Хээл хахуульд зуучлах, засгийн газрын гэрээтэй холбогдож ашиг олох, эрх мэдлээ урвуулан хэрэгжүүлж ашиг олох, худалдааны түнш компанид ажилд орох, засгийн газрын шийдвэр болон шүүхийн шийдвэрт холбогдуулан үндэслэлгүйгээр хохирол учруулах, хувийн ашиг олохын тулд албан үүргээ гүйцэтгэхгүй байх, мөн хувийн ашиг олохын тулд төрд ашиггүй худалдаа хийх, төртэй харилцдаг компанийн хувьцаа эзэмших, тусгай зөвшөөрөл авахад өөртөө давуу эрх үүсгэж ашиг олох, шаардлага хангаагүй тусгай зөвшөөрлийг хүлээн зөвшөөрөх, итгэл эвдэх зэрэг болно. Филиппин улсад авилгатай тэмцэхтэй холбоотой дээрх хуулиас гадна дараах хуулиуд байдаг байна. Үүнд: • Дээрэм тонуулыг таслан зогсоох тухай хуульд (Хууль 7080) дээрэм тонуулын гэмт хэргийн талаар тодорхойлж, төрийн албан хаагч нийт дүнгээр 50 сая филиппин доллараас дээш хууль бус ашиг олсон бол ял шийтгэл оногдуулахаар зааж өгсөн байна. • Төрийн албан хаагч болон засгийн газрын ажилтны албаны дүрэм болон ёс зүйтэй холбогдох хууль (Хууль 6713)-аар төрийн албан хаагчийн албан үүргийг зохицуулж, албан үүрэгтэй холбогдуулж бэлэг авах, гар цайлгах мөнгө авах, зээл авах, тусгай хангамж эдлэх, хүлээн авалтад уригдах зэргийг хориглодог. • Төрийн албан хаагч болон засгийн газрын ажилтны хууль бусаар олсон ашгийг хураан авах хууль (Хууль 1379)-д, төрийн албан хаагч ажиллаж байх хугацаанд олсон эд хөрөнгө нь авч байсан цалин хөлс, хуулийн дагуу олсон орлого болон хуулийн дагуу олсон эд хөрөнгөнөөс давсан хэмжээний буюу орлогоос нь их хэмжээний, бодит байдалтай үл нийцэх шинжтэй бол тухайн эд хөрөнгийг хууль бусаар олсон орлого гэж үзэх ерөнхий үзэл баримтлалтайгаар хуульчилж өгсөн байна. • Төрийн албан хаагч болон засгийн газрын ажилтны авилгын гэмт хэрэгт ял оноох тухай хуульд төрийн албан хаагч бэлэг хүлээн авах, иргэдээс төрийн албан хаагчид талархсан сэтгэлээ илэрхийлж хүлээн авах, хүлээн авалтанд оролцох зэргийг хориглодог байна. • 2007 оны Хүнд сурталтай тэмцэх хууль (Хууль 9485)-д иргэдэд засгийн газрын үйлчилгээг үр дүнтэй болгохыг зорьж, энэ хүрээнд захиргааны процессын шат дамжлагын ажиллагааг цөөрүүлж, авилга, албан тушаалаа урвуулан ашиглахаас сэргийлэх үүднээс засгийн газрын төлөө ажилладаг эсэхээс нь үл хамааран мөнгөн ашиг, өөр бусад аргаар ашиг аван, худалдаа арилжааг түргэн шуурхай гүйцэтгэхэд дэмжлэг үзүүлж шан харамж авагчдын эсрэг эрүүгийн ял шийтгэлийг тусгаж өгсөн байна. • 2001 оны Мөнгө угаахаас урьдчилан сэргийлэх тухай хуульд (шинэчлэн найруулсан 9160 дугаар хууль, үүний дараа мөн нэмэлт өөрчлөлт орсон) уг хуулиар хориглосон мөнгө угаах гэмт хэргийг үйлдсэн этгээдэд (төрийн албан хаагч мөн хамаарна) эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан бөгөөд, мөнгө угаах үйлдэлд Авилгатай тэмцэх хуульд заасан мөнгө угаах үйлдлийг даалгасан үйлдэл мөн хамаарах юм. Хуулийн этгээдийн хариуцлага: хувь хүнд л зөвхөн гэмт хэрэг үйлдсэний төлөө яллаж, эрүүгийн хариуцлага ноогдуулдаг. Гэвч хуульд тодорхой заасан тохиолдолд компанид (бусад хэлбэрийн хуулийн этгээд) ч мөн хариуцлага ноогдуулж, тохиолдлоос хамаараад дампууруулах болон тусгай зөвшөөрлийг цуцлах зэрэг арга хэмжээг авч байна.
	Гадаадын улсын төрийн албан хаагчид холбогдох авилга	Филиппин улсад өнөөгийн байдлаар гадаад улсын төрийн албан хаагчид холбогдох авилгын хэргийг зохицуулсан хууль тогтоомж байхгүй байна.
	Иргэд хоорондын авилга	Филиппин улсад өнөөгийн байдлаар иргэд хоорондын авилгыг хориглосон дотоодын хууль тогтоомж байхгүй байна.

АВЛИГА, АЛБАН ТУШААЛЫН ГЭМТ ХЭРЭГ

Тодорхой- лолт	Төрийн албан хаагч	Төрийн албан хаагч гэдгийг Авилгатай тэмцэхтэй холбоотой хууль тогтоомж бүрт өөр өөрөөр тусгасан байна. Эрүүгийн хуулийн 203 дугаар зүйлд “төрийн албан хаагч” гэж “хуульд заасны үндсэн дээр, жирийн сонгууль болон харьяалсан захиргааны дээд байгууллагаас томилогдсон, Филиппины арлуудын захиргааны байгууллагын нийтийн чиг үүргийг гүйцэтгэхэд оролцож, бусад арлын захиргааны байгууллага болон салбар газарт харьяалагдахгүй албан хаагч, төлөөлөгч мөн доод шатны байгууллагын албан хаагч” гэж тодорхойлсон байна. Хууль 3019-ийн хоёр дугаар зүйлийн 6-д төрийн албан хаагч гэж: энэ хуулийн хоёрдугаар зүйлийн а-д холбогдох этгээд бөгөөд энэ нь сонгуулиар сонгогдсон мөн эрх бүхий байгууллагаас томилогдсон төрийн албан хаагч, ажилтан, хөлсөөр ажиллаж байгаа нь үл хамааран засгийн газраас ямар нэгэн байдлаар цалин хөлс авч байгаа этгээд гэж тодорхойлсон байна. Хууль 6713-ын гуравдугаар зүйлийн 6-д “төрийн албан хаагч” гэж: энэ хуулийн гуравдугаар зүйлийн а-д заасан этгээд бөгөөд энэ нь сонгуулиар сонгогдсон мөн эрх бүхий байгууллагаас томилогдсон төрийн албан хаагч, ажилтан байх ба мэргэжлийн болон мэргэжлийн бус ажил үүрэг гүйцэтгэж байхаас үл хамааран, цалин хөлсний хэмжээ харгалзахгүйгээр засгийн газраас ямар нэгэн байдлаар цалин хөлс авч байгаа этгээд байх ба цэргийн болон цагдаагийн албан хаагч мөн хамаарна гэж тодорхойлсон байна. Филиппин улсын хуульд UNCAC-ын хоёрдугаар зүйлд заасан тодорхойлолтоос гадна “гадаад улсын төрийн албан хаагч”-ын талаар тодорхойлсон зүйл байхгүй байна.
	Бэлэг, илгээмж (бэлэглэх, хүлээн авалт)	Бэлэг гэдгийг Авилгаас урьдчилан сэргийлэх, тэмцэхтэй холбоотой хууль тогтоомжид өргөн утгаар тодорхойлж, хүлээн авалтанд оролцож, зээл авах, хангамж болон үйлчилгээ үзүүлэх зэргийг агуулсан ойлголт гэж үздэг байна. Хууль 3019-ийн 14 дүгээр зүйлд онцгой тохиолдлыг тусгаж өгсөн бөгөөд тухайн орон нутгийн соёл уламжлал, зан заншлыг даган, талархсан сэтгэлээ илэрхийлэхэд өгсөн бэлэг нь бага хэмжээний, өндөр үнэ бүхий зүйл биш бол хуулиар хориглосон бэлгийн зүйлд хамаарахгүй гэж тодорхой зааж өгсөн байна. Эрүүгийн хууль болон Хууль 3019-ын аль алинд бэлгийн зүйлийн мөнгөн дүнгийн доод хэмжээг зааж өгөөгүй бөгөөд шүүх авилгатай холбоотой хууль тогтоомжийн тодорхойлолтыг нарийн тайлбарлаж хууль хэрэглэх хандлагатай байдаг.
Өнөөгийн нөхцөл байдал	Хэрэгжүүлэх байгууллага	Авилгатай тэмцэх чиг үүрэг бүхий дараах байгууллагууд байдаг байна. • Омбудсман болон Тусгай прокурорын газар авилгын гэмт хэргийг мөрдөн шалгадаг байна. • Тусгай шүүх (Sandiganbayan) болон орон нутгийн шүүх нь авилгын гэмт хэргийг харьяалан шийддэг. Энэ хоёр шүүхийн харьяалал нь хэргийн оролцогч болох төрийн албан хаагчийн зэрэг дэвээс хамаардаг байна. • Филиппин улсын төрийн цагдаа нь Цагдаагийн байгууллагын гэмт хэргийг мөрдөн шалгах, илчлэн илрүүлэх хэлтсээр дамжуулан, Төрийн мөрдөн шалгах газар нь авилгатай тэмцэх хэлтсээрээ дамжуулан авилга, албан тушаал урвуулан ашиглах гэмт хэргийг мөрдөн шалгадаг. • Ерөнхийлөгчийн дэргэдэх авилгатай тэмцэх зөвлөл нь засгийн газрын авилгатай тэмцэх бодлогын хүрээнд ерөнхийлөгчид дэмжлэг үзүүлж ажилладаг. Мөн ерөнхийлөгчөөс томилдог төрийн өмчийн компанийн албан тушаалтанд холбогдох авилгын хэргийг шалгадаг байна. • Иргэдэд үйлчлэх зөвлөл нь засгийн газрын төвийг сахисан боловсон хүчний захиргааны төв байгууллага бөгөөд үндсэн хуулийн хүрээнд хараат бус байхаар хуульчлагдсан, төрийн үйлчилгээг голч шударга, үр дүнтэй, иргэдэд мэдээлэл хүргэх зэрэг чиг үүргийг хариуцдаг байна. Уг зөвлөл нь авилга болон албан тушаалаа урвуулан ашигласантай холбоотой гомдол мэдээллийг мөн харьяалан шийддэг байна.
	Хэрэгжилттэй холбоотой асуудал	Мөрдөн байцаалт болон шүүхийн процессын ажиллагаа мухардалд орох, хууль бусаар олсон орлогыг хураан авах процессын хүндрэл, хуулийн төсөл батлах процессын удаашрал, авилга, албан тушаалаа урвуулан ашигласан гэмт хэрэгт холбогдсон төрийн албан хаагчид ял оноосон хувь харьцангуй бага зэрэг асуудал үүсч байна.
	Сүүлийн үеийн хандлага	2011 оны 12 дугаар сард, Глориа Арроё (Gloria Arroyo) ерөнхийлөгч болон холбогдох төрийн албан хаагчдад Омбудсманы байгууллагаас Хууль 3019 болон Хууль 6713-ыг зөрчсөн гэсэн үндэслэлээр эрүүгийн хэрэг үүсгэсэн байна. Энэ хэрэг нь Филиппин улсын төрийн өмчит радио телевиз болон БНХАУ-ын Цахилгаан түгээх компанийн хооронд болсон худалдааны асуудалтай холбоотой үүссэн байна. Уг хэрэг мөрдөн шалгах ажиллагаанд байгаа бөгөөд яллагдагч этгээдүүд авилга авсан, албан тушаалаа урвуулан ашигласан гэмт хэргээр яллагдаж байгаа юм байна. 2011 оны 12 дугаар сард, парламентын доод танхим тухайн үеийн улсын дээд шүүхийн ерөнхий шүүгчийг эрүүгийн хариуцлагад татахыг хүлээн зөвшөөрсөн байна. Эрүүгийн хэрэг үүсгэсэн үндэслэл нь хээл хахууль авсан, албан тушаалаа урвуулан ашигласан гэх үндэслэлээр үүссэн байна. Улмаар 2012 оны 5 дугаар сард парламентын дээд танхимаас уг шүүгчийг буруутай гэж үзэн ял ногдуулсан байна. 2012 оны 7 дугаар сард, Омбудсманы байгууллагаас Глориа Арроё (Gloria Arroyo) ерөнхийлөгч болон холбогдох төрийн албан хаагчдыг “буяны хонжворт сугалаа” нэрээр 366 сая филиппин доллар завшсан гэх үндэслэлээр эрүүгийн хариуцлагад татсан байна. Уг хэргийг тусгай шүүхийн (Sandiganbayan) анхан шатны шүүхэд харьяалан шийдвэрлэх юм. Түүнчлэн 2012 оны 7 дугаар сард цөөнгүй төрийн албан хаагчид авилга авсан, албан тушаалаа урвуулан ашигласан хэргээр эрүүгийн хариуцлагад татагдаад байна.

Бүс нутаг		Зүүн Өмнөд Ази
Улс		Тайландын хаант улс
2011 CPI	Байр	80/183
	Оноо	3.4
Авилгатай холбоотой хууль тогтоомж	Төрийн албан хаагчид холбоотой авилга	Тайланд улсад авлигын гэмт хэргийг Эрүүгийн хууль, Төрийн албан хаагчийн холбогдсон гэмт хэргийн хууль, Авилгатай тэмцэх ерөнхий хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрэм, Ёс суртахуун ёс зүйн бодлогын дүрэм болон ёс зүйн стандартад үндэслэсэн төрийн албан хаагчийн эд хөрөнгө, бэлэг хүлээн авахтай холбоотойгоор Улсын авилгатай тэмцэх газарт мэдэгдэх журам зэрэг хууль, дүрэм журмаар зохицуулдаг байна. Ерөнхий зарчмын хувьд авилга авсан этгээд, зуучилсан этгээд, хүлээн авсан этгээдүүдэд эрүүгийн хариуцлага ногдуулдаг байна. Авилга өгөх: Төрийн албан хаагчаар хууль бус үйл ажиллагаа хийлгэх, эс үйлдэхүй, мөн албан үүргийг тасалдуулах, удаашруулах зорилгоор эд хөрөнгө, ашиг амалсан, гэрээ байгуулсан, ярилцаж тохирсон, амлалт өгсөн бол дараах ял шийтгэл ногдуулахаар заасан байна. (Эрүүгийн хуулийн 144 дүгээр зүйл) Үүнд: - Тав хүртэл жил хорих, 10000 хүртэлх тайланд бахт (baht)-аар торгох - Шүүгч, прокурор болон бусад шүүн таслах ажиллагаанд оролцогч төрийн албан хаагчийн авилгын гэмт хэрэгт 7 жил хүртэлх хорих ял, 14000 хүртэлх тайланд бахт (baht)-аар торгоно. (Эрүүгийн хуулийн 167 дугаар зүйл) Авилга авах: Төрийн албан хаагч үйлдэл болон эс үйлдэхүйгээр эд хөрөнгө, ашиг хонжоо шаардсан, түүнчлэн олж авахаар тохиролцсон бол дараах ял шийтгэл ногдуулна. - Таваас хорин жил хүртэлх хугацаагаар хорих болон 20-40 тайланд бахт (baht)-аар торгох эсвэл цаазаар авна. Авилгын гэмт хэргийн бүрэлдэхүүн нөхцөл нь төрийн албан хаагчийн үйлдэл эс үйлдэхүй нь тухайн албан хаагчийн хуульд заасан үүрэгтэй зөрчилдсөнөөр бий болно. Хуулийн этгээдийн хариуцлага: Хуулийн этгээдийн төлөөлөгч эрх хэмжээнийхээ хүрээнд хуулийн этгээдийн ашигтай үйл ажиллагааны төлөө авилга өгсөн бол хуулийн этгээдийг эрүүгийн хариуцлагад татах боломжтой. Хуулийн этгээдэд зөвхөн торгох ялыг хэрэглэдэг. Гэхдээ авилга өгсөн компанийн төлөөлөгчийг хувь хүнийх нь үүднээс эрүүгийн хариуцлагад татдаг байна.
	Гадаадын улсын төрийн албан хаагчид холбогдох авилга	Тайланд улсад өнөөгийн байдлаар гадаад улсын төрийн албан хаагч болон олон улсын байгууллагын ажилтанд холбогдуулж авилгын гэмт хэргээр эрүүгийн хариуцлагад татах эрх зүйн орчин байхгүй. Тайландын хууль боловсруулах газраас гадаад улсын төрийн албан хаагчид холбогдох авилгын гэмт хэрэг, албан тушаалаа урвуулан ашиглах гэмт хэргийг зохицуулах шинэ хуулийн төслийн боловсруулж байгаа. Гэхдээ одоогийн байдлаар уг хуулийн төсөл засгийн газраар хэлэлцүүлээгүй байна.
	Ард иргэдийн дундах авилга	Тайланд улсад өнөөгийн байдлаар иргэд хоорондын авилгыг гэмт хэрэгт тооцдоггүй. Гэхдээ авилга нь үгсэн хуйвалдсан тендер болон бусад хууль бус аргаар явагдсан бол Шударга бус өрсөлдөөний тухай хууль болон Тендер үгсэн хуйвалдах тухай хуулиар эрүүгийн хариуцлагад татах боломжтой.
Тодорхойлолт	Төрийн албан хаагч	Төрийн албан хаагчийг өөр өөрөөр тодорхойлсон байдаг байна. Эрүүгийн хуульд: төрийн албан хаагч гэдэг нь Тайландын засгийн газраас цалин хөлс авдаг эсэхээс үл хамааран, захиргааны чиг үүргийг гүйцэтгэж буй засгийн газраас томилогдсон этгээдийг хэлнэ гэж тодорхойлсон. Төрийн эзэмшлийн үйлдвэрийн газрын ажилчид төрийн албан хаагчид хамаардаг. Засгийн газрын албан хаагчийн хуульд: Засгийн газрын үйл ажиллагаатай холбоотой байгууллагын ажилтан гэдэг нь Тайландын засгийн газар үндсэн хөрөнгийн 50 дээш хувийг эзэмшдэг байгууллага, үйлдвэрийн газарт ажилладаг этгээдийг хамааруулна гэж заасан. Авилгатай тэмцэх хуульд: Нийтийн албанд ажилладаг этгээд гэдэг нь улс төрийн албан тушаалтан, төрийн өмчит үйлдвэрийн газарт албан үүрэг гүйцэтгэж буй этгээдийг хэлнэ гэж тодорхойлжээ.
	Бэлэг, илгээмж (бэлэглэх, хүлээн авалт)	Авилгатай тэмцэх зөвлөлийн 2000 онд гаргасан "3000 тайланд бахтын дүрэм"-д зааснаар төрийн албанд ажиллаж буй этгээд гэр бүлийн гишүүнээс бусад хүнээс хэлбэр харгалзалгүй 3000 тайланд бахтаас дээш үнийн дүн бүхий бэлэг авахыг хориглоно. Хэрэв төрийн албанд ажиллаж буй этгээдэд хамтран ажиллагч, найз нөхөд, дотно харилцаа бүхий этгээдийн бэлэглэсэн 3000 тайланд бахтаас дээш үнийн дүн бүхий бэлэг хүлээж авахаар бол дээд шатны албан тушаалтанд мэдэгдэх үүрэгтэй бөгөөд дээд шатны албан тушаалтан нь уг бэлгийг авч болох эсэх, эсвэл буцаахыг шийддэг байна.

АВЛИГА, АЛБАН ТУШААЛЫН ГЭМТ ХЭРЭГ

Ө н ө ө г и й н нөхцөл байдал	Хэрэгжүүлэх байгууллага	Авлигатай тэмцэх зөвлөл нь авлигын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, мөрдөн шалгахын тулд 1997 онд Үндсэн хууль болон Авлигатай тэмцэх хуульд үндэслэн байгуулагдсан. Авлигатай тэмцэх зөвлөл нь өргөн хүрээний эрх мэдэлтэй боловч гэмт хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэх эрх мэдэл байхгүй бөгөөд эрүүгийн хэрэг үүсгэхийн тулд прокурорт хэргийг танилцуулах шаардлагатай байсан бөгөөд уг хуулийн 2011 оны нэмэлт өөрчлөлтөөр Авлигатай тэмцэх зөвлөлд Эрүүгийн хэрэг үүсгэх хэлтэс байгуулах тухай заалт оруулсан байна. Авлигатай тэмцэх зөвлөл нь төрийн албан хаагчийн талаар авлигын гэмт хэргийн гомдол мэдээллийг шийдвэрлэн таслах, парламентын дээд танхимд мэдээллэх үүрэг бүхий байгууллага юм.
	Хэрэгжүүлэхтэй холбоотой асуудал	Авлигатай тэмцэх зөвлөлийн хүний нөөцийн дутагдал: Авлигатай тэмцэх тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулахаас өмнө Авлигатай тэмцэх зөвлөлд ердөө 9 хүний орон тоотой ажилладаг. 2003 онд эрүүгийн хэргийн гэрчийг хамгаалах хууль батлагдсан боловч Авлигатай холбоотой хууль тогтоомжийн хүрээнд авилгын талаар мэдээлэл өгсөн болон хэргийн гэрчийг хамгаалах тогтолцоо сул.
	Сүүлийн үеийн чиг хандлага	Авлигатай тэмцэх тухай хуулийн нэмэлт өөрчлөлт, шинэ хуулийн төслийн хүрээнд гадаад улсын төрийн албан хаагчийн холбогдох авилгын гэмт хэргийг зохицуулсан заалт оруулахаар хэлэлцүүлэг өрнөсөн боловч нааштай шийдэгдээгүй байна. Авлигатай тэмцэх тухай хуулийн 2011 оны нэмэлт өөрчлөлтөөр Орон нутгийн авилгатай тэмцэх зөвлөлийг байгуулсан байна. Орон нутгийн авилгатай тэмцэх зөвлөл нь ерөнхийдөө Авлигатай тэмцэх зөвлөлийн чиг үүргийг орон нутагт хэрэгжүүлэх чиг үүрэгтэй. 2013 оны 4 дүгээр сард Орон нутгийн авлигатай тэмцэх зөвлөл үйл ажиллагаанд орсноор төв Авлигатай тэмцэх зөвлөлөөс 200 албан хаагчийг орон нутагт томилж, авилгыг мөрдөн шалгах хүний нөөцийг бэхжүүлсэн байна.

Бүс нутаг		Зүүн Өмнөд Ази
Улс		Социалист Бүгд Найрамдах Вьетнам улс
2011 CPI	Байр	112/183
Авлигын индекс	Оноо	2.9
А в л и г а т а й х о л б о о т о й х у у л ь т о г т о о м ж	Төрийн албан х а а г ч и д х о л б о о т о й авлига	Эрүүгийн хууль болон 2005 оны Авлигатай тэмцэх тухай хуульд авлига өгсөн, авсан, зуучилсан бол гэмт хэрэгт тооцохоор зохицуулсан байна. Авлига өгөх: 2 сая вьетнам дон-оос дээш үнэ бүхий авилга өгсөн үйлдэл нь гэмт хэрэгт тооцогдоно. Хуульд нарийн тодорхой заагаагүй боловч авлига нь засгийн газар болон нийтийн байгууллагын эрх мэдэл бүхий шийдвэр гаргах түвшний албан тушаалтанд өгсөн авлига байх ёстой гэж тайлбарладаг байна. Авлига авах: Авлига авагч нь эрх мэдэл, албан тушаалаа ашиглан 2 сая вьетнам дон-оос дээш авлига авсан үйлдэл эс үйлдэхүй хийсэн бол гэмт хэрэгт тооцохоор хуульчилсан байна. Авлигад зуучлагч: Албан тушаалаа урвуулан ашиглах нь авлигын гэмт хэрэгтэй холбоотой бол Эрүүгийн хуулиар авлигад зуучилсан этгээд эрүүгийн хариуцлага хүлээнэ. Хуулийн этгээдэд ял ногдуулдаггүй бөгөөд зөвхөн хувь хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэдэг. Хувь хүнд бүх насаар нь хорих ял болон хугацаатай хорих, авсан авилгын үнийн дүнг 5 дахин нэмэгдүүлсэн торгууль төлөх, тодорхой хугацаагаар тусгай албан тушаалд ажиллахыг хориглох зэрэг эрүүгийн хариуцлага хүлээлгэдэг байна.
	Г а д а а д ы н улсын төрийн албан хаагчид х о л б о г д о х авлига	Вьетнам улсад гадаад улсын төрийн албан хаагчид холбогдох авилгын гэмт хэргийг зохицуулсан хууль байхгүй. Авлигатай тэмцэх хуульд гадаад улсын төрийн албан хаагчийн холбогдох авилгын талаар дурьдаагүй бөгөөд энэ хууль гадаад улсын төрийн албан хаагчид хамаарахгүй. Засгийн газраас UNCAC гэрээг биелүүлэхийн тулд Авлигатай тэмцэх тухай шинэ хуулийн төслийн хүрээнд гадаад улсын төрийн албан хаагчид холбогдох авилгын гэмт хэргийн талаар зохицуулалт оруулах эсэх нь тодорхойгүй байна.
	Ард иргэдийн дундах авлига	Вьетнамд иргэд хоорондын авлигыг зохицуулсан дотоодын эрх зүйн тогтолцоо байхгүй. Засгийн газрын байгууллагын шийдвэр гаргах түвшний албан хаагчид холбогдох хэрэгт эрүүгийн хариуцлага хүлээлгэдэг.

Тодорхойлолт	Төрийн албан хаагч	Авлигатай тэмцэх тухай хуульд "эрх мэдэлтэй, өндөр албан тушаал бүхий этгээд" гэдэгт сонгогдсон болон томилогдсон үндсэн албан хаагч, засгийн газраас цалинждаг нийтийн албан хаагч, цэргийн албан хаагч, цагдаа, болон төрийн өмчит компанийн эрх бүхий албан тушаалтан, удирдах албан тушаалтан хамаардаг байна.
	Бэлэг, илгээмж (бэлэглэх, хүлээн авалт)	Ерөнхий сайдын баталсан 64/2007/QD-ТТ тушаалд төрийн төсвийг захиран зарцуулах байгууллагын үндсэн албан хаагч болон төрийн албан хаагчид бэлэг өгөх, төрийн албан хаагчид хариу талархал илэрхийлэх талаарх зохицуулалтыг оруулж, төрийн албан хаагч хүлээн авч болох бэлгийн хүрээг тогтоож өгсөн байна. Төрийн албан хаагчийн удирдлаган доор ажилладаг байгууллага болон хувь хүнээс ямар нэгэн үндэслэлгүйгээр бэлэг авахыг хориглодог.
Ө н ө ө г и й н нөхцөл байдал	Хэрэгжүүлэх байгууллага	Тусдаа бие даасан чиг үүрэг бүхий байгууллага байхгүй. Олон нийтийн амгалан тайван байдлыг хангах яамны харьяанд, авлигатай тэмцэх хэлтэс гэсэн нэрээр мэргэжлийн чиг үүрэг бүхий хэлтэс болон байгуулагдсан.
	Хэрэгжүүлэхтэй холбоотой асуудал	Эрүүгийн хариуцлагад татах үндэслэл нь 2 сая вьетнам дон-оос давсан авилгыг гэмт хэрэг гэж үзэн эрүүгийн хариуцлага хүлээлгэдэг. Авлигатай тэмцэх тусдаа бие даасан мэргэжлийн байгууллага байхгүй. Авлигатай тэмцэх хэлтэс нь хэргийг шууд мөрдөн шалгах эрх хэмжээ бүхий байгууллага боловч бодит байдал дээр мөрдөн байцаагчид туслах, дэмжлэг үзүүлэх хэмжээнд байна. Шүүх засаглалын хараат бус байдал бүрэн хангагдаагүй бөгөөд дотроосоо тогтолцооны ялзралд орох боломжтой. Байгууллагын дотроос өргөдөл гомдол гаргах тогтолцоо байхгүй бөгөөд иргэдийн хамтын ажиллагаа сул хөгжсөн. Авлигатай тэмцэх талаар явуулсан судалгаанд хамрагдсан аж үйлдвэрийн тал хувь нь үйл ажиллагаагаа явуулахын тулд төрийн албан хаагчид авилга өгөхөөс өөр аргагүй байдалд ордог.
	Сүүлийн үеийн чиг хандлага	Онцгой зүйл байхгүй.

III БҮЛЭГ. АВЛИГА, АЛБАН ТУШААЛЫН ГЭМТ ХЭРГИЙН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ХАНДЛАГА

НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 2003.10.31-ний 58/4 тоот тогтоолоор НҮБ-ын Авлигын эсрэг конвенц (“Конвенц”) батлагдсан нь 1990-ээд оноос хойш авлигатай тэмцэх талаар олон улсын түвшинд хийгдсэн институтын болон эрх зүйн шинжтэй олон алхмыг нэгтгэсэн томоохон баримт бичиг юм.

Конвенц нь үйлчлэх цар хүрээ, зохицуулалтын зүйлс, хууль зүйн хүчин чадлаараа өмнө байгуулагдсан авлигын талаарх бусад бүс нутгийн болон олон улсын гэрээ, конвенцээс илүү өргөн, гүн гүнзгий ба заавал дагаж мөрдөх үүрэг хүлээлгэсэн олон заалттай.

Монгол Улс Конвенцийг 2005 онд соёрхон баталж, энэ нь 2006 оны 2 сараас манай улсад хүчин төгөлдөр үйлчилж, улмаар Конвенцийг хэрэгжүүлэхтэй холбоотой олон ажил явагдаж байна.

Конвенцийн хэрэгжилтийг хянах механизмын хүрээнд Азийн Хөгжлийн Банк, Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага зэрэг хэд хэдэн субъектээс үнэлгээ хийж, манай улсын хууль эрх зүйн орчин, ялангуяа авлигын гэмт хэргийг хуульчлах асуудал Конвенцийн шаардлагыг бүрэн хангаж чадахгүй байгааг анхааруулж ирсэн билээ.

Нөгөө талаас, авлигын гэмт хэрэг, мөнгө угаах гэмт хэрэг, бусад зохион байгуулалттай гэмт хэргийн гаралт энэхүү хууль эрх зүйн орчныг илүү боловсронгуй, нарийн болгохыг шаардаж байна.

Хууль зүйн яамнаас Шударга ёсыг хамгаалах тогтолцооны шинэтгэлийн хүрээнд Гэмт хэргийн тухай хуулийн төслийг боловсруулахад НҮБ-ын тус конвенцийн үзэл санаа, заалтуудыг удирдлага болгосон бөгөөд “Авлига, албан тушаалын гэмт хэрэг” гэсэн бүлэг шинээр боловсруулан УИХ-д өргөн бариад байна.

3.1. НИЙТИЙН АЛБАН ТУШААЛТАНД ХЭЭЛ ХАХУУЛЬ ӨГӨХ, АВАХ ГЭМТ ХЭРЭГ

НҮБ-ын Конвенцээр, дотоодын нийтийн албан тушаалтанд нэг талаас хээл хахууль өгөх (энд амлах, санал болгохыг мөн хамруулна) нөгөө талаас дотоодын албан тушаалтан өөрөө хээл хахууль авах (энд хээл хахууль авахаар хясан боогдуулж, шахалт үзүүлэхийг мөн хамруулна) үйлдлүүдийг заавал гэмт хэрэгт тооцох ёстой гэж гишүүн орнуудад үүрэг болгосон. Монгол Улс Эрүүгийн хуульд (268, 269, 270 заалт) эдгээр үйлдлийг тодорхой хэмжээнд гэмт хэрэгт тооцон, зохицуулсан боловч дараах учир дутагдалтай байна.

1. “Төрийн /нийтийн/ албан тушаалтан гэсэн нэр томъёог тодорхойлох.

2002 оны Эрүүгийн хуулийн 268, 269-д “...албан тушаалтан хээл хахууль авсан бол эсвэл албан тушаалтанд хээл хахууль өгсөн бол...” гэж “албан тушаалтан” гэсэн нэр томъёог ашиглажээ. Гэвч уг нэр томъёог Эрүүгийн хуульд өөрт нь эсвэл холбогдох бусад хууль, УДШ-ийн тогтоолд тодорхойлж, тайлбарлаагүй байна.

Өөрөөр хэлбэл “албан тушаалтан” гэдгээр төрийн эсвэл хувийн байгууллагын алиных нь албан тушаалтныг ойлгох, тэр дундаа аль түвшний ямар албан тушаалтан байх нь тодорхойгүй байна. Практикт үүнийг зөвхөн төрийн байгууллагын дээд, удирдах албан тушаалтнууд гэж ойлгон хэрэглэж байна (төрийн байгууллагын бусад албан тушаалтан эсвэл төрийн байгууллагын чиг үүргийг хэрэгжүүлж нийтэд үйлчилдэг хувийн байгууллагын бусад албан тушаалтан эсвэл бүр хувийн байгууллагын албан тушаалтан зэргийг хамруулдаггүй).

Гэвч энэ ойлголт хуульд томъёолсонтой нийцэхгүй, ямар ч байдлаар ойлгогдохоор байна. Энэ нь зарим гэм буруутай албан тушаалтныг ял завших эсвэл зарим гэм буруугүй хүнийг гэмт хэрэгтэн болгох, хэлмэгдүүлэх, улмаар эцэстээ хээл хахууль, авлигын гэмт хэргийн суурь ойлголт, үзэл санааг гажуудуулах, буруу тодорхойлох томоохон сөрөг үр дагаврыг бий болгож байна.

Иймд тус “албан тушаалтан” гэсэн нэршлийг НҮБ-ын Конвенц, авлигын талаарх бусад олон улсын конвенц болон гадаад орнуудын туршлагад үндэслэн зөв нэр томъёонд оруулах, нарийн тодорхойлох шаардлагатай юм. НҮБ-ын Конвенцэд “албан тушаалтан” гэдэг нэр томъёог бус “нийтийн албан тушаалтан (public official)” гэсэн нэр томъёог ашиглаж улмаар түүнийг тодорхойлохдоо:

(i) хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн томилогдсон, сонгогдсон, түр, байнгын, цалинтай, цалингүй бүх төрлийн албан тушаалтан,

(и) дотоодын хуулиар тодорхойлсоноор нийтийн чиг үүргийг гүйцэтгэж байгаа, эсвэл нийтэд аливаа үйлчилгээ үзүүлдэг хуулийн этгээдийн ажилтан, эсвэл аливаа хувь этгээд этгээд ,

(iii) дотоодын хууль тогтоомжоор “нийтийн албан тушаалтан” гэж тодорхойлсон бүх албан тушаалтан”-г бүгдийг хамруулна гэж зүйлчилжээ.

Эндээс харахад НҮБ-ын Конвенц нь авлигын гэмт хэрэгт “нийтийн албан тушаалтан (public official)” гэсэн нэршлийг ашиглаж, түүнийг маш өргөн хүрээгээр тодорхойлж өгсөн байна. Тодорхойлолтын амин сүнс, гол санаа нь нэгдүгээрт, төрийн нэрийн өмнөөс “нийтийн чиг үүргийг хэрэгжүүлдэг” эсвэл “нийтэд аливаа үйлчилгээ үзүүлдэг” л бол аль ч өмчийн хэлбэрийн ямар ч албан тушаалтан, эсвэл хувь хүн хээл хахууль буюу авлигад өртөх магадлалтай, эрсдэлтэй болдог учир эдгээр бүх этгээд хээл хахууль буюу авлигын гэмт хэргийн субъект болно гэсэн санаа, агуулга юм.

Өөрөөр хэлбэл, энд зөвхөн төрийн байгууллагын ажилтан, албан хаагчдыг хамруулахгүй, мөн төрийн нэрийн өмнөөс нийтийг чиг үүрэг гүйцэтгэж буй, нийтэд үйлчилгээ үзүүлж буй хувийн өмчийн байгууллага,

төрийн бус байгууллагын албан тушаалтан эсвэл бүр хувь хүн ч (жишээ нь шүүх хуралд оролцож буй иргэдийн төлөөлөгч) мөн адил гэмт хэргийн субъект болж болохыг илэрхийлж байгаа юм.

Харин энд гол шалгуур болох “нийтийн чиг үүрэг”, “нийтийн үйлчилгээ” гэдгээр юуг ойлгохыг гишүүн орон өөрөө дотоодын хуулиараа тодорхойлох учиртай гэж Конвенц онцолжээ.

Хоёрдугаарт, албан тушаалтан нь томилогдсон, сонгогдсон, байнгын эсвэл түр, цалинтай эсвэл цалингүй (сайн дурын ажилтан ч юмуу), ахлах түвшний эсвэл туслах түвшний албан тушаалтан байхаас үл хамааран бүх төрлийн албан тушаалтан, ажилтан субъект болохыг Конвенц мөн онцолсон байна.

Мөн үүнээс гадна, авлигын талаарх бусад олон улсын конвенцууд ч тус үзэл санааг гол удирдлага болгон “нийтийн албан тушаалтан” гэсэн нэршлийг ашиглаж, түүнийг өргөн утгаар тодорхойлсон байна. Жишээ нь, ЭЗХАХБ-ын Хээл хахуультай тэмцэх конвенцэд “Нийтийн албан тушаалтан гэж хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн салбарт томилогдсон буюу сонгогдсон аливаа этгээд, эсвэл нийтийн чиг үүргийг гүйцэтгэж байгаа аливаа этгээдийг хэлнэ” гэсэн бол Авлигын эсрэг Америкийн конвенцэд “нийтийн албан тушаалтан гэдэгт төрийн нэрийн өмнөөс үйлчилгээ үзүүлж байгаа, төрийн нэрийн өмнөөс үүрэг гүйцэтгэж байгаа, томилогдсон, сонгогдсон, шалгарсан бүх шатны албан тушаалтнууд болон төрийн бүх байгууллагад бүх төрлийн албан тушаалтан, ажилтныг ойлгоно” гэж тодорхойлжээ.

Эдгээрээс гадна НҮБ-ын Авлигын эсрэг конвенцэд хувийн хуулийн этгээдийн (хувийн өмчит хуулийн этгээдийн) ажилтан, албан тушаалтантай холбогдох хээл хахуулийн гэмт хэргийг тусдаа, бие даасан заалтаар зохицуулж, тус гэмт хэргийн субъектийг “person” буюу хувь этгээд гэж нэрлэн тодорхойлсон тул энэ нь дээр тайлбарласан нийтийн эрх зүйн хуулийн этгээдийн гэмт хэргийн субъект болох “public official” буюу “нийтийн албан тушаалтан”-д хамаарахгүйг дурьдах нь зүйтэй.

Мөн Монгол Улсад шинээр батлагдсан Сонирхлын зөрчлийн тухай хуульд “нийтийн албан тушаалтан” гэсэн нэршлийг анх удаа хэрэглэж, түүнийг тодорхойлсон боловч энэ нь агуулгын хувьд НҮБ-ын Конвенцээс явцуу хүрээг хамарсан учир НҮБ-ын Конвенц дахь “нийтийн албан тушаалтан” гэсэн тодорхойлолтын шаардлагыг агуулгын хувьд хангахгүй байгаа юм.

Жишээ нь, Сонирхлын зөрчлийн тухай хуулийн тодорхойлолтоор “нийтийн албан тушаалтан”-д төрийн үйлчилгээний албаны зөвхөн удирдах албан тушаалтныг хамруулж, бусад гүйцэтгэх, туслах төрлийн албан тушаалтныг орхигдуулсан байна.

Ингэснээр НҮБ-ын Конвенцийг агуулгыг ч бүрэн хамарч чадахгүй байгаагаас гадна хэрэв тус тодорхойлолтыг Эрүүгийн хуульд ишлэн авч хэрэглэвэл, тухайлбал төрийн үйлчилгээний албаны “гүйцэтгэх” ангиллын албан тушаалтан болох багш, эмч гэх мэт хээл хахуульд өртөмтгий хэсэг хуулийн харъяаллын гадна үлдэх үр дагавар бий болно.

Иймд Эрүүгийн хууль дахь хээл хахуулийн гэмт хэргийн “албан тушаалтан” гэсэн нэршлийг оновчтой томъёоллоор өөрчилж, НҮБ-ын Конвенц дахь агуулгад нь нийцүүлэн өргөн утгаар, нарийн тодорхойлж өгөх нь зүйтэй.

1. “Хээл хахууль” нэр томъёоны тодорхойгүй байдал.

ЭХ-ын 268, 269 болон 270 дугаар заалт дахь хээл хахуулийн гэмт хэргүүдэд хээл хахууль авсан, хээл хахууль өгсөн, хээл хахуульд зуучилсан бол гэж “хээл хахууль” гэсэн нэр томъёог ашиглажээ. Гэвч тус нэр томъёогоор чухам юуг ойлгох вэ гэдгийг Эрүүгийн хууль, холбогдох бусад хууль болон Дээд шүүхийн тогтоолын алинаар нь ч тодорхойлоогүй байна.

Хээл хахуулийн гэмт хэргийн хамгийн чухал, суурь нэр томъёог ийнхүү тодорхойлоогүй байгаа нь өөрөө уг гэмт хэргийг тогтоох, тодорхойлох, гэм буруутай этгээдийг олж, хариуцлага тооцоход хүндрэл учруулж байна.

Тэгвэл НҮБ-ын Конвенцийн хээл хахуулийн гэмт хэргийн зүйлчлэлд “хээл хахууль” бус “хууль бус давуу байдал” гэсэн нэр томъёог ашигласан.

Тухайлбал, ..зорилгоор нийтийн албан тушаалтанд хууль бусаар давуу байдал олгосон бол. . . эсвэл . . . зорилгоор нийтийн албан тушаалтан нь өөртөө гуравдагч этгээдээс хуульбусаар давуу байдлыг олж авсан бол ...” гэх мэтээр томъёолж өгсөн. Улмаар “хууль бус давуу байдал” гэдгээр юуг ойлгохыг Конвенцийн Эрх зүйн удирдамжид тодорхой тайлбарласан бөгөөд үүний дагуу, “хууль бус давуу байдал” гэдгээр зүй бусаар олдсон мөнгөн, мөнгөн бус, эдийн болон эдийн бус бүх төрлийн зүйлсийг ойлгох ажээ.

Өөрөөр хэлбэл, бэлэн мөнгөнөөс эхлээд, хөнгөлөлттэй зээл, хөнгөлөлттэй эсвэл үнэгүй гишүүнчлэл, аялал, үйлчилгээ, сургуульд орох эрх, бусад бүх төрлийн өмчийн эрх (хөрөнгийн бирж, хувьцаа эзэмших, хувь хүртэх гэх мэт), нууц мэдээлэл, ноу хау болон секс, зугаацуулах зүйлс зэргийг ойлгож байна.

НҮБ-ын Конвенцийн энэ санаа ихэнх гишүүн орны дотоодын хуульд тусгалаа олж нарийн, ойлгомжтой тодорхойлогдсон байна. Тухайлбал, Швейцарь улс “undue advantage буюу хууль бус давуу байдал”, Австрали улс “gift or any other kind of benefit whether pecuniary or otherwise - бэлэг эсвэл мөнгөн болон бусад төрлийн бусад ашиг хонжоо”, Болгар улс “material or non-material benefit - материаллаг эсвэл материаллаг бус ашиг хонжоо” гэх мэтээр зүйлчилсэн бол Сингапур улс илүү нарийвчлан “gratification - шан харамж” гэж нэрлээд тус “gratification”-нд “бэлэн мөнгө, зээл, эд хөрөнгө, үнэт цаас, ажлын байр, ирээдүйд олгох шан харамж, хувьцааны эрх ...” гэх мэт орно гэж жагсаалт гаргах хэлбэрээр тодорхойлжээ.

Мөн Гүрж улсын эрүүгийн хуульд хээл хахуулийн хэлбэрүүдийг, мөн түүний үнийн дүнг нарийн тодорхойлсон байна. Жишээ нь, их хэмжээний хээл хахуульд бэлэн мөнгө, үнэт цаас, эд хөрөнгө болон бусад ашигтай хэлбэрээр илэрхийлэгдсэн 10000-аас дээш Ларрис-мөнгөн тэмдэгтийг ойлгоно гэх мэтээр. Европын Зөвлөлийн конвенц, ЭЗХАХБ-ын конвенц гэх мэт авлигатай холбогдох бусад олон улсын конвенцэд ч мөн “undue advantage” буюу давуу байдал гэсэн нэршлийг ашиглажээ.

Хоёрдугаарт, эдгээр конвенц болон бусад гадаад орнуудын өөр нэг нийтлэг зүйлийг тэмдэглэвэл, тэдгээрийн ихэнх нь “bribery” буюу “хээл хахууль” гэсэн нэршлийг, конвенцийн нэгэн адилаар, зөвхөн тухайн гэмт хэргийн төрлийг нэрлэхдээ буюу гарчиг хэсэгт ашиглаж (bribe giving crime, bribe taking crime гэх мэтээр), харин зүйлчлэл хэсэгт ялгаатай нэр томъёо болох “undue advantage - хууль бус давуу байдал”, “material or non-material benefit-материаллаг эсвэл материаллаг бус ашигтай байдал”, “Money or any other advantage - мөнгөн болон бусад төрлийн давуу байдал” гэх мэт “bribery”-аас өөр нэр томъёог өргөнөөр ашигласан нь анзаарагдаж байна.

Гэтэл манай ЭХ-д “bribery” буюу “хээл хахууль” нэршлийг гэмт хэргийн төрлийг нэрлэхдээ ч түүнийг зүйлчлэхдээ ч нэгэн адил ашиглажээ. Энэ нь болохгүй зүйлгүй ч конвенцийн болон бусад гадаад орны нийтлэг жишгээр томъёолбол илүү зохимжтой болов уу. Хамгийн гол нь “Bribery - хээл хахууль” гэдэг томъёоллоор ч бай, “undue advantage-хууль бус давуу байдал” эсвэл өөр бусад томъёоллыг ч хэрэглэсэн эцсийн дүндээ тус томъёоллыг нарийн тодорхойлж өгөх нь чухал.

Хээл хахуулийг тодорхойлохдоо i) Гүрж улс шиг үнэлэмж, үнийн дүнг тодорхойлох замаар эсвэл (ii) Сингапур улс шиг хээл хахуульд хамрагдах зүйлсийг жагсаан бичих замаар эсвэл (iii) хээл хахуульд хамаарахгүй зүйлсийг жагсаах замаар тодорхойлж болно.

Хэдийгээр Эрүүгийн хуульд “хээл хахууль” гэдэг нэр томъёог хэрэглэсэн боловч, НҮБ-ын Конвенц болон гадаадын хуулиудад нийтлэгээр хэрэглэсэн “давуу байдал” болон “ашиг хонжоо” гэсэн 2 нэр томъёог манай улс Эрүүгийн хуульд бус Авлигын эсрэг хуулиар тодорхойлж өгсөн байгааг тэмдэглэх нь зүйтэй.

Гэсэн хэдий ч тус тодорхойлолтуудыг Эрүүгийн хуультай уяж, түүнд ишлэн хэрэглээгүй бөгөөд Авлигын эсрэг хуульдаа ч “нэр томъёоны тодорхойлолт” гэсэн хэсгээс өөр хэсэгт хэрэглээгүй байна. Мөн “бэлэг”, “хандив” гэх мэт ойлголтуудыг Сонирхлын зөрчлийн тухай хуулиар тодорхойлсон боловч мөн Эрүүгийн хуультай уяж, уялдуулаагүй байна. Иймд шинээр Эрүүгийн хуульд тусгах тодорхойлолтыг эдгээр бүх тодорхойлолттой уялдуулах, холбон- уях, эсвэл нэгтгэх, ижилсүүлэх замаар эдгээр салангид олон ойлголтыг аль аль хуульд тодорхой, ойлгомжтой, авцалдаатай болгох шаардлагатай.

2. Эрүүгийн хууль дахь “хээл хахууль”-ийн гэмт хэргийн зохицуулалт, мөн хууль дахь “хууль бус шан харамж”-ын зохицуулалт, Сонирхлын зөрчлийн хууль болон Төрийн албаны тухай хууль дахь “бэлэг сэлт”-ийн зохицуулалтуудын харилцан уялдаа, зааг ялгаа тодорхойгүй байна.

НҮБ-ын Конвенц шан харамж, бэлэг сэлтний зохицуулалтыг тусад нь салгаагүй. Харин гадаад орны туршлагаас харахад, тэдгээр хуулиудад зарим үйлдлийг хээл хахууль гэж үзэхгүй, хээл хахуульд тооцохгүй тохиолдол байна. Энэ нь тухайн орны соёл, заншил, эрх зүйн уламжлалтай холбоотой бөгөөд улс орон бүрт өөр өөр байна.

Жишээ нь, зарим оронд тодорхой хэмжээнээс доош үнийн дүнтэй бэлэг, шан харамжийг хээл хахуульд тооцохгүй, зарим оронд тодорхой үнийн дүн бүхий шан харамжийг “tip” буюу гар цайлгах мөнгө эсвэл “facilitation fee” буюу

үйлчилгээг түргэвчлэх хөлс гэж үзэж хээл хахуулийн гэмт хэрэгт тооцохгүй тохиолдол байна.

Эдгээр нь эцсийн дүндээ хээл хахуулийн тодорхой хэлбэрийг өөгшүүлж байгаа хэлбэр бус, бүрэн төлөвшөөгүй нийгэм, “шилжилтийн” үед зориулан авч буй “түр” арга хэмжээ юм. Иймд тус арга хэмжээг маш болгоомжтой хэрэгжүүлэх шаардлагатайг ухамсарлан, дийлэнх улсууд тус “бэлэг сэлт” гэсэн ойлголтыг “хээл хахууль”-ийн ойлголтоос нарийн зааглаж, тус бүрт нь бие даасан зохицуулалтын механизмыг тусгаж өгчээ.

Манай орны хувьд Эрүүгийн хуулийн Албан тушаалын гэмт хэргийн бүлэгт “хээл хахууль өгөх, авах, зуучлах” гэмт хэргүүдийг, Аж ахуйн эсрэг гэмт хэргийн бүлэгт “хууль бусаар шан харамж авах” гэмт хэргийг, Сонирхлын зөрчлийн хууль болон Төрийн албаны тухай Хуулиар “бэлэг сэлт”-ний талаарх зохицуулалтыг тус тус оруулжээ. Гэвч эдгээрийн зааглал, эсвэл уялдаа холбоо нь тодорхойгүй байна.

Нэгдүгээрт, хээл хахууль өгөх, авах, зуучлах гэмт хэргийг (268, 269, 270 дугаар зүйл) “Албан тушаалын гэмт хэрэг” гэсэн бүлэгт, “хууль бусаар шан харамж авах” гэмт хэргийг (170 дугаар зүйл) “Аж ахуйн эсрэг гэмт хэрэг” гэсэн бүлэгт хамруулж “хууль бусаар шан харамж авах” гэмт хэргийн субъектийг зөвхөн тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллагын ажилтан байна гэж явцуу тодорхойлсон. Энэ субъектээс өөр бусад этгээд шан харамж авбал яах вэ, мөн хээл хахууль болон шан харамжийг хэрхэн ялгах нь тодорхойгүй байна.

Ихэнх улсуудад эдгээр гэмт хэргийг а) гэмт хэргийн нэг төрөл бүлэгт хамруулж, б) субъектийг “нийтийн албан тушаалтан” гэж өргөн хүрээгээр тодорхойлсон. Жишээ нь Гүржийн Эрүүгийн хуульд “хууль бус шан харамж авах” тухай 340 дүгээр заалтыг “хээл хахууль авах”, “хээл хахууль өгөх” тухай зохицуулалтуудтай нэг бүлэгт хамруулан, улмаар “хууль бус шан харамж авах” гэмт хэргийн субъектийг “нийтийн албан тушаалтан” гэж тогтоожээ.

Хоёрдугаарт, өөр нэг зохицуулалт нь, Сонирхлын зөрчлийн тухай хууль болон Төрийн албаны тухай хуулиар аливаа төлбөр урамшуулал, бэлэг сэлтний асуудлыг зохицуулсан. Үүгээр албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэснийхээ төлөө тодорхой дүнгээс дээш үнэ цэнэ бүхий бэлэг сэлт, аливаа төлбөр авахыг хориглосон буюу бэлэг сэлтний үнийн дүн тухайн ажилтны нэг сарын цалингийн хэмжээнээс хэтэрвэл мэдэгдэх, 6 сараас хэтэрвэл төрийн өмчлөлд шилжүүлэх үүрэгтэйгээр зохицуулсан. Гэвч энд дараах дутагдал байна:

Бэлэг сэлтийн нийт үнийн дүн тухайн албан тушаалтны 1 сарын цалингийн хэмжээнээс хэтэрсэн тохиолдолд зөвхөн мэдэгдэл хүргүүлэх төдий, харин 6 сарын хөдөлмөрийн хөлснөөс давж байж тус бэлгийг төрийн өмчлөлд шилжүүлж байна. Энэ үнийн дүн нь олон улсын жишиг, пост-социалист, шилжилтийн эдийн засагтай орнуудтай харьцуулахад маш өндөр байгаа юм.

Тухайлбал, шилжилтийн эдийн засагтай ихэнх орнуудад тухайд (Гүрж, Казахстан, Азербайжан, Армен гэх мэт), бэлгийн зөвшөөрөгдсөн нийт үнийн дүн 15-50 ам.долларын хооронд буюу дээд тал нь 50 ам.доллараас

хэтрэхгүй байна. Жишээ нь Казахстаны албан тушаалтан 15 ам.доллар, Гүрж албан тушаалтан 50 ам.доллараас хэтрэхгүй үнэ бүхий бэлэг авахаар зөвшөөрөгдсөн байхад, Монголын албан тушаалтан дээд тал нь 2,400,000 төгрөг буюу 1800 ам.долларын үнэ бүхий бэлэг авч болж байна (төрийн албан тушаалтны дундаж цалинг 400,000 гэж үзвэл, нийт 6 сард 2,400,000 төгрөг бөгөөд үүнээс давж байж л төрийн өмчлөлд шилжүүлнэ). Иймд бэлэг сэлтийн үнийн дүнгийн зөвшөөрөгдөх хэмжээг олон улсын жишигт нийцүүлэн бууруулах шаардлагатай. Энэ нь Монгол улсын ихэнх захиргааны хариуцлагын торгуулийн хэмжээнээс хэд дахин өндөр байгаа нь сонирхолтой.

Сонирхлын зөрчлийн тухай хууль дахь “нийтийн албан тушаалтан” гэсэн нэр томъёоны тодорхойлолт нь учир дутагдалтай, бүрэн бус байгаагийн улмаас (өмнөх хэсэгт тайлбарласан) зарим авлигад өртөмхий албан тушаалтан хуулийн харъяаллаас гадуур үлдэж, бэлэг сэлтний хязгаарлалтад хамаарагдахгүй болж байна. Жишээ нь, тус тодорхойлолтод төрийн үйлчилгээний албанаас зөвхөн “удирдах” төрлийн албан тушаалтныг хамруулж, үлдсэн “гүйцэтгэх” болон “туслах” албан тушаалтнуудыг оруулаагүй байна. Ингэснээр, жишээ нь, төрийн үйлчилгээний “гүйцэтгэх” албан тушаалтан болох авлигад өртөмхий бүлгийн нэг багш, эмч, сувилагч нь хуулиас гадуур үлдэж ямар ч үнийн дүн бүхий бэлэг сэлт авах боломж бүрдэж байна.

Сонирхлын зөрчлийн тухай хууль болон Төрийн албаны тухай хуулийн хариуцлагын хэсгүүдэд, бэлэг сэлтийн талаарх журмыг зөрчвөл “эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй” бол сахилгын болон захиргааны хариуцлага (торгохоос эхлээд ажлаас халах хүртэл) хүлээлгэнэ гэж зохицуулсан. Гэвч энд ямар тохиолдлыг “эрүүгийн хариуцлага хүлээлгэх тохиолдол” гэж үзэх нь тодорхойгүй байна. Цаашлаад, аль тохиолдлыг хээл хахуулийн гэмт хэрэг, аль тохиолдлыг хууль бусаар шан харамж авсан гэж үзэх нь мөн тодорхойгүй.

Иймд Эрүүгийн хууль, Төрийн албаны тухай хууль, Сонирхлын зөрчлийн тухай хуулиар зохицуулсан эдгээр “хээл хахууль”, “хууль бус шан харамж” болон “бэлэг сэлт” гэсэн ойлголтуудыг нарийн зааглаж, хуулиудын уялдаа холбоог хангах шаардлагатай.

3. “Хээл хахууль өгөхийг санал болгох, эсвэл амлах” мөн “хээл хахууль хахууль авахын тулд хясан боогдуулах-шахалт үзүүлэх” үйлдлүүдийг гэмт хэрэгт тооцсон зохицуулалт байхгүй.

Монгол Улсын ЭХ-н 268-д “хээл хахууль авахыг”, 269-д “хээл хахууль өгөхийг” тус тус эрүүгийн гэмт хэрэгт тооцно гэж заажээ. Гэтэл НҮБ-ын Конвенцээр, нэг талаас 15 (а)-ын дагуу хээл хахууль өгөхөөс гадна тийнхүү өгөхийг “амлах” болон “санал болгох”-ыг, нөгөө талаас 15(б)-д зааснаар хээл хахууль авахаас гадна тийнхүү авахаар санаархаж бусдыг “хясан боогдуулах, шахалтад оруулах”-ыг гэмт хэрэг гэж үзэж, тооцохыг гишүүн орнуудад үүрэг болгосон. Гэтэл Монгол улсын Эрүүгийн хуулиар зөвхөн “өгөх” болон “авах” үйлдлүүдийг гэмт хэрэгт тооцон, тэдгээртэй дагалдах үйлдлүүд болох “өгөхөөр санал болгох”, “өгөхийг амлах”, мөн “авахаар хясан боогдуулах” үйлдлүүдийг гэмт хэрэгт тооцоогүй.

Хэдий гэмт хэрэгт тооцоогүй ч Эрүүгийн хуулийн 32 дугаар зүйлийн дагуу эдгээр “өгөхөөр санал болгох”, “өгөхийг амлах” эсвэл “авахаар хясан боогдуулах” үйлдлүүдийг гэмт хэргийн “завдалт” гэж үзэж болохоор байгаа. Конвенцийн Эрх зүйн удирдамжид өгсөн тайлбараар, ийнхүү “завдалт” гэж тооцож болохыг гишүүн орнуудад зөвшөөрсөн ч манай хуулийн тус зохицуулалт нь яг энэ гэмт хэргийн тухайд нийцэлгүй, энэ талаар өнөөдрийг хүртэл практик хэрэглээ, бодит кэйс, шүүхийн шийдвэр гараагүй байна.

НҮБ-ын Конвенцээс бусад авлигын талаарх олон улсын конвенцуудад, тухайлбал гол конвенцууд болох ЕЗ-ийн Конвенц, ЭЗХАХБ-ын Конвенц, Америкийн улсуудын конвенц гэх мэтэд хээл хахууль “өгөхийг санал болгох”, “өгөхөөр амлах” болон “хээл хахууль авахаар хясан боогдуулах” үйлдлүүдийг “өгөх” болон “авах” үйлдлүүдээс тусад нь нэг бүрчлэн эрүүгийн гэмт хэрэгт тооцон хуульчлахыг гишүүн орнууддаа үүрэг болгожээ.

Энэ нь, дээрх үйлдлүүдийг зайлшгүй, тус бүрд нь, бие даасан гэмт хэрэгт тооцох шаардлагатай байгааг олон улсын хамтын нийгэмлэг болон олон улсын стандарт шаардаж буйн илрэл юм.

Тухайлбал, Их Британи 1906 оны хуулиндаа “амлах” гэдгийг шууд бус хэлбэрээр буюу “өгөхийг зөвшөөрөх” гэж үгчлэн оруулсан боловч ЭЗХАХБ-аас тус улсыг уг заалтыг засварлаж яг “амлах” гэдэг үгээр нь хуулиндаа шууд тусгахыг зөвлөсөн байна (Их Британи 2010 онд Авлигын акт гэх шинэчилсэн хуулиа баталсан).

Иймд улс орнууд тус заалтыг биелүүлж, дотоодын хууль тогтоомждоо “өгөх”, “өгөхийг санал болгох”, “өгөхөөр амлах”, “авах”, “авахаар хясан боогдуулах” үйлдлүүдийг салангид, тус бүрд нь гэмт хэрэгт тооцон хуульчлах шаардлагатай болсон.

Тэгвэл гадаад орнуудын тус заалтыг хэрэгжүүлж буй, хуульчилж буй туршлагаас харахад, дийлэнх өндөр хөгжилтэй орнууд, ЭЗХАХБ-ын гишүүн орнууд тус заалтыг хэрэгжүүлж хээл хахууль “өгөхийг санал болгох”, “өгөхөөр амлах” мөн “хээл хахууль авахаар хясан боогдуулах” үйлдлүүдийг хээл хахууль “өгөх” болон “авах” үйлдлүүдээс ялган тусад нь гэмт хэрэг гэж хуульчилсан бол дийлэнх пост-социалист орнууд (Төв Ази болон Зүүн Европын орнууд) зөвхөн “өгөх”, “авах” үйлдлүүдийг хуульчилж, бусад холбогдох үйлдлүүд болох “өгөхийг санал болгох”, “өгөхөөр амлах”, “хясан боогдуулах” зэргийг хуульчлаагүй орхисон байна. Тэдний зарим нь эдгээр үйлдлийг гагцхүү гэмт хэргийн “завдалт” эсвэл “бэлтгэл” гэж үзжээ.

Гэвч үүнд ОУБ-с “конвенцийн үүргээ биелүүлээгүй, хангалтгүй” дүгнэлт өгч, орхигдуулсан үйлдлийг заавал “хуульчлах” зөвлөмжийг хүргүүлээд байна.

Харин өндөр хөгжилтэй, авлигын индексээр дээгүүр зогссон орнуудаас жишээ дурьдахад, тэдгээр нь дээрх үйлдэл тус бүрийг дараах байдлаар хуульчилсан: Швейцарь улс Эрүүгийн хуулийн 322 (а)-даа . . нийтийн албан тушаалтанд хууль бус давуу байдлыг олгох, олгохоор санал болгох, олгохоор амласан бол . . . эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ” мөн 322 (б)-д . . нийтийн албан тушаалтан нь хууль бус давуу байдал олж авах, эсвэл аливаа этгээдийг хясан боогдуулсан бол . . . эрүүгийн хариуцлага хүлээнэ” гэж заасан бол Сингапур улсын Авлигаас урьдчилан сэргийлэх тухай хуулийн 6

(Б)-д “... хууль бус шан харамж өгсөн, эсвэл өгөхийг амласан эсвэл өгөхөөр санал болгосон бол ...эрүүгийн хариуцлага хүлээнэ”, мөн цаашлаад 6(а)-д “..нийтийн албан тушаалтан нь хууль бус шан харамжийг аливаа этгээдээс авсан эсвэл авахаар оролдсон бол . . . эрүүгийн хариуцлага хүлээнэ” гэж тус тус заасан байна.

Тэгвэл пост социалист орнуудаас, жишээ нь Гүрж улс зөвхөн “авах” болон “өгөх” үйлдлүүдийг гэмт хэрэгт тооцсон, мөн хээл хахууль авахаар хясан боох үйлдлийг тусад нь гэмт хэрэг гэж үзэхгүйгээр хээл хахууль авах гэмт хэргийн хүндрүүлсэн хэлбэр гэж үзсэн байна.

Эдгээр өндөр хөгжилтэй орнууд (Итали, Франц, Люксембург гэх мэт) “өгөхөөр амлах”, “өгөхийг санал болгох” болон “хясан боогдуулах” үйлдлүүдийг дараах байдлаар ойлгож хэрэглэж байна. “Амлах” гэдэгт “meeting of two minds” буюу хахууль өгөгч болон хахууль авагчийн санаа зориг нэгдсэн буюу урьдчилан ойлголцон тохиролцсон байхыг шаардана. Энд заавал талуудын “бичгэн” тохиролцоо, бичгээр байгуулагдсан гэрээг ч юмуу шаардахгүй, гагцхүү 1) хахууль өгөгч нь өөрийнх нь өгч буй хахууль (хууль бус давуу байдал) нь хахууль авагчийн үйлдэл, шийдвэрт нөлөөлөх зорилготой, 2) хахууль авагчийн гаргаж буй үйлдэл, шийдвэр нь өөртөө хахууль авах (өөртөө хууль бус давуу байдал олж авах) зорилготой гэдгийг шүүх нотлоход хангалттай гэж үзэж байна.

Харин хээл хахууль “өгөхийг санал болгох”-ын тухайд ихэнх улс энд ердийн аман саналыг дангаар нь тооцохгүй, харин санал гаргахын зэрэгцээ уг саналаа яг биелүүлэхэд бэлэн байгаа нөхцөл байдлыг тооцдог аж.

Жишээ нь, шууд буюу шууд бус байдлаар санал гаргаад, банкнаас мөнгө аваад өгөхөд бэлэн байх ч юмуу, илүү гүнзгий үйлдлийг тооцдог аж. Мөн “хээл хахууль авахаар хясан боох” үйлдлийг extortion буюу сүрдүүлэн заналхийлж хээл хахууль гэмт хэргээс тусдаа гэмт хэрэг буюу энд “сүрдүүлэг, заналхийллийн” шинж чанар байхгүй гэж үзсэн бөгөөд гол шинж чанарыг нь нийтийн албан тушаалтны албан үүргээ үл гүйцэтгэх эсвэл эс үйлдэлтэй холбон ойлгосон байна.

Эцэст нь дурьдахад, албан тушаалтныг хоолонд урих эсвэл албан тушаалтан аливаа этгээдийн гэрээнд шалтгаангүйгээр гарын үсэг зурахгүй удаашруулах гэх мэт үйлдэл нь эдгээр “амлах”, “санал болгох” болон “хясан боогдуулах үйлдлүүд”-ийн манай улс дахь практик жишээ бөгөөд эдгээр нь Монгол улсад түгээмэл байгаа нь эрх зүйн зохицуулалт зайлшгүй үгүйлэгдэж байгаагийн илрэл юм.

Иймд НҮБ-ын Конвенцээр хүлээсэн үүрэг болон бусад олон улсын хамтын нийгэмлэгийн зохицуулалт стандартыг харгалзан Монгол Улс хээл хахууль “өгөхийг санал болгох”, “өгөхөөр амлах” болон “хээл хахууль авахаар хясан боогдуулах” үйлдлүүдийг Эрүүгийн хуульд бие даасан гэмт хэрэгт тооцон хуульчлах шаардлагатай

Ийнхүү гэмт хэрэгт тооцохдоо тэдгээр үйлдлийг бусад орны туршлагад үндэслэн зөв, нарийн тодорхойлж өгөх нь зүйтэй. Эсвэл хэрэв эдгээрийг бусад пост социалист улсуудын адилаар гэмт хэрэгт тооцохоос зайлсхийж, гэмт хэргийн завдалт гэж үзэхээр бол, ерөнхий завдалтыг зохицуулсан Эрүүгийн хуулийн 32 дугаар заалтыг хээл хахуулийн гэмт хэргийн завдалтад

уялдуулан, түүнд хэрэглэж болохуйцаар илүү тодорхой болгох, эсвэл Дээд Шүүхийн тогтоол болон бусад эрх зүйн актаар тус заалтыг хэрхэн хэрэглэх талаар тодорхой зөвлөмж, тайлбар гаргах нь зүйтэй.

4. “Шууд бус” хэлбэрээр хээл хахууль өгөх, авах үйлдлүүдийг гэмт хэрэгт тооцсон зохицуулалт хангалтгүй.

НҮБ-ын Конвенцийн 15 (а)-д хээл хахуулийг өгөхдөө “шууд” хэлбэрээр буюу зөвхөн тухайн албан тушаалтанд өөрт нь өгөхийг бус мөн “шууд бус” хэлбэрээр буюу өөр бусад гуравдагч этгээдэд, байгууллагад өгөхийг мөн адил гэмт хэрэгт тооцох үүрэгтэйг, мөн 15 (б)-д албан тушаалтан хээл хахууль авахдаа түүнийг “шууд” хэлбэрээр буюу зөвхөн ӨӨРТӨӨ бус мөн “шууд бус” хэлбэрээр буюу өөр бусад гуравдагч этгээд байгууллагад авахыг мөн гэмт хэрэг гэж үзэхийг гишүүн улсуудад тус тус үүрэг болгожээ (энд дагалдах үйлдлүүд болох хээл хахууль өгөхийг санал болгох, өгөхөөр амлах эсвэл хээл хахууль авахаар хясан боогдуулахыг мөн ойлгоно).

Конвенцийн Эрх зүйн удирдамжид тайлбарласнаар “шууд бус” хэлбэрээр хээл хахууль өгөх эсвэл авах гэдэгт 1) хахууль өгөгчийн эрх ашгийн үүднээс тухайн албан тушаалтны хийсэн үйлдэл, гаргасан шийдвэрийнх нь төлөө хахууль өгөгч тухайн албан тушаалтанд өөрт нь бус харин түүний гэр бүлийн гишүүн, хамаатан садан, эсвэл харъяалагдах улс төрийн нам зэрэгт нь хээл хахууль өгөх, эсвэл тэдгээр нь хээл хахууль авахыг ойлгоно, 2) хээл хахуулийг хөндлөнгийн этгээдээр, зуучаар дамжуулан өгч авахыг ойлгоно гэж тус тус тайлбарласан байна (энд дагалдах үйлдлүүд болох санал болгох, амлах, хясан боогдуулах үйлдлүүд мөн хамаарна).

Манай улсын Эрүүгийн хуулийн 268, 269, 270-д хээл хахуулийг хөндлөнгийн этгээдээр дамжуулан авсан, өгсөн эсвэл хөндлөнгийн этгээд хээл хахуульд зуучилсан бол тэдгээрийг гэмт хэрэгт тооцно гэжээ. Энд “шууд бус” хэлбэрийн зөвхөн нэг тохиолдол болох “дамжуулах буюу зуучлах” тохиолдол тусгагдсан бөгөөд харин өөр тохиолдол болох гуравдагч этгээд буюу байгууллагад хээл хахууль өгөх тохиолдол зохицуулагдаагүй орхигдсон байна. Өөрөөр хэлбэл, албан тушаалтны гэр бүлийнхэн, хамаатан садан, найз нөхөд, сурч байсан сургууль, клуб, хувь эзэмшдэг компани, улс төрийн нам эсвэл сонгуулийн компани ажилд нь хээл хахууль буюу давуу байдлыг олгосон буюу “шууд бус” хэлбэрээр хээл хахууль өгснийг, эсвэл авсан үйлдлийг гэмт хэрэг гэж үзэхгүй байна.

“Шууд бус” хэлбэрийн хахуулийн гол зорилго нь албан тушаалтан хээл хахуулийн зүйлийг шууд өөр дээрээ бус өөрөөсөө холдуулах, гэмт хэргийг зувчуулах, төөрөгдүүлэх, нуун далдлах зорилготой байдаг. Энэ утгаараа манайд хамгийн түгээмэл хэлбэр боловч хуулийн зохицуулалтгүй байна. Тухайлбал ялангуяа, хүүхдийг нь сургуульд авах, хувийн компанитай нь худалдааны гэрээ байгуулах, хамаатан садныг нь ажилд авах, улс төрийн намд эсвэл сонгуулийн компани ажилд нь “хандив” нэрээр санхүүжилт хийх, гадаадад бүртгэлтэй компани руу нь мөнгө шилжүүлэх, гэр бүлд нь орон сууц өгөх гэх мэт хэлбэрийн хахууль түгээмэл боловч сайн зохицуулалтгүй учир зарим нь бүр ил цагаандаа гарсан байна.

НҮБ-ын Конвенцээс гадна ЕЗ-ийн Конвенц, ЭЗХАХБ-ын Конвенц мөн Америкийн улсуудын конвенц зэрэг бусад гол олон улсын конвенцууд мөн

“шууд бус” хээл хахуулийн бүх хэлбэрийг гэмт хэрэгт тооцохыг гишүүн орнууддаа үүрэг болгожээ.

Харин бусад гадаад орнуудын туршлагаас харахад, өндөр хөгжилтэй, авлигын индексээр дээгүүр зогсдог орнууд болон шилжилтийн үедээ явж буй пост социалист орнууд ялгаатай байна. Энд өндөр хөгжилтэй орнуудын дийлэнх нь шууд бус хэлбэрийг маш тодорхой хуульчилсан байна, тухайлбал Сингапурын Авлигаас урьдчилан сэргийлэх тухай хуулийн 5-д “аливаа албан тушаалтанд өөрт нь эсвэл өөр бусад этгээдэд хээл хахууль өгсөн, амласан, санал болгосон бол ..эсвэл аливаа албан тушаалтан өөртөө эсвэл өөр бусад этгээдэд хээл хахууль авахаар хясан боогдуулсан, эсвэл авсан бол ...” гэж хуульчилсан бол Швейцарын Эрүүгийн хуулийн 322 дугаар заалт, мөн Чилийн Эрүүгийн хуулийн 248-д “..хээл хахуулийг албан тушаалтанд өөрт нь эсвэл аливаа гуравдагч этгээдэд өгсөн бол эсвэл хээл хахуулийг өөртөө эсвэл аливаа гуравдагч этгээд авсан бол . .” гэх байдлаар маш тодорхой зүйлчилсэн байна.

Харин пост-социалист орнуудын тухайд, тэдгээрийн дийлэнх нь тус хэлбэрийг (гуравдагч этгээдэд хахууль очих тохиолдлыг) орхигдуулсан бөгөөд улмаар тэдгээр нь ЭЗХАХБ гэх мэт олон улсын байгууллага болон бусад бүс нутгийн байгууллагуудаас тус зохицуулалтуудыг заавал хуульчлах анхааруулга, зөвлөмжийг удаа дараа аваад байна.

Энд пост-социалист орнуудаас хурдтай хөгжиж яваа Гүрж, мөн Польш, Чех, Украин зэрэг улс ч хамрагдсан бөгөөд улмаар тэдгээр нь зөвлөмжийн дагуу зохицуулалтыг боловсронгуй болгох хуулийн төсөл дээр эрчимтэй ажиллаж байна.

Нэгэнт НҮБ-ын Конвенцээр үүрэг хүлээсэн, мөн бусад олон улсын конвенц болон өндөр хөгжилтэй орнуудын жишгийг харгалзан Монгол улс Эрүүгийн хуульдаа тус гуравдагч этгээдэд хээл хахууль өгөх болон авах тухай “шууд бус” хэлбэрийг зүйлчлэх нь зүйтэй.

5. Хээл хахууль өгөх гэмт хэргийн бүрэлдэхүүнийг бүрэн тодорхойлоогүй буюу тус гэмт хэргийн урьдчилсан нөхцөл, элемент болох субъектив санаа зорилгыг тусгаагүй.

НҮБ-ын Конвенцэд зааснаар, хээл хахуулийг өгөхдөө, түүний өгч буй этгээдийн субъектив санаа, эцсийн зорилго нь гагцхүү “тухайн албан тушаалтнаар тодорхой үйлдэл хийлгэх эсвэл хийлгэхгүй байх” санаа зорилго байх ёстойг онцгойлжээ. Өөрөөр хэлбэл, хахууль өгөгчөөс албан тушаалтанд өгч байгаа хээл хахууль (давуу байдал) нь тухайн албан тушаалтны албаны ажил үүрэгтэй нь зайлшгүй холбогдох ёстой буюу тодорхой үүргийг гүйцэтгүүлэх эсвэл гүйцэтгүүлэхгүй байх санаа зорилгыг цаанаа агуулсан байх ёстой.

Субъектын энэхүү санаа, зорилгын талаар манай Эрүүгийн хуулийн 268 буюу хээл хахууль авах гэмт хэрэгт урьдчилсан нөхцөл, элемент болгон тусгасан боловч, тус хуулийн 269 дүгээр заалт дахь хээл хахууль өгөх гэмт хэрэгт үүнийг тусгаагүй буюу зүгээр л “хээл хахууль өгсөн бол эрүүгийн хариуцлага тооцно” гэж зүйлчилсэн байна.

Ийм зүйлчлэл нь хэт ерөнхий, ойлгомжгүй байдлыг бий болгож, гэмт хэргийг тогтооход хүндрэл учруулах үр дагавартай. НҮБ-ын Конвенц болон бусад олон улсын конвенцэд зааснаар энэхүү урьдчилсан нөхцөл нь хээл хахуулийн гэмт хэргийг тодорхойлох суурь элемент, зайлшгүй бүрэлдэхүүн нь юм. Энэ утгаараа тус элементийг хуулинд тусгалгүйгээр үндсэн гэмт хэргийг тодорхойлох нь туйлын учир дутагдалтай буюу тодорхойлох боломжгүй юм.

Гадаадын орнуудын зохицуулалтад энэ урьдчилсан нөхцөл буюу элемент маш тодорхой орсон байна. Тухайлбал, Швейцарийн Эрүүгийн хуулийн 322-д “..албан үүрэгтэй нь холбогдуулан гүйцэтгэх үүргээ гүйцэтгэхгүй байх эсвэл өөр үүрэг гүйцэтгүүлэх зорилгоор хээл хахууль өгсөн бол..” гэсэн бол Чилийн Эрүүгийн хуулийн 248-д “ажил үүрэгтэй нь холбоотой үйлдэл хийлгэхийн тулд эсвэл хийлгэсний төлөө хахууль өгсөн бол ...” гэж тусгажээ. Энэхүү санаа зорилгыг нотлох нь онолын хувьд бэрхшээлтэй асуудлуудын нэг боловч улс орнуудын туршлагаас харахад, тэдгээр нь НҮБ-ын Конвенцийн 28-д зааварчилсаны дагуу бодит факт, тухайн нөхцөл байдалд тулгуурлан нотолж байна. Мөн нотолгооны энэ арга барилаа эрүүгийн процессийн хуулиараа нарийн зохицуулсан байна.

Иймд манай улс Эрүүгийн хуулийн 269 дүгээр заалт буюу хээл хахууль өгөх гэмт хэргийн суурь урьдчилсан нөхцөл болох хээл хахууль өгөгчийн эцсийн санаа зорилгыг хуульд тодорхой тусгах шаардлагатай. Нөгөөтэйгүүр, мөн хуулийн 268 дугаар заалт дахь хээл хахууль авах гэмт хэргийн санаа зорилгын талаарх урьдчилсан нөхцлийг засан сайжруулах шаардлагатай.

7. Гүйцэтгэх ёстой үүргээ гүйцэтгэснийхээ төлөө хээл хахууль авахыг гэмт хэрэгт тооцсон зохицуулалт байхгүй.

Эрүүгийн хуулийн 268-д заасан хээл хахууль авах гэмт хэрэгт гэмт хэрэг үйлдэгчийн субъектив санаа зорилгыг тусгасан билээ. Энд тусгахдаа “ албан тушаалтан хээл хахууль өгөгчийн ашиг сонирхлын үүднээс албан үүргийн хувьд гүйцэтгэх үүргээ хэрэгжүүлэхгүй байх эсвэл гүйцэтгэх ёсгүй үүргийг хийхээр урьдчилан амлах буюу амлахгүйгээр хээл хахууль авсан бол . . гэмт хэрэгт тооцно” гэж зүйлчилсэн. Эндээс харахад, албан тушаалтан албан үүргийн хувьд гүйцэтгэх үүргээ хэрэгжүүлснийхээ төлөө аливаа шан харамж, хахууль авбал яах вэ гэдэг нь тодорхойгүй буюу хуульчлагдаагүй байна. Энэ нь НҮБ-ын Конвенцийн 15 (b)-д заасан хээл хахууль авах гэмт хэргийн бүрэлдэхүүний нэг чухал элемент болох “албан үүргээ гүйцэтгэх явцдаа тус үүргээ гүйцэтгэснийхээ төлөө хахууль авсан бол . . гэмт хэрэгт тооцно ” гэсэн санаа тусгагдаагүй орхигдсоныг гэрчилж байна. Ингэснээр хамгийн гол, эцсийн сөрөг үр дагавар нь “хуулийн цоорхой, хийдэл”үүсч буй явдал бөгөөд ингэснээр ийм төрлийн үйлдлийг гэмт хэрэгт тооцох боломжгүй болгож байгаа юм.

Албан тушаалтан гүйцэтгэх ёстой албан үүргээ гүйцэтгэснийхээ төлөө бусдаас шан харамж, хахууль авах үзэгдэл Монгол улсад маш түгээмэл (ялангуяа барилга, ашигт малтмалын салбарт) байдаг ч уг үйлдэлд эрүүгийн хариуцлага ногдуулах эрх зүйн орчин байхгүй нь харагдаж байна.

Иймд Эрүүгийн хуулийн 268 дугаар заалтыг засан сайжруулж, албан тушаалтан зөвхөн “гүйцэтгэх ёстой үүргээ гүйцэтгээгүйн төлөө” эсвэл “гүйцэтгэх ёсгүй үйлдлийг гүйцэтгэсний төлөө” бус мөн нэмээд “гүйцэтгэх ёстой үүргээ гүйцэтгэснийхээ төлөө” бусдаас шан харамж, хахууль авахыг мөн адил гэмт хэрэгт тооцох шаардлагатай.

Ингэснээр Монгол Улс НҮБ-ын Конвенцийн дагуу хүлээсэн үүргээ биелүүлж, мөн ийм төрлийн зохицуулалт бүхий гадаад улсын, олон улсын стандарттай нийцэж буйгаар зогсохгүй, хамгийн гол нь Монголд ихээхэн газар авсан энэ төрлийн гэмт хэргийг таслан зогсоох, түүнээс урьдчилан сэргийлэх томоохон алхам болох юм.

Энэ нэмэлт өөрчлөлтийг, НҮБ-ын Конвенцийн Монгол улс дахь хэрэгжилтийн талаар гаргасан хэд хэдэн олон улсын байгууллага болон хөндлөнгийн гуравдагч улсуудын үнэлгээ, тайлангаар зөвлөмж болгосныг энд дурьдах нь зүйтэй. Эдгээр үнэлгээ, тайланд НҮБ-аас гаргасан үнэлгээ, Кени болон Йемэн улсуудын хамтарсан үнэлгээ, Швед болон Пакистан улсуудын хамтарсан үнэлгээ, мөн АХБ болон ЭЗХАХБ-ын хамтарсан үнэлгээ зэрэг багтана.

Санал - Зөвлөмж

1. “Албан тушаалтан” нэр томъёонд “Нийтийн албан тушаалтан” гэсэн агуулгыг оруулж, түүнийг нарийн тодорхойлох.

Эрүүгийн хуулийн 268, 269 дүгээр заалт дахь “албан тушаалтан” гэсэн нэр томъёонд “нийтийн албан тушаалтан” гэсэн агуулгыг оруулж, НҮБ-ын Конвенцийн тодорхойлолтоос дордуулахгүйгээр, өргөн хүрээтэй, нарийн тодорхойлох шаардлагатай.

НҮБ-ын Конвенцийн 65-ын “конвенцийн нөхцлийг дордуулахгүй” зарчмын дагуу тодорхойлолтод дор хаяж дараах элементийг заавал харгалзан үзэж, хамруулна:

- Хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн бүх шатны албан тушаалтнуудыг (удирдах, гүйцэтгэх, туслах) хамруулах
- Дээрх албан тушаалтнууд нь томилогдсон, сонгогдсон, байнгын, түр хугацааны, цалинтай эсвэл цалингүй (сайн дурын) алин байхаас үл хамаарах
- Төрийн нэрийн өмнөөс нийтийн чиг үүргийг гүйцэтгэдэг, нийтийн үйлчилгээг үзүүлдэг төрийн өмчит, төрийн өмчийн оролцоотой болон хувийн хуулийн этгээд, төрийн бус байгууллагын бүх шатны албан тушаалтан, ажилтан эсвэл төрийн нэрийн өмнөөс нийтийн чиг үүргийг гүйцэтгэдэг, нийтийн үйлчилгээг үзүүлдэг хувь хүнийг мөн хамруулах
- Дээрх шаардлагатай уялдан “нийтийн чиг үүрэг” болон “нийтийн үйлчилгээ” гэсэн нэр томъёог мөн давхар нарийн тодорхойлох

2. “Хээл хахууль” нэр томъёог тодорхойлох.

Эрүүгийн хуулийн 268, 269, 270 дугаар заалтад дурьдагдсан “хээл хахууль” гэсэн нэр томъёог НҮБ-ын Конвенц болон гадаад орнуудын туршлагад үндэслэн өргөн хүрээгээр тодорхойлох шаардлагатай. Энд дараах зүйлсийг анхаарвал зохино:

- “Хээл хахууль” гэсэн нэршлийг, НҮБ-ын Конвенц болон гадаадын улсуудын нийтлэг жишгээр “хууль бус давуу байдал” эсвэл “хууль бус ашиг хонжоо” гэсэн нэршлээр орлуулах;
- Хээл хахуулийн (хууль бус давуу байдал эсвэл ашиг хонжоо) тодорхойлолтыг хээл хахуулийн үнийн дүнд үндэслэн эсвэл түүнд хамаарагдах зүйлсийг жагсаах замаар эсвэл түүнд хамаарагдахгүй зүйлсийг жагсаах замаар шалгуур тогтоон боловсруулах;
- Ийнхүү тодорхойлохдоо, хээл хахуульд зөвхөн бэлэн мөнгөнөөс гадна өөр хэлбэрийн эд юмс, мөн цаашлаад эдийн бус зүйлсийг хамруулж ойлгохыг тодорхой тусгах. Тухайлбал, үл хөдлөх хөрөнгө, хөнгөлөлттэй зээл, үнэт цаас, хувьцаа ноогдол ашгийн эрх, хөнгөлөлттэй буюу үнэгүй үйлчилгээ, эрх, давуу байдал, гишүүнчлэл, нууц мэдээлэл, ноу хау, ирээдүйд өгөх шан харамж, өр төлөөс гэх мэт байж болно.
- Авлигын эсрэг хууль дахь холбогдох нэр томъёо (ашиг хонжоо, давуу байдал гэх мэт)-г Эрүүгийн хуулийн ойлголт зохицуулалттай уялдуулах эсвэл нэгтгэх ижилсүүлэх.

3. “Хээл хахууль”-ийн гэмт хэрэг “хууль бус шан харамж”-ын гэмт хэрэг болон “бэлэг сэлт”-ийн ойлголтын ялгааг нарийн зааглаж, хуулиудын (Эрүүгийн хууль, Сонирхлын зөрчлийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль) уялдааг хангах;

4. Хээл хахууль өгөхийг санал болгох, эсвэл амлах” мөн “хээл хахууль хахууль авахын тулд хясан боогдуулах-шахалт үзүүлэх” үйлдлүүдийг гэмт хэрэгт тооцох;

5. Гуравдагч этгээдэд хээл хахууль өгөх, авах тухай хээл хахуулийн “шууд бус” хэлбэрийг тусгах

6. Хээл хахууль өгөх гэмт хэргийн урьдчилсан нөхцөл-бүрэлдэхүүнийг бүрэн тодорхойлж, гэмт хэрэг үйлдэгчийн субьектив санаа зорилгыг хуульчлах;

7. Гүйцэтгэх ёстой үүргээ гүйцэтгэснийхээ төлөө хээл хахууль авахыг гэмт хэрэгт тооцох.

Гэмт хэргийн тухай хуулийн төслөөс

22.5 дугаар зүйл. Хахууль авах

1.Нийтийн албан тушаалтан, эсхүл хууль, тогтоомж, дүрэм, журам, заавар, гэрээгээр үүрэг хүлээсэн хүн, хахууль өгөгчийн ашиг сонирхлын үүднээс албан үүргээ хэрэгжүүлсний хариуд, эсхүл хэрэгжүүлэхийн тулд шууд, эсхүл бусдаар дамжуулан хахууль өгөхийг шаардсан, авсан, эсхүл хахууль өгөх саналыг хүлээн зөвшөөрсөн бол гэж объектив талыг тодорхойлсон.

2.Нийтийн албан тушаалтан, эсхүл хууль, тогтоомж, дүрэм, журам, заавар, гэрээгээр үүрэг хүлээсэн хүн хахууль өгөгчийн ашиг сонирхлын үүднээс албан үүргээ хэрэгжүүлээгүйн хариуд, эсхүл хэрэгжүүлэхгүй байхын тулд, эсхүл гүйцэтгэх ёсгүй үйлдлийг хийсэн, эсхүл хийхийн тулд

шууд, эсхүл бусдаар дамжуулан хахууль өгөхийг шаардсан, авсан, эсхүл хахууль өгөх саналыг хүлээн зөвшөөрсөн бол хариуцлагыг хүндрүүлнэ.

3.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан гэмт хэргийг улс төрд нөлөө бүхий этгээд, эсхүл зохион байгуулалттай гэмт бүлэг, хясан боогдуулах аргаар үйлдсэн бол нийтийн албанд томилогдох, эсхүл сонгогдох эрхийг хасч, арван таван сая төгрөгөөс жаран сая төгрөгөөр торгох, эсхүл хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

4.Энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан гэмт хэргийг улс төрд нөлөө бүхий этгээд, эсхүл зохион байгуулалттай гэмт бүлэг, хясан боогдуулах аргаар үйлдсэн бол гучин зургаан сая төгрөгөөс ерэн сая хүртэл төгрөгөөр торгох, эсхүл таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

22.6 дугаар зүйл. Хахууль өгөх

1.Нийтийн албан тушаалтан, гадаад улсын төрийн албан тушаалтан, олон улсын байгууллагын албан тушаалтанд албаны чиг үүрэг, бүрэн эрх, албан тушаалын байдалтай нь холбогдуулан өөрийн ашиг сонирхлыг гүйцэлдүүлэх зорилгоор өөрт нь, эсхүл бусдаар дамжуулан эдийн, эдийн бус баялаг, тэдгээрийг өмчлөх эрхийг шилжүүлсэн, төлбөргүй, эсхүл хөнгөлөлттэй үйлчилгээ үзүүлсэн, эсхүл эдгээрийг амласан, санал болгосон бол нийтийн албанд томилогдох, эсхүл сонгогдох эрхийг хоёр жил хүртэл хугацаагаар хязгаарлаж, зургаан зуун мянгаас хорин нэгэн сая төгрөгөөр торгох, эсхүл нэг сараас гурван жил хүртэл хугацаагаар эрх чөлөө хязгаарлах, эсхүл нэг сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Тайлбар:

- Хясан боогдуулсны улмаас аргагүй байдалд орж хахууль өгч, нийтийн албан тушаалтан хууль ёсны дагуу албан үүргээ гүйцэтгэж үзүүлэх төрийн үйлчилгээг авсан хүн энэ тухайгаа эрх бүхий байгууллагад сайн дураараа илчлэн ирсэн бол түүний авсан төрийн үйлчилгээг хэвээр үлдээж ялаас чөлөөлнө.

- Хахууль авагчийг хууль бус үйлдэл хийлгэхээр хахууль өгсөн хүнийг ялаас чөлөөлөхгүй. Хахууль өгсөн хүн энэ тухайгаа эрх бүхий байгууллагад сайн дураараа илчлэн ирсэн нь түүнд оногдуулах ялыг хөнгөрүүлэх үндэслэл болно.

3.2. ГАДААД УЛСЫН НИЙТИЙН АЛБАН ТУШААЛТАН БОЛОН ОЛОН УЛСЫН БАЙГУУЛЛАГЫН АЛБАН ТУШААЛТАНД ХАХУУЛЬ ӨГӨХ ҮЙЛДЛИЙГ ГЭМТ ХЭРЭГТ ТООЦОХ

НҮБ-ын Конвенцийн 16 (а)-д олон улсын бизнесийн харилцаа, олон улсын бизнес эрхлэхтэйгээр холбогдуулан өөртөө бизнесийн болон бусад зүй бус давуу байдал олж авах эсвэл түүнийгээ хадгалах зорилгоор хэрэв гадаад орны нийтийн албан тушаалтан эсвэл олон улсын байгууллагын

албан тушаалтан, ажилтанд хууль бус давуу байдал (хахууль гэх мэт) олгосон бол тус үйлдлийг, дотоодын хуулиараа заавал гэмт хэрэг гэж үзэн түүнийг заавал хуульчлах ёстой гэж гишүүн орнуудад үүрэг болгосон.

Тус үүргийн дагуу Монгол улс, гадаадын нийтийн албан тушаалтан, мөн олон улсын байгууллагын албан тушаалтан, ажилтанд хууль бус давуу байдал олгох, хахуульдах үйлдлийг гэмт хэрэгт тооцож, хуульчлах ёстой боловч өнөөдрийг хүртэл уг хуулийн зохицуулалт хийгдээгүй, Монгол улс хүлээсэн үүргээ биелүүлээгүй байна.

Нөгөө талаас, дотоодын нөхцөл байдлын хувьд, тус зохицуулалтыг зайлшгүй хуульчлах, эрх зүйн орчинг бий болгох дараах бодит шаардлага, практик хэрэгцээ Монгол улсад бий болоод байна. Үүнд:

- Гадаадын хөрөнгө оруулалт, гадаад худалдаа хурдацтай өсч буйтай холбоотойгоор зөвхөн хувийн гэлтгүй, мөн гадаад улсын нийтийн эрх зүйн субъект Монгол улсад орж ирэх, тэдэнтэй харилцах харилцаа нэмэгдэж байна.
- Гадаад хөрөнгө оруулалт, нээлттэй гадаад бодлого, эдийн засгийн өсөлттэй холбоотойгоор Монгол улсын дотоодын бизнес хил дамнан өргөжин тэлж байна. Монгол улс эдийн засгийн шилжилтийн үед яваатай холбоотойгоор, бүс нутаг, олон улсын байгууллагын тусламж, зээл, төсөл хөтөлбөрүүд хэрэгжиж байна.
- Монгол улс дахь дотоодын авлигын хэмжээ өндөр, мөн дээд түвшиндээ улс төр, бизнесийн соёл төлөвшөөгүй, доод түвшиндээ нийт массын ухамсар, төлөвшил төдийлөн сайн биш, ардчиллын үнэт зүйлс төдийлөн бэхжээгүй өнөө үед, дээр дурьдсан 3 нөхцөл байдал нь гадаад улсын болон олон улсын байгууллагын албан тушаалтанд хээл хахууль өгөх магадлал, боломжийг улам бүр нэмэгдүүлж байна.
- Монгол улсын хил дамнасан, зохион байгуулалттай гэмт хэргийн тоо өдрөөс өдөрт нэмэгдэж байна.

Энэхүү гэмт хэрэг нь зөвхөн дотоодын эдийн засаг, нийгэмд төдийгүй Монгол улсын дэлхийн тавцан дахь нэр хүнд, Монгол улсын ардчиллыг хөгжүүлж буй чиг баримжаа, түвшинг тодорхойлох томоохон үр дагавартай. Энэ нь улмаар Монгол улс дахь цаашдын гадаадын хөрөнгө оруулалт, зээл, тусламж, гадаад хамтын ажиллагаа, гадаад харилцаа, бүс нутаг болон олон улсын түвшин дэх стратегийн түншлэл, дипломат харилцаанд сөргөөр нөлөөлөх үр дагавартай.

Эцэст нь дурьдахад, гадаадын болон ОУБ-ын албан тушаалтанд хахууль өгөх үйлдлийг бусад олон улсын конвенцуудаар ч мөн гэмт хэрэгт тооцон хориглож байна. Тухайлбал энд ЭЗХАХБ-ын Конвенц, ЕЗ-ийн Конвенц, Авлигын эсрэг Америкийн улсуудын конвенц зэрэг гол конвенцууд бүгд хамрагджээ. Иймд манай улс тус зохицуулалтыг Эрүүгийн хуульд нэн яаралтай шинээр оруулах шаардлагатай. Энд дараах зүйлсийг анхаарвал зохино. Үүнд.

1. Хуульчлах хэлбэр

Тус гэмт хэрэг нь нэгэнт хээл хахуулийн гэмт хэрэг учир, түүнийг Эрүүгийн хуулийн 28 дугаар бүлэг буюу “албан тушаалын гэмт хэрэг” гэсэн бүлэгт хамруулж, тусад нь бие даасан заалт болгон оруулах эсвэл дотоодын албан тушаалтны хээл хахуулийн гэмт хэрэгтэй нэгтгэн оруулбал зүйтэй. Гадаадын орнууд тусад нь гэмт хэрэг болгон оруулах эсвэл дотоодын хээл хахуулийн гэмт хэрэгтэй нэгтгэн оруулах хувилбарыг хэрэглэсэн ч дийлэнх орнууд тусад нь гэмт хэргийн заалт болгон хуульчилжээ.

2. “Гадаадын нийтийн албан тушаалтан” болон “олон улсын байгууллагын албан тушаалтан” нэр томъёог зөв, нарийн тодорхойлох

Гадаадын нийтийн албан тушаалтан болон олон улсын байгууллагын албан тушаалтанд хээл хахууль өгөх үйлдлийг гэмт хэрэг гэж тодорхойлоход, тус үйлдлийн чухал бүрэлдэхүүн, элемент болох “гадаад улсын нийтийн албан тушаалтан” болон ОУБ-ын албан тушаалтан” гэсэн нэршлүүдийг зөв, нарийн тодорхойлох шаардлагатай.

НҮБ-ын Конвенцэд эдгээр нэршлийг тодорхойлсон байдаг. Конвенцийн 2(б)-д “гадаадын нийтийн албан тушаалтан” гэдгээр “гадаад орны хууль тогтоох, гүйцэтгэх болон шүүх засаглалд ажиллаж буй томилогдсон болон сонгогдсон аливаа этгээдийг, мөн нийтийн эрх зүйн хуулийн этгээдэд ажиллаж буй этгээд буюу нийтийн чиг үүргийг гүйцэтгэж байгаа аливаа этгээдийг ойлгоно” гэсэн бол харин конвенцийн 2 (с)-д тодорхойлсноор “олон улсын байгууллагын албан тушаалтан” гэдгээр “ОУБ-ын ажилтан эсвэл тухайн байгууллагын нэрийн өмнөөс түүнийг төлөөлөхөөр, тухайн байгууллагаар томилогдсон аливаа бусад этгээдийг ойлгоно” гэж тус тус тодорхойлжээ.

Конвенцийн Эрх зүйн удирдамжид зөвлөснөөр “гадаад улсын албан тушаалтан” нэршлийг тодорхойлохдоо дараах зүйлсийг анхаарах аж:

- Тодорхойлолтыг НҮБ-ын Конвенцийн тодорхойлолтоос дордуулахгүй байх буюу түүнд заасан бүх элементийг хамруулах
- Нэршлийг тодорхойлохдоо, тухайн гадаад улсын өөрийнх нь хуулиар тодорхойлсон үндэсний буюу дотоодын “нийтийн албан тушаалтан” гэсэн нэр томъёог авч ашиглахгүй байх. Энэ нь гэмт хэргийг тогтоож буй улсын хувьд хэрэглэхэд хүндрэл, төвөг үүсгэдэг. Иймд гэмт хэргийг тогтоож буй улс “гадаад улсын нийтийн албан тушаалтан” гэдгийг бие даан өөрөө хуулиараа тодорхойлох нь зүйтэй. Тухайлбал, Монгол улс Эрүүгийн хуулиараа гадаад улсын нийтийн албан тушаалтанд хээл хахууль өгөхийг гэмт хэрэг гэж үздэг гэж бодвол “гадаад улсын нийтийн албан тушаалтан” гэж хэн бэ гэдгийг Монгол улс өөрөө хуулиараа тодорхойлсон байх хэрэгтэй. Тодруулбал, жишээ нь иргэн Бат АНУ-д ажиллаж амьдарч байхдаа тус улсын гаалийн албан тушаалтанд хээл хахууль өгсөн бол, тус гэмт хэргийг шалгахдаа эхлээд АНУ-ын гаалийн ажилтан нь Монгол улсын хуулийн дагуу “гадаадын нийтийн албан тушаалтан” мөн үү? гэдгийг тогтооно, тус гаалийн ажилтан нь АНУ-ын хуулиар тэдний үндэсний “нийтийн албан тушаалтан”-д хамаардаггүй ч байж болно.

- Гадаад улс гэдэгт тусгаар улсаас гадна, бие даасан засаг захиргааны нэгж зэргийг мөн хамруулж ойлгоно
- “ОУБ-ын албан тушаалтан” гэдгийг тодорхойлохдоо НҮБ-ын Конвенцийн тодорхойлолтыг харгалзан үзэхээс гадна Монгол улсын Олон улсын гэрээний тухай хуулийн 3.5- дахь “олон улсын байгууллага” гэсэн тодорхойлолтыг мөн харгалзан үзэж, хуулиудад тохирох холбоосыг хийж өгөх нь зүйтэй.

3. Хэргийн харъяалал

Монгол Улсын Эрүүгийн хуулийн 14.1-д “Монгол улсын иргэн, тус улсад байнга оршин суудаг харъяалалгүй хүн энэ хуульд заасан гэмт хэрэг үйлдэж, тухайн хэрэгтээ ял шийтгүүлээгүй бол энэ хуулиар эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ” гэжээ. Эндээс харахад Монгол Улсын Эрүүгийн хууль нь Монгол Улсын хилийн гадна үйлдэгдсэн гэмт хэрэгт үйлчилж болох боловч энэ нь гагцхүү гэмт этгээд нь тухайн гэмт хэрэгт ял шийтгүүлээгүй тохиолдолд үйлчлэх боломжтой байна.

Гадаад улсын албан тушаалтан болон олон улсын байгууллагын албан тушаалтанд хээл хахууль өгөх гэмт хэргийн нэг үндсэн шинж нь тус гэмт хэрэг дотоодод үйлдэгдэхээс гадна гадаад улсын нутаг дэвсгэрт үйлдэгдэх тохиолдол олон байдаг. Тухайлбал, Монгол Улсын иргэн гадаадад амьдарч байхдаа, эсвэл гадаад гарч бизнес хийхдээ ч юмуу гадаад улсын эсвэл олон улсын байгууллагын албан тушаалтанд хахууль өгөх, өгөхөөр амлах, санал болгох үйлдлүүд гарч болно.

Энэ онцлог шинж чанарыг харгалзан, Конвенцийн Эрх зүйн удирдамж хэргийн харъяаллын талаар зөвлөмж өгсөн бөгөөд тус зөвлөмжид дурьдсанаар, гадаад улсын албан тушаалтан болоно олон улсын байгууллагын албан тушаалтанд хээл хахууль өгөх гэмт хэргийн тухайд, хэрэв тус гэмт хэргийг тухайн улсын иргэн гадаад улсын нутаг дэвсгэр дээр үйлдсэн бол нутаг дэвсгэрийн харъяалал болон бусад нөхцлийг үл харгалзан уг гэмт хэргийг тус улсын эрүүгийн хуулийн харъяаллаар шийдвэрлэж, Эрүүгийн хуулийн дагуу хариуцлага хүлээлгэвэл зохино гэжээ.

Иймд онцлог шинж чанартай нь уялдуулан, энэ гэмт хэргийн тухайд, Эрүүгийн хуулийн 14.1-р заалтад онцгой нөхцөл оруулж, “Монгол Улсын иргэн гадаад улсын нутаг дэвсгэрт, гадаадын болон ОУБ-ын албан тушаалтанд хээл хахууль өгөх гэмт хэрэг үйлдвэл гадаадын хуулиар ял шийтгүүлсэн эсэхээс үл хамааран, тус гэмт хэргийг Монгол Улсын Эрүүгийн хуулийн харъяалалд бүрэн хамруулж, түүний дагуу хариуцлага хүлээлгэнэ” гэсэн зарчмыг тусгах нь зүйтэй.

4. Гэмт хэргийн бүрэлдэхүүний зайлшгүй элементүүдийг тусгах

Гадаад улсын нийтийн албан тушаалтан болоно олон улсын байгууллагын албан тушаалтанд хээл хахууль өгөх гэмт хэрэг нь НҮБ-ын Конвенцийн 15-д заасан “үндэсний буюу дотоодын нийтийн албан тушаалтанд хээл хахууль өгөх” гэмт хэрэгтэй зарчмын хувьд ижил юм. Өөрөөр хэлбэл, эдгээр 2 гэмт хэрэг нь гагцхүү хээл хахууль өгч буй субъектийн хувьд ялгаатай бөгөөд харин гэмт хэргийн бүрэлдэхүүний элементийн хувьд ижил юм. Иймд эдгээр элемент буюу урьдчилсан нөхцлийг энэ гэмт хэрэгт зайлшгүй тусгах ёстой ба тэдгээрийн агуулгыг мөн ижил утгаар ойлгоно. Үүнд:

- Хээл хахууль өгөхөөс гадна “амлах”, “санал болгох” үйлдлүүдийг мөн хамруулна.
- “Хээл хахууль” гэхээс илүүтэйгээр “хууль бус давуу байдал” гэсэн нэршлийг хэрэглэж, тус давуу байдлаар мөнгөн, мөнгөн бус, эдийн болон эдийн бус гэх мэт бүх төрлийн эд юмсыг ойлговол зохино.
- “Шууд” болон “шууд бус” аль ч хэлбэрээр хээл хахууль өгснийг гэмт хэрэгт тооцно.
- Хээл хахууль болон албан тушаалтны албан үүрэгтэй холбогдох үйлдэл хоёрт заавал холбоос байх ёстой. Хээл хахуулийн зорилго нь санаатай байх бөгөөд албан тушаалтны үйлдэлд нөлөөлөх, харин албан тушаалтан үйлдлээ хээл хахууль авах зорилгоор хийсэн байна.

Гадаад улсын туршлагаас харахад, НҮБ-ын Конвенцийн энэхүү заалтыг, ЭЗХАХБ-ын дийлэнх гишүүн орнууд буюу өндөр хөгжилтэй орнууд хэрэгжүүлж, “гадаад улсын нийтийн албан тушаалтан болон олон улсын байгууллагын албан тушаалтанд хээл хахууль өгөх” үйлдлийг дотоодын хуулиараа гэмт хэрэгт тооцсон бол харин пост-социалист орнууд дунд тус заалтыг бүрэн хэрэгжүүлсэн улс олон биш байгаа бөгөөд хэрэгжүүлэх тухай зөвлөмж, шаардлагыг олон улсын байгууллагуудаас аваад байна.

Хэрэгжүүлж буй орнуудын тухайд, тус заалтыг хуульчилсан хэлбэр нь НҮБ-ын Конвенцийн 16 дугаар заалттай маш төстэйгээр хуульчилж, “гадаадын нийтийн албан тушаалтан” болон “олон улсын байгууллагын албан тушаалтан” нэршлүүдийг нарийн тодорхойлж өгчээ.

Гэмт хэргийн тухай хуулийн төслөөс

22.3 дугаар зүйл. Гадаад улсын төрийн албан тушаалтан, олон улсын байгууллагын албан тушаалтан эрх мэдлээ урвуулан ашиглах

1. Гадаад улсын төрийн албан тушаалтан, олон улсын байгууллагын албан тушаалтан, албаны чиг үүрэг, бүрэн эрхээ албаны эрх ашигт харшаар ашиглаж өөртөө, эсхүл бусдад давуу байдал бий болгосон бол 7-36 сая төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

- Тайлбар: энэ зүйлд заасан гадаад улсын төрийн албан тушаалтан гэдэгт гадаад орны хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх засаглалд ажиллаж байгаа, эсхүл томилогдсон, эсхүл сонгогдсон хүнийг, нийтийн эрх зүйн хуулийн этгээдэд ажиллаж буй хүн, эсхүл нийтийн чиг үүргийг гүйцэтгэж байгаа хүнийг ойлгоно.

- Энэ зүйлд заасан олон улсын байгууллагын албан тушаалтан гэдэгт олон улсын, эсхүл Засгийн газар хоорондын олон улсын байгууллагын ажилтан, эсхүл тухайн байгууллагыг төлөөлөх, эсхүл тухайн байгууллагын нэрийн өмнөөс үйл ажиллагаа явуулах эрх бүхий, эсхүл тухайн байгууллагаас томилогдсон хүнийг ойлгоно.

3.3. ЭД ХӨРӨНГИЙГ ХУУЛЬ БУСААР ЗАВШИХ ГЭМТ ХЭРЭГ

НҮБ-ын Конвенцийн 17-д дараах үйлдлийг заавал гэмт хэрэг гэж үзэж, түүнийг заавал хуульчилж өгөхийг гишүүн улсуудад үүрэг болгосон байна. Энэ үйлдэл нь “нийтийн албан тушаалтан нь, түүнд албан тушаалтай нь холбогдуулан өөрт нь итгэж хариуцуулсан аливаа эд хөрөнгө, төрийн болон хувийн секторын мөнгө /санхүү/ сан, үнэт цаас болон апиваа бусад үнэ цэн бүхий зүйлсийг өөрийнхөө эсвэл өөр бусад этгээд, байгууллагад зориулан санаатайгаар завгиих, ашиглан шамшигдуулах эсвэл өөр бусад зориулалтын бус хэлбэрээр зарцуулах” үйлдэл юм.

17 дугаар заалт дахь гэмт хэргийн бүрэлдхүүнийг шинжвэл, энд дараах урьдчилсан нөхцөл буюу элементийг багтаасан байна:

- гэмт хэргийн субъект нь “нийтийн албан тушаалтан” байх
- албан тушаалтай нь холбогдуулан итгэж хариуцуулсан зүйлс байх
- итгэж хариуцуулсан зүйлсэд (i) аливаа эд юмс, эд хөрөнгө, (ii) улсын буюу хувийн секторын мөнгө /санхүү/ сан гэх мэт, (iii) үнэт цаас, (iv) үнэ цэн бүхий бусад зүйлс
- гэмт үйлдлийг зөвхөн өөрийнхөө төдийгүй, өөр бусад гуравдагч этгээд, байгууллагад зориулан үйлдсэн байх
- гэмт үйлдлийг “санаатайгаар” үйлдсэн байх
- гэмт үйлдэлд (i) завших, (ii) ашиглан шамшигдуулах, (iii) бусад төрлийн зориулалтын бус ашиглалтууд хамаарна.

Манай улсын хувьд НҮБ-ын Конвенцийн 17 дугаар заалтын агуулгыг бүрэн илэрхийлсэн, түүнийг бүрэн хэрэгжүүлсэн зохицуулалт Эрүүгийн хуульд байхгүй байна.

Харин тус заалтын тодорхой зарим санаа, зорилт тусгагдсан байж болох зохицуулалтад Эрүүгийн хуулийн 273 (Төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах), Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 82 (Төрийн өмчийн эд хөрөнгийг эрх бүхий албан тушаалтны зөвшөөрөлгүйгээр, эсвэл хууль зөрчиж захиран зарцуулахад тооцох хариуцлага), мөн Эрүүгийн хуулийн 150 дугаар заалт (Бусдын эд хөрөнгийг завших, үрэгдүүлэх) зэргийг нэрлэж болох ч эдгээрт дараах дутагдал, зөрчлүүд байна. Үүнд:

1. Эрүүгийн хуулийн 273 дугаар заалтад, төсөв захирагч нь төрийн өмч, төсвийн хөрөнгөтэй холбогдуулан дараах үйлдлүүдийн аль нэгийг хийж, түүний улмаас үлэмж хэмжээний хохирол учирсан бол түүнийг гэмт хэрэгт тооцон эрүүгийн хариуцлага оногдуулахаар хуульчилсан байна: (i) төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулсан, (ii) зах зээлийн дунджаас дээгүүр үнээр эд хөрөнгө худалдан авсан, (iii) нөөцлөх нэрээр хэрэгцээнээс илүү хэмжээгээр бараа бүтээгдэхүүн худалдан авч, мөнгөний эргэлтийг саатуулсан, (iv) зохиомол хомсдол бий болгох замаар бараа бүтээгдэхүүн бэлтгэн нийлүүлэх үнийг зориудаар өсгөсөн, (v) төрийн өмчийн болон төсөвт байгууллагын эд хөрөнгийг зах зээлийн дунджаас доогуур үнээр борлуулсан, (vi) улсын төсвийн болон өөрийн хөрөнгө оруулалтаар баригдаж байгаа барилга байгууламж, тоног төхөөрөмжийн угсралтад шаардлага хангаагүй

бараа бүтээгдэхүүн ашиглах замаар төсөвт өртгийг бүрдүүлсэн.

Тус зохицуулалтыг шинжвэл, дараах шалтгаанаар НҮБ-ын Конвенцийн 17 дугаар заалтад заасан шаардлагыг бүрэн хангаж чадахгүй байна:

- Гэмт хэргийн субъект явцуу буюу хязгаарлагдмал байна.

“Төсөв захирагч” гэдэг нь Конвенцийн 17-д заасан “нийтийн албан тушаалтан” гэсэн субъектын агуулгыг бүрэн хангаж чадахгүй байна. 17 дугаар заалтын гэмт хэргийн бүрэлдэхүүн ёсоор, гэмт хэргийн субъектыг заавал “нийтийн албан тушаалтан” байхыг шаардсан бөгөөд тус нэр томъёогоор хууль тогтоох, шүүх болон гүйцэтгэх засаглалын бүх төрлийн албан тушаалтан, ажилтан мөн нийтийн чиг үүргийг гүйцэтгэж буй хувийн хуулийн этгээдийн албан тушаалтан болон хувь хүнийг ойлгохоор маш өргөн байдлаар тодорхойлсон байгаа (дэлгэрэнгүй тайлбарыг өмнөх бүлгээс үзнэ үү).

Гэтэл энд заасан “Төсөв захирагч”-ид зөвхөн өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийн байгууллага болон бусад этгээдээс нийлүүлэх бүтээгдэхүүний хэрэгцээг тодорхойлон, гэрээ байгуулах эрх бүхий албан тушаалтан хамрагдахаар харагдаж байна.

- Хохирлын хэмжээ заасан бөгөөд уг хохирол нь дор хаяж “үлэмж хэмжээний” буюу хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 50 болон түүнээс дээш нэмэгдүүлсэнтэй тэнцэх буюу 9,6 сая төгрөгний хохирол байх хуулийн шаардлага тавьсан байна.

Гэтэл Конвенцийн 17-д аливаа хохирлын хэмжээ шаардаагүй бөгөөд гагцхүү дээр дурьдсан элементүүдийг агуулсан үйлдэл үйлдэгдсэн тохиолдолд түүнийг гэмт хэрэгт тооцох тухай заасан. Үүнээс гадна, Конвенцийн 3 дугаар заалтад, “тус конвенцэд заасан аливаа гэмт хэргийг дотоодын хууль тогтоомжид тусган хуульчлахдаа төрд заавал аливаа “хохирол” учирсан байхыг шаардахгүй” гэжээ.

Иймд Эрүүгийн хуульд заасан тус “хохирлын хэмжээ”-ний шаардлага, босго нь Конвенцэд нийцэхгүй байна. Практикийн хувьд, хэрэв Эрүүгийн хуульд заасан хохирлын хэмжээ болох 9,6 сая төгрөгөөс бага хэмжээний хохирол учирвал уг үйлдэлд хариуцлага хүлээлгэх үү, хэрэв хүлээлгэхээр бол ямар хариуцлага хүлээлгэх нь тодорхойгүй байна. Захиргааны хариуцлагын тухай хуулийн 36, 37-д “бусдын эд хөрөнгийг ашиглан шамшигдуулах” нэртэй захиргааны зөрчлийг хуульчилсан боловч тус зохицуулалт нь мөн л Эрүүгийн хуулийн энэ зохицуулалттай яг таг дүйцэх эсэх нь эргэлзээтэй, 2-рт зөрчилд оногдуулсан захиргааны хариуцлагын хэмжээ нь 1500-50000 төгрөгний хооронд хэлбэлзэж байна.

Тэгэхээр төсвийн хөрөнгийг зүй бусаар ашиглаад, хэрэв тэр нь 9,6 сая төгрөгөөс бага хохирол учруулсан бол тус үйлдлийг гэмт хэрэгт тооцохгүйгээр эрүүгийн хариуцлагаас чөлөөлөн, улмаар магадгүй Захиргааны Хариуцлагын хуулийг дүйцүүлэн хэрэглэвэл ердөө 1500-50000 төгрөгийн торгууль ноогдуулахаар харагдаж байна.

- “Төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах” үйлдлийн илэрч болох хэлбэрүүдийг жагсаасан байгаа нь уг гэмт үйлдлийг тодорхойлох, тодорхой болгох оролдлого мөн боловч тус жагсаалт нь хязгаарлагдмал

байдлаар томъёологдсон, өргөн хүрээг хамарч чадаагүй учир тус гэмт хэрэгт хамаарч болох өөр бусад гэмт үйлдлүүд хуулийн харьяаллаас гадуур үлдэх нөхцөл бүрдэж байна.

Эрүүгийн хуулийн 273-д заасан агуулга бүхий гэмт хэрэг манай улсад маш түгээмэл байдаг. Хамгийн доод түвшний нярав, нягтлангаас эхлээд, санхүүгийн хэлтсийн дарга, бусад төсвийн эрх мэдэл бүхий дарга, түүнд хамааралтай мэргэжилтнүүд төсвийг завших үзэгдэл маш их бий. Хамгийн энгийн, наад захын жишээ гэвэл чанаргүй зам, сургууль эмнэлгийн чанаргүй засвар гэх мэтийг дурьдаж болно. Гэвч хуулийн дагуу хариуцлага тооцуулсан болон төсөвт, төрд учирсан хохирлыг нөхөн төлүүлсэн тохиолдол ховор бөгөөд энэ нь сул, боловсронгуй бус эрх зүйн орчин, дээр дурьдсан дутагдлуудтай холбоотой.

2.Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд төрийн өмчийн эд хөрөнгийг хууль бусаар захиран зарцуулбал тооцох хариуцлагын талаар тусгажээ. Хуулийн 82.1-д “төрийн өмчийн эд хөрөнгийг эрх бүхий байгууллагайш зөвшөөрөлгүйгээр хандивласан, бэлэглэсэн, барьцаалсан, зээлдүүлсэн, бусад өмчийн хуулийн этгээдэд хувь хөрөнгө болгон оруулсан бол эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол гэм буруутай албан тушаалтныг 30000-60000 төгрөгөөр торгож, учирсан хохирлыг нөхөн төлүүлнэ”, мөн 82.2-т “энэ хуульд заасан журмыг зөрчиж төрийн өмчийн эд хөрөнгийг худалдсан, түрээслүүлсэн бол гэм буруутай этгээдийг эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол 25000-60000 төгрөгөөр торгож, уг хохирлыг нөхөн төлүүлнэ” гэж тус тус заажээ.

3. Эрүүгийн хуулийн 150-д “Бусдын эд хөрөнгийг завших” нэртэй гэмт хэргийг хуульчилж дараах байдлаар томъёолсон байна: “аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн өмчийг итгэмжлэгдэн хариуцсан этгээд завшсан буюу үрэгдүүлсний улмаас бага бус хэмжээний хохирол учирсан бол эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ” гэжээ. Энэ зохицуулалт нь Конвенцийн 17 дугаар заалтын агуулгыг бүрэн хамарч чадахгүй байгаа нь дараах дутагдлаар илэрч байна:

- “Итгэмжлэгдэн хариуцсан этгээд” гэдэгт ямар этгээдийг ойлгох нь тодорхойгүй буюу энд төрийн байгууллага, хуулийн этгээдийн албан тушаалтан, ажилтныг ойлгох уу эсвэл хувийн хуулийн этгээдийн албан тушаалтан, ажилтныг ойлгох уу эсвэл аль алиныг нь ойлгох уу, мөн цаашлаад тэр дундаа албан тушаалтныг ойлгох уу эсвэл нярав, нягтлан гэх мэт эд хөрөнгө хариуцсан этгээдийг ойлгох уу гэдэг нь тодорхойгүй байна. Хэрэв энд төрийн байгууллагын албан тушаалтан, ажилтныг ойлгохоор бол энэ гэмт хэргийг Эрүүгийн хуулийн 273-т заасан “Төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах” гэмт хэргээс хэрхэн зааглаж, ялгах нь тодорхой харагдахгүй байна. Энэ талаар Дээд Шүүхийн тайлбар болон бусад эрх зүйн баримт бичиг байхгүй байна. Практикт энэ заалтыг дийлэнхдээ хувийн байгууллагын ажилтан, албан тушаалтны үйлдэл (банкны ажилтан, байгууллагын нярав гэх мэт) эсвэл хувь хүний үйлдэлд хэрэглэж байгаа боловч нэгэнт хуулинд тодорхой бичигдээгүй байгаа нь эргэлзээ үүсгэж байгаа юм.

- Хохирол учирсан байхыг шаардсан буюу тус хохирол нь доод тал нь “бага бус” буюу хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг дор хаяж нэг

дахин нэмэгдүүлсэнтэй тэнцүү 280800 төгрөг байхыг шаардсан. НҮБ-ын Конвенцэд хохирол зайлшгүй байхыг шаардаагүй. НҮБ-ын Конвенцийн 17 дугаар заалтын хэрэгжилттэй холбогдуулан, Эрүүгийн хуульд дараах нэмэлт өөрчлөлтийг оруулах зөвлөмж өгсөн. Үүнд:

1. Эрүүгийн хуулийн 273 дахь “Төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах” гэмт хэрэг, Эрүүгийн хуулийн 150 дахь “Бусдын эд хөрөнгийг завших, үрэгдүүлэх” гэмт хэрэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль дахь “төрийн өмчийг хууль бусаар захиран зарцуулах” үйлдэл, Захиргааны хариуцлагын тухай хууль дахь “бусдын эд хөрөнгийг ашиглан шамшигдуулах” зөрчил зэргийг бүрэлдэхүүн, элементийн хувьд нарийн зааглаж, нэг мөр ойлголтыг бий болгох.

2. Дээр дурьдсанаар ялгааг тодорхойлж, заагийг тогтоохдоо, НҮБ-ын Конвенцийн 17 дугаар заалтыг хэрэгжүүлж “Нийтийн албан тушаалтан эд хөрөнгө завших, ашиглан шамшигдуулах буюу бусад хэлбэрээр зориулалтын бусаар зарцуулах” гэмт хэргийг тусд нь тодорхойлж, бие даасан гэмт хэрэг болгон зүйлчлэх

3. Дээр дурьдсанаар, “нийтийн албан тушаалтны” гэмт хэргийг тусд авч тодорхойлохдоо, НҮБ-ын Конвенцэд дурьдсан бүх элементүүдийг хамруулах.

22.8 дугаар зүйл. Төрийн өмч, төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах

1.Төсөв захирагч төрийн өмч, төсвийн хөрөнгийг:

1.1.зориулалтын бусаар зарцуулсан;

1.2.төсвийн зөвшөөрөгдсөн хэмжээнээс хэтрүүлсэн;

1.3.зарцуулах нөхцөл, журмыг зөрчиж зарцуулсан;

1.4.зах зээлийн дунджаас дээгүүр үнээр эд хөрөнгө худалдан авч зарцуулсан;

1.5.эд хөрөнгийг зах зээлийн дунджаас доогуур үнээр борлуулсан;

1.6.хэрэгцээнээс илт илүү хэмжээгээр эд хөрөнгө худалдан авч зарцуулсан;

1.7.төсвийн хөрөнгийг зарцуулах нөхцөл, журмыг зөрчиж өөртөө, эсхүл бусдад давуу байдал олгосон бол нийтийн албанд томилогдох, зургаан зуун мянгаас 21 сая төгрөгөөр торгох, эсхүл нэг сараас гурван жил хүртэл хугацаагаар эрх чөлөө хязгаарлах, эсхүл нэг сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

2.Энэ гэмт хэргийг улс төрд нөлөө бүхий этгээд үйлдсэн, эсхүл тавин сая төгрөгөөс дээш хэмжээний хохирол учруулсан бол нийтийн албанд томилогдох, эсхүл сонгогдох эрхийг хоёр жилээс таван жил хүртэл хугацаагаар хязгаарлаж, 7-36 сая төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар эрх чөлөө хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

22.9 дүгээр зүйл. Төрийн өмчийн төсвийн бус хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах

1.Нийтийн албан тушаалтан төрийн өмчийн төсвийн бус хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулсан бол нийтийн албанд томилогдох, эсхүл сонгогдох эрхийг хоёр жил хүртэл хугацаагаар хязгаарлаж, зургаан зуун мянган төгрөгөөс долоон сая төгрөгөөр торгох, эсхүл 240-480 цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас нэг жил хүртэл хугацаагаар эрх чөлөө хязгаарлах, эсхүл нэг сараас нэг жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

22.10 дугаар зүйл. Төрийн өмчийн эд хөрөнгийг хууль бусаар захиран зарцуулах, завших

1.Нийтийн албан тушаалтан хуульд заасан үндэслэл, журмыг зөрчиж төрийн өмчийн хөдлөх эд хөрөнгийг хандивласан, бэлэглэсэн, барьцаалсан, зээлдүүлсэн, худалдсан, түрээслүүлсэн, хөрөнгө оруулалт хийсэн, эсхүл төсвийн мөнгөн хөрөнгийг бусдад зээлдүүлсэн, ашиглуулсан бол нийтийн албанд томилогдох, эсхүл сонгогдох эрхийг хоёр жил хүртэл хугацаагаар хязгаарлаж, зургаан зуун мянгаас хорин нэгэн сая төгрөгөөр торгох, эсхүл нэг сараас гурван жил хүртэл хугацаагаар эрх чөлөө хязгаарлах, эсхүл нэг сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

2.Нийтийн албан тушаалтан хуульд заасан үндэслэл, журмыг зөрчиж төрийн өмчийн үл хөдлөх эд хөрөнгө, эзэмшил газрыг үндсэн чиг үүрэгт нь харшлах өөр зориулалтаар хандивласан, бэлэглэсэн, барьцаалсан, зээлдүүлсэн, худалдсан, түрээслүүлсэн, хөрөнгө оруулалт хийсэн, эсхүл өмчлөх, эзэмших эрхийг шилжүүлсэн бол нийтийн албанд томилогдох, эсхүл сонгогдох эрхийг хоёр жилээс дөрвөн жил хүртэл хугацаагаар хязгаарлаж, 7-36 сая төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар эрх чөлөө хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

3.Нийтийн албан тушаалтан хуульд заасан үндэслэл, журмыг зөрчиж төрийн өмчийн хөдлөх эд хөрөнгө, үл хөдлөх хөрөнгө, төсвийн мөнгөн хөрөнгийг завшсан бол нийтийн албанд томилогдох, эсхүл сонгогдох эрхийг гурван жилээс таван жил хүртэл хугацаагаар хязгаарлаж, арван таван сая төгрөгөөс жаран сая төгрөгөөр торгох, эсхүл хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

4.Нийтийн албан тушаалтан энэ зүйлд заасан гэмт хэргийг үйлдэж тавин сая төгрөгөөс дээш хохирол учруулсан бол нийтийн албанд томилогдох, эсхүл сонгогдох эрхийг таван жилийн хугацаагаар хязгаарлаж, 36-90 сая хүртэл төгрөгөөр торгох, эсхүл таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

22.11 дүгээр зүйл. Улсын нөөцийг хууль бусаар зарцуулах

1.Улсын нөөцийн бараа, материалыг хуульд заасан үндэслэл, журмыг зөрчиж, улсын нөөцөөс гаргасан, эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүй бусдад шилжүүлсэн, зээлдүүлсэн, барьцаалсан, хандивласан, устгасан, худалдсан бол нийтийн албанд томилогдох, эсхүл сонгогдох эрхийг хоёр жил хүртэл хугацаагаар хязгаарлаж, зургаан зуун мянгаас 21 сая төгрөгөөр торгох, эсхүл нэг сараас гурван жил хүртэл хугацаагаар эрх чөлөө хязгаарлах, эсхүл нэг сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

22.12 дугаар зүйл. Албан тушаалтны нэрийг ашиглах

1.Нийтийн албан хаагч өөрт олгогдоогүй албан тушаалын бүрэн эрхийг бусдын нэрийн өмнөөс хэрэгжүүлсэн, ашигласны улмаас бусдын эрх ашигт ноцтой хохирол учирсан бол нийтийн албанд томилогдох, эсхүл сонгогдох эрхийг хоёр жил хүртэл хугацаагаар хязгаарлаж, зургаан зуун мянгаас хорин нэгэн сая төгрөгөөр торгох, эсхүл нэг сараас гурван жил хүртэл хугацаагаар эрх чөлөө хязгаарлах, эсхүл нэг сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

22.13 дугаар зүйл. Хуулийн этгээдийн эрх мэдлийг урвуулан ашиглах

1.Хуулийн этгээдийн удирдах, гүйцэтгэх албан тушаалтан хууль тогтоомж, дүрмээр олгогдсон бүрэн эрх, албан тушаалын байдлыг байгууллагын эрх ашигт харшаар ашиглаж өөртөө, эсхүл бусдад давуу байдал олгосон бол зургаан зуун мянгаас хорин нэгэн сая төгрөгөөр торгох, эсхүл нэг сараас гурван жил хүртэл хугацаагаар эрх чөлөө хязгаарлах, эсхүл нэг сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

3.4. ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ХАРИУЦЛАГА ХҮЛЭЭЛГЭХ

НҮБ-ын Конвенцийн 26.1-д “Энэхуу Конвенцэд заасан аливаа гэмт хэрэгт хуулийн этгээд аливаа байдлаар оролцсон бол, гишүүн орнууд нь тус хуулийн этгээдэд хариуцлага тооцож, энэ тухай тухай дүрэм журам батлах үүрэгтэй” гэж заажээ.

Цаашлаад, 26.2-т “тус хариуцлагын арга хэмжээ нь эрүүгийн, захиргааны эсвэл иргэний аль ч төрлийн арга хэмжээ байж болно” гэсэн байна. Мөн, хуулийн этгээдэд тооцож буй хариуцлагын арга хэмжээ нь, тухайн гэмт хэргийг гардан үйлдсэн хувь хүнийг эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй, бөгөөд хариуцлагын хэмжээ нь гэм буруугийн хэмжээнд тохирсон, үр нөлөөтэй байхыг онцолсон байна.

Монгол улсын Эрүүгийн хуулийн 8 дугаар зүйлд “Эрүүгийн хариуцлагыг зөвхөн хувь хүнд хүлээлгэнэ, мөн гэм буруутай этгээд үйлдсэн гэмт хэрэгтээ зөвхөн өөрөө хариуцлага хүлээнэ” гэж заасны дагуу эрүүгийн хариуцлагыг зөвхөн хувь хүнд оногдуулдаг буюу хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага оногдуулдаггүй.

Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж буй хуулиар, хуулийн этгээд нь гагцхүү захиргааны болон иргэний хариуцлага хүлээх боломжтой. Захиргааны хариуцлагыг, Захиргааны хариуцлагын тухай хуулийн 8.4-т зааснаар, захиргааны зөрчил гаргасан бол, эсвэл өөр бусад хуулийн аливаа зөрчилд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй тохиолдолд, эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр хүлээлгэдэг бол иргэний хариуцлагыг, Иргэний хуулийн 498.1 болон 498.2-т зааснаар, хуулийн этгээдийн ажилтан албан үүргээ гүйцэтгэж яваад бусдад гэм хор учруулсан тохиолдолд тухайн хуулийн этгээдэд хүлээлгэдэг.

НҮБ-ын Конвенцээр хуулийн этгээдэд хүлээлгэх хариуцлагыг заавал эрүүгийн хариуцлага байхыг шаардаагүй буюу бусад төрлийн хариуцлага болох захиргааны эсвэл иргэний хариуцлага байж болохыг зөвшөөрсөн. Гэсэн хэдий ч дээр дурьдсан захиргааны болон иргэний хариуцлагууд нь “авлигын” шинжтэй хэрэг, зөрчлийг хамарч чадахгүй байгаа буюу түүнд зориулагдаагүй байна.

Энэ талаар бодит практик, кэйс, эрх бүхий албан тушаалтан болон шүүхийн шийдвэр байхгүй учир авлигын хэрэг зөрчилд ямарваа байдлаар оролцсон хуулийн этгээдэд Монгол Улс захиргааны, иргэний мөн эрүүгийн аль ч төрлийн хариуцлага оногдуулаагүй байна гэж дүгнэж болохоор байна.

Иймээс Монгол Улс дараах шаардлага, шалтгааны улмаас авлигын хэрэг, зөрчилд оролцсон хуулийн этгээдэд заавал хариуцлага, тэр дундаа эрүүгийн хариуцлага оногдуулах шаардлагатай байна:

1. НҮБ-ын Конвенцийн 26 дугаар заалтаар, тус конвенцэд заасан авлигын гэмт хэргүүдэд аливаа хэлбэрээр оролцсон хуулийн этгээдэд заавал хариуцлага оногдуулахыг гишүүн орнуудад үүрэг болгосон.

2. Зөвхөн Монгол Улсад төдийгүй, дэлхий нийтийн түвшинд, авлигын гэмт хэрэг “хуулийн этгээд”-ээр дамжин хамгийн түгээмэл үйлдэгддэг. Үндэстэн дамнасан том корпорациуд, тэдний нүсэр, комплекс дотоод зохион байгуулалт, бүтэц, шийдвэр гаргалтын олон шат дамжлага, давхаргууд нь зохион байгуулалттай том гэмт хэргүүд, авлигын гэмт хэргийг болон түүний жинхэнэ эзнийг нуух, халхавчлах гол давуу тал болдог. Ялангуяа, том компани, корпорацийн олон шат, давхарга бүхий шийдвэр гаргалтын процесс нь авлигын талаарх шийдвэр гаргасан эцсийн буруутанг олж тогтооход хүндрэл учруулдаг. Нөгөө талаар эцсийн буруутанг хөөж олсон ч, тухайн этгээд нь гадаадруу удаан хугацаагаар дүрвэн зугатаж, байцаан шийтгэх ажиллагаа, нотлох процессыг бүдэгрүүлэн сааруулж, гэмт хэргийг замхруулдаг. Иймд энэ бүхнийг шийдвэрлэх цор ганц арга нь, тухайн авлигын гэмт хэрэгтэй холбогдсон хуулийн этгээдийн захирал, албан тушаалтан, ажилтныг олж тогтоон хариуцлага тооцохоос илүүтэйгээр тухайн хуулийн этгээд, компанид өөрт нь хариуцлага оноох нь илүү үр дүнтэй механизм болох нь тогтоогдоод байна.

3. Нөгөө талаар, бизнесийн шийдвэр гаргалтын олон шат бүхий процессын дундаас ганц этгээдийг, цор ганц хувь хүнийг “эцсийн буруутан” болгон тодорхойлох нь мөн учир дутагдалтай.

4. Авлигын гэмт хэрэгт холбогдуулан хуулийн этгээдэл хариуцлага тооцох санаачилга нь энгийн нэг онолын түвшний санаачилга биш, харин бодит амьдралд хурцаар тулгамдаж буй эрсдлээс үүдэлтэй юм. Статистик судалгаагаар, нийт авлигын гэмт хэргийн дийлэнх хувийг хуулийн этгээдийн үйлдсэн бизнесийн болон дээд түвшний, том хэмжээний авлигын гэмт хэргүүд эзлээд байна. Монгол Улсад бизнес-улс төрийн бүлэглэл, сүлжээ бий болон тэдгээр нь харилцан бие биедээ үйлчилснээр, нэг талд шударга өрсөлдөөн, зах зээлийн эдийн засгийн гажуудал, нөгөө талд төрийн бодлого, хууль тогтоомжийн гажуудал, эцэстээ нийгэм дэх шударга ёс, ардчиллын гажуудлыг бий болгоход хүргээд байна.

5. Авлигын гэмт хэрэгт оролцсон хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага оногдуулах нь дараах 2 гол ач холбогдолтой аж: (i) хуулийн этгээдэд оногдуулж буй эрүүгийн хариуцлага нь тухайн хуулийн этгээдэд их хэмжээний мөнгөн хохирол учруулах төдийгүй, бизнесийн нэр хүнд, цаашдын стратеги зэрэгт туйлын сөргөөр нөлөөлдөг тул бусад хуулийн этгээдэд сэрэмжлүүлэх, урьдчилан сэргийлэх хамгийн үр нөлөөтэй аргуудын нэг болдог нь хуулийн этгээд, компанийн дотоод менежмент, хяналтыг чангатгаж, тэдгээр нь хуулийн дагуу үйл ажиллагаа явуулах баталгаа болдог байна.

6. Зөвхөн НҮБ-ын Конвенц төдийгүй, бусад олон улсын гол конвенц, эрх зүйн баримт бичгүүдэд, хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх механизмыг тусгасан байна. Энд хамгийн анхны НҮБ-ын Эдийн засаг, нийгмийн зөвлөлийн 1994.07.25-ны 1994/15 тоот тогтоолоос эхлээд ЭЗХАХБ-ын Конвенц, ЕЗ-ийн конвенц, Америкийн улсуудын конвенц зэрэг багтана. Тухайлбал, ЭЗХАХБ-ын Конвенцийн 2-т . . гишүүн улсууд нь, гадаадын төрийн албан тушаалтныг хахуульдсан өөрийн хуулийн этгээд, компанид дотоодын хуулиараа эрүүгийн хариуцлага оногдуулах үүрэгтэй” гэжээ. Мөн, эдгээрт тусгасан бас нэгэн чухал зарчим нь, “Хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага оногдуулах нь тухайн авлигын гэмт хэрэгт оролцсон, холбогдсон хувь хүнийг эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй” гэсэн зарчим юм.

7. Өнөөдөр онолын түвшинд ч, хуулийн этгээдийн эрүүгийн хариуцлагын асуудал дэлхий нийтэд хүлээн зөвшөөрөгдөөд байна. Учир нь олон арван жил оршин тогтносон “societas delinquere non potest” буюу “корпорациуд гэмт хэрэг үйлдэж чадахгүй” гэсэн утгатай эрх зүйн уламжлалт зарчим үндсэндээ өөрчлөгдөж, “корпорациуд эрүүгийн хариуцлага хүлээж чадах уу?” гэсэн асуулт нь “корпорациудад хэрхэн, яаж эрүүгийн хариуцлага хүлээлгэх вэ?” гэсэн асуулт руу аль хэдийн шилжсэн байна.

8. Гадаад орнуудын туршлагаас харахад, хуулийн этгээдэд зарим улс иргэний эсвэл холимог хариуцлага тооцсон боловч, дийлэнх улс эрүүгийн хариуцлага тооцсон байна. Жишээ нь: Сингапур улсын Нягтлан бодох болон корпорацийн хариуцлагын тухай хуульд . . хэрэв хуулийн этгээдийг төлөөлж буй этгээд нь хээл хахуулийн болон бусад гэмт хэрэг үйлдсэн бол тус этгээдийг болон түүний харьяалж буй хуулийн этгээдийг эрүүгийн хариуцлагад татна” гэжээ.

Иймд авлигын гэмт хэрэгтэй холбогдуулан хуулийн этгээдэд хариуцлага, тэр дундаа эрүүгийн хариуцлага оногдуулах тухай хуулийн зохицуулалтыг Монгол Улс даруй батлах шаардлагатай. Монгол Улс авлигын гэмт хэрэгт

холбогдсон хуулийн этгээдэд дотоодын эрүүгийн хуулиараа эрүүгийн хариуцлага оногдуулах шаардлагатай.

Энд дараах зүйлсийг анхаарвал зохино:

1. НҮБ-ын Конвенцийн 26.3-т, эрүүгийн хариуцлага нь үр дүнтэй, гэм буруугийн хэмжээнд тохирсон, сэрэмжлүүлэх шинж чанар бүхий хариуцлага байхыг онцолсон. Үүний дагуу улс орнуудад нийтлэг хэрэгжиж буй эрүүгийн хариуцлагын хэлбэрүүд нь: (i) өндөр хэмжээний мөнгөн торгууль - хамгийн түгээмэл хэлбэр, (ii) ирээдүйд Засгийн газартай байгуулах гэрээ хэлэлцээрт оролцуулахгүй байх - энд жишээ нь, тендерт оролцох, тендерийн гэрээ байгуулах гэх мэт үйл ажиллагаанд хориг тавина, (iii) эд хөрөнгийг хураан авах, (iv) битүүмжлэх, дансны гүйлгээг тодорхой хугацаагаар зогсоох, (v) тусгай зөвшөөрлийг цуцлах, (vi) үйл ажиллагааг бүр мөсөн хаах гэх мэт хэлбэрүүд багтана. Эдгээрээс гадна эдийн бус хариуцлага болох тодорхой төрлийн үйл ажиллагаа эрхлэхийг тодорхой хугацаагаар хориглох, итгэмжлэгдсэн төлөөлөгч томилох болон гэмт хэргийнх нь талаар олон нийтэд мэдээлэх, зарлах гэх мэт мөн хамрагдана. Монгол Улс эдгээр түгээмэл хэлбэрийг харгалзан үзэж, тусгавал зохино.

2. Хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага оногдуулах нь тухайн авлигын гэмт хэрэгт оролцсон, холбогдсон хувь хүнийг эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй. Үүнийг Конвенцийн Эрх зүйн удирдамж, хөндлөнгийн орны үнэлгээ, тайлан болон гадаад орнуудын туршлага ийнхүү зөвлөж байна.

3. Хуулийн этгээдийн оролцсон авлигын гэмт хэргийг олж тогтоон, нотлоход цаг хугацааны хувьд урт хугацаа шаарддаг. Иймд тус гэмт хэргийн тухайд хөөн хэлэлцэх хугацааг ердийн гэмт хэргээс урт тогтоож өгөх нь зүйтэй.

4. Бусад улстай харилцах “Эрх зүйн харилцан туслалцаа”-ны механизмыг боловсронгуй болгох шаардлагатай.

Гэмт хэргийн тухай хуулийн төслөөс:

8.1 дүгээр зүйл. Хуулийн этгээдэд ял оногдуулах үндэслэл

1. Энэ хуулийн тусгай ангид хуулийн этгээдэд ял оногдуулахаар заасан гэмт хэргийн бүрэлдэхүүнийг хуулийн этгээдийг төлөөлөх эрх бүхий албан тушаалтан дангаараа, эсхүл хамтран шийдвэр гаргаж, эсхүл хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө хийсэн үйлдэл, эс үйлдэхүйгээр хангасан нь хуулийн этгээдэд ял оногдуулах үндэслэл болно.

2. Хуулийн этгээдийг төлөөлөн шийдвэр гаргах эрх бүхий албан тушаалтанд хуулийн этгээдийн нэрийн өмнөөс шийдвэр гаргаж, зөвшөөрөл өгч энэ хуульд заасан гэмт хэргийг бусдаар үйлдүүлсэн, эсхүл хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө өөрийн үйлдэл, эс үйлдэхүйгээр энэ хуульд заасан гэмт хэргийг үйлдсэн бол ял оногдуулна.

3. Энэ хуулийн тусгай ангид хуулийн этгээдэд ял оногдуулахаар заасан нь энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан журмын дагуу хуулийн этгээдийг

төлөөлөн шийдвэр гаргах эрх бүхий албан тушаалтныг ялаас чөлөөлөх үндэслэл болохгүй.

4.Энэ хуульд заасан тохиолдолд хуулийн этгээдэд оногдуулах ялыг дангаар нь эсхүл давхардуулан оногдуулж болно.

8.2 дугаар зүйл. Хуулийн этгээдэд оногдуулах ялын төрөл

1.Гэмт хэрэг үйлдсэн хуулийн этгээдэд торгох болон эрх хасах, хязгаарлах ял оногдуулна.

8.3 дугаар зүйл. Торгох

1.Энэ хуульд заасан тохиолдолд арван таван сая төгрөгөөс арван тэрбум төгрөгөөр хуулийн этгээдийг торгох ял оногдуулна.

8.4 дүгээр зүйл. Эрх хасах, хязгаарлах

1.Энэ хуульд заасан тохиолдолд 1-8 жил хүртэл хугацаагаар хуулийн этгээдэд нэг, эсхүл хэд хэдэн төрлийн үйл ажиллагаа явуулах эрхийг хязгаарлах, эсхүл эрх хасах ял оногдуулна.

3.5. НӨЛӨӨГӨӨР НАЙМААЛЦАХ БОЛОН ХУУЛЬ БУСААР ХӨРӨНГӨЖИХИЙГ ГЭМТ ХЭРЭГТ ТООЦОХ

НҮБ-ын Конвенцийн 18-д, гишүүн орнууд нь нөлөөгөөр наймаалцах үйлдлийг гэмт хэрэгт тооцохоор харгалзан үзнэ гэжээ. “Нөлөөгөөр наймаалцах” гэдэг нь өөртөө эсвэл гуравдагч этгээдэд төрийн эрх бүхий албан тушаалтнаас давуу тал олж авахын тулд, түүнд нөлөө үзүүлж чадах өөр нэг этгээдийн эрх нөлөөг урвуулан ашиглуулж (ашиглуулах зорилгоор) түүнд хээл хахууль (давуу тал) өгөх, өгөхөөр амлах эсвэл өгөхийг санал болгох үйлдлийг ойлгоно. Энд мөн шийдвэр гаргагчид нөлөөлөх нөлөө бүхий этгээд тус үйлдлийнхээ төлөө гуравдагч этгээдээс хээл хахууль авах, авахаар хясан боогдуулах идэвхигүй үйлдлийг мөн хамруулна.

“Нөлөөгөөр наймаалцах” гэмт хэрэг нь Монгол улсын хуулинд аливаа хэлбэрээр тусгагдаагүй байна. Энэ нь манай хуулинд тусгагдсан эрх мэдлээ урвуулан ашиглах гэмт хэргээс ялгаатай юм. Нөгөө талаар, энэ нь шууд бус хээл хахууль болон лоббидох үйлдлүүдээс ч мөн ялгаатай юм. Олон улсын болон бүс нутгийн конвенцууд, мөн бусад улсын хууль тогтоомжоос харахад “нөлөөгөөр наймаалцах” гэмт хэрэг нь дээр дурьдсан “шууд бус хахууль” болон лоббидох үйлдлүүдээс дараах байдлаар ялгарч байна:

- Давуу тал буюу хээл хахуулийг хүлээн авч буй этгээд нь заавал шийдвэр гаргагч албан тушаалтан байх албагүй. Энэ нь харин шийдвэр гаргагч албан тушаалтанд нөлөөлөх шинж чанар, чадвар бүхий хөндлөнгийн этгээд байна (үүнд, шийдвэр гаргагч албан тушаалтны нэгэн адил албан тушаалтан ч байж болно, эсвэл өөр бусад хувь этгээд ч байж болно).
- Нөлөөгөөр наймаалцаж буй этгээд буюу хээл хахууль авч буй этгээд нь шийдвэр гаргагч этгээд, түүний гаргаж буй шийдвэрт зохисгүйгээр буюу хууль бусаар нөлөөлсөн байна. Үүгээрээ “хууль ёсны” буюу

хуулийн хүрээнд явагддаг “лобби”-оос ялгаатай юм.

- Нөлөөгөөр наймаалцаж буй этгээдийн шийдвэр гаргагчид нөлөөлж буй үйлдэл нь өөртөө хууль бус давуу байдал буюу “хээл хахууль” авах зорилготой байдаг.
- Нөлөөгөөр наймаалцаж буй этгээдийн нөлөөнд автаж буй шийдвэр гаргагч албан тушаалтан нь, нөлөөгөөр наймаалцан хээл хахууль авч буй этгээдийн тус хууль бус үйлдлийг заавал мэдсэн байх албагүй.

“Нөлөөгөөр наймаалцах” үйлдлийн үр дүнд “background corruption” буюу нуугдмал, далд авлига бий болдог. Энэ нь шийдвэр гаргагч албан тушаалтан болон хээл хахууль өгөгч этгээдийн хооронд явагддаг, хоёр талыг хамарсан “шууд” хээл хахуулийн хэлбэрээс илүү сөрөг үр нөлөөллийг нийгэмд үзүүлдэг.

Манай улсад хоёр талыг хамарсан шууд хээл хахуулийн гэмт хэргийг нэгэнт хуульчилсан учир энэ гэмт хэргээс зайлсхийх, гарц буюу хуулийн цоорхой нь “нөлөөгөөр наймаалцах” хэлбэр болоод байна. Иймд тус хэлбэрийг мөн “гэмт хэрэг”-т тооцон хуульчилж өгснөөр “background corruption”- ыг устгах, нийгэм дэх нийт авлигын гэмт хэргээс зайлсхийх, урьдчилан сэргийлэх чухал хэрэгсэл болох юм.

“Нөлөөгөөр наймаалцах” гэмт хэргийг НҮБ-ын Конвенцээс гадна өөр бусад олон улсын конвенцуудаар мөн “гэмт хэрэгт”-т тооцон хуульчилсан байна. Жишээ нь ЕЗ-ийн Конвенцийн 12 дугаар зүйлд “..аливаа шийдвэр гаргагчид эсвэл аливаа этгээдийн шийдвэр гаргах ажиллагаанд зохисгүйгээр буюу хууль бусаар нөлөөлж чадна гэж үзсэн этгээдэд санаатайгаар хууль бус давуу байдал шууд болон шууд бусаар олгосон, амласан эсвэл санал болгосон бол түүнийг гишүүн улс нь гэмт хэрэгт тооцох үүрэгтэй”, мөн “...аливаа шийдвэр гаргагчид эсвэл аливаа этгээдийн шийдвэр гаргах ажиллагаанд зохисгүйгээр буюу хууль бусаар нөлөөлж чадна гэж тохирон санаатайгаар хууль бус давуу байдлыг өөртөө олж авсан эсвэл ийнхүү олж авахаар шаардсан бол түүнийг гишүүн улс нь гэмт хэрэгт тооцох үүрэгтэй” гэж тус тус заажээ.

Авилгын гэмт хэргийг үндсээр нь байхгүй болгох, түүнээс урьдчилан сэргийлэхийн тулд “нөлөөгөөр наймаалцах” үйлдлийг “гэмт хэрэгт” тооцон хуульчлах нь эрх зүйн хувьд зарчмын томоохон алхам болох юм.

22.1 дүгээр зүйл. Эрх мэдлийг урвуулан ашиглах

1.Нийтийн албан тушаалтан албаны чиг үүрэг, бүрэн эрх, албан тушаалын байдлаа урвуулан ашиглаж, эсхүл зориуд хэрэгжүүлэхгүйгээр өөртөө, эсхүл бусдад давуу байдал бий болгосон бол нийтийн албанд томилогдох, эсхүл сонгогдох эрхийг хоёр жил хүртэл хугацаагаар хязгаарлаж, 7-36 сая төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

2.Энэ гэмт хэргийг улс төрд нөлөө бүхий этгээд үйлдсэн бол нийтийн албанд томилогдох, эсхүл сонгогдох эрхийг хоёр жилээс таван жил хүртэл хугацаагаар хязгаарлаж, 15-60 сая төгрөгөөр торгох, эсхүл хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

22.2 дугаар зүйл. Албан тушаалтан бусдад хууль бусаар нөлөөлөх

1.Нийтийн албан тушаалтан хөнгөлөлт, давуу байдал бусдад үзүүлэх, эсхүл өөртөө давуу байдал олж авах зорилгоор өөрөө, эсхүл бусдаар дамжуулан хувь нийлүүлсэн, эсхүл хамтарсан аж ахуйн нэгжийг үүсгэн байгуулсан, эсхүл аж ахуйн үйл ажиллагааг гардан эрхэлсэн, удирдсан, тэдгээрийн удирдах зөвлөл, эсхүл захиргааны гишүүнээр ажилласан бол хөрөнгө, орлогыг хурааж, зургаан зуун мянгаас хорин нэгэн сая төгрөгөөр торгох, эсхүл нэг сараас гурван жил хүртэл хугацаагаар эрх чөлөө хязгаарлах, эсхүл нэг сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

2.Нийтийн албан тушаалтан албаны чиг үүрэг, бүрэн эрх, нөлөөг ашиглан аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд оролцсоны улмаас аж ахуйн нэгжийн төлбөрийн чадвар, ашигт ажиллагаанд тавин сая төгрөгөөс дээш хэмжээний хохирол учруулсан бол нийтийн албанд томилогдох, эсхүл сонгогдох эрхийг хоёр жил хүртэл хугацаагаар хязгаарлаж, 7-36 сая төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

3.Нийтийн албан тушаалтан өөрийн албаны чиг үүрэг, бүрэн эрх, нөлөөг ашиглан бусад нийтийн албан тушаалтнаар өөртөө болон бусдад давуу байдал олгуулах зорилгоор хүсэлт тавьсан, амлалт өгсөн, санал тавьсан, өөрийн албан тушаалын байдлыг ашиглан давуу байдал олгосон бол нийтийн албанд томилогдох, эсхүл сонгогдох эрхийг хоёр жилээс таван жил хүртэл хугацаагаар хязгаарлаж, 7-36 сая төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

4.Энэ гэмт хэргийг үйлдэхдээ нийтийн албан тушаалтан заналхийлсэн, албадсан, улс төрд нөлөө бүхий этгээд үйлдсэн бол нийтийн албанд томилогдох, эсхүл сонгогдох эрхийг хоёр жилээс таван жил хүртэл хугацаагаар хязгаарлаж, 15-60 сая төгрөгөөр торгох, эсхүл хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

НҮБ-ын Конвенцийн 20-д “нийтийн албан тушаалтан нь өөрийнх нь өмч хөрөнгө огцом өссөнийг буюу хууль бусаар хөрөнгөжсөнөө өөрийн хууль ёсны орлоготойгоо үндэслэлтэйгээр холбон тайлбарлаж чадахгүй байгаа бол түүнийг гэмт хэрэгт тооцож болохыг хэлэлцэн тодорхойлох үүрэгтэй” гэжээ.

Монгол Улсын Эрүүгийн хуульд 2012 онд орсон нэмэлт өөрчлөлтөөр, **“Хууль бусаар хөрөнгөжих”** үйлдлийг гэмт хэрэгт тооцон хуульчилсан (270-р зүйл). Ингэхдээ түүнийг “хууль ёсны орлогоос гадна их хэмжээгээр эд хөрөнгө, орлого олсон бол хууль бусаар хөрөнгөжсөн гэмт хэрэгт тооцон эрүүгийн хариуцлага оногдуулна” гэж томъёолсон. Энэ зохицуулалтад, НҮБ-ын Конвенцээр онцолсон “тайлбарлаж чадаагүй орлого”-ыг дурьдаагүй буюу гэмт хэрэгт тооцоогүй бөгөөд харин түүнийг Авлигын эсрэг хуулийн 7.1.8-ын тайлбарт “үндэслэлгүйгээр хөрөнгөжих зөрчил” гэж үзсэн байна.

НҮБ-ын Конвенцийн санаа зорилгоор бол, өөрийн хууль ёсны орлоготойгоо холбон үндэслэлтэйгээр тайлбарлаж чадаагүй орлогыг хууль бусаар хөрөнгөжсөн “зөрчил” бус харин хууль бусаар хөрөнгөжсөн “гэмт хэрэг” гэж үзэж болохыг илэрхийлсэн.

Нийтийн албан тушаалтан нь өөрийнх нь өмч хөрөнгө огцом өссөнийг буюу хууль бусаар хөрөнгөжсөнөө өөрийн хууль ёсны орлоготойгоо үндэслэлтэйгээр холбон тайлбарлаж чадахгүй байгаа бол түүнийг хууль бусаар хөрөнгөжих “гэмт хэрэг” гэж үзэн, Авлигын эсрэг хууль бус Эрүүгийн хуулийн зохицуулалтад оруулах нь зүйтэй.

22.4 дүгээр зүйл. Үндэслэлгүйгээр хөрөнгөжих

1.Нийтийн албан тушаалтан өөрийн хөрөнгө, орлого илт нэмэгдсэн нь хууль ёсны болохыг үндэслэлтэй тайлбарлаж чадаагүй бол үндэслэлгүйгээр нэмэгдсэн хөрөнгө, орлогыг хурааж, нийтийн албанд томилогдох, эсхүл сонгогдох эрхийг 2 жил хүртэл хугацаагаар хязгаарлаж, зургаан зуун мянгаас хорин нэгэн сая төгрөгөөр торгох, эсхүл нэг сараас гурван жил хүртэл хугацаагаар эрх чөлөө хязгаарлах, эсхүл нэг сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

2.Энэ гэмт хэргийг улс төрд нөлөө бүхий этгээд үйлдсэн бол үндэслэлгүйгээр нэмэгдсэн хөрөнгө, орлогыг хурааж, нийтийн албанд томилогдох, эсхүл сонгогдох эрхийг хоёр жилээс таван жил хүртэл хугацаагаар хязгаарлаж, 7-36 сая төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар эрх чөлөө хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

3.6. ХУВИЙН ХЭВШИЛ ДЭХ ХЭЭЛ ХАХУУЛИЙГ ГЭМТ ХЭРЭГТ ТООЦОХ

НҮБ-ын Конвенцийн 21-д “Эдийн засаг, худалдаа, санхүүгийн аливаа үйл ажиллагаа эрхлэх явцдаа хувийн салбарт ажиллаж буй аливаа этгээдээр албан үүргийг нь зөрчүүлэн тодорхой үйлдэл хийлгэх эсвэл хийлгэхгүйн тулд түүнд аливаа хууль бус давуу байдал олгох, олгохоор амлах, олгохыг санал болгох” үйлдлийг гишүүн орнууд гэмт хэрэгт тооцохоор харгалзан үзэх шаардлагатай гэжээ. Энд тус үйлдлийн идэвхигүй хэлбэр болох хувийн салбарт ажиллаж буй этгээдээс өөртөө хууль бус давуу байдал, хээл хахууль олж авах эсвэл олж авахын тулд гуравдагч этгээдийг хясан боогдуулах, шахалт үзүүлэх үйлдлийг мөн ойлгоно.

Монгол Улсын хуулиар, хувийн хэвшил дэх албан тушаалтан, ажилтан хээл хахууль авах (авахаар хясан боогдуулах), тэдгээрт хээл хахууль өгөх үйлдлийг (амлах, санал болгохыг оролцуулан) тусгайлан гэмт хэрэг гэж хуульчлаагүй байна. Эрүүгийн хуулийн 265 болон 266 дугаар заалтад “төрийн бус байгууллага болон аж ахуй нэгжийн албан тушаалтан эрх мэдлээ урвуулах болон хэтрүүлэх” гэмт хэргийг хуульчилж өгсөн боловч энэ нь гэмт хэргийн субъект, үйлдлийн шинж чанарын хувьд дээр дурьдсан хувийн байгууллага дахь хээл хахуулийн гэмт хэргээс ялгаатай юм.

Гадаадын хөрөнгө оруулалт, эдийн засаг өсч буй өнөө үед үндэстэн дамнасан том корпорациуд Монгол Улсад олноор орж ирж байгаа бөгөөд эдгээр нь зах зээлийн шударга өрсөлдөөн, нийт эдийн засагт чухал нөлөөтэй учир энэ салбар дахь засаглалын механизмыг сайжруулах, бизнесийн шударга зарчмыг бий болгох, бэхжүүлэх үүднээс хувийн салбар дахь хээл хахуулийг гэмт хэрэгт тооцон хуульчлах нь зүйтэй.

Ингэснээр, өнөөдөр зөвхөн нэг хувь байгууллага, хувь этгээдэд үр нөлөөтэй гэхээсээ илүү, нийт нийгэм, улс оронд илүү чухал ач холбогдолтой болох юм. Учир нь үүний үр дүнд тухайлбал дэлхийн хэмжээний, үндэстэн дамнасан томоохон корпорациуд дахь бараа үйлчилгээ ханган нийлүүлэх ажиллагаа, ажилтан сонгон шалгаруулах механизм нь илүү ил тод, шударга явагдаж, улмаар нийт зах зээлийн өрсөлдөөн, эдийн засгийг эрүүл байлгах, нийгмийн шударга ёс, ардчиллын зарчмыг гажуудуулахгүй байхад чухал үүрэг гүйцэтгэнэ.

Гадаад орнуудын туршлагаас харахад ч авлигын гэмт хэргийн гаралт хамгийн багатай дийлэнх улсууд, мөн зарим пост-социалист улсууд хувийн хэвшил дэх хээл хахуулийн гэмт хэргийг хуульчилсан байна.

Тухайлбал, Германы Эрүүгийн хуулийн 299.1-д, “.. хувийн хуулийн этгээдийн ажилтан болон түүнийг төлөөлж буй бусад этгээд нь аливаа бизнесийн хэлцэл хийх явцдаа буюу бараа үйлчилгээ худалдан авах өрсөлдөөнт ажиллагаанд хэн нэг этгээдэд шударга бус давуу тал, нөхцөл байдал олгох зорилгоор, шууд өөртөө эсвэл бусад этгээдэд хээл хахууль авсан эсвэл авахаар шаардсан бол тус этгээдийг 3 хүртэл жилээр хорих, эсвэл торгох ял шийтгэнэ”, мөн цаашлаад тус хуулийн 299.2-т “аливаа этгээд бизнесийн аливаа хэлцэл буюу бараа үйлчилгээ худалдах ажиллагаанд оролцох явцдаа, өөртөө шударга бус давуу байдал олж авах зоршгоор аливаа хуулийн этгээдийн ажилтанд эсвэл түүнийг төлөөлж буй бусад этгээдэд ашигтай нөхцөл (хээл хахууль) өгсөн, санал болгосон эсвэл амласан бол, тус этгээдэд мөн 3 жил хүртэл хорих эсвэл торгох эрүүгийн хариуцлага оногдуулна”. Тэгвэл Гүржийн Эрүүгийн хуулийн 221-д “... хэрэв албан тушаалтай нь холбогдуулан өөртөө ашигтай үйлдэл хийлгэх зорилгоор хувийн хуулийн этгээдийн удирдах, төлөөлөх болон бусад эрх бүхий албан тушаалтанд мөнгө, үнэт цаас, эд хөрөнгө болон бусад үйлчилгээг хууль бусаар өгсөн, үзүүлсэн бол тус этгээдийг торгох, 2 хүртэл жилээр баривчлах, 3 хүртэл жилээр хорих эсвэл тодорхой ажил хөдөлмөр эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг нь 3 хүртэл жилээр хасна” гэжээ.

Иймд манай улсад хувийн хэвшил дэх хээл хахуулийн гэмт хэргийг хуульчилж, холбогдох зохистой зохицуулалтыг сайтар судлан тусгаж өгөх нь зүйтэй гэж зөвлөсөн байна.

22.7 дугаар зүйл. Хууль бусаар шан харамж авах

1.Хууль тогтоомж, дүрэм, журам, заавар, гэрээгээр хүлээсэн үүргээ хэрэгжүүлсэн, эсхүл зохих ёсоор хэрэгжүүлээгүйн төлөө бусдаас шан харамж авсан нь хахууль авах гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй бол зургаан зуун мянган төгрөгөөс долоон сая төгрөгөөр торгох, эсхүл 240-480 цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас нэг жил хүртэл хугацаагаар эрх чөлөө хязгаарлах, эсхүл нэг сараас нэг жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

IV БҮЛЭГ. АВЛИГА, АЛБАН ТУШААЛЫН ГЭМТ ХЭРГИЙГ ШАЛГАХ АЖИЛЛАГАА⁸²

4.1. АЛБАН ТУШААЛЫН ГЭМТ ХЭРГИЙН ТАЛААРХ ГОМДОЛ, МЭДЭЭЛЭЛ ХҮЛЭЭН АВАХ, БҮРТГЭХ АЖИЛЛАГАА

Авлигын гэмт хэргийн талаарх гомдол мэдээлэл өгөх ажиллагааны онцлог:

- Хууль сахиулах байгууллагуудад нэгэн зэрэг гомдол мэдээлэл өгдөг /Гомдол мэдээллийг хүлээн авахдаа тэрхүү гомдол, мэдээллийг ямар байгууллагад хандаж гаргасныг тодруулах, шаардлагатай гэж үзвэл гомдол мэдээлэлд дурьдагдсан байгууллагаас тухайн асуудлыг шалгаж байсан эсэхийг тодруулж болно.

- Хууль сахиулах байгууллага, мэргэжлийн хяналт, шүүх, прокурорын байгууллагын шийдвэр гарчихсан асуудлаар дахин гомдол гаргах /гомдол гаргагч нь бүх шатны байгууллагад хандаж шалгуулан цөхөрсөний эцэст итгэсэн хууль сахиулах байгууллагадаа ханддаг, түүнчлэн тэдгээр шийдвэр гаргах явцад авлигатай холбоотой асуудал үүссэн байж болох талтай/

- Улс төрийн зорилгоор гомдол, мэдээлэл гаргах /ихэвчлэн хэвлэл мэдээллийн байгууллагынханыг дагуулсан, тодорхой бүлэг хүмүүсийн жагсаал хэлбэрээр өргөдөл гомдол гаргадаг. Түүнчлэн гомдол мэдээлэл хүлээн авагчаас тодорхой тайлбар хэлэхийг хүсэх, шаардах байдал гаргадаг/

- Гомдол, мэдээлэл гаргагч өөрийн болон гэр бүлийн аюулгүй байдлыг хамгаалах зорилгоор нэрээ нууцлан мэдээлэл өгөх

- Утсаар мэдээлэл өгөх /хүмүүс холбоо барих хаяг, утсаа тодорхой хэлэхгүй, буруу худал хэлэх тохиолдол гардагийг анхаарах/

- Бусдаар дамжуулан гомдол мэдээлэл өгүүлэх /тухайн хүний талаарх мэдээллийг тодорхой тэмдэглэж авах/

- Биеэр ирж мэдээлэл өгөх /тухайн хүний талаарх мэдээллийг тодорхой авах, дэлгэрэнгүй тэмдэглэлд тусгах/

Гомдол, мэдээлэл авахдаа анхаарах асуудал:

- Гомдол мэдээлэл гаргагчийн хаяг, утас, түүнчлэн холбоо барих бусад шаардлагатай утас, хаягийг бичиж тэмдэглэж авах;

⁸² Энэ бүлгийг бичихэд: Авлигын хэрэг мөрдөх аргачлал /Ерөнхий редактор Б.Батзориг/ УБ., 2010, Амгаланбаяр "Байцаалтанд нотлох баримтыг ашиглах нь" УБ., 1989, Батзориг.Б., Зүмбэрэллхам. Д. "Сэжигтэн, яллагдагч, гэрчийн мэдүүлэг нотлох баримт болох нь" УБ., 2006, Батзориг.Б., Бямбаа. Ж, Сүхбаатар.Т., "Эд мөрийн баримт" УБ., 2006, Бат-Эрдэнэ.Б., Байцаалт түүний онцлог, УБ., 1994, Глазырин.Ф.В., Мөрдөн байцаалтын сэтгэл зүй, УБ., 1987, Мягмарцэрэн.Ш.,Цог.Д., "Эдийн засгийн гэмт хэрэгтэй тэмцэх эрүүгийн тагнуулын ажлын тактик" УБ, 2008, Кушниренко.С.П Особенности расследования взяточничества, Санкт-Петербург 2002 зэрэг бүтээлүүдийг ашиглав.

- Өгсөн хаягийг шалгаж байх, /өгсөн утас, гэрийн хаягийг боломжит бүх хэлбэрээр шалгах/;
- Гомдол, мэдээлэл гаргаж буй хүнээр өөрийнх нь гараар нь бичүүлэх;
- Гадаадын иргэн гомдол, мэдээлэл өгч байгаа тохиолдолд бичиг баримтын хуулбарыг авах, монгол хэлээр гомдол, мэдээллийг авах;
- Орчуулагч байхгүй байгаа тохиолдолд /боломжтой/ бол гадаадын иргэний гомдол, мэдээллийг өөрийнх эх хэлээр, гараар нь бичүүлж авч болно;

Нэрээ нууцлан мэдээлэл өгч байгаа тохиолдолд тусгайлан зохицуулсан журмаар гомдол, мэдээллийг бүртгэнэ.

Гомдол, мэдээлэл хүлээн авсаны дараа хийгдэх ажиллагаа

- Гомдол, мэдээлэлтэй сайтар уншиж танилцана;
- Уншихдаа харъяалал, гэмт хэргийн шинжтэй эсэхийг анхаарах;
- Урьд нь тухайн гомдол, мэдээлэлд тусгагдсан асуудлын хүрээнд шалгасан эсэхийг лавлах /*асуудал нь нэг боловч өөр нэг, утгаар гомдол мэдээлэл орж ирж болно*/;
- Урьд нь ийм төрлийн эсхүл тухайн салбарын чиглэлээр шалгагдаж байсан гомдол, мэдээлэл, танилцуулгатай танилцаж /*туршлага хуримтлуулна*/;
- Тухайн гомдол, мэдээллийн талаар холбогдох албан тушаалтнууд, мэргэжлийн хүмүүстэй зөвлөлдөх, шаардлагатай мэдээлэл олж авах /*нууцлалыг хангаж ажиллах*/;
- Гэмт хэрэгт /*албан тушаалын гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээлэлд*/холбогдож байгаа албан тушаалтны ажилладаг тухайн салбарын зохион байгуулалт, үйл ажиллагаатай танилцах, тухайн салбарын үйл ажиллагааны талаар гарсан тогтоол, шийдвэр, дүрэм, журам, заавар зэрэг удирдлагын бичиг баримт болон бусад байгууллагатай харилцах зарчим, журам зэргийг нарийвчлан судлах;
- Холбогдож буй албан тушаалтны үйл ажиллагааны хүрээ, эрх мэдэл, түүний үйл ажиллагаатай холбогдох хууль, дүрэм, тогтоол, заавар, удирдамж, тэдгээрийн ямар заалтыг зөрчсөн болохыг судлах;
- Тухайн албан тушаалтнаас албан тушаалын гэмт хэрэгт холбоотойгоор гаргаж байсан байж болох тушаал, заавар, тогтоол, шийдвэр, бичиг баримтыг судлан үзэж шаардлагатайг нь хуулбарлан авах, холбогдох журам, хурал, зөвлөгөөний шийдвэр, материал, санал, шүүмжлэлийг судлах, албан тушаалтныг холбогдуулан шалгаж байгаа асуудал нь ямар хууль, дүрэм, тогтоол, зааврын ямар заалтыг зөрчсөн болохыг нэг бүрчлэн тогтоох аргачлалаа боловсруулна;
- Албан тушаалын гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийг шалгах явцад уулзаж ярилцах хүмүүсийн дарааллыг тогтоох, үзлэг, нэгжлэг зэрэг ажиллагааг хэдийд, хэрхэн хийх, түүний явцад ямар нөхцөл байдал, эд зүйлийг тогтоох, хураан авах зэргийг төлөвлөнө;

- Бизнесийн болон улс төрийн зорилгоор өрсөлдөгчөө дарах, өш хонзонгийн байдлаар гомдол, мэдээлэл гаргаж шалгуулж байгааг судалж тогтоох;
- Өргөдөл, гомдолд дурьдагдсан зүйлд хэт автахгүй байх. Дан яллах болон цагаатгах талыг баримтлахаас зайлсхийх;
- хүчин төгөлдөр шийдвэр байгаа эсэхийг тодруулах;
- Албан тушаалын гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдлыг шалгаж тогтооход мэргэжлийн байгууллагын үнэлэлт, дүгнэлттэй танилцах;
- Тухайн асуудлыг сайн мэдэх, үйл явдалд аль ч талаасаа зөв үнэлэлт, дүгнэлт өгч чадах, ажил амьдралын дадлага туршлагатай, нийгэмд эзлэх байр суурь нь төлөвшсөн хүмүүсээс сонголт хийж уулзан олон түмний санаа бодлыг сонсоно;
- Тайлбар гаргуулах авах этгээдүүдийн дарааллыг зөв тогтоох, хоорондоо болон тухайн албан тушаалтантай холбоо харилцаа тогтоох, хэл авалцахаас болгоомжилсон нөхцөлийг бүрдүүлэхэд анхаарч шуурхай, төгс байх зарчмыг баримтлана;
- Нотлох баримт, эд мөрийн хангалттай баримтыг олж тогтооход шаардагдах чухал баримт материалыг хаанаас олж болох, ялангуяа үзлэг хийхдээ холбогдогчийн хувийн болон албан бичгийн баримтанд онцгой анхаарал тавьж гэмт хэрэг үйлдэхэд ашигласан, хээл хахуульд авсан зүйлийг биет байдлаар нь олох, захидал харилцаа, тэмдэглэл, мөнгөн хадгаламж, хувьцаа зэрэг зүйлийг илрүүлэхэд илүү анхаарна.
- Гүйцэтгэх алба болон бусад холбогдох албадтай хамтран ажиллах;

4.2. БАЙЦААЛТ ЯВУУЛАХ ТАКТИК, АРГА ЗҮЙ

1. Байцаалтын бэлтгэл Байцаалтын зорилго нь:

- Хэрэгт хамаарал бүхий шинэ мэдээ баримтыг олох;
- Цугларсан баримт сэлтийг шалгах;
- Мэдүүлгүүдэд буй зөрүүг арилгах;
- Нэмэлт, тодруулга, тайлбар гаргуулах замаар нөхцөл байдлыг тодруулах;
- Байцаагдагч болон бусад оролцогчдын талаар мэдээлэл цуглуулахад оршдог;
- Дараагийн ЭБШ тодорхой ажиллагаа явуулахад шаардагдах мэдээлэл цуглуулах.

Байцаалтын өрөөг бэлтгэхдээ дараах зүйлийг анхаарч үзнэ:

- Байцаалт явуулахад тохиромжтой байх;
- Байцаагдагчтай сэтгэл зүйн холбоо тогтоох, байцаах асуултад түүний анхаарлыг төвлөрүүлэх бололцоо бүрдсэн байх;

- Хүний эрхийг зөрчигдөх орчин, нөхцлийг хаасан;
- Мөрдөн байцаалтын нууцыг чандлан хадгалсан байх;
- Тусгайлан тоноглогдсон өрөөнд байцаалт явуулах тохиолдолд техник хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг шалган, техникийн мэргэжилтнүүдийг байлгах;
- Байцаагдаж буй хүний аюулгүй байдал, нэр хүндийг хамгаалах арга хэмжээ авах;
- Өрөөнд байцаалтанд оролцож буй хүмүүсийн аюулгүй байдлын хангах;
- Хэрэгтэй гэж үзвэл байцаагдах хүний дуртай цай, тамхийг бэлтгэх;
- Байцаалтын явцад түүнд үзүүлж болох эд зүйлс, зарим нотлох баримтыг хэрхэн, ямар байдалтай байхад нь харуулах, түүнийг байцаалт явагдах байрны хаана байрлуулахыг төлөвлөх;
- Байцаалт явуулахад шаардлагатай бланк, бичгийн хэрэгсэл, компьютерийн бүрэн бүтэн байдлыг шалгах.

Байцаалт явуулах цагийг тодорхойлох:

- Өдрийн цагаар байцаах, шөнийн цагаар байцаах гэж буй тохиолдолд хойшлуулшгүй тохиолдол гэсэн үндэслэлээ урьдчилан бэлтгэсэн байна;
- Байцаагдах хүний сэтгэл зүйн онцлогт тааруулан цаг сонгох;
- Төрийн өндөр албан тушаалтныг байцаахдаа төрийн албан ёсны арга хэмжээ хэдийд зохион байгуулагдахыг урьдчилан тооцоолох;
- Ажлын бус цагаар байцаах боломжийг судлах;
- Байцаалтанд байлцах хүмүүсийг аль болох дуудсан цагт ирүүлэх арга хэмжээ авах;
- Байцаагдаж буй хүмүүсийг тактикийн хувьд уулзахаар төлөвлөөгүй бол хоорондоо уулзах боломжгүй цаг хугацаанд дуудах.

Байцаалтанд дуудах:

- Зарлан дуудах хуудсыг хэдийд, хаана байхад нь, хэнд өгөхийг урьдчилан судалсан байна;
- Албан тушаалтныг ямар оролцогчоор дуудаж байгаагаас үл хамааран бусдаар дамжуулан өгөхөөс зайлсхийх;
- Бусдын нөлөөнд байгаа оролцогчийг дуудахдаа нөлөөнд байгаа хүнээс тусдаа, ямар нэгэн хамгаалалтгүй байгаа үед дуудаж байцаах;
- Бусдын нөлөөнд байгаа оролцогчийг дуудахдаа аль болох бусдад мэдэгдэхгүй байх арга хэмжээ авах;
- Хэрэгтэй гэж үзвэл зарлан дуудах хуудсыг шууд гардуулан өгч байцаалт авч болно. /албадлага хэрэглэхээс зайлсхийх/;

- Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, түүнчлэн гэрч, хохирогч, шинжээч нь дуудсан үед хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ирээгүй бол хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүх тогтоол, шүүгч захирамж гарган албадан ирүүлнэ;
- Хойшлуулшгүйгээс бусад тохиолдолд шөнийн цагт албадан ирүүлэхийг хориглоно. Шөнийн цагт албадан ирүүлж байгаа тохиолдолд үндэслэлээ урьдчилан бэлтгэсэн байна;
- 14 насанд хүрээгүй этгээд, жирэмсэн эмэгтэй, хүнд өвчний учир ирж чадахгүй этгээдийг албадан ирүүлэхийг хориглоно. Хүнд өвчтэй эсэхийг эмнэлгийн байгууллагын тодорхойлолтоор тогтооно;
- Албадан ирүүлэх ажиллагааг хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгчийн даалгаснаар цагдаагийн байгууллага гүйцэтгэнэ.
- Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийг албадан ирүүлэхэд гарсан зардлыг тооцоолж хавтаст хэрэгт хавсаргах;

Байцаах асуулт бэлтгэх:

- Байцаагдагчийн талаарх мэдээллийг байцаалт явуулах үед өргөн, ашиглахаар мэдээлэл цуглуулах;
- Байцаагдагчийг урьдчилан нарийн судлах;
- Судалгааны үндсэн дээр түүнд тавих асуултыг боловсруулах;
- Тухайн хүний мэдлэг, боловсрол, бичиг үсгийн чадвар, гэмт хэргийн ертөнцтэй холбоотой эсэх, өөрийгөө өмгөөлөх, хамгаалах чадвар нь ямар эсэхээс хамааруулж сэтгэл зүйн холбоо тогтоох сэдлийг гаргах;
- Байцаалтын асуулт, хариултаа урьдчилан бэлтгэж, хэдийд асуух, хэдийд ямар эд зүйл үзүүлэх дарааллаа төлөвлөж, түүний дагуу явах;
- Байцаагдагчидтай сэтгэл зүйн холбоо тогтоох боломжийг судлах;
- Ярилцах, асуух асуудлын логик дарааллыг тогтоох;
- Байцаах явцад бодит мэдээлэлд тулгуурлан цугларсан өмнөх баримтад түшиглэн, байцаах тактикаа хянах, өөрчлөх;
- Итгэл үнэмшил, нотолгоонд түшиглэн хөтөлж байцаахгүй байх;
- Бүх мэдээлэл биш, түүнээс тодорхой нэг хэсэг чухал мэдээлэл авах урьдчилан бодож боловсруулсан зорилготой асуултын дагуу асууж хариулт авах;

Байцаалтын явцад анхаарах зүйл:

- Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч санаачилгыг гартаа авах;
- Байцаагдаж байгаа хүнээс сэтгэл зүйн давамгайл байдалтай биеэ авч явах /дээрэнгүй, ёс зүйгүй байдал гаргахгүй байх/;
- Аль болох өөрөөр нь яриулах /өөрөө бага ярьж байцаагдагчаар их яриулах/;

- Өмгөөлөгч байцаалтанд оролцохдоо байцаалтын ажиллагаанд саад хийлгэхгүй байх боломжийг бүрдүүлэх;
- Өмгөөлөх эрхтэй буюу хуулийн мэдлэгтэй хүн орчуулагчаар оролцож байгаа тохиолдолд орчуулгыг найруулан хэлмэрчлэх явдал гарч болзошгүй тул гадаадын иргэн оролцсон байцаалтыг бичлэг хийх;
- Бичлэг хийхдээ тухайн оролцогчдод мэдэгдэх;
- Байцаалтыг гадны хүний дэргэд болон өөр мөрдөн байцаагч нарын дэргэд байцаалт авахгүй байх;
- Байцаалтанд гаднаас ямар нэг бичлэг хийлгэхгүй байх /мөрдөн байцаалтын нууцлалтай холбоотой/ зөвхөн мөрдөн байцаагчийн техник хэрэгслээр байцаах;
- Тусгайлан бэлтгэсэн өрөөнд ирүүлж байцааж байгаа тохиолдолд тайлбарлаж өгөх.

Байцаалтыг өөр газарт хийж байгаа тохиолдолд:

- Ажлын байранд буюу гэрт нь очиж байцаалт авах гэж байгаа тохиолдолд санаачилгыг хуулийн дагуу гартаа авч байцаах;
- Албан тушаалтныг ажил дээр нь байцаахаас аль болох татгалзах. Учир нь: “сэжигтэн /яллагдагч/-д эрх мэдэлдээ бардах, эрэмших, мөрдөн байцаагчид дарамт үзүүлэхэд түүний ажлын байр тусалдаг”. Тухайлсан албан тушаалтан нарийн бичгийн даргатайгаа утсаар ярих зэрэг мөрдөн байцаагч тактикийн арга хэрэглэх нөхцөлийг боогдуулж, төлөвлөсөн асуултаар байцаасан ч хүссэн үр дүндээ хүрдэггүй;
- Төрийн өндөр албан тушаалтныг байцаах үед /олны танил/ ажлынх нь ширээн дээр нь байцаахгүй байх, ширээнээс өөр ширээнд суулгаж байцаах;
- Албаны ширээ болон зөөлөн буйдан дээр суусан албан тушаалтан байцаагдаж байхдаа сэтгэл зүйн тодорхой давуу байдал бий болгодогийг анхаарах;
- Сэжигтэн, яллагдагчийг өрөөнд нь буюу ажлын байранд ганцаараа очиж байцаахгүй байх /өөр мөрдөн байцаагч дагуулж очих/.

Байцаалтын явцад аюулгүй байдлыг хангах:

- Хэргийн нөхцөл байдлаас шалтгаалан эрсдэлтэй тохиолдолд /сэжигтэн, яллагдагч/ хоёр мөрдөн байцаагч байцаах;
- Шаардлагатай тохиолдолд албан тушаалтнаар өөрөө гараараа мэдүүлэг бичих боломжийг олгох;
- Сэжигтэн, яллагдагчийн сэтгэл зүйн хувьд амиа хорлох болон бусад сөрөг үр дагаврыг сайтар тооцоолох;
- Байцаалтан ширээн дээр байцаагдагчийн зүгээс ирэх ирэх довтолгоонд ашиглаж болзошгүй зэвсгийн чанартай зүйл байгаа эсэхийг анхаарч холдуулах;

- Өөрийн болон байцаагдагч, бусад оролцогчдын аюулгүй байдлыг бүх талаас нь хангах;
- Байцаалтын явцад гүтгэлгийн шинжтэй үйл ажиллагаа гарч болзошгүйг анхаарч байх;
- Гэмт хэргээ илчилж ирсэн тохиолдолд болж өгвөл дүрс бичлэг ашиглаж бэхжүүлэх.

Байцаалт явуулах тактик:

- Энгийн яриа өрнүүлж, биеийн хүлээс, сэтгэхүйн саадыг арилгах;
- Хэрэв танил, урьд нь мэддэг хүнийг байцаах бол албаны яриа, байцаалт явуулах гэж байгааг ойлгуулах;
- Байцаагдагч аль болох чөлөөтэйгээр өөрийн мэдэж байгаа зүйлийг саадгүй ярих нөхцлийг бүрдүүлэх;
- Түүгээр аль болох их яриулж, байцаагч нь өөрөө аль болох цөөн асуулт тавих;
- Яриаг идэвхжүүлэх, байцаагдагчийг урамшуулах үг хэллэг хэрэглэж тэвчээртэй, анхааралтай сонсох;
- Ярьж дууссаны дараа орхигдуулсаныг лавлах, зөрүү мэдээллийг тодруулах асуулт тавих;
- Асуулт нь үндсэн, нэмэлт, тодотгол, хяналтын гэх асуултуудаас бүрдэхээр тооцоологдоно;
- Сэдвээ гэнэт өөрчлөх нь үг алдуулах, бажигдуулахад хүргэж үнэнийг мэдэхэд тусалдаг;
- Мэдээллүүдийн зөрөөг ашиглан хуурамч мэдүүлэг өгөгчийг илчлэх;
- Нөлөө бүхий хүнээр нь бусдадаа хандсан захидал бичүүлэх;
- Мөрдөн байцаагч мэдээлэл сайтай, нууж хаах зүйл байхгүй болсныг байцаагдагчид ойлгуулах;
- Нотлох баримт ашиглах, хөтөлбөргүй нотолгоо үзүүлж тулгах.

Гэрчийг байцаахад анхаарах асуудал

- Гэрч мөн эсэхийг байцаах /аль нэг талын ашиг сонирхлыг хамгаалсан, худалдагдсан гэрч байгаа эсэхийг шалгах/;
- Гэрчүүд сэжигтэн, яллагдагчийн шууд удирдлаганд байгаа тохиолдолд эрсдлээс хамгаалах зорилгоор сэжигтэн, яллагдагчийн албан тушаалын эрхийг түдгэлзүүлсэний дараагаар байцаах;
- Гэрчид байгаа бүхий л мэдээллийг авчруулах арга хэмжээ авах;
- Гэрчийг нэг удаа байцааж дахин байцаахгүйгээр бүх мэдээллийг авах талаар бүх арга хэмжээ авах;
- Хуульд заасан зарлан дуудах, байцаалтын техник ажиллагааны алдаа гаргахгүй;

- Гэрчийг байцаахдаа албан газар нь очиж байцаахаас зайлсхийж байцаах газар, цаг хугацааг нарийн тооцоолох;
- Гэрчийн аюулгүй байдлыг хангах.

Алибиг шалгах явцад анхаарах асуудал:

- Гэмт хэрэг үйлдэгдсэн цаг хугацаанд сэжигтэн, яллагдагч өөр газар байсан;
- Албан тушаалын гэмт хэрэг нь албан тушаалтан өөрт байгаа албаны эрх мэдлээ ашиглан нөлөөлөх байдлаар буюу бусдаар үйлдүүлэх байдлаар үйлдэгддэгийг анхаарах;
- Албан тушаалын гэмт хэрэг үйлдэх тохиролцоог албан тушаалтан урьдчилан хийгээд дараа нь хууль бус ажиллагааг бусад хүмүүс хийдгийг анхаарах;
- Харилцагчаар дамжуулан гэрээ байгуулаад эсхүл хээл хахуулийн гэмт хэрэгт зуучлагчаар дамжуулан үйлдэж байгааг анхаарах;
- Гадаадад сурч байгаа буюу өөр улсад ажиллаж байгаа хүний дансанд гэнэт их хэмжээний мөнгө орж ирдэг гэдгийг сайтар шалгах;
- Алибиг бусдыг албан тушаалын гэмт хэрэгт холбогдуулан гүтгэж байгаа тохиолдолд мөрдөн байцаагч анхаарч шалгах хэрэгтэй.

4.3. ҮЗЛЭГ, НЭГЖЛЭХ ЯВУУЛАХ ТАКТИК, АРГА ЗҮЙ

Үзлэгийн явцад анхаарах зүйл:

- Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч үзлэгийг удирдаж явуулах;
- Орон нутагт үзлэг хийхдээ боломжтой бол прокурор оролцуулах;
- Боломжтой бол үзлэгийн явцад хэмжилт хийх, гэрэл зураг авах, гар зураг үйлдэх, дуу авиа болон дүрс бичлэг хийх, ул мөрний хэв авах, хуулбар авах ажлыг өөрөө хийх;
- Үзлэгийн нууцлалыг сайтар хангах;
- Үзлэг хийхдээ сэтгэл зүйн давамгай байдалтай биеэ авч явах /дээрэнгүй, ёс зүйгүй байдал гаргахгүй байх/;
- Шаардлагатай тохиолдолд үзлэг хийлгэж буй хүнээс хайрцаг, савыг онгойлгуулах, эд зүйлийн онцлог шинжийг хэлүүлэх;
- Компьютерт үзлэг хийхдээ эхний ээлжинд байгаа газар нь үзлэг хийх /компьютерт байгаа мэдээлэл устахаас хамгаалах/ мэдээллийг хуулж авах боломжийг хангах;
- Их хэмжээний бичиг баримт байгаа байранд олон хоногоор үзлэг хийх тохиолдолд тэнд байсан зүйлийг нэгбүрчлэн тоочих, өрөөг битүүмжлэх;
- Үзлэгээр илэрсэн зүйлийг аль болох оролцогчдод үзүүлэх;

- Оролцогчдыг үзлэгийн ажиллагаанд саад хийлгэхгүй байх боломжийг бүрдүүлэх;
- Дүрс болон дууны бичлэг хийж байгаа тохиолдолд оролцогчдод мэдэгдэх;
- Техник хэрэгсэл ашиглан бэхжүүлэх үйл ажиллагаанд орчны нөхцлийг харуулах. Тухайлбал, үзлэгийн орчин тойрны байшин барилга, содон зүйлийг тодорхой харуулсан байх шаардлагатай;
- Үзлэгт хэд хэдэн дүрс бичлэг хийж байгаа тохиолдолд аль болох үзлэгийн бүх үйл явц харагдаж байх газраас бичлэг хийх;
- Үзлэгийн явцад эрүүгийн хэрэгт ач холбогдолтой эсхүл сул үг яриа ярихгүй байх;
- Гаднаас ямар нэг бичлэг хийлгэхгүй байх /мөрдөн байцаалтын нууцлалтай холбоотой/ зөвхөн мөрдөн байцаагчийн техник хэрэгслээр байцаах;
- Хэвлэл мэдээллийн хэрэгслийн байгууллагын ажилтан, сэтгүүлч, сурвалжлагчийг оролцуулахгүй байх талаар хуулийн заалтыг тайлбарлаж өгөх.

Үзлэгийн явцад аюулгүй байдлыг хангах:

- Оролцогчид үзлэгийн газарт буй эд мөрийн баримт, улс мөрийг устгахаас сэргийлэх арга хэмжээ авах;
- Бичиг баримтыг шатааж болзошгүй учир хийн гал унтраагуурыг бэлтгэж болно;
- Оролцож буй сэжигтэн, яллагдагчийн сэтгэл зүйн хувьд амиа хорлох болон бусад сөрөг үр дагаврыг сайтар тооцоолох;
- Төрийн нууцтай холбоотой бичиг баримтад үзлэг хийхдээ хуулийн шаардлагыг сайтар хангах, хамгийн гол нь нууцлалыг задруулахгүй байх арга хэмжээ авах;
- Үзлэгийн газарт орж гарах хөдөлгөөнийг хаах;
- Хөдөлгөөнийг хааж байгаа тохиолдолд байгууллагын хэвийн үйл ажиллагааг удаан хугацаагаар алдагдуулахгүй байхад анхаарна.

Хээл хахуулийн хэрэгт нэгжлэг явуулах тактик

- Мөрдөж буй эрүүгийн хэрэгт чухал ач холбогдолтой эд зүйл, баримт бичиг, үнэт зүйл, орон сууц, албан тасалгаа, тээврийн хэрэгсэл, түүний гажид байж болох тухай хангалттай үндэслэл бүхий мэдээлэл /бичиг баримт, гэрч хохирогчийн мэдүүлгээ бусад зүйл/-д тулгуурлан дээрх байруудад бүхэлд нь эсхүл тодорхой хэсэгт нэгжлэг явуулах тухай тогтоол үйлдэж зөвшөөрөл авна;
- Хаана, ямар объектод нэгжлэг хийх тухай нууцлалыг хангах;
- Гүйцэтгэх албаны шугамаар олох гэж байгаа зүйлийг тогтоолгосон байх;

- Тогтоолыг сэжигтэнд сонсгох учраас мэдээлэл алдагдахгүй, гэхдээ бодитой үндэслэлтэй бичдэг;
- Нэгжлэг хийхээр бэлтгэхдээ хээл хахуулийн эд зүйлийн тухай төсөөлөл, эрж буй эд зүйлийн шинж тэмдэг, түүнийг хадгалж байж болох газар, халхавчилсан арга, нуусан байдлын талаар хангалттай мэдээлэл олж эрэлхийх газар, хугацааг товлон;
- Нэгжлэг явуулах цэгийн тоо, тухайн объектын том, жижгээс хамаарч оролцох хүн, хүч, шаардлагатай тоног төхөөрөмж, тээврийн хэрэгсэл, холбоо барих аргыг тодорхойлно;
- Нэгжлэгийг нэгэн зэрэг явуулах бол ажлын хэсгийг зохион байгуулж, хэсгүүдийн үйл ажиллагааг уялдуулах харилцах мэдээллийг хүлээн авах шуурхай удирдлагаар хангах хүнийг томилох зэрэг асуудлыг шийдүүлнэ;
- Хоёроос доошгүй хөндлөнгийн гэрчийг нэгжлэгт оролцуулна. Хэрүүл, тэмцэл гарахаас сэрэмжлэх, нэгжлэгээр олдсон эд зүйлийг маргааны бай болгохоос болгоомжлох бүхий л арга хэмжээг нэгжлэгт оролцогч бүрт сайтар ойлгуулна;
- Нэгжлэгийг мөрдөн байцаагч, гүйцэтгэх ажилтнуудаас бүрдсэн баг явуулна. Гүйцэтгэх ажилтан нэгжлэг хийлгэж буй хүнийг байнгын анхааралдаа авч, нэгжлэгийн эд зүйл, бичиг баримт устгах, нуух, нэгжлэгт саад учруулах оролдлого хийхээс хамгаална;
- Нэгжлэгийн эхлэл, төгсгөлд сэжигтний биед нэгжлэг хийдэг. Энэ нь сэжигтэн /яллагдагч/ жижиг эд зүйлийг хяналтгүй үеийг далимдуулж биедээ нуусан, хэсэгчлэн хадгалж болох боломжийг таслан зогсоох, улмаар хүний эрхийг хамгаалах ач тустай;
- Болзошгүй тохиолдолд нэгжлэг явуулж буй байранд дайран орж хүч хэрэглэх, зэвсэг ашиглах явдал гаргахаас сэрэмжлэх, гарсан тохиолдолд авран хамгаалах, баривчлан саатуулахад бэлэн байх хүчийг эртнээс бэлэн байдалд байлгана;
- Кассын орлого, зарлагын баримт, харилцахын гүйлгээний анхан шатны бичиг баримт, төлбөрийн даалгаврыг нэгжлэг хийх үед аль болохоор бүрэн бүрдүүлж, тусгайлсан сав, өрөө тасалгаанд хийж хамгаалалтанд авна. Албан тушаалын гэмт хэргийн ул мөр чухамдаа эдгээр баримт дээр хадгалагдах нь цөөнгүй;
- Мөрдөн байцаагч яарч сандрах, айж балмагдах нэгжүүлж буй этгээдийн үг яриа, үйл хөдлөлд автах, сэтгэл зүйн дарамтанд орох байдалд огт хүрэх учиргүй;
- Мөрдөн байцаагч нэгжлэгт оролцогч бүрт нэгжлэг явуулж буй байрыг орхих, өөр хоорондоо болон бусадтай харилцахыг хориглох эрхтэй;
- Нэгжлэг хийхийн өмнө тогтоолоо прокуророор батлуулахын өмнө нэгжлэг хийх гэж байгаа орон байрны ойролцоо хүн байрлуулж орох, гарах хөдөлгөөнд хяналт тавих;
- Нэгжлэг хийх гадны янз бүрийн дайралтаас хамгаалахын тулд хаалга

түгжих зэрэг хөдөлгөөнийг хязгаарлах арга хэмжээ авч, түлхүүрийг авах;

- Нэгжлэг хийх үед албадлага хэрэглэж орж байгаа тохиолдолд хаалга үүдний лац тэмдэгийг сайтар тусгах;
- Нэгжлэг хийж байгаа тохиолдолд нэгжүүлэгч этгээд буюу сонирхогч этгээдийн зүгээс нэгжлэгийг саатуулах ажиллагааг урьдчилан тогтоох */хүчээр орон байранд орлоо гэж цагдаа дуудах, хамгаалалтын алба ирэх боломжийг анхаарах/;*
- Албан тушаалтны зүгээс ирэх сэтгэл зүйн дайралт, хамгаалалтын албаны дайралтанд сэтгэл зүйн бэлтгэлтэй байх;
- Нэгжлэг хийж байгаа өрөөнд байгаа утсыг салгах зэргээр аюулгүй байдлыг хангах;
- Нэгжлэгт мэргэжлийн хяналтын байцаагч, гааль, татварын ажилтнуудыг оролцох боломжийг судлах;
- Нэгэн зэрэг олон байранд нэгжлэг хийж байгаа тохиолдолд нэгжлэгт оролцох хүмүүсийн талаар урьдчилан төлөвлөгөө, удирдамж гаргах;
- Тусгай хамгаалалтанд байдаг байранд нэгжлэг хийх үед нэгжлэгт оролцох хүмүүсийг оролцох боломжийг хангах;
- Нэгжлэг тасалдсан тохиолдолд тухайн өрөөг мөрдөн байцаагч болон хамгаалалтын албадаас давхар лацдуулах;
- Хураан авч буй эд зүйлийн чанарыг алдагдуулахгүй байхад анхаарах;
- Хураан авсан зүйлийн шинж чанарыг мэдэхгүй, сэжигтэй, юу болох нь тодорхойгүй */өвөрмөц өнгө, үнэр, бодит байдлаас хүнд, хөнгөн/* байгаа тохиолдолд аюулгүй байдлыг тухайн газраас хөдөлгөхгүй, мэргэжилтнийг дуудах;
- Бичиг баримт хурааж авахдаа бүгдийг нь хавтасаар нь ерөнхийд нь хурааж авах бус хуудас бүрээр нь тоолж, онцлог шинжийг нь тусгах;
- Их хэмжээний бичиг баримтад үзлэг хийх гэж байгаа тохиолдолд газар дээрээс нь хөндлөнгийн гэрч, хураалгаж байгаа этгээдийг байлгаж байгаад хураан авч битүүмжлээд тайван үзлэг хийх боломжтой газар аваачиж хөндлөнгийн гэрч болон бусад шаардлагатай оролцогчдыг байлцуулан үргэлжлүүлнэ.

Эрж хайх, бэхжүүлэх, үндсэн эд зүйл, эрлийн объект:

а. Хэргийн газар бүхэлдээ байрлалын болон материаллаг нөхцлийн онцлог, хэрэв байрны гадаа бол ямар цэгээс ажиглалт хяналт явуулах боломжтой, байр нь хөл хөдөлгөөнтэй юу, бөглүү эсэх, дурын хүн нэвтрэх боломжтой юу? Зэргэлдээ байр байшин баригдаж буй эсэх, түүний зориулалт, ойртох, зайлах замууд, энэ байранд нууцаар ирэх, нууцаар зугатах боломж, зэргэлдээх байшингаас ямар зайд байрладаг /тавилга,

овортой эд зүйлийн онцлог: шинэ, хуучин, өнгө, ханын будаг, обойны өнгө гэх мэт/

б. Хээл хахуулийн эд зүйлийг хамгаалах сав баглаа боодол буюу түүний хэсгүүд;

в. Гэмт хэрэгт оролцогсдын болон байлцагсдын үлдээсэн ул мөр;

г. хүний гээсэн, мартсан, орхисон /тухайлбал тамхины иш, идэж уусан зүйлийн үйлдэгдэл гэх мэт/ жижиг эд зүйл;

д. Судалж буй үйл явдалтай холбоотой захиа, зурвас, бичиг баримт;

е. Соронзон диск, тууз, электрон дэвтэр, видео, фото баримтуудад агуулагдаж буй мэдээлэл;

ё. Телефон, гар утас, факсын аппарат, автомашины хаалганы бариул, руль, цүнх, сав, ном, компьютерын гар, хулгана зэрэгт хадгалагдаж буй гар, хурууны хээ /санаандгүй үйлдлээс эдгээрт буй мэдээллийг устгасан баримт олон байдаг/

4.4. ШИНЖИЛГЭЭ ХИЙХ, ШИНЖИЛГЭЭНД ТОМИЛОХОД АНХААРАХ АСУУДАЛ

Шинжилгээ хийх, шинжээч томилоход анхаарах асуудал

- Шинжилгээ хийх шаардлага байна уу гэдгийг онцгой анхаарна. Нөхцөл байдал шинжээчийн дүгнэлтгүйгээр бусад нотлох ажиллагаагаар тогтоох боломжтой эсэхийг нягтлах хэрэгтэй. Зайлшгүй мэргэжлийн хүний дүгнэлт шаардагдахгүйгээр нөхцөл байдлыг тогтоох боломжтой байгаа тохиолдолд шинжээч томилохгүй бусад ажиллагаагаар тогтоож болно. Шинжээчид буюу шинжилгээний байгууллагад шинжилгээ хийлгэхэд шаардлагатай бүх мэдээлэл, баримт бичгийг бүрэн хүргүүлэхгүй бол шинжээч зөвхөн өөрт нь ирүүлсэн материалд тулгуурлан дутуу дүгнэлт гаргах, шинжилгээ хийх боломжгүй гэсэн хариу өгөхөд хүргэдэг.
- Тактикийн хувьд бусад мэргэжлийн хүмүүстэй уулзаж ийм төрлийн шинжилгээ хийхэд ямар ямар мэдээлэл авч болох, ямар материалыг цуглуулсан байх талаар урьдчилсан байдлаар мэдээлэл авч болно. Мөн энэ чиглэлийн ном, гарын авлага уншиж судалсан байвал зохино.
- Аль нэг төрлийн шинжилгээг хийлгүүлэхээр шинжээч томилж шинжилгээ хийлгэх тогтоолыг үйлдэхдээ тавигдаж байгаа асуудлаа анхаарч зөв оновчтой асуулт тавидаг. Зөв оновчтой асуулт шинжээчийн дүгнэлт гаргуулах хэргийг зөв шийдвэрлэхэд болон нотлох баримт цуглуулж, бэхжүүлэхэд ихээхэн ач тустай болдог.

Шинжилгээ заавал хийлгэх тохиолдлуудыг ЭБШ хуулийн 156-дугаар зүйлд заасан байгаа. Шинжилгээний олон төрөл байдаг ба ихэнх тохиолдолд шинжилгээг төрөлжсөн шинжилгээний байгууллагууд хийдэг.

Тухайлбал, Хууль зүйн яамны харъяа Шүүхийн шинжилгээний хүрээлэнгийн Шүүх эмнэлэг, Кримналистикийн шинжилгээний төв, Шүүх нягтлан бодох бүртгэлийн магадлах товчоо, Сэтгэцийн эмгэг судлалын төв, Мэргэжлийн Хяналтын байгууллагууд, Замын цагдаагийн газрын Мэргэжил техникийн хяналтын хэлтэс, Үндэсний аудитын газар болон хувийн хэвшлийн аудит, хараат бус судалгаа шинжилгээний төрийн бус байгууллагууд, мониторинг үнэлгээний болон шинжилгээний төрийн бус байгууллагуудаар шинжилгээ хийлгэж дүгнэлт гаргуулдаг.

Хэргийн товч утгыг бичихдээ хэзээ хаана ямар байдалд ямар гэмт хэрэг үйлдэгдсэн. Үүний улмаас ямар асуудлыг тодруулах шаардлагатай байгааг тусгана.

Тавигдах асуулт нь товч бөгөөд тодорхой байх шаардлагатай. Тухайлбал: Хээл хахуулийн гэмт хэргийн үнэт эдлэлийн гарал үүсэл, өртөг, үнэ, санхүүгийн болон валютын гүйлгээний баримт дахь гарын үсгүүд нь харьцуулах шинжилгээнд ирүүлсэн хүмүүсийнх мөн эсэх, мөнгө хүлээн авсан, чек бичигчийн гарын үсэг, үсгийн хэв маяг загвар нэг хүнийх мөн эсэх, шилжүүлэг дээрх гарын үсэг, тамга нь баталгаатай гарын үсэг болон жинхэнэ тамганыхтай тохирох эсэхийг тодруулах асуултууд тавигддаг.

Бичиг баримт, мэдээллүүдээс ердийн бус буюу сэжигтэй үйл ажиллагааг илрүүлэх арга нь:

- Санхүүгийн гүйлгээнд мониторинг үнэлгээ хийлгэх;
- Харилцагч, үйлчлүүлэгч нартай уулзах, ярилцлага хийх, ажлын байрыг судлах зэргээр шинжлэн тандах;
- Үл хамаарах эх сурвалжуудын мэдээллийг мэдээллийн хэрэгсэл, интернэт ашиглан харьцуулан шинжлэх;
- Үйлчлүүлэгч, үйлчлэгчийн орчны талаарх мэдээллийг цуглуулж шинжлэх зэргээр явуулдаг. Эдгээрийг анхдагч шинжилгээ гэж нэрлэдэг.

Шүүх нягтлан бодох бүртгэлийн чиглэлээр явуулах шинжилгээний онцлог нь: Шүүх нягтлан бодох бүртгэлийн чиглэлээр явуулах шинжилгээг хийлгэхдээ аль нэг санхүү, хяналт шалгалтын байцаагч, татварын улсын байцаагч, аудиторын дүгнэлт зэргийг үндэслэн хийлгэдэг.

Мөрдөн байцаагч хэрэг мөрдөх явцад нэмэгдэл үйлдэл, өөр гэмт хэргийг илрүүлсэн бол үндсэн хэргийн бодит үндэслэл санхүүгийн акт дүгнэлтээр шинжээч, мэргэжилтэн томилж болдог. Ингэж шинжилгээ хийлгэхдээ тухайн акт, дүгнэлт үндэслэлтэй эсэх, үндэслэлийн талаар тайлбарлуулах, давхар нотлуулах, үүссэн шинэ нөхцөлд учирсан хохирлын цар хүрээг тогтоолгох, анхны акт дүгнэлт дээр нэмэлт дүгнэлт гаргуулах чиглэлээр асуултыг боловсруулна.

Шинжээчид асуулт тавихад анхаарах асуудал

Аливаа шинжилгээ хийж дүгнэлт гаргаж байгаа шинжээч зөвхөн тогтоолд дурьдагдсан асуултын хүрээнд л дүгнэлтээ гаргадаг. Тэгэхээр шинжээчид тавигдаж байгаа асуулт нь зөв, оновчтой хэргийн бодит үнэнийг тогтооход чиглэгдсэн байх ёстой.

Бичиг баримтанд шинжилгээ хийлгэхэд дараахь асуултыг гол төлөв тавьдаг.

- Бичиглэл, түүний хэсгүүдийг үйлдсэн арга, нөхцөл, хугацааг тодорхойлох;
- Баримтанд буй өөрчлөлт, түүнийг хийсэн аргыг тогтоох, */арилгах, уусмалаар идүүлэх, оруулга хийх зэргээр чухал өөрчлөлтийг яаж хийснийг магадлах/*;
- Бүдэг, үл уншигдах бичиглэл тодруулах, гэмтэлтэй бичлэгийн агуулгыг сэргээх;
- Бичиг үйлдэхэд ямар материал ашигласныг тодорхойлох;
- Бичиг баримт, түүний хэсгийг үйлдэхэд ашигласан бичгийн хэрэгслийг адилтгах;
- Олдсон хэд хэдэн баримтыг нэг эсхүл хэдэн хүн үйлдсэнийг тодорхойлох;
- Чөлөөт загварыг бичигч, шинжлэгдэж буй загварыг үйлдсэн эсэхийг тодорхойлох;
- Хэргийн газраас олдсон шинжлэгдэж буй гар бичмэлтэй харьцуулах замаар зохиогч, бичигчийг адилтган судлах, шинжлэхээр авсан загвар нь чөлөөт загвар байх ёстой.

Гэмт хэрэг үйлдэхээс өмнө үүссэн тухайн эрүүгийн хэрэг үйлдэгдэх агшин, орчноос өөр нөхцөлд бий болсон эх бичгийг шинжилгээний чөлөөт загвар гэдэг. Чөлөөт загварыг шинжилгээгээр судлах загвартай харьцуулах нь бодит үнэнийг олж тогтооход илүү үр дүнд хүргэдэг. Иймд харьцуулан шинжлэх чөлөөт загварт дараахь шаардлагыг тавьдаг:

- Чөлөөт загварын гарал үүсэл маргаангүй байх;
- Бичигдсэн цаг хугацаа, хэлбэр, агуулга, бичиг хэрэгслийн хувьд шинжлэгдэж буй бичиг баримттай жиших, харьцуулан дүгнэхээр байх;
- Загварын хуудас, бичвэрийн хэмжээ хангалттай буюу 2-5 хуудас бичвэр буюу 10-15 гарын үсэг, тамга тэмдэг байх;
- Харьцуулах шинжилгээнд хүргүүлэх бичиг баримт нь эх хувиараа байх;
- Төлбөрийн даалгавар, нэхэмжлэл, чек, кассын баримт зэрэг тодорхой маягт хэвлэмэл хуудсаар хийгддэг гүйлгээний баримтыг сонгож буй бол овог нэр, тоо цифр, огноог бичмэл, дармалаар хольж бичсэн хувийг сонгох гэх мэт шаардлагыг хангасан байна. Энэ нь хэргийн газар үлдээсэн баримт бичиг зориуд санаатайгаар гэмт хэргийг илрүүлэх ажиллагаанд саад учруулах зорилготой зориуд бичгийн хэв загварыг өөрчилж бичсэн байвал түүнийг тодорхойлоход тус болдог.

Үзлэг, нэгжлэгийн явцад дараах ил шинж тэмдэг харагдаж буй бичиг баримтыг хураан авч шинжилгээнд явуулдаг. Тухайлбал, хуурамч болон өөрчлөн зассан баримт, тамга, тэмдгийн дардасыг таних шинжүүд нь:

- Үсгийн шрифт, стандарт бус;
- Ижил үсгүүдийн дүрс хэмжээ ялгаатай байх;
- Үсгийн тэнхлэг, тойргийн радиустай үл тохирох;
- Үсгийн байрлалын тэгш хэм алдаатай байх;
- Дүрмийн алдаа ажиглагдах;
- Тэмдэгтүүдийн налуу жигд бус байх;
- Дардасууд өөр хоорондоо зөрүүтэй байх;
- Дардасыг урьдчилан дарсан шинж илрэх.

Уусмалаар идүүлсэнийг таних шинж:

- Хамгаалалтын торны будагч нүүсэн;
- Толбо үүссэн, цаасны өнгө тухайн хэсэгт өөрчлөгдсөн;
- Цаасны гадаргад өөрчлөлт үүссэн, гялгаргүй бүрсийх;
- Анхны бичвэрийн үлдэц илрэх;
- Нэмж бичсэн бичлэгийн өнгө ялгарах.

Нэмэлт оруулга хийснийг таних шинж:

- Үг, үсэг, цифрийн өнгө ялгарах;
- Зураасны бүтэц зөрөөтэй байх;
- Бичлэгийн байрлал мөр хооронд, цаасны захад ялгаатай болсон;
- Бичгийн хэрэгслийн тэмдэгтүүд зөрүүтэй байх;
- Үсэг, мөр хоорондох зай ялгаатай болсон;
- Үг, үсэг тоог оновчгүй хураангуйлсан;
- Бичлэг, логик бүтэц алдагдсан.

Хуурамч гарын үсгийг таних шинж:

- Үг, үсэг, цифрийн өнгө ялгарах;
- Гарын үсэгт онцолсон тохирсон хэлбэр зонхилох;
- Гэрэлтүүлж зурсан чичирхийлсэн хэлбэр ажиглагдах;
- Зураасууд нь жигд бус;
- Хэт яагаан туяанд ажиглагдах толбо цаасанд ажиглагдах.

Албан тушаалтан өөрийн эрх мэдэл, үүргийн хүрээнд ажиллахад төвөг саад байдаггүй. Нягтлан бодогчтой гар нийлж ажилладаг учир өөрөө баримт бичиг засварлах нь цөөн тохиолддог. Харин даргын гарын үсгийг нягтлан бодогч урьдчилан зуруулж авсан чек, кассын баримт, шилжүүлгээр өөр их хэмжээний мөнгө авч ашиглах тохиолдол олонтой байдаг. Доод шатны дарга, дээд шатны төсөв захирагч, компаний захирал, үйлдвэрийн газрын даргын гарын үсэг, тамга тэмдэг дуурайлгах, хуурамч тэмдэг дарах зэргээр мөнгөн хөрөнгөд халддаг.

Мөрдөн байцаагч сэжиг бүхий баримт бичиг, санхүүгийн баримтыг төвөггүй ашиглах боломжтой. Түүнээс улбаалж албан тушаалтны үйлдсэн гэмт хэргийг бүрэн илрүүлэхэд төрөл бүрийн хянан шалгах, шинжлэх магадлах, судлан дүгнэлт гаргах эрх бүхий байгууллагуудын боломж бололцоог чадварлаг ашигладаг байх нь чухал.

Шинжээчийн дүгнэлт гарснаар хохирогч, гэрчийн мэдүүлэг, хэргийн газрын үзлэгийн тэмдэглэл, хэргийн газраас хураан авсан эд зүйл нь нотлох баримт болох эсэх эргэлзээг ихээхэн тайлдаг.

Тухайлбал, Бэлтгэн нийлүүлэгчтэй үгсэн тохиролцсоны дараа илүү үнээр гэрээ, хэлэлцээр байгуулсан, тендерт ялах магадлалтай аж ахуйн нэгжийг зориуд сонгон шалгаруулалтад оруулаагүй, орон сууц халамж үйлчилгээг ажилтанд үзүүлэхдээ илт дүрэм, заавар зөрчсөн шударга бус хандсан, зээлийг хуурамчаар гүйлгээ хийж төлсөн мэт харагдуулсан зэргээс банкны албан тушаалтан ашиг хонжоо олсон, хөрөнгө мөнгө завшсан тухай мэдүүлэг, үүнийг баталсан, үгүйсгэсэн гэрчүүдийн мэдүүлгүүд нь үнэн зөв бодитой гарсан шинжээчийн дүгнэлтээр батлагдаж, эсхүл үгүйсгэгдэх талтай байдаг.

Кримналистикийн шинжээч, замын цагдаагийн мэргэжлийн шинжээчийн дүгнэлт, Сэтгэгц эмгэг судлалын нарийн мэргэжлийн эмчийн дүгнэлт зэрэг нь ч эргэлзээг тайлахад хамааралтай.

Манай улсад цөөн хэрэглэгдэж буй чухал шинжилгээний төрөл нь хүний дуу авиа, гар бичмэлийн хэв маягаар нь хүнийг таньж, мэдэх хүнээр гэрчлүүлэх, иргэний тайлбар бичгээр гаргуулах ажиллагаа мөн. Үүнийг гэрэл зургаар таниулахтай адил өргөн хэрэглэгдэх учиртай.

4.5. АЛБАН ТУШААЛЫН ГЭМТ ХЭРГИЙГ МӨРДӨХӨД АНХААРАХ ЗАРИМ АСУУДАЛ

1. Хууль бус орлогыг илрүүлэх нь

Албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулах, эрх мэдлээ хэтрүүлэх, мөнгө угаах, хээл хахууль авах, өгөх, зуучлах, төсвийн болон төрийн өмчийг зориулалт бусаар зарцуулах зэрэг албан тушаалын гэмт хэрэг дээр халдлагын зүйл нь гол төлөв мөнгө, мөнгөн хөрөнгө, эд зүйл, бараа, материал байдаг. Хууль бус замаар олсон хөрөнгөө ил гаргаж эргэлт, гүйлгээнд оруулах арга олон янз. Иймээс нуугдмал хөрөнгө ил гаргах буюу мөнгө угаах аргыг мэдэж авах нь сэжигтэн, яллагдагчийн үйлдлийг бүрэн илчлэх чухал ач холбогдолтой. Завшсан, хээл хахуульд авсан бэлэн мөнгийг дараах аргаар ил болгодог.

- Байшин барилга, орон сууц, орд харш барих (татвар төлөөгүй мөнгөөр);
- Нууцаар хил давуулсан мөнгөө гадаадын хөрөнгө оруулалт мэтээр илээр хил гаальд мэдүүлж нэвтрүүлэх;
- Өөрийн дотны хүмүүсийн нэр дээр хувийн хадгаламж нээж банкинд байршуулах;

- Бэлэн мөнгө эргэлддэг банк, хадгаламж зээлийн хоршоо, барьцаалан зээлдүүлэх цэг, ресторан, бар, мөрийтэй тоглоомын газрын эргэлтэнд оруулах;
- “Хавала” аргаар мөнгө гуйвуулах;
- Өндөр үнэтэй эд зүйл буюу автомашин, үл хөдлөх хөрөнгө, гоёлын эд зүйл худалдаж авах;
- Валют худалдан авах, худалдаалах арилжааны цэг ажиллуулах;
- Бэлэн мөнгийг дипломат халхавч, курьер бусад албан тушаалтнаар хил давуулж гадаадын аль нэг улсад байршуулдаг.

Хууль бус аргаар олсон бэлэн бус мөнгө хөрөнгийг ил болгож ашиглах, иргэний гүйлгээнд оруулах хууль ёсны өмчлөгч нь болоход дараах аргуудыг хэрэгжүүлдэг;

- Импорт, экспортын барааг худалдан авч бусдад худалдан борлуулах (хуурамч бичиг баримтаар);
- Урьдаас хэлэлцэн тохиролцсон компани, аж ахуйн нэгжийн харилцах данс руу ямар нэг бараа ажил үйлчилгээний үнэ, төлбөр мэтээр шилжүүлэх;
- Хуурамч компани, санхүүгийн хяналтгүй буюу оффшор компани ашиглах;
- Үнэт цаасны биржүүд рүү мөнгөө оруулж хувьцаа, үнэт цаас худалдан авах зэрэг арга хэргэлдэг.

Харин хууль бус аргаар олсон эд хөрөнгийг ил болгох арга нь үгсэн тохирсон хувь хүн, аль нэг аж ахуйтай ажил үйлчилгээ үзүүлсэн, эд бараа худалдсаны төлбөр мэт гэрээ хэлцэл үйлдэж түүнийг дагуулж хуурамч зарлагын баримт олж авдаг.

Албан ёсны баримтаа түшиглэн үл хөдлөх байшин сав, бараа материалыг бэлэн мөнгө, бусад зүйлээр бусдад худалдаж хууль ёсны өмч болгодог. Зүй бусаар олсон мөнгө, бэлэн бус мөнгө, эд хөрөнгийг үзлэг нэгжлэгээр олж илрүүлэх эмзэг цэг нь:

- Санхүүгийн сүлжээнд бэлэн мөнгө орж ирэх үе, мөнгө байршиж буй цэг;
- Улсын хилээр бэлэн мөнгө, валют нэвтрэх үе, түүнийг тээж яваа тээврийн хэрэгсэл, хариуцаж яваа бие хүн;
- Хуурамч компани байгуулсан, улсын бүртгэлд оруулж буй цаг, түүний нэр дээр банкинд нээсэн харилцах данс (сүүлийн үед баг өмсөж авахуулсан фото зургаар иргэний үнэмлэх авч, банкинд хадгаламжийн дэвтэр тухайн нэрээр нээж банкны их хэмжээний мөнгийг банкны албан тушаалтантай хуйвилдан уг зохиомол иргэний хадгаламж руу шилжүүлж бэлнээр авч ашиглах арга дэлгэрч байгаа) уг данс руу мөнгө гуйвуулж буй үе;

- Дээрх санхүүгийн гүйлгээнүүдийг хийхэд үйлдсэн бичиг баримт зэрэг болно.

Албан тушаалын гэмт хэргийг таних доорх шинж тэмдгүүд байдаг. Тухайлбал

- Их хэмжээний бэлэн мөнгө харилцах данс, хадгаламж руу гэнэт шилжих;
- Санхүүгийн гүйлгээг эзэмшигч өөрөө банкинд ирж хийхгүй итгэмжлэгчээр гүйцэтгүүлэх;
- Харилцах данс, хадгаламж нээлгэгч өөрийн тухай шалгах боломжгүй, эсхүл хуурамч мэдээлэл өгөх.
- Харилцагч бизнесийн боломжоосоо давсан гүйлгээ хийлгэх;
- Үйлчлүүлэгчийн ашиг сонирхлыг төрүүлэхээр их хэмжээний валютыг солиулах зэрэг байдлаар илэрдэг.

Албан тушаалын гэмт хэрэг дээр үзлэг, нэгжлэгийн явцад олсон баримт болон дээрх сэжигтэй шинж тэмдгүүдийг мөрдөн байцаагч өөрт байгаа мэдээллүүдийг судлах, цэгцлэх, системчлэх замаар олж авдаг.

2. Санхүүгийн болон валютын гүйлгээний журам зөрчсөн албан тушаалын гэмт хэргийг мөрдөх онцлог

Санхүүгийн болон валютын гүйлгээний журам зориуд зөрчиж хувьдаа ашиг хонжоо олох явдал шилжилтийн эхний буюу 1990-ээд оны эхэн болон дунд үед түгээмэл байв.

Тухайлбал, Нэгэн яамны дэд сайд, хэрэгжүүлэгч агентлагийн санхүүгийн хэлтсийн дарга нар бүлэглэн бүтээгдэхүүний борлуулалтын орлогыг зориуд бэлнээр касст авахуулж банкинд хадгалахгүй албан байгууллагын касст төвлөрүүлж түүнийгээ өөрсдөө дур мэдэн гар дээрээ авч их хэмжээний доллар худалдан авч цүнхлэн дипломат паспортаар хойд хөрш рүү онгоцоор гаргаад Москвад рублээр солин, рублээ Улаанбаатарт төгрөг болгон борлуулж дундаас нь хувьдаа үлэмж ашиг унагаж хуваан завшдаг байж, Гуравдахь этгээд буюу валют солигч нь Москвад суурин төлөөлөгчөөр амьдардаг “ачааны хүндийг үүрдэг” ашиг хуваалцдаг нэгэн байв.

Ашиг хувааж авахаас тэд хоорондоо эвдрэлцэн салцгаахад энэ хэрэг хожим илэрч толгой цусдах аюул ирэхээс болгоомжилсны үр дагавар болсон уу? Ашгийн 90-95 хувийг эзэмшсэн хоёр нөхөр бизнесээ цэцэглүүлэн байхад гуравдахь этгээд ертөнцийн мөнх бусыг үзүүлсэн амьд “хар” жишээ одоо түүх болон үлджээ. Энэ эрүүгийн хэрэг илчлэгдэж хэн нэг хүн ял эдлээгүй ч ямар зүйл ангиар зүйлчлэгдэх, санхүүгийн болон валютын гүйлгээ гэж юуг хэлэх, ямар журмыг яахын тулд зөрчиж байсан нь сургамжтай юм.

Энэ бол албан тушаалын албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулан ашигласан, эрх мэдлээ хэтрүүлсэн, төрийн өмчийг зориулалт бусаар зарцуулсан албан тушаалын гэмт хэрэг, санхүүгийн гүйлгээний журам, валютын гүйлгээний журам зөрчсөн эдийн засгийн эсрэг

гэмт хэрэг, хууль бус замаар олсон орлогоороо орон сууцны нэг бүтэн орц, сангийн аж ахуй, хүүхдийн зуслан, гурилын үйлдвэр хувьчлан авсан үйлдлээрээ мөнгө угаасан гэмт хэрэг байлаа.

Санхүүгийн гүйлгээ, валютын гүйлгээ гэдгийг ихэнх хуульчид нэг байгууллагаас нөгөө рүү, эсхүл нэг хуулийн этгээдээс нөгөө хуулийн этгээд рүү мөнгө шилжүүлэх, үйлдлийг ойлгодог нь өрөөсгөл.

Валютын гүйлгээ гэдэг нь иргэд, хуулийн этгээдүүдийн мөнгөн хөрөнгө, үнэт цаас, төрөл бүрийн төлбөрийн болон тооцооны хэрэгсэл хүлээн авах, олгох, төлөх, дамжуулах, тээвэрлэх, шилжүүлэх, солих болон санхүүгийн хэрэгсэл, материал үнэт зүйлийг хадгалах үйл ажиллагааг хамарсан ерөнхий ухагдахууныг хэлдэг. Валютын гүйлгээ гэдэг нь эх орны мөнгөн тэмдэгт гадаад улс орны хөрвөх чадвартай валютыг авах, олгох, төлөх, дамжуулах, тээвэрлэх, шилжүүлэх, солих, хадгалах үйлдлийг хэлнэ.

Ам долларын эрэлт ихэсч, ханш чангарч байгааг ашиглан, их хэмжээний ам доллар худалдан авах зорилгоор бүтээгдэхүүний төлбөр тооцоог зөвхөн бэлэн мөнгөөр хийх шийдвэрийг дээрээс зориуд бодлогоор гаргаж, төвлөрүүлсэн бэлэн мөнгөөр монголын валютын захаас доллар худалдан авч ОХУ-руу гарган рублээр солиод түүнийг монголын валютын ченжүүдэд худалдан хуулиар хориглосон валютын гүйлгээний журмаар зөвшөөрөөгүй үйлдлийг олон дахин давтан хийгээд улирал, жилийн тайлан баланс гаргах үед касс төгрөгөө тушааж хонуулаад ээлжит эргэлтэнд оруулдаг байсан энэ мэт гэмт үйлдлийн уршгийг Монголын жирийн ард иргэд, аж ахуйн нэгж үүрсэн бөгөөд хохирогчид нь төр, ард иргэд байв.

3. Шүүн таслах ажиллагааны үед үүсэх нөхцөл байдлыг таамаглан, эсрэг үйлдэл хийхээс урьдчилан сэргийлэх нь

Мөрдөн байцаах ажиллагаа дуусахад мөрдөн байцаагч эрүүгийн хавтаст хэрэг бүрэн дүүрэн, бодитой, бүх талаас магадлан шалгагдсан гэдэгт бүрэн итгэлтэй үлдэх ёстой. Нотолгоо, нотлох баримтыг бүгдийг мэдэж байгаагийн хувьд шүүгдэгч өөрийгөө хэрхэн хамгаалах талаар таамаг дэвшүүлж нотолгоог хэрхэн няцаах, ямар нотлох баримт түшиглэж хамгаалалтаа хүчтэй болгож болохыг төсөөлдөг, шүүгч мэтгэлцээнд хэрхэн хандаж ямар асуулт тавьж, хамгаалалтын бодит үндэслэлийг шалгаж магадлан болохыг ч урьдчилан хардаг байх учиртай.

Шүүхээс эрүүгийн хэрэг нэмэлт мөрдөн байцаалтанд буцах нь нэг ёсны гологдол, нөгөө талаар мөрдөн байцаагчийг алдаанаасаа сурах ташуур болдог. Алдаа гаргаж түүнээсээ сурах биш, алдаа дутагдал гаргахгүйгээр эрүүгийн хавтаст хэргийг шалгаж, бүрэн, бүх талыг шалгаж, бодитой эргэж буцахгүй болгож прокурорын хяналтад шилжүүлдэг байхад юунд анхаарах ёстой вэ?

- Шүүгдэгч, гэрчүүд мэдүүлгээ өөрчлөх шалтаг өгөлгүйгээр эргэлт буцалтгүй нотолгоожуулж олон эх үүсвэрээр мэдээллүүдийг нь батлах;
- Шүүгдэгч шүүн таслах ажилгааны явцад гаргаж тавьж болох мөрдөн байцаалтын үед хөндөгдөөгүй буюу орхигдуулсан ямар асуудал байж болохыг нягтлан таамаглаж мухарлан шалгах;

- Эрүүгийн хавтаст хэрэгт буй нотолгоо, баримт сэлт, мэдээллүүд, мэдүүлгүүдэд нэг нь нөгөөгөө үгүйсгэсэн, зөрчилдсөн, дутуу магадласан мэдээлэл байгаа эсэхийг нарийвчлан шалгах, зөрүүг арилгах;
- прокурор яллах дүгнэлтийг бичихдээ дээрх алдаа, зөрүүтэй зүйл үндсэн болон хөндлөнгийн нотлох баримт, баримт сэлт байгаа эсэхийг магадлах бөгөөд шүүх дээр мэтгэлзэх үед зөрүү илэрвэл түүнийг өөрийн итгэл үнэмшлээр арилгах, няцаалт өгч мэтгэлцээнд зөрүү нь бага ач холбогдолтой буюу эрүүгийн гэмт хэрэгт голлох зүйл биш болохыг нотолдог. Прокурор, мөрдөн байцаагч нар нэг эрүүгийн хэрэг дээр ажиллаж байгаагийн хувьд эхнээсээ зөв ойлголцсон, нэгдмэл санаа бодолтой гар нийлж ажиллах ёстой;
- Мэдүүлгийг нарийвчилж авснаар хожмын өдөр хэн нэгэн мэдүүлгээ буцаах боломжийг хаадаг учир мэдүүлэг бүрийг үйл явдлын болон уг ярианы өнгө нүдэнд харагдаж, чихэнд сонсогдож, гарт мэдрэгдэж, сэтгэл санаанд буухаар бичих ёстой;
- Байцаах, нүүрэлдүүлэх, турших зэрэг ЭБШ ажиллагааг аль болохоор дүрс дууны техник хэрэгслээр бичиж бэхжүүлнэ. Энэ нь “мөрдөн байцаагч буруу бичиж авсан байна” гэдэг муйхар шүүгдэгч, хоёр нүүртэй гэрч мэдүүлгээ буцахаас хамгаална;
- Мэдүүлгээ буцаах өөр нэг шалтаг нь “байцаагч сэтгэл зүйн дарамт үзүүлж хүч хэрэглэн зохиомол мэдүүлгээ өгөхөд хүргэсэн” гэх үндэслэл гаргадаг. Иймэрхүү үндэсгүй шалтагийг техник хэрэгслээр бичиж авсан хуурцган дахь дуу, дүрс няцаадаг;
- Дүрс дууны бичлэгийг хүч хэрэглэсэний дараа бичиж авсан мэтээр шүүгдэгч мэтгэж болох учир, дээрх бичлэгүүдийг сэтгэл зүйн шинжээч томилж дүгнэлт гаргуулж болно;
- Шүүгдэгч гэрчийг худалдан авсан, сэтгэл зүйн болон бие эрхтэнд нь, гэр бүлийнхэнд нь дарамт учруулснаас мэдүүлгээ эрс өөрчилсөн нь шүүх дээр илэрхий болох үед улсын яллагч гэрчийг ямар учраас өөр мэдүүлэг өгөх болсон бодит шалтгааныг тодруулж дэлгэрэнгүй, үнэн зөв мэдүүлэг түүнийг хүнд байдлаас гаргах гарц болно. Гэрчийг тусгай хамгаалалтанд авах боломж нээлттэйг сануулна. Байцаагч, прокурор нарын гар нийлсэн ажиллагаа үүгээр шалгагддаг;
- Гол гэрчийг шүүгдэгчийн нөлөөнд орж болзошгүй тохиолдолд хамгаалалд авахуулах арга хэмжээ авдаг. Болзошгүй үед гол гэрчийг устгаж мэдэх учраас түүнийг гүйцэтгэх ажлын хяналт, хамгаалал дор байлгадаг. Энэ үед гэрчийн этгээдтэй нөхөрсөг яриа өрнүүлж, түүний сэтгэл санааны байдлыг тандаж, шүүгдэгчийн зүгээс гарах санал санаачлага, ирж болзошгүй бэлэг дурсгал, мөнгө төгрөгөөс хол байхын хамт, халдлага ч учирч болох учир түүнийг хамгаалагчтай болгоход санаа тавьж байгаагаа ойлгуулдаг.

Албан тушаалын гэмт хэргийг мөрдөхөд гардаг түгээмэл алдаа

- Тухайн албан тушаалтны ажлын байрны тодорхойлолтод заасан чиг үүргийг сайтар судлалгүйгээр зөвхөн нөхцөл байдал, мэдээлэлд тулгуурлан шалгах;
- Шинжээчийн дүгнэлтэнд хэт шүтэх, хөтлөгдөх, бусад нотлох баримтаас илүү хүчтэй гэж үнэлэх;
- Шууд харагдаж, мэдрэгдэж буй хор уршигт тулгуурлан хэргийг шалгах;
- Албан тушаалын гэмт хэргийг шалгахад цаг хугацаа алдах. Албан тушаалын гэмт хэргийн мөрдөлт сунжрах тусам эрүүгийн хэргийн хохирол, холбогдогчдын тоо хорогддог, эсхүл хэрэг замхардаг;
- Санхүү, аудитын шалгалтыг давхар нягталж шалгалгүйгээр шууд авч ашиглах;
- Багаар ажиллаж буй тохиолдолд ажлын хэсгийн ахлагчийн шийдвэрт захирагдан, нэгдмэл, уялдаа холбоотой, бие биенээ дэмжиж ажиллахгүй байх;
- Онц их хэмжээний болон олон холбогдогчтой, төрийн өндөр албан тушаалтан холбогдсон эрүүгийн хэргийг хичнээн олон удаа дарга, прокуроруудад танилцуулахын хирээр эрүүгийн хэргийн мөрдөн байцаалтанд төвөг учирдагийг тооцоолдоггүй;
- Аудитын болон магадлах нягтлан бодогч томилсон эрүүгийн хэрэгт санхүүгийн бүртгэл материалуудыг хайнга хүлээлгэн өгөх. Ингэснээр эрүүгийн хэрэгт чухал ач холбогдолтой эд мөрийн баримт нотолгоонууд устгагдах үүд хаалгыг нээдэг;
- Албан тушаалтны эрүүгийн хэрэгт уг ажилтны удирдлага, халамж анхааралд багтаж байсан бүх хүн үнэн зөв мэдүүлэг өгөхгүй. Хонзогносон чанартай мэдүүлэг мөрдөн байцаалтыг алдаанд хүргэх, хууль зөрчих үндэслэл болох нь цөөнгүй. Иймд өнгөц харахад хөтөлбөргүй үнэн мэт харагдаж буй мэдээлэл, мэдүүлгүүдийг олон талаас сайтар нягтлан шалгах шаардлагатай.
- Шалгалт, хяналт мониторинг үнэлгээ хийлгэж байгаа үед мөрдөн байцаагч, шалгалтыг хяналтын гадна үлдээж, ЭБШ ажиллагаанд илүү анхаардаг. Энэ нь эрүүгийн хэргийн үндсэн нотлох баримтыг үгүй хийх, өөрчлөх, устгах боломжийг ялгадагч, шүүгдэгч, шалгалт хийж буй хувийн сонирхол бүхий аудитор, нягтлан бодогч, шинжээч, мэргэжилтнүүдэд олгодог.

Мөрдөн байцаагчийн анхаарах асуудал

Албан тушаалын гэмт хэрэг мөрдөж буй байцаагчийн ажлын үр дүнг шүүхэд шилжүүлсэн болон шүүхээс буцсан эрүүгийн хэргээр үнэлдэг практик байцаагчийг тоо хөөцөлдөх, эсхүл гологдол гаргахаас сэрэмжилж, эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгох алхам хийхэд хүргэж болно.

Эрүүгийн хэргийг шүүхээс буцахгүй болтол гэмт этгээдүүдийн үйлдлийг

хөдөлбөргүй нотолдог, албан тушаалын гэмт хэргийг мөрдөж мэргэшсэн байцаагч, мэргэшсэн прокурор, шүүгч нар албан тушаал, авлигын гэмт хэрэгтэй тэмцэх гол хүч ноён нуруу нь болно.

Авилга хүчтэй, өргөн цар хүрээтэй байгаа өнөө үед албан тушаалтныг мөрдөх, авлигын гэмт хэргийг нотолгоожуулахад санаанд оромгүй арга замаар эрүүгийн хавтаст хэргийг резиндэх буюу үндсэн нотлох баримтыг хэсэгчлэн устгах, хулгайлах, солих янз бүрийн аргыг хэрэглэж мэднэ.

Мөрдөн байцаагчийг өрөөгөө түр орхих, компьютерээ асаалттай үлдээх, ширээн дээр хавтаст хэргийг түр орхиж гарах, компьютерт нэвтрэх нууц үгээ санаандгүй задлах зэрэг болгоомжгүй, сэрэмжгүй байдлыг ялладагч болон, түүний төлөөний хүн ашиглах боломжтой. Үгсэн хуйвалдаж бүлэглэн зохион байгуулалтай үйлдсэн эрүүгийн хэрэг дээр тэр дундаа албан тушаалын хэрэг дээр албан тушаалтанд худалдагдсан ажилтан байх магадлалтай.

Мөрдөн байцаагчийг аль нэг эмзэг зүйл дээр нь эвгүй байдалд оруулах, буруутгаж чадвал сэжигтэн, ялладагч өөрийн санасан хэмжээнд хэрэг, материалыг үгүйсгэх, устгах, эргүүлэх, гэм буруугүй болгох үнэ хөлс төлж, худалдан авахыг оролдож ч болох. Албан тушаалын гэмт хэрэг мөрддөг мөрдөн байцаагчид нөхөр олон юм шиг атлаа ачир дээрээ дайсан болж хувирах хүн нь олон байдаг.

Иймд мөрдөн байцаагч албан ажил дээрээ сонор сэрэмжтэй байх ёстой.

- Өрөө тасалгаагаа түр ч атугай эзэнгүй бүү орхи.
- Хөндлөнгийн хүн өрөөнд чинь байхад ширээн дээрээ бичиг баримтаа бүү үлдээ. Ажлын өдөр дууссан ч эрүүгийн хавтаст хэрэг, материалыг задгай үлдээж хэрхэвч болохгүй.
- Албаны компьютерыг анхаарлынхаа гадна бүү үлдээ, компьютерт нэвтрэх нууц үгээ хаа нэгтээ бичиж огт болохгүй
- Мөрдөн байцаалтын дараа компьютерт бичиж авсан мэдээллийг нууцалж хадгал.
- Эрүүгийн хавтаст хэргийг биедээ хэзээ ч авч явж болохгүй.
- Эрүүгийн хэрэгт сонирхол, хамааралтай танил хүн болон тохиолдлын хүний урилгыг бүү хүлээж ав.
- Эрүүгийн хэрэгт сонирхлоор хамаарах хүмүүс болон тохиолдлын “сайхан ааштай” хүнээс бэлэг авч огт болохгүй. Тэднээс ямар нэг үйлчилгээ авах нь алдаанд хүргэнэ.
- Ажиглалтын электрон төхөөрөмж, боломжтой бүх сувгаар өөрийн болон өрөө тасалгааны аюулгүй байдал, бичиг баримтын халдашгүй байдлыг шалгаж бай.
- Хөндлөнгийн хүнд мөрдөж буй эрүүгийн хэргийн нөхцөл байдлын талаар бүү ярь.
- Гэртээ шалгаж буй хэргийн талаар ярихгүй байх зэрэг болно.

4.6. ХЭЭЛ ХАХУУЛИЙН ГЭМТ ХЭРГИЙГ ШАЛГАХ АЖИЛЛАГАА

Хээл хахууль өгсөн, өгөхөөр бэлтгэж байгаа тухай мэдээлэл хүлээж авсны дараа түүнийг шалгах хойшлуулшгүй ажиллагаа явуулна. Түүнийг гүйцэтгэх ажлын хэд хэдэн арга хэмжээтэй хослуулан нэгдсэн ажиллагааг нэгдсэн төлөвлөгөө хүчээр өндөр зохион байгуулалттай явуулж, гүйцэтгэх ажлын туршилтыг чанд хяналтын дор явуулж хууль зөрчигчийг үйлдэл дээр нь баривчилдаг.

Ажиллагааны үр дүнгээр эрүүгийн хэрэг үүсгэдэг. Өөр нэг тохиолдолд хээл хахуулийн тухай гомдол, мэдээлэл хүлээн авсан мөрдөн байцаагч, мэдээлэгчээс тайлбар авах, хойшлуулшгүй ажиллагаа явуулж баримт сэлт цуглуулж эхэлдэг. Хангалттай үндэслэл байна гэж үзвэл эрүүгийн хэрэг үүсгээд гүйцэтгэх ажил эрхэлдэг байгууллагад даалгавар бичиж гүйцэтгэх ажлын чиглэлээр судалгаа, тандалт явуулж нэмэлт баримт, нотолгоо цуглуулахыг даалгадаг. Энэхүү даалгавар нь уг гомдол, мэдээлэлд холбогдсон хүмүүсийг гүйцэтгэх ажлын хараа хяналтад авах, гүйцэтгэх ажлын идэвхтэй арга хэмжээ зохион байгуулах үндэслэл болдог.

Гүйцэтгэх ажлын туршилтыг хяналтын дор амжилттай зохион байгуулах, үйлдэл дээр нь гэмт этгээдийг баривчлах ажиллагааг өнөө үед хээл хахуультай тэмцэх үндсэн шийдвэрлэх арга гэж үздэг. Гэмт этгээдүүдэд оноосон ялын 80 гаруй хувь чухамдаа энэхүү арга хэмжээний үр дүнд цуглуулсан баримт нотолгоонд тулгуурладгийг судлаачид тогтоожээ.

Гүйцэтгэх ажлын туршилтыг ОХУ-ын Дотоод явдлын яамны аюулгүй байдлын алба хамгийн үр дүнтэй зохион байгуулдаг байна. Ажилтнууд нь энэ чиглэлээр илүү мэргэшсэн байдаг. Яам, тусгай газруудад ажилладаг аюулгүй байдлын албад хээл хахуулийн гэмт хэрэгтэй тэмцэн хээл хахууль өгөгчийн талаарх гомдол, мэдээллийг хүлээн авдаг журам тогтоосон нь илүү үр дүнтэй болж байгаа ажээ.

Өмнө нь эдийн засгийн цагдаагийн алба гомдол, мэдээллийг хүлээн авдаг байв. Харин манай улсын хувьд АТГ хараат бусаар ажиллах болсноор авлига, хээл хахуулийн гэмт хэргийн тухай мэдээллийн хангамж нэмэгдэж, илрүүлж шалган шийдвэрлэж буй албан тушаалын гэмт хэргийн тоо өсөх болов.

Бизнесийн аюулгүй байдлын албатай хувийн хэвшлийн томоохон аж ахуйн нэгжүүд болон улс төрийн өндөр албан тушаалтан хууль сахиулах байгууллагад өөрийн төлөөний хүнтэй болсон гэгдэх өнөө үед хээл хахуулийн гэмт хэргийг гүйцэтгэх ажлын туршилтаар баримтжуулан, үйлдэл дээр нь баривчлахад дээрх алба, ажилтны зүгээс хууль сахиулах байгууллагад ихээхэн бэрхшээл учруулах болжээ.

Гүйцэтгэх ажлын туршилтыг зөвхөн хүнд гэмт хэрэг буюу хээл хахуулийн гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох онцгой тохиолдолд урьдчилан сэргийлэх зорилгоор гүйцэтгэх ажил эрхэлдэг байгууллагын даргын тогтоолоор зохион байгуулдаг. Энэхүү хязгаарлалт нь хээл хахууль авахыг санаархаагүй, бэлтгээгүй хүмүүс, албан тушаалтныг хээл хахуульд өдөөн хатгахаас сэрэмжилж, энэ чухал гүйцэтгэх ажлын арга хэмжээний агуулга, ач холбогдлыг хамгаалдаг.

Гүйцэтгэх ажлын туршилт, түүнийг дагалдуулан зохион байгуулдаг бусад арга хэмжээний явцад олж цуглуулсан фото зураг, дуу, дүрсний хуурцаг тэдгээрийг сонсож буулган авсан бичиг, соронзон тууз зэрэг нь тактикийн зорилгод /гэмт хэрэг илрүүлэх, мөрдөн шалгах ажиллагаанд/ төдийгүй эрүүгийн хэргийг нотлох шүүн таслах ажиллагаанд ашиглагддаг. Дуу авиа, дүрсний соронзон тууз дээрх хүн түүний дуу хоолой нь сэжигтэн, яллагдагчийнх мөн эсэхийг шинжээч томилон гаргуулсан дүгнэлт мөн адил нотолгоонд хамаардаг.

Иймээс гүйцэтгэх ажлын туршилт, түүнийг дагасан гүйцэтгэх ажлын нэгдсэн арга хэмжээг явуулахдаа хууль ёсыг чанд сахин, хүний эрхийг НҮБ-ын конвенцийн шаардлагад нийцүүлэн, хээл хахуулийн гэмт хэргийг илрүүлэх таслан зогсоох, урьдчилан сэргийлэх далайцтай нөлөөтэй арга хэрэгсэл болгох шаардлагатай. Энэ шаардлагыг хангахад доорх загварын хавсралтууд, түүнд бичигдсэн нөхцөл болзол боломж, техник хэрэгсэл дадлагатай хүн хүч чухал болох нь ойлгомжтой.

Албан тушаалтныг худалдан авахаар хээл хахууль өгсөнөө /өгөх болсноо/ өргөдлөөр илэрхийлсэн эсхүл ийм үйлдэлд сэжиглэж буй хүнтэй ярилцахад тавих загвар асуултууд

Ярилцаж байгаа хүнтэй сэтгэл зүйн холбоо тогтоох хамгийн сайн тактик бол уг хүнд бусдад хээл хахууль өгсөнөө /өгөх болсноо/ сайн дураараа хуулийн байгууллагад хэлэх нь эрүүгийн хариуцлагаас чөлөөлөгдөх хангалттай үндэслэл болохыг ойлгуулахаас эхэлдэг. */Монгол Улсын Эрүүгийн хуульд хахууль өгсөн этгээд сайн дураараа хэргээ илчлэн ирсэн тохиолдолд эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх заалт орсон тохиолдолд энэ аргыг ашиглана/*

Сайн дураараа хэлнэ, мэдүүлнэ гэдэгт өөрийн хувийн санаачлага, түүний ойрын төрөл төрөгсөд, найз нөхдийн зөвлөгөө саналаар болж өнгөрсөн үйл явдал, болох гэж буй үйл явдлын тухай хуулийн байгууллагад асуудал тодорхой болохоос өмнө өрсөж хээл хахууль өгөгч /өгөхөөр тохиролцсон этгээд/ биечлэн очиж, мэдээлэхийг ойлгодог.

“Хуулийн байгууллагад асуудал тодорхой болно” гэдэг нь бусдад хээл хахууль шагнал өгсөн асуудлыг хуулийн байгууллага сэжиглэн шалгаж эрүүгийн хэсэг үүсгэсэн, үүсгээгүйгээс үл хамаарч нотлох баримт бүрдээгүй, авлигын факт батлагдаагүй үед хээл хахууль /шагнал/ өгөгч өөрөө сэдэж эсхүл бусдын санал зөвлөгөөг дагаж хуулийн байгууллагад бодит явдлыг нотлох баримтын хамт дэлгэн тавьж гэмт хэрэг илрүүлэхэд дэмжлэг үзүүлснээр бүх зүйл тодорхой болж факт нотлогдсон үеийг хэлнэ.

Хээл хахууль өгснөө сайн дураар илчилсэн эсхүл ийм үйлдэлд сэжиглэгдэж буй хүнээс тайлбар авах үед тавьж болох загвар асуултууд:

1. Яагаад хээл хахууль өгөх, өгсөн явдлыг мэдээлэх болов?

- Хэзээ, хэнтэй, юутай холбогдуулж гомдол, мэдээлэл гаргах болов?
- Хэнтэй, юунаас болж зөвлөлдөн гомдол, мэдээлэл гаргах болов?

- Үйлдлээ сайн дураараа илчлэхээр шийдвэрлэсэн үү, хэрэв тийм бол түүнийгээ юугаар батлах вэ?
- Мөнгө, үнэт зүйлийг өгсөн, өгөх болсон даруйдаа яагаад АТГ-т хандаагүй, өдийг хүргэв?
- Авилга өгсөн цэг нь тодорхой байгаа юм бол хээл хахуулиа өгөхөөс өмнө яагаад мэдээлсэнгүй вэ?
- Хүлээн авагчийн зүгээс аюул учруулсан гэж үзэж хээл хахууль өгөх газрыг нуусан уу? Хэрэв тийм бол энэ нь юугаар илэрч байна?

2. Ямар учраас албан тушаалтныг худалдан авах болов?

- Өөрийн хувийн эсхүл бусдын ашиг сонирхлын төлөө хөдөлсөн үү?
- Ашиг сонирхол чухамдаа юу байв, юутай холбогдож үүсэв, юу хүсч байв, яагаад?
- Ашиг сонирхлоо хээл хахуульгүйгээр хангах боломжгүйд хэзээ итгэв, хэзээ ямар нөлөөн дор ийм ойлголт бүрдэв?
- Өөрийн сонирхлыг хууль ёсоор хангах ямар арга хэрэглэв?
- Хээл хахуулиар хүссэндээ хүрэв үү, хэрэв тийм бол бүрэн үү хагас уу?

3. Хээл хахууль өгөх, авах талаар ямар хэлэлцээр хийгдэв?

- Хуйвалдаан буюу хэлэлцээрийг санаачлагч хэн бэ?
- Хаана, хэзээ, хэний хооронд болсон бэ?
- Хээл хахуулийн төрөл хэмжээг яаж тохиров, юуг үндэслэв, тодорхой үйл явдлын төлөө хэдийг төлдөг хатуу жишиг /такс/ аль эртнээс тодорхой байсан уу?
- Албан тушаалтны үйл ажиллагааны үр дүнгээс мэдээлэгч буюу хээл хахууль өгөгч юуг хүлээж юу шаардсан?
- Хэлэлцээрт өөр талууд оролцсон уу тийм бол ямар бүрэлдэхүүнтэй, оролцоогүй бол ямар шалтгаанаар?
- Хээл хахуулийг ямар аргаар, хаана, хэзээ уулзаж өгч, авах болов?
- Хэлэлцээр хийх газрыг хэн сонгосон чухам яагаад энэ байрыг сонгох болов?
- Хэлэлцээртэй холбогдуулан уулзахаас өмнө болон хойно уг байранд очиж байсан уу? тийм бол ямар зорилго шалтгаанаар хэдийд очив? уг байр ямар нөхцөл байдалтай, онцлогтой вэ?
- Хэлэлцээрийн тухай мэдэж байсан хүмүүсээс гадна өөр ямар хүн хэлэлцээрт ирэв, ямар учраас, юутай холбоотой ирэв? түүний үүрэг юу байсан бэ?
- Хэлэлцээрт оролцогчид болон бусад хүмүүсийн ямар ул мөр тухайн байранд үлдэх боломжтой вэ? /Жишээлбэл хөрсөн дээрх гутлын мөр, гарын хурууны хээ, шил, саван дээр гэх мэт/

- Хэлэлцээр явагдсаныг нотлох ямар эд мөрийн баримтыг хууль хамгаалах байгууллага олж болох вэ? хаанаас түүнийг олж болох? /бичиг тэмдэглэл, эх бичиг, тэмдэглэлийн дэвтэр, мэдээлэл агуулагч бусад зүйл/

4. Хээл хахуулийг гардуулж өгсөн нөхцөл байдал

- Хаана, хэзээ, /огноо, цаг/ хэнд өгсөн шууд хэлэлцээрийн дараа юу, эсхүл хэсэг хугацааны хойно уу?
- Хээл хахуулийн эд зүйл, чухам юу байв? /мөнгөний хэмжээ, мөнгөн дэвсгэртийн тоо, тэдгээрт гадны ямар нэг бичиг, гэмтэл байсан эсэх, ямар эд зүйл байв? түүний өртөг, шинж тэмдэг, хээл хахуулийн эд зүйлийг юунд савласан байв? тухайлбал, мөнгө банкны баглаа боодолтой байв уу? үйлдвэрийн савлагаатай юу? савлагаагүй бол юун боодолтой байв? хуучин боодол, савны хаана хадгалж байгаа үлдэгдэл нь хаана байна?
- Ямар аргаар хээл хахуулийг өгөв?
- Амалсан үүргээ гүйцэтгэхээс өмнө хээл хахуулиа авсан уу, хойно нь авсан уу?
- Хээл хахууль эд хөрөнгийн шинжтэй үйлчилгээ бол тэр нь юугаар илэрхийлэгдэх вэ? /хүүгүй болон хөнгөлөлттэй зээл олгов уу? түүнийг хүлээн авах эрхгүй хүнд өгсөн үү? барилга угсралт, засварын болон оёдлын үнэгүй, эсхүл хямдруулсан үнээр гэр бүлд нь өгөв үү? Зорчих, амрах, жуулчлах билет өгөв үү? эмчлүүлэх, эмнэлгийн үйлчилгээ үнэгүй авах боломж олгов уу? албан тушаалтан түүний гэр бүлийнхний их дээд сургууль магистрантур, докторантурт үнэгүй сургах, унацтай мэргэжил эзэмшүүлэх давтан сургалтад явуулав уу? гэх мэт/
- Хээл хахууль өгөхөд албан тушаалтнаас өөр хэн оролцов? яагаад оров?
- Тэдний үүрэг нь юу байв, хээл хахууль өгөх байрын байдал ямар байв? түүний онцлог, тэд гардуулж өгөхийн өмнө болон хойно ч байсан уу? тийм бол хэзээ юунаас үүдэж ингэв?

5. Хээл хахууль өгөх үеийг дагалдсан нөхцөл байдал мөнгө, эд зүйлийг хээл хахууль болгон өгөхөд яаж хүлээн авав /зээл хэлбэрээр, арилжааны эргэлтээс авсан хэлбэрээр, банкнаас бэлэн бус тооцоогоор гүйлгээ хийсэн байдлаар, эсхүл эд зүйл худалдсан мэтээр/

- Хэн, хэзээ, ямар туслалцаа үзүүлэхэд дэмжих болов;
- Энэ үед мөнгө, эд зүйл ямар шалтгаанаар өгч байгааг тайлбарлах хэрэг гарсан уу, гарсан бол ямар тайлбар хийв;
- Хэрэв хээл хахууль болгон эд зүйл худалдан авсан бол хэнээс ямар хэмжээгээр авав, бусдад өгөх хүртэл хаана хадгалж байв;
- Шаардлагатай мөнгө, үнэт цаас, эд зүйлийг олох, босгох, эрэн сураглахыг хэн үзэж харсан;

- Мөнгө хийх данс шинээр нээлгэсэн үү, хуучин дансанд нь хийсэн үү, хэн үзэж харсан;
- Хээл хахууль авагчийн болон төрөл төрөгсдийн дансны дугаарыг хэнээс олж авсан, өөрөө өгсөн үү г.м

6. Хээл хахууль авсан хүний үйл ажиллагаа, үр дүн хээл хахуулийн төлөө тэр хүн юу хийв, энэ нь юугаар илрэв, ямар нөхцөл нөлөөлөв.

- Хээл хахууль авагч этгээдэд төр, арилжааны болон өөр байгууллагын хэн нэг хүн дэмжлэг үзүүлэв үү, үзүүлсэн бол чухам ямар холбоо байна.
- Хээл хахууль авсан удирдах үүрэг гүйцэтгэж буй албан тушаалтны үйл ажиллагааны үр дүн асуугдаж буй хүний хэрэгцээг хангав уу?
- Үр дүнг ашиглав уу, ашигласан бол хээл хахууль авагч өөрөө эсхүл бусад хүн хэний ашиг сонирхолд нийцүүлж, чухам ямар хэлбэрээр юуг бүтээв
- Хээл хахууль өгөх үйлдэл, хуулийн эсрэг факт дагуулсан уу, тийм бол ямар

7. Нэмэгдэл мэдээллийн боломжтой эх сурвалжийн тухайд

- Хээл хахууль өгөх гэж сэдэж байгаагаа хэн нэг хүнд ярьсан уу, тийм бол чухам хэнд
- Гэмт хэрэгт оролцогчид хэрхэн танилцсан байдал, тэдний харилцаа хэн хэнд тодорхой болсон бэ, /хөршүүд, найз нөхөд, төрөл садан, хамт ажиллагсад гэх мэт/
- Хөндлөнгийн хүмүүсээс хэн нь яагаад үйл явдлын гэрч, хээл хахуультай холбоотой асуудлыг мэдэх болов,
- Албан тушаалтан, арилжааны болон өөр байгууллагын удирдах ажилтны хээл хахууль авсан үйлдлийн аль үеийг хэн мэдэж болох, чухам юу нь тодорхой болсон ямар эх сурвалжаас тодорхой болов.

Хээл хахууль авсанд сэжиглэгдэж байгаа этгээдийг байцаах загвар асуултууд

Хээл хахуулийн гэмт хэрэгт сэжигтнийг нэг удаагийн байцаалтаар бүх асуудлыг мухарлаж, мэдүүлгийг буцах боломжгүйгээр нотолгоожуулж хэргийг “боох”-ыг хичээх ёстой.

1. Хээл хахууль өгсөн хүнтэй ямар харилцаатай

- Хэзээ, хаана, ямар байдалд юугаар холбогдож, яаж танилцсан бэ?
- Хэний санаачлагаар танилцсан, хэн нь юу зохион байгуулсан, танилцахад хэн нэг хүн тусалсан уу? тийм бол яагаад?
- Ямар шалтгаар уулзалдаж, нөхөрлөлөө юугаар бэхжүүлж, хэдэн удаа эсхүл байнга хаана уулздаг байв? өөр хүн уулзалтанд оролцсон уу? оролцсон бол хэн хэдийд?
- Харилцаа юун дээр үндэслэгдэж байна, хээл хахууль өгөх авах тухай тохиролцоо хэдийд хаана болов?

- Энэ харилцаанд хэн нь гол үүрэг /хөтлөгч/ гүйцэтгэсэн?
- Мөнгө, үнэт зүйл өгсөн хүн өөрийн хувийн болон бусдын ямар ашиг сонирхолд хөтлөгдөж хийв, юугаар холбоотой байв?
- Хүлээж буй үр дүндээ хээл хахуулиар хүрэх ямар шалтгаан байв?
- Хээл хахууль авахыг хэн нэг хүн албадсан уу?

2. Хэлэлцээрийн нөхцөл байдал

- Хаана, хэзээ, хэнтэй, ямар асуудлаар хэлэлцээ хийв?
- Уулзах газрыг хэн сонгов? асуугдаж буй хүн тухайн газарт хээл хахууль авахаас өмнө буюу авсны дараа байсан уу? байсан бол хэзээ, яагаад?
- Хэлэлцээ явуулсан газрын байдал, түүний онцлог?
- Хэн хээл хахуулийн төрөл хэмжээг тодорхойлсон?
- Ямар үндэслэлээр яаж хээл хахуулийн хэмжээг гаргав?
- Хээл хахууль өгсөний төлөө ямар үйлчилгээ үзүүлэхийг шаардав?
- Энэ нөхцөлийг бүрэн эсхүл хагас /хэсэгчлэн/ биелүүлэх амлалтыг хэн өгсөн?
- Энэ амлалтыг биелүүлэх нөхцөл байсан уу? түүнийг биелүүлэхэд бэлтгэж байна уу?
- Хээл хахууль авах үйл ажиллагаа яаж төлөвлөв? /хугацаа, байр, газар орон, арга/ оролцогчдоос хэн нь санал гаргав? Хээл хахуулийг гардаж авах санал болгосон нөхцөлийг юуг үндэслэж гаргав?
- Хэлэлцээ хийгчдээс өөр хэн уулзалтад оров?
- Хэлэлцээ хийсэн газар ямар ул мөр үлдсэн, хэлэлцээнд оролцогч, байлцагсдаас юу юу тэнд үлдэж болох вэ?

3. Хээл хахууль хүлээн авсан нөхцөл, байдал

- Хаана, хэзээ /огноо цаг/ ямар аргаар хэнээс юуг /мөнгө, эд зүйл/ хээл хахуульд авсан?
- Энэ байранд хээл хахуулийн чанартай мөнгө, эд зүйл хээл хахууль, хүлээн авахаас өмнө, авсаны дараа байсан уу?
- Энэ газрын онцлог тав тухтай байдал?
- Хээл хахууль өгөхөд оролцогсдоос гадна энэ газар хэн байсан, ямар шалтгаанаар, ямар зорилгоор?
- Хээл хахууль өгсөн газарт ямар нэгэн ул мөр үлдэж болох байсан эсэх?
- Хээл хахуулийн эд зүйл чухам юу байв, юунд боосон, боодол нь байгаа болох?
- Хэлэлцээний үед тохиролцсон бүхэн ёсоороо хийгдсэн үү?
- Эд хөрөнгийн шинжтэй ямар үйлчилгээ байв?

- Мөнгө, үнэт зүйл өгсний төлөө хийх үйл ажиллагаа хээл хахууль авмагц хийгдсэн үү, эсхүл түүнээс хойш хийгдсэн үү?

4.Албаны үйл ажиллагаа, түүний үр дүн

- Эрхэлж буй албан тушаалд ямар хугацаанд ажилласан түүний эрх үүргийг тодорхойлж буй эрхийн хэм хэмжээнүүдтэй танилцсан уу? чухам ямар эрх үүрэгтэйг мэдэж байсан бол яагаад зөрчив? Мэдэхгүй байсан бол яагаад?
- Хээл хахуулиар өгсөн хүний ашиг сонирхолд нийцүүлэн хийсэн үйлдэл албан тушаалтны эрх хэмжээнд багтаж байгаа юу?
- Хээл хахууль аваад түүний төлөөсөнд юуг хэзээ, яаж ямар үр дүн гаргаж хийв?
- Тухайн үйл ажиллагаа яаж хэрэгжих ёстой байв, хэрэг дээрээ яаж хэрэгжив?
- Байх ёстой хэмжээнээс гажсан үйлдэл хийгдсэн бол үүнийг юугаар тайлбарлах?
- Ямар бичиг баримтаар үйл ажиллагааны явц, үр дүнг тусгав? энэ баримт бичиг хаана хадгалагдаж байгаа? /түүний эх хувь, хуулбар, орлох бичиг/
- Хээл хахуулийн хэрэгт оролцсоноо хээл хахууль авагч буюу асуугдагч ямар шалтгаантай гэж үздэг?

5.Нэмэгдэл мэдээллийн боломжтой эх сурвалжууд

- Мөнгө, үнэт зүйл өгсөн хүнтэй танил болохыг хэн хэн мэддэг эсэх?
- Хээл хахууль авсан, авах тухайгаа хэн нэгэнд ярьсан уу? тийм бол чухам ямар шалтгаанаар?
- Хэлэлцээр болон хээл хахууль гардан авч байгааг үзэж харсан хөндлөнгийн хүн холбоотой байж болох эсэх?
- Хээл хахууль гардуулахын тулд авсан мөнгө хөрөнгийн талаар өөр юу тодорхой байна?
- Хээл хахууль өгөгчийн эрх ашигт нийцүүлж хийсэн үйл ажиллагааг тэрээр яаж ашигласан, энэ нь өөр гэмт хэрэг үйлдэхэд хүргэсэн үү? эсхүл гэмт хэрэг үйлдэхэд дөхөм /хөнгөлөлт/ үзүүлсэн?

Хээл хахуулийн талаарх гомдол, мэдээлэл хүлээн авсан мөрдөн байцаагчийн таамаглалууд

- Хээл хахууль өгсөн, авсан газар хаана байж болох эсхүл албан тушаалтан үйлчлүүлэгчээ шахаанд /хясан боогдуулсан/ оруулсан уу?
- Мэдээлэгч албан үүргээ хуулийн дагуу гүйцэтгэж яваа албан тушаалтныг чадах зорилгоор гомдол, мэдээлэл гаргасан уу?
- Албан тушаалтанд дамжуулан өгсөн зүйл нь түүнд өгсөн хээл хахууль бус худалдан авсан бараагаа хүргүүлсэн байж болох хээл хахууль өгөгч авагч гэж үзэж буй хүмүүсийн харилцааг мэдээлэгч буруу ойлгож

болох эсэх?

- Албан тушаалтны албаны үүрэгтэй холбоотой бус номын зохиогч, редактор, сургууль курст багш, мэргэжлийн зөвлөгчөөр ажилласан цалин, хөлс өгч байгааг хээл хахууль мэтээр мэдээлэгч ойлгосон эсэх?
- Гомдол, мэдээлэлд холбогдож буй нэр бүхий хүмүүсийн талаар урьд өмнө нь гомдол, мэдээлэл ирж шалгагдаж байсан бол хэрэг материал хаана байгаа тухай үйл явдлын үргэлжлэл мөн эсэх?
- Гомдол, мэдээллийн зарим шалгалт судалгаанаас харахад уг үйл явдал, түүнд оролцогсод тухайн үйлдлийг байнгын чанартай, үргэлжилсэн үйлдлээр зохион байгуулалттайгаар хээл хахууль өгдөг авдаг байж болох эсэх?
- Гомдол, мэдээлэл гаргагч гуравдахь этгээдээс буюу дүүрэн итгэлтэй бус мэдээллийн эх сурвалжаас сонссон, дуулсан зүйлээ болоод өнгөрсөн эсхүл болох гэж буй үйл явдал мэтээр мэдээлсэн байх боломжтой юу?

Хээл хахуулийн гэмт хэрэг дээр криминалистикийн шинжилгээгээр шийдвэрлэх үндсэн асуудлууд

1. Техник-криминалистикийн шинжилгээгээр

- Шатаагдсан баримтанд буй бичгийн агуулга, ямар аргаар уг бичгийг бичсэн?
- Нэгдмэл баримтын цаасны тасархай өмнө нь бичигдсэн эсэх? анхны хэлбэр, сэдэв нь ямар байсан бэ?
- Баримтыг өөрчилсөн үү? Тийм бол ямар хэсгийг яаж /угаасан, урсан эсхүл гараар болон бичгийн машинаар гүйцээж бичсэн гэх мэт/ өөрчилсөн эсэх?
- Өөрчлөгдсөн баримтын анхны бичлэг нь ямар байв?
- Бичлэгийг үйлдвэрийн анхны бичгийн бэхээр бичээгүй юу? Өөр үзэг, балаар бичсэн үү?
- Загварыг фломастер, харандаагаар хийв үү?
- Сэдвийг бүхэлд нь нэг компьютерээр бичсэн үү? түүний үйлдлийн систем нь ямар вэ?
- Сэдвийн зарим хэсгийг гүйцээж бичсэн шинж тэмдэг байна уу? тухайн компьютерээр үү, өөр компьютерээр бичсэн эсэх?
- Сэдвийг тухайн компьютерээр бүхэлд нь бичсэн боловч зарим хэсэг үйл явдлаас өмнө эсхүл хойно нь бичигдсэн үү?
- Бичиг баримтанд буй гарын үсгийг хувилагчаар буулгасан бол ямар аргаар хувилж зөөвөрлөв?
- Штрикээр дарсан хэсэгт бичсэн сэдэв?
- Тамганы дардасыг ямар байдлаар буулгасан?

• Компьютерийн арчигдсан файл /хуудас/ байгаа эсэх? түүнийг сэргээх боломжтой юу?

2. Гарын үсгийн криминалистик шинжилгээ гараар бичигдсэн баримтыг тухайн хүн бүхэлд нь эсхүл хэсэгчлэн бичсэн үү? /тусгайлсан тоо, гарын үсэг, тогтоох хэсэгт анхаарч шинжилнэ/

3. Ул мөрийн шинжилгээ

- Тухайн хүний хуруу, гарын алганы ул мөр, үлдсэн эсэх?
- Хэргийн газарт илрүүлсэн гутлын мөр тухайн этгээд / хээл хахууль авсан, өгсөн хүн/ -ийнх мөн эсэх?
- Хэргийн газарт олдсон тээврийн хэрэгслийн мөр ямар төрөл, маркад хамаарах вэ?

Хээл хахуулийн хэрэгт шалгаж тогтоох гол асуудлууд

1. Гэмт хэргийн үйл явдал;

- Тодорхой үйлдэл хийгдсэн газар орон, цаг хугацаа;
- Гэмт үйлдлээр үр дүнд хүрэхэд чиглэгдсэн үйлдэл /эс үйлдэл/-ийн арга, субъект бүрийн гүйцэтгэх үүрэг;
- Хээл хахуулийг шууд дамжуулсан уу, эсхүл нууцлалыг сайтар бодож боловсруулсан аргаар хээл хахууль “эзэндээ очсон уу” ямар халхавчаар хуульд нийцсэн үйл ажиллагаа хийгдсэн;

2. Хээл хахуулийн субъектууд;

- Хэн өгсөн, хэн авсан?
- Зуучлагч ашигласан, оролцуулсан уу?
- Хээл хахууль авагч нь гүйцэтгэх засаглалын, зохион байгуулан хуваарилах эсхүл аж ахуй, санхүүгийн үүрэг гүйцэтгэдэг албан тушаалтан мөн үү? Нутгийн өөрөө удирдах байгууллагад ажилладаг алба хаагч уу, ямар эрх мэдэлтэй, ямар дархлааг албан тушаал, эрх үүрэг, найз нөхөд, төрөл садны хүрээллээр бий болгосон хүн бэ?

3. Хээл хахуулийн субъект бүрийн гэм буруу;

4. Хээл хахуулийн субъектуудийн ашиг сонирхол чухам юу байв? Тэдний зорилго, шалтаг, чухам юу авч өгөлцсөн;

5. Хээл хахуулийн эд зүйл нь юу байв. Түүний өртөг, овор хэмжээ;

6. Хээл хахуулийг нэг бус удаа авч өгөлцсөн үү;

7. Хээл хахууль өгөгчийн сонирхлоор ямар үйлдэл хийгдсэн, чухам ямар үйлдлээс болгоомжилж байсан, тэр үйлдэл нь түүний эрх мэдэлд багтдаг уу, эрх мэдлээ яаж хэтрүүлэв, эсхүл хийх ёстой үйлдлээ хийсэнгүй юу;

8. Хээл хахуулийг авсан газар нь хаана байна, /хэргийн газар/;

9. Буруутай этгээдийн хариуцлагыг хөнгөрүүлэх, хүндрүүлэх ямар нөхцөл байдал байна вэ;

10. Эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх болон нийгмийн хор аюулыг үгүйсгэх нөхцөл байдал байгаа эсэх, хээл хахууль өгөгч сайн дураараа гэмт хэрэг үйлдсэн, үйлдэхээр бэлтгэж байгаа тухайгаа мэдээлсэн эсэхэд хамаарах нөхцөл байдал;

11. Хээл хахуулиар учирсан хохирлын шинж байдал хэмжээ;

12. Хээл хахууль өгч авалцахад хүргэсэн нөхцөл шалтгаан, гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал яаж тодорхойлогдов;

13. Яллагдагчийн хувийн байдал;

Хээл хахуулийн хэргийн тухай гүйцэтгэх ажлын мэдээллийг шалгах хойшлуулшгүй ажиллагаа

- Мэдээллийн эх сурвалжаас аль бололцоотойг ил болгох замаар байцааж баримтжуулах;
- Эрүүгийн тагнуулын байгууллагад гүйцэтгэх ажлын арга хэмжээ, түүний дотор гүйцэтгэх ажлын туршилтыг хээл хахууль өгч авалцах үеэр нь хяналттай /олон нийтийн 2 төлөөлөгчийг оролцуулан/-гаар явуулах талаар даалгавар бичих;
- Үйлдэл дээр нь баривчлах;
- Биед нь үзлэг хийж илэрсэн зүйлийг бэхжүүлэх;
- Хэргийн газар үзлэг хийх;
- Хээл хахуулийн гэмт хэргийн гол субъектүүдийг байцаах;
- Ажлын байр, оршин суугаа болон тухайн үед байгаа байранд нэгжлэг хийх;
- Ял сонсгосны дараа эд хөрөнгийг бүртгэх, битүүмжлэн хамгаалах;
- Хээл хахуулийн эд зүйлд үзлэг хийх;
- Албаны бичиг баримтад үзлэг хийж хураан авах;
- Зарим шаардлагатай субъектуудыг нүүр тулган байцаах /нүүрэлдүүлэх/;
- Хэрэв гуравдахь этгээдээс мэдээлэл хүлээн авсан бол түүнээс хэн болохыг нь тодорхойлох дэлгэрэнгүй тайлбар гаргуулна. Мэдээлэгч /гомдол, мэдээлэл гаргагчийн/ хэн болохыг түүнийг тодорхойлох мэдээллүүдээс тогтооно. Ямар нэг бүртгэлд орсон эсэхийг шалгана. Хээл хахуульд оролцогчидтой ямар холбоотойг судална.

Гурав дах этгээдээс ирүүлсэн хээл хахуулийн талаарх мэдээллийг шалгах хойшлуулшгүй ажиллагаа

- “Хээл хахууль өгөгч” гэж үзэж буй хүний үйл ажиллагааг судлан дүгнэлт хийж, хээл хахуулийн криминалистик шинжүүдийг илрүүлж, нөхцөл байдлыг тогтооно.
- Албан тушаалтан болон хээл хахууль өгөгч гэж үзэж буй хүмүүсийн хувийн харилцааг тогтооно.
- Эрүүгийн тагнуулын байгууллагад гүйцэтгэх ажлын шугамаар сэжиглэгдэж буй хүмүүсийн тухай мэдээлэл олох тухай даалгавар өгнө.
- Мэдээллийн эх сурвалж болж буй гомдол, мэдээлэл гаргагч болон бусад хүнийг байцаана.
- Бичиг баримтуудыг судалж хуулбарыг авна.
- Хээл хахуулийн гэмт хэрэгт оролцогчдын ажлын байр, оршин суугаа газарт нэгжлэг хийнэ.
- Гүйцэтгэх ажлын ажиглалтыг зохион байгуулах үеэр хээл хахуульд оролцогчдыг үйлдэл дээр нь баримтжуулж, шаардлагатай гэж үзвэл баривчилна.
- Хээл хахуулийн хэргийн оролцогч субъектүүдийг байцаах, нүүрэлдүүлэх

Хээл хахуулийн хэргийг мөрдөх төлөвлөгөө, онцлог, шаардлага

Хээл хахуулийн хэргийг туршлагатай мөрдөн байцаагчаар мөрдүүлдэг.

- Мөрдөн байцаагчийн ажлын төлөвлөгөө нь түүний мэргэшлийн бэлтгэлийн түвшин, ажлын туршлага, мөрдөн байцаах байгууллагын зохион байгуулалтын боломж */тээврийн хэрэгсэл, техникийн хангамж/* эрүүгийн тагнуулын албатай хамтран ажиллах боломж, хамтран ажиллагсдын мэргэшил ур чадвар, техникийн хангамж, ажлын дадлага болон мөрдөн байцаагч нь мэдээлэгч, ЭБШ ажиллагаанд оролцогч бусад хүмүүстэй сэтгэл зүйн харилцаа тогтоох ур дүй, мөрдөн байцаалтын тодорхой агшинд зөв шийдвэр гаргах, түргэн сэтгэх чадвар зэргээс ихээхэн шалтгаалан хийгддэг.
- Факт бүрийг шууд болон шууд бус нотлох баримтуудаар хөдөлбөргүй нотлуулахад мөрдөн байцаагч хичээх ёстой. “Нэг нотлох баримт эргэлзээтэй, хуурамч байвал хээл хахуулийн гэмт хэргийн мөрдөн байцаалтын үр дүнд сөргөөр нөлөөлөх магадлал ихтэй” байдаг. Эргэлзээтэй фактууд хавтаст хэрэг дотор огт байж болохгүй. Нэг бол хөдөлбөргүй нотлогдож, нэг бол үгүйсгэгдэж байх ёстой.
- Ер нь мөрдөн байцаагч бодит мэдээлэлгүй, байгаа мэдээллээ тал бүрээс нь бүрэн дүүрэн судлалгүй сэжигтэн, яллагдагчийг байцаах нь мөрдөн байцаалтын тактикийн томоохон алдаа юм.

- Сэжигтэнтэй уулзах, байцаахаас өмнө түүний боловсрол, гэр бүлийн байдал, намтрын гол хэсэг, оршин суудаг газар, амьдралын хэв маяг, гэр бүлийн байдал, тэдний хэд нь ажил сургуультай, ажил хэргийн болон багын анд найз нөхөд, хобби, албан тушаал түүний эрх хэмжээ, зан чанар, сэтгэл зүйн онцлогийн талаар мэдээлэлтэй болсон байхаар төлөвлөгөө хийгдэх ёстой.
- Цуглуулсан мэдээллүүдийг судлан шинжлээд хийсэн таамаглал, таамаглалыг шалгаад олсон мэдээллүүдийг нарийвчлан шалгахад шаардагд ах хугацаа, хэрэглэгдэх тоног төхөөрөмж, оролцуулах хүн /шинжээч, мэргэжилтэн, орчуулагч, хэлмэрч/-ийг сайтар бодож төлөвлөнө.
- Гүйцэтгэх алба, аудит, мэргэжлийн хяналтын байгууллагатай хэрхэн хамтарч, юуг шалгах, ямар хугацаанд явуулах, хэдийд дуусгах, ямар үр дүн хүлээж байгаа зэргийг дээрх байгууллагатай хамтран эсхүл тэдэнтэй зөвлөлдөн цаг, боломжийг судалсны үндсэн дээр дангаараа хийх ажлаа төлөвлөнө.
- Хамтын ажиллагааны үр дүнг хэрхэн ашиглах талаар төлөвлөгөөнд тусгана.

Хээл хахуулийн гэмт хэргийн газрыг судлах, шинжлэх /байр, байшин, байгууламж, хэсэг газар, тээврийн хэрэгсэл/: Мөрдөн байцаагч гомдол, мэдээлэл хүлээн авч хойшлуулшгүй ажиллагаа, гүйцэтгэх ажлын арга хэмжээний явцад ил болон далд аргаар энэ ажиллагааг хийдэг. Хээл хахууль өгсөн тухай мэдээлэгчийг оролцуулж хэргийн газрыг судлан шинждэг. Үүнд:

- Үзлэг хийх хэргийн газрыг товлох;
- Эд мөрийн баримт: Тухайн газарт байсан хохирогч буюу хээл хахууль өгөгчийн болон бусад оролцогчдын ул мөрийг илрүүлэх;
- Түүнээс авсан мэдүүлгийг тодруулах, нарийвчлан лавлаж тодорхойлох;

1.5. Хээл хахуулийн гэмт хэрэгт хураан авах бичиг баримт:

Гэмт хэрэг нотлох чухал нотлох баримт бичиг баримт учраас түүнийг албан тушаалтны ажлын өрөө тасалгаа, орон байраас хураан авдаг. Бичиг баримтуудад:

- Албан тушаалтныг томилсон тухай тушаал;
- Албан тушаалтанд эрх олгосон тухай шийдвэр;
- Хөдөлмөрийн буюу нийгмийн даатгалын дэвтэр, алба хаасан жагсаалтын хуулбар;
- Албан тушаалын заавар, дүрэм, албан тушаалын үйл ажиллагааг зохицуулж байгаа эрхийн хэм хэмжээний актууд;
- Ажиллах хугацаанд олгож байсан мөнгөн хөрөнгийн тоо, хэмжээг харуулах цалин, хувцас хангамжийн картууд;

- Ажлын цагийн бүртгэл;
- Сонирхож буй хугацаанд албан тушаалтны авсан цалингийн тодорхойлолт;
- Хөрөнгө, орлогын тухай мэдүүлэг;
- Төрийн байгууллага, албан тушаалтны эрх мэдэл, үйл ажиллагааг тодорхойлох бичиг баримт;
- Албан тушаалтны эрх, үүрэг, ажлын байрны тодорхойлолтод холбогдох бичиг баримтыг хүлээн авах, шийдвэрлэх журам;
- Хээл хахууль аваагүй ч албан тушаалтны үйлдсэн ижил төстэй үйлдэлд холбогдох бичиг баримт;
- Хээл хахууль авах зорилгоор албан тушаалтны үйлдсэн ижил төстэй үйлдэлд холбогдох бичиг баримт;
- Хээл хахуульд эд хөрөнгө авахаар эрж сурагласныг болон хууль бус үйлдлээ нуун далдлах /зээллэг авсан тухай, хувийн эд юмсаа худалдсан тухай эд зүйлээ ломбардад барьцаалсан тухай/ халхавчийг гэрчлэх гэрээ, хэлцэл;
- Хээл хахууль өгөгчийн арилжааны байгууллагын эд хөрөнгийг ашиглаж байгаа тухай, гэмт замаар хөрөнгө олсон тухай хээл хахуулийн эд зүйл эзэмшиж байгаа тухай, хээл хахууль өгсөн авсныг хаацайлсан тухай бичиг;
- Хээл хахууль өгөгч албан тушаалтнаас юу хүсч түүний төлөө хээл хахууль өгсөн тухай бичиг баримт;
- Хээл хахууль авсны төлөө албан тушаалтны хийсэн үйлдлийн үр дүнг хээл хахууль өгөгч ашигласан тухай захирамж, тушаал, гэрчилгээ, лиценз, сургалтын зардлын баримт, орон сууцны ордер;
- Хээл хахуулийн хэрэгт оролцогчдийн амьдралын хэв маяг орлого, зарлага, эрүүл мэндийн байдал болон амралт зугаалгаар хамт байсныг гэрчлэх бичиг баримт;
- Мөрдөж буй гэмт хэрэгт хамаарах нөхцөл байдлыг тогтооход хамаарах бусад бичиг баримтууд ордог. Эдгээр баримт мэдээллүүд цаасан дээр төдийгүй цахим диск, дуут болон дүрсний туузан хуурцаг, фото хальс хэлбэртэй байдаг. Тэдгээр нь гэмт үйлдлийн тухай мэдээлэл агуулж байгаа бол эд мөрийн баримт болдог.

Хээл хахуулийн гэмт хэрэгт сэжиглэгдсэн албан тушаалтанд холбогдох мэдээллийг цуглуулж судлах арга

Хээл хахуулийг гараас гар дамжуулж өгсөн энгийн үйлдэлтэй, хээл хахуулийг төрөл бүрийн аргаар хаацайлан өнгөлөн далдалсан нийлмэл үйлдэлтэй гэж хоёр ангилдаг. Эхнийхийг хээл хахуулийн гэмт хэрэгт оролцогсад төвөггүй нотолдог бол хоёрдахь үйлдлийг баримтжуулахад мөрдөн байцаагчаас тал бүрийн мэдлэг, нарийн ур ухаан шаарддаг.

Сэжигтэн, яллагдагчийн санхүүгийн байдлыг цуглуулан бичиг баримтууд, гэрчүүдийн мэдүүлэг, мөрдөн байцаалтын үйл ажиллагааны

бусад үр дүнд тулгуурлан 3 үе шаттайгаар шинжилдэг.

1. Хээл хахууль авагчийн гэр бүлийн гишүүдийн орлогын бүх эх сурвалжийг /гэр бүлийн гишүүн бүрийн цалин, орлого, тухайлбал багшлах, зөвлөх үйлчилгээ, шинжлэх ухааны судалгаа хийсэн, үнэт цаасны арилжаа явуулсан, өвлөсөн хөрөнгөөс орлого олсон, хонжворт сугалааны хонжвор, бэлэг шагнал, материаллаг туслалцаа болон бусад орлого/ нарийвчлан судалж тогтооно.

2. Батлагдах зарлагуудыг тогтооно /орон сууц, хүнс, амралт, хобби, хүүхдийн хэрэгцээ, сургалт, байрын засвар, тээврийн хэрэгслэлийн зардлууд, зуслангийн байр, бусдад өгөх бэлэг, харуул хамгаалалт, цэвэрлэгээ үйлчилгээний хөлсөнд өгөх хөлс, мөрийтэй тоглоом тоглох, ойн баяр тэмдэглэх, буяны ажиллагаанд оролцох зарлагууд/

3. Орлого, зарлагыг харьцуулж, зарлага нь орлогоосоо давж байвал хууль бус орлого олсныг батална. Энэхүү баталгааг цуглуулсан бүх мэдээллээр баримтжуулна.

Хэнээс, хэдийд яаж, ямар мөнгөн хөрөнгө, эд зүйлийг хээл хахуульд авсан нь тодорхойгүй, хээл хахуулийн эд зүйл нь тогтоогдоогүй эрүүгийн хэргийг дээрх аргаар баримтжуулж, нотолгоожуулна.

Хээл хахуулийн гэмт хэрэгт төрийн эрх барих дээд байгууллага, олон нийт, иргэний нийгмээс тавих хяналт, шаардлага өндөржихийн хэрээр хээл хахууль өгсөн авснаа халхавчлах нарийн арга хэрэглэж хөрөнгөө илүү ихээр нууцлах болдог. Энэ үед ч сэжигтэн /яллагдагч/-ийн амьдралын хэв маяг, хөрөнгө орлого, биеэ авч яваа байдлын талаар аль болох өргөн мэдээлэл цуглуулж шинжлэх нь мөрдөн байцаагчийн шинэ үүрэг болов. Мөрдөн байцаагч бол гэмт явдлын аналитик шинжээчийн мэдлэг чадвар, дадлага эзэмшихэд цуцалтгүй суралцах шаардлагатай.

Хээл хахуулийн гэмт хэргийн бичиг баримтыг судлах аргачлал

Хээл хахуулийн гэмт хэрэг үйлдэгдсэн, үйлдэгдсэн байж болох албан байгууллагад бичиг баримт хүлээн авах, судлах, боловсруулах, шийдвэрлэх талаар тогтоосон журам хэрхэн хэрэгжиж байгааг судалснаар хээл хахуулийн хэргийн шинж тэмдгийг олж тогтоох боломж олдог. Үүнд:

- Бичиг хүлээн авах журмыг мөрдсөн үү. Ямар баримт бичиг журмыг зөрчсөн, ямар нь шат дамжлага алгассан, хэн түүнд хариуцлага хүлээх;
- Ёсчлох журмыг сахисан уу;
- Бичиг баримтанд хийсэн тэмдэглэл, гарын үсэг, шийдвэр хэн түүнийг бичсэн;
- Хэзээ хэн бичиг баримтыг компьютерт оруулсан түүнийг өөрчилсөн эсэх, хэзээ хэн хэвлэсэн, хэн компьютерт нэвтэрсэн;
- Хэнд асуудалд хариу өгөхийг даалгасан, асуудлыг хугацаандаа, чанартай /даацтай/ шийдсэн үү;
- Бичиг баримт дамжих дарааллыг зөрчсөн бол хэний санаачлагаар;

- Асуудлыг шийдэхэд бичиг баримтын бүрдэл хангалттай байсан уу;
- Асуудлыг хурдавчлан шийдсэн эсэх, хэрэв тийм бол хаана, хэн, хэзээ шийдсэн;
- Шийдвэр нь албан тушаалтны эрх мэдлийн хүрээнд багатах эсэх;
- Албан тушаалтны хийсэн үйлдэл, бичиг баримт дээрхи шийдвэртэйгээ тохирч байгаа эсэх;
- Бичиг баримтын шинжилгээгээр гэмт хэргийн нөхцөл байдал, түүний шалтгаан нөхцөлийг тайлбарлах, олон асуултуудын хариуг олох боломж бүрддэг.

Хээл хахууль өгөгчийг судлахдаа:

- Аж ахуйн ямар салбар эрхэлдэг, ажил үйлчилгээний чиглэл, албан тушаалтны эзэлж буй байр суурь, эрх мэдэл, тухайн байгууллагын бүтэц
- Ажил үйлчилгээний орлогоор хомс эсхүл өндөр аль нь болох
- Аж ахуйн нэгжийн үйлдвэрлэл, үйлчилгээний баримтын эргэлт, эргэлтийн хөрөнгийн эргэцийн хурд
- Байгууллагын бүртгэлийн систем, хяналт шалгалтын байдал, бүртгэлгүй орлого, хяналтгүй мөнгө гаргах боломж
- Ажлын хэмнэл, удирдлагын шийдвэр гаргахад асуудлыг боловсруулах, судлах, шинжлэхэд бусдыг оролцуулдаг эсэх, эсхүл дан ганцаар бүхнийг шийддэг үү.
- Үйлдвэрлэл, ажил хэрэг, гэрээ, хэлэлцээрийн харилцаа хамааралтай байгууллагууд, захирах, захирагдах, шалгах, шалгуулах уялдаа, албан бус хувийн харилцаа, өмнө нь аль байгууллагад ажилладаг байсан
- Аж ахуйн үйл ажиллагааны ашиг алдагдал, өр зээл, бүртгэл тооцоо хяналт шалгалтын хэвийн горимд байгаа эсэх, гэмт хэргийн хэлхээтэй байсан эсэх
- Албан тушаалтны биеэ авч яваа байдал, ёс зүйн зан заншил хэр сахидаг, бүдүүлэг түрэмгий, эсхүл ухаалаг авхаалжтай байдал
- Аж ахуйн үйл ажиллагааны орлого, албан тушаалтны зарцуулж буй хэрэглээтэй хэр тохирдог
- Бүх төрлийн татвар, нийгмийн даатгалын шимтгэл төлдөг байдал
- Хөдөлмөрийн хөлсний баталгаажих түвшинээс доош цалин ажиллагсдад олгодог эсэх

Эдгээр нөхцөл байдлыг доорх аргаар судалдаг.

- тухайн байгууллагад бүртгэл тооцоо хяналт шалгалт эрхэлдэг байсан хүмүүстэй уулзах, байцаах
- удирдлагатайгаа зөрж маргаж, ажлаас халагдаж хөөгдсөн болон хамт ажиллагсдаа өмөөрч, хууль дүрэм сахихыг шаардаж байсан, шаарддаг хүмүүстэй уулзах

- албан тушаалтны жолооч, бие хамгаалагч, нарийн бичгийн дарга, шууд удирдлаган дор нь байдаг хүмүүстэй ярилцах
- гэр бүлийн харилцаатай, дарга-эзэнтэйгээ дотно нөхөрлөдөг хүмүүс, олонтоо очдог, зочилдог цэг, наргиж хамт амардаг хүмүүсийн талаар мэдээлэл цуглуулах, тэдэнтэй уулзах
- цуглуулсан мэдээллүүдийг үндэслэж албан тушаалтантай уулзах, байцаах
- аж ахуйн үйл ажиллагааны баримт бичгүүдийг судлах
- тооцоо, бүртгэлд оруулаагүй, тусгаагүй үйлдвэрлэл үйлчилгээний орлого, зориулалт нь тодорхойгүй зарлага, гэнэт алга болсон валют, үнэт эдлэл, үл хөдлөх хөрөнгийн тухай анхан шатны баримт сэлтийг хураан авах, шинжлүүлэх
- тухайн байгууллагын ажиллагаанд мониторинг үнэлгээ хийлгэх, аудитын болон татварын шалгалт оруулах, шинжээч нягтлан бодох томилох зэргээр шуурхай ажиллаж нөхцөл байдлыг хяналтдаа авах, үнэнийг тогтоох, бүрхэг мэдээллийг тодруулах шалгалтыг шуурхай явуулан судалж шинжилдэг.

V БҮЛЭГ. АВЛИГА, АЛБАН ТУШААЛЫН ГЭМТ ХЭРГИЙГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААН ДАХЬ ПРОКУРОРЫН ОРОЛЦОО

5.1. АВЛИГЫН ХЭРГИЙГ МӨРДӨН БАЙЦААХ, ПРОКУРОРЫН ХЯНАЛТАНД АНХААРВАЛ ЗОХИХ АСУУДАЛ

Улс орны нийгэм, эдийн засгийн хөгжил, ардчиллын ололт, амжилтанд саад учруулж буй хүчин зүйлийн нэг нь албан тушаалтнуудын өөрийн эрхэлж байгаа албан тушаалын байдлыг ашиглан өөртөө давуу байдал олж авах замаар нийгэм, иргэдийн эрх ашиг сонирхол, эд хөрөнгөнд хор хохирол учруулж байгаа явдал юм.

Албан тушаалтнуудад төрийн хуулиар олгосон эрх мэдэл, төсөв хөрөнгө, цалин хангамж, танил тал, төсөл, тендер, сан зэрэг хөрөнгийн арвин эх сурвалжтай учир тэдний үйлдсэн хэргийг илрүүлэх, мөрдөн байцаах, хяналт тавих, шүүхээр шийдвэрлэх ажиллагаа туйлын бэрхшээл, хүндрэлтэй болох нь практикаас мэдрэгдэнэ. Нөгөө талаас авлигын төрлийн гэмт хэрэг нь нууц далд аргаар үйлдэгддэг, гэрчлэх гэрч, эд мөрийн баримт олоход маш бэрх, ихэнх тохиолдолд авлига авагч, өгөгч, зуучлагч нарын эрх ашиг, сонирхолд нийцдэг учир илрүүлэхэд маш бэрхшээлтэй.⁸³

Ихэнх тохиолдолд албан тушаалтнууд үйлдсэн хэргээ хүлээхгүй, хэрэгт холбогдсон даруйд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд ямар нэг хэлбэрээр /албан тушаалаараа далайлгах, танил талаараа лоббидох, мөнгө амлах, өс хонзонгоор шударга хуульчдын эсрэг худал матаас, мэдээлэл бичих/ хууль бус нөлөө үзүүлэхийг оролддог. Энэ бол тэдний үнэн нүүр царай, хийж чадах ажил бөгөөд ийм нөхцөлд албан тушаалтны үйлдсэн гэмт хэргийг мөрдөж илрүүлнэ гэдэг нь мөрдөн байцаагч, прокурор, шүүгч зэрэг хуульчдаас ихээхэн дадлага, туршлага, мэдлэг чадвар, шударга зан чанар, ёс зүйг хатуу чанд шаардана.

АТГ үүргээ зохих ёсоор гүйцэтгэж байгаа ч ажилтнууд нь авлига, албан тушаалын хэргийг мөрдөж ирсэн түүхэн уламжлалгүй, дадлага туршлага мөхөс, зарим талаар мөрдөн байцаагчийн арга барил, ур чадвар дутагдалтайгаас төдийлөн үзэгдхүйц амжилтанд хүрч чадахгүй байна.

Албан тушаал, авлигын хэрэг мөрдөх ажиллагаанд эрүүгийн болон Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны эрх зүйн зохицуулалт учир дутагдалтай учир холбогдох бусад хууль тогтоомжийг ч эргэж харах шаардлагатай, хуульчдын дунд нэгдмэл нэг мөр ойлголт, практик хараахан төлөвшөөгүй, ямар нэг байдлаар хэрэг шийдвэрлэхэд субъектив нөхцөл байдал байгаа зэрэг нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд сөргөөр нөлөөлж байгааг ч тэмдэглэх хэрэгтэй.

Нийслэлийн прокурорын газар нь авлига, албан тушаалын гэмт хэргийн ихэнхийг харьяалан хяналт тавьдаг чиг үүргийг хэрэгжүүлдэг нэгжийн хувьд тэнд ажиллаж буй прокуроруудын дадлага туршлага дутмаг, ажлын ачаалал ихтэй зэрэг нөхцөл байдлаас болж алдаж онох явдал байсаар байна.

⁸³Э. Сагсай. Азийн сангийн 2012 оны 10 сард хийсэн хурал дээр тавьсан илтгэлээс.

Иймд авлига, албан тушаалын гэмт хэргийн тухай мэдээллийг хүлээн авах, бүртгэх ажиллагаанд онцгой анхаарах, ялангуяа АТГ-ын гомдол, мэдээлэл хүлээн авдаг утсыг байнга ажиллуулах, нэргүй мэдээлэл хүлээн авах, холбоо мэдээллийн бүх төрлийн хэрэгсэл ашиглан мэдээлэл авч байгааг ялган зааглах шаардлагатай. Дээрх байдлаар авсан бүх мэдээллээ шууд бүртгэлд авахгүйгээс мэдээллийн баазад бүртгэж, холбогдох албаар шалгуулах, харин илэрхий гэмт хэргийн шинжтэй, гэмт хэрэг үйлдсэн болох нь нотлох баримтуудаар тогтоогдож байгаа гомдол мэдээллүүдийг шалгамаар байна.

Авлига, албан тушаалын гэмт хэргийн субъект нь төрийн үйлчилгээний ажилтнууд, эмч багш нар болох эсэх нь эргэлзээтэй хэвээр л.

Жилд дунджаар 1400 орчим авлига, албан тушаалын гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээлэл ирж байгаагаас 19 хувьд нь эрүүгийн хэрэг үүсгэж, 49 хувьд нь эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзсан, 29,6 хувийг харъяаллын дагуу шилжүүлсэн, эрүүгийн хэрэг үүсгэсэн шийдвэрийн 6,5 хувь нь мөн хүчингүй болсон нь энэ төрлийн гэмт хэргийг шалгах сонирхол хуулийн байгууллагад байна уу гэх эргэлзээг өөрийн эрхгүй төрүүлж байна.

Гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийг хүлээн авах шалгахдаа мэдээлэлд дурьдсан асуудлуудаас аль нь авлига, албан тушаалын шинжтэй үйлдэл болох, тэдгээрийг урьд шалгаж шийдвэрлэсэн шүүх, прокурорын хүчин төгөлдөр шийдвэр байгаа эсэх, холбогдох этгээд нь албан тушаалын гэмт хэргийн субъект мөн эсэх, гомдол мэдээлэл гаргагч нь хэн болох, мэдээлэл нь үнэн бодитой эсэх зэргийг бүрэн шалгаж тогтоохгүйгээр эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзахыг яаравчилдаг нь энэ төрлийн гэмт хэрэг нуугдмал байхад хүргэж байна. Энэ төрлийн гэмт хэргийг мөрдөн байцаах ажиллагаанд гарч байгаа нийтлэг дутагдлуудыг жагсаавал⁸⁴ :

- Мөрдөн байцаалтыг нарийвчилсан төлөвлөгөөтэйгээр анхнаас нь цэгцтэй явуулдаггүй, цуглуулсан нотлох баримтандаа боловсруулалт хийж дахин шалгадаггүйгээс өөр хоорондоо зөрүүтэй болдог;
- тухайн хэрэгт ач холбогдолгүй олон материал цуглуулан цаашид хянах, шийдвэрлэх ажиллагаанд хүндрэл учруулдаг;
- гэрч хохирогч, сэжигтэн, яллагдагч, иргэний нэхэмжлэгч, шинжээч нараас мэдүүлэг авах, үзлэг нэгжлэг хийх, эд мөрийн баримт хураан авах, байцаан шийтгэх ажиллагааны тэмдэглэл хөтлөх, шинжээч томилох, сэжигтнээр тооцох, яллагдагчаар татах, хохирогч, иргэний нэхэмжлэгчийг тогтоох баримт бичгийг үйлдэхдээ хуульд заасан журам зөрчдөгөөс нотлох чадвараа алдан үнэгүүддэг;
- байцаан шийтгэх ажиллагаанд оролцогчдын эрхийг бүрэн хангадаггүй, санхүү, нягтлан бодох бүртгэлийн хуулийн хүчинтэй баримтуудыг бүрэн цуглуулж шинжилгээний байгууллагад хүргүүлдэггүйгээс гэмт хэргийн улмаас учирсан хохирлын хэмжээ бүрэн бодитой бус гарч дахин шинжилгээ хийхэд хүрдэг;
- албан тушаалтныг буруутгах үндэслэл болсон хууль нийгмийн ямар харилцааг зохицуулсан, түүний аль заалт Эрүүгийн хуультай хэрхэн

⁸⁴Азийн сангийн захиалгаар судлаач Б. Галдаа, Т. Жадамбаа, Т. Доохүү нарын хийсэн судалгааны дүнгээс. УБ хот, 2013 оны 10 сар.

уялдаж байгаа, тухайн хуулийг хэрэглэх, хэрэгжүүлэх талаарх дүрэм, журам зэргийг бүрэн судалдаггүй;

- байцаалтыг нотлох баримт болгон цуглуулах арга болгож байгаа нь өрөөсгөл, тухайн хэрэгт хамааралгүй этгээдийн хэргийг тусгаарлан зохих газарт шилжүүлдэггүй, хамааралтай этгээдийн хэргийг нэгтгэдэггүй;
- Мөрдөн байцаалтыг бүрэн явуулаагүй байж харъяалал тогтоолгохоор шилжүүлэх санал гаргаж хугацаа алдах;
- Прокурорын даалгавар, шүүгчийн захирамж, шүүхийн тогтоол, магадлалын заалтыг биелүүлдэггүй буюу зохих ёсоор биелүүлдэггүй;
- Тухайн гэмт хэрэг хэзээ гарсан, холбогдсон этгээдийн хувийн байдал, учруулсан хохирлын хэмжээ, үйлдлийн тоо зэргийг эхний ээлжинд шуурхай шалгаж тогтоолгүйгээр урсгал байдалтай ажиллагаа явуулан зардал, чирэгдэл гаргасаны эцэст хөөн хэлэлцэх хугацаа дуусах эсхүл өршөөл үзүүлэх хуульд хамрагдахад хүргэж хариуцлага тооцож чаддаггүй;
- Мөрдөн байцаагчийн хайнга, хариуцлагагүй, шуурхай биш ажиллагаа, мөрдөн шалгах арга, туршлага, хууль хэрэглээний мэдлэг, нотлох баримт үнэлэх чадвар зэргийн дутагдал;
- Шүүх, прокуророос хэрэгт нэмэлт ажиллагаа хийлгэхээр олон дахин буцаасан тохиолдолд мөрдөн байцаагч залхан хайнга хариуцлагагүй ажиллаж өмнөх саналаасаа /яллах дүгнэлт үйлдүүлэх/ татгалзахад хүрдэг;
- Мөрдөн байцаалтын ажиллагаа хэтэрхий удаан байгаа нь хэргийн эцсийн шийдвэрлэлтэнд сөрөг нөлөө үзүүлж байгаа зэргийг прокурор хяналтаараа анхаарч засах учиртай.

Прокурорын хяналтын тухайд үндсэндээ хуульд заасан үүргээ зохих ёсоор биелүүлж байгаа боловч анхаарвал зохих цөөнгүй дутагдал байна. Тухайлбал,

Мөрдөн байцаагч байцаан шийтгэх ажиллагааны тогтоолыг хуульд зааснаар үйлдээгүй, нотлох баримтыг цуглуулахдаа хууль зөрчсөн зэргээс тэдгээр баримтууд үнэгүйдэхэд хүрч нотлох баримтаас хасагдаж байгаа нь прокурор тухайн хэргийг мөрдөх ажиллагааг эхнээс нь тасралтгүй хянаж зөрчлийг тухай бүр илрүүлэн засуулах арга хэмжээ аваагүйтэй холбоотой;

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 80 дугаар зйлд заасан нотлогдвол зохих зүйлийн талаар гүйцэд хяналт тавьдаггүй, мөрдөн байцаагчид бичгээр өгч байгаа даалгавар нь нотлогдвол зохих асуудлаас хальсан буюу дутуудсан, үүнээс шалтгаалан мөрдөх ажиллагаанд хүндрэл учруулах, мөрдөн байцаагч даалгаврыг эс зөвшөөрч дээд шатны прокурорт санал гаргадаг, саналыг дээд шатны прокурор шийдвэрлэх гэж цаг алддаг зэрэг нь хэргийг удтал сунжрахад хүргэдэг. Прокурор хэд хэдэн харилцааг зохицуулсан хууль тогтоомж зөрчсөн, олон холбогдогчтой, их хэмжээний хохиролтой хэргийг ажиллагааны явцад тэр болгон биечлэн хянадаггүй, мөрдөн байцаагчийн амаар танилцдагаас сэжигтэн, яллагдагч нарын гэмт

үйлдлүүдийн хоорондын уялдаа холбоо, тэдгээрийг нотолсон баримтуудын уялдааны учрыг ойлгоогүй буюу өөрийн болгож аваагүйн улмаас шүүхэд яллах дүгнэлтээ хамгаалж чаддаггүй байдал ажиглагддаг.

Нотлох баримтыг дахин шалгуулах, нэг баримтыг өөр баримтаар нотлуулах талаар хангалтгүй, яллах нотолгоо баримтыг хэтрүүлэн үнэлж эсхүл цагаатгах баримтыг давуу үнэлж шийдвэр гаргадаг, тухайн баримтын эх сурвалжийг шалгасан эсэхийг анхаарахгүй байна.

Авлига, албан тушаалын гэмт хэргийн дийлэнх нь гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй буюу нотлогдоогүй гэх үндэслэлээр хэрэгсэхгүй болж байгаа нь Эрүүгийн хэрэг үүсгэх ажиллагаанд тавих хяналтын хүртээмж, чанартай холбоотойгоос гадна хэргийг хэрэгсэхгүй болгосон зарим шийдвэр хуульд нийцсэн эсэх нь эргэлзээтэй олон шийдвэр байгааг эргэн харах хэрэгтэй.

Түүнчлэн яллах дүгнэлт болон тогтоол үйлдэх талаар хуульд заасан журмыг зохих ёсоор биелүүлээгүй, тухайн хэрэг материалд авагдсан баримт нотолгоонуудыг гаргаж байгаа шийдвэртээ тодорхой, ойлгомжтой тусгадаггүйгээс шүүхээс хэрэг буцах, зарим шүүгдэгчийн хэрэг, үйлдэл хэрэгсэхгүй болоход хүргэжээ.

Мөрдөн байцаалтыг шуурхай явуулахад хяналт хангалтгүй байгаа нь гэмт этгээдүүд баримт, нотолгоог бүдгэрүүлэх, үгүй болгох, хэргийг будлиантуулах буюу гэрч хохирогчийн мэдүүлгүүд өөрчлөгдөх улмаар эрүүгийн хариуцлагад татах хугацаа өнгөрөх зэрэг сөрөг нөлөө үзүүлсэн.

Шүүхийн өмнөх шатанд хэргийг хэрэгсэхгүй болгох тохиолдолд хохирлын талаар тогтоолд заахгүй орхигдуулах, төрийн болон төрийн өмчит байгууллага, аж ахуйн нэгжүүдэд учирсан хохирлыг арилгуулах талаар прокурорын санаачлага дутмаг байна. Наад зах нь прокурор тухайн байгууллагаар нэхэмжлэл гаргуулж иргэний хэрэгт нь оролцож дүгнэлт гаргах бололцоотойг анхаардаггүй.

Байцаан шийтгэх ажиллагаанд оролцогчдоос гаргаж байгаа гомдолд дурдсан асуудлыг анхаардаггүй, хэргийг нэгтгэх, тусгаарлах болсон хуулийн үндэслэлийг сайтар хянадаггүй зэргээс үйлдсэн яллах дүгнэлт нь дээд шатны прокурорын хяналтаар хүчингүй болдог, мөрдөн байцаалтын ажиллагааг бүрэн гүйцэтгээгүй байхад хэргийг хэрэгсэхгүй болгодог, хохирогчоос гаргасан гомдол, хүсэлт болон шинээр гаргасан баримт сэлтийг дутуу үнэлдэг, шийдвэрийнхээ үндэслэлийг сайтар гаргаагүй зэргээс хэрэг хэрэгсэхгүй болж байна.

Прокурор тухайн үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэг гэж үзээд яллах дүгнэлт үйлдэн шүүхэд шилжүүлсэнийг шүүх хянан хэлэлцээд нэмэлт ажиллагаа хийлгэхээр буцаахад нь гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй гэж шийдвэрлэсэн тохиолдол ч цөөнгүй. Тухайлбал, Сэлэнгэ аймгийн Мандал сумын засаг дарга Ц нар хахууль авсан, албан тушаалын байдлаа хэтрүүлсэн гэх 210477334 тоот хэрэг, Төв аймгийн Баянчандмань сумын газрын мэргэжилтэн А нар хахууль авсан гэх 20915222 тоот хэргүүдэд прокурор тухайн хэргийн нотолгоо баримт болон уг үйлдэл, эс үйлдэхүй нь гэмт хэрэг мөн эсэх талаарх итгэл үнэмшил нь эргэлзээтэй, эсхүл бусдын нөлөөнд автсан байж болохоор байна.⁸⁵

⁸⁵Веретенников.В.И. Очерки истории генеральной прокуратуры России доекатерининского времени. Харьков 1915г. 29 дэх тал

5.2. ПРОКУРОРЫН ХЯНАЛТЫН МӨН ЧАНАР, ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

Прокурорын хяналт хэмээх ойлголтын үндэс суурийг анх XIV зууны эхээр буюу 1302 онд Францын IV Филипп хаан⁸⁶ тавьжээ. IV Филипп анх прокурорын байгууллагыг төрийн нэрийн өмнөөс гэм буруутай этгээдийг залхаан цээрлүүлэх, яллах чиг үүрэг бүхий хааны зарлигийг биелүүлдэг төрийн механизмийн нэг болгон байгуулсан нь тухайн үедээ Францад “эзэн хааны хүмүүс”⁸⁷ хэмээн нэрлэгдэж байсан байна.

Прокурор хэмээх ойлголт нь “procurare” гэсэн латин үгнээс гаралтай бөгөөд санаа тавих, хэрэг мөрдөх, хангах, бэхжүүлэх, арилгах, урьдчилан сэргийлэх гэсэн утгатай үг аж. Хэдийгээр прокурорын хяналт нь XIV зууны үед Францад үүссэн боловч “прокурор” хэмээх нэр томъёог XVIII зууны эхээр анх хэрэглэгдэж ирсэн хэмээн оросын түүхч В.И.Веретенников өөрийн бүтээлдээ дурджээ.

Аливаа төрийн байгууллага, тэр тусмаа прокурорын байгууллагын үүсэл, төлөвшин тогтсон түүхийг судлаж ойлгохын тулд дараахь гурван хүчин зүйлийг мэдэх шаардлагатай. Үүнд:

1.Прокурорын байгууллага байгуулагдах болсон зорилго, нөхцөл шалтгааныг тогтоон, төрийн тогтолцоонд уг байгууллагын эзлэх байр суурийг тодруулах;

2.Тухайн байгууллагад оногдуулсан зайлшгүй гүйцэтгэх үүргийн талаар нарийвчлах;

3.Мөн прокурорын байгууллагын үүсэл хөгжлийг судласны үр дүнд орчин үеийн эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, түүний цаашдын чиг хандлагыг тогтоон уг байгууллагын үйл ажиллагааг дээшлүүлэхэд чухал ач холбогдолтой.

XIV зуунаас өмнө Европын зарим орнууд эзэн хааны зарлигаар бусдыг шийтгэхдээ олон нийтийн өмнө ялладаг байсан бол XIV зуунаас хойш залхаан цээрлүүлдэг тусгай хүмүүсийг бий болгосон нь одоогийн прокурорын байгууллагын үйл ажиллагааны үндэс болж байв. Тухайлбал, Испанид эзэн хааны дэргэд эзэн хааны зарлигийг зөрчсөн этгээдийг мөрдөн шалгадаг залхаан цээрлүүлэгч хүмүүсийг буй болгосон байна.

Францад 1586 онд Прокурорын байгууллага болон түүний үйл ажиллагааг зохицуулсан хуулийг анх гаргаснаар төрийн тогтолцоонд прокурорын байр суурийг тодорхойлж өгчээ.⁸⁸ Энэ хуулиар прокурорын хяналтын бүрэн эрхийн хүрээнд нэгдүгээрт: захиргаа, улс төрийн шинжтэй үйл ажиллагааг хянах, хоёрдугаарт: мөрдөн байцаалтын үйл ажиллагааг хянах, гуравдугаарт: эрүүгийн болон иргэний хэргийг шүүхээр шийдвэрлэж буй үйл ажиллагаанд хяналт тавьж байхаар уг хуулинд тусгаж өгсөн байдаг.

⁸⁶ Мөн тэнд үзэх

⁸⁷ В.И.Басков “Прокурорский наздор” Москва 1996, 14 дэх тал

⁸⁸ В.И.Басков “Прокурорский наздор” Москва 1996, 14 дэх тал

Прокурорын хяналт нь Францад 1789-1810 онуудад төрийн дээд засаглалыг хэрэгжүүлэн залхаан цээрлүүлэх чиг үүргийг гүйцэтгэгч хааны дэргэдэх хүмүүс болж ирсэн. Францийн прокурорын байгууллагын энэ жишгээр Орос орон өөрийн прокурорын байгууллагаа байгуулжээ.

XVII зууны сүүл, XVIII зууны эхэн үеэр Орос улсад албан тушаалын гэмт хэргийн гаралт /улсын өмч хөрөнгийг завших, авилгалын гэмт хэрэг зэрэг/ өссөнөөс шалтгаалан энэ сөрөг үзэгдэлтэй тэмцэх төрийн тусгай байгууллагыг бий болгох шаардлага гарсан.

Оросын I Петр хааны 1711.03.02-ны өдрийн зарлигаар “Бүх хэргийг нууцаар хянаж байх, буруу шүүх, татвар хураах болон бусад үйл ажиллагааг мэдэж байх” зорилготой Фискалийн албыг байгуулсан. Энэ байгууллагын бүтэц зохион байгуулалт, чиг үүргийг Германы ижил төстэй төрийн байгууллагаас жишиглэсэн. 1714.03.17-ны өдрийн I Петр хааны зарлигаар “Фискалийн албаны тухай” гэсэн хамгийн анхны эрх зүйн хэм хэмжээний актыг гаргажээ. Энэ зарлигаар фискалийн албаны бүрэн эрх, тэдгээрийн үйл ажиллагаа явуулах арга хэрэгслийг тодорхойлон дээд, орон нутгийн, хотын болон доод фискалиудын эрх хэмжээг тус тус тодорхой зааглаж өгчээ.

Дэлхийн улс орнуудын жишгээс үзэхэд прокурорын хяналтын эрх зүйн зохицуулалт нь аливаа улс орны Үндсэн Хууль, прокурорын хяналтын тухай хууль, эрүүгийн байцаан шийтгэх хууль болон холбогдох бусад хууль, тогтоомжоос бүрэлддэг.

Прокурорын хяналтын тухай хууль, тогтоомжийн үндсэн эх сурвалж нь олон улсын гэрээ болон үндэсний хууль, хууль тогтоомжууд бөгөөд энэ харилцааг зохицуулж буй эрх зүйн гол эх сурвалж бол прокурорын хяналт, түүний эрх зүйн үндсэн асуудлыг зохицуулдаг хууль тогтоомжуудаас бүрддэг. Энэ хуулиар прокурорын хяналтын болон эрх зүйн байдлын бүхий л асуудлыг тухайлбал, төрийн хяналт, мөн эрүүгийн процессын буюу мэргэжлийн хяналт, түүнчлэн шүүн таслах үйл ажиллагаанд оролцохдоо төрийн хууль ёсыг сахин биелүүлэх, мөн сахин биелүүлж байгаа эсэхэд хяналт эрх хэмжээг тодорхойлж өгөх ёстой.

Прокурорыг ихэнх улс орнуудад үндсэн хуулийн институтэд хамааруулан шүүх эрх мэдлийн хүрээнд багтаадаг бөгөөд зарим тохиолдолд засгийн газрын буюу хууль зүйн асуудал эрхэлсэн яамны харъяанд хамааран төрийн гүйцэтгэх эрх мэдлийн хүрээнд харъяалагдаж байна.

Тухайлбал, Америкийн Нэгдсэн Улс, Польш, Япон зэрэг орнууд прокурорын байгууллагыг Хууль Зүйн Яамны бүрэлдэхүүнд багтаадаг. Ялангуяа Америкийн Нэгдсэн Улс, Польшид Хууль Зүйн Сайд нь Ерөнхий Прокурор /АНУ-д ерөнхий прокурорыг Ерөнхий Атторней гэж нэрлэдэг/-ын үүрэгт ажлыг хавсарган гүйцэтгэдэг байна.

Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улсад Ерөнхий Атторнейгоор толгойлуулсан **төрийн мөрдөлт мөшгөлтийн захирлын алба** нь хамгийн ноцтой хүнд гэмт хэргүүдийг мөрдөн шалгах бөгөөд шүүхэд хуралд улсын яллагчийн чиг үүргийг гүйцэтгэн оролцдог ажээ.

Энэ алба нь цагдаагийн мөрдөн байцаасан хэргийг бүх шатны шүүхэд

яллагчаар оролцох ба зарим тохиолдолд эрүүгийн хэрэг үүсгэн мөрдөн байцаалтанд биечлэн оролцдог байна.

Дээрх улс орны жишгийг нэгтгэн дүгнэвэл прокурорын байгууллагыг 4 үндсэн бүлэгт хуваан авч үзэж болох юм. Тодруулбал,

1.Прокурорын байгууллага нь Хууль зүйн асуудал эрхэлсэн яамны буюу гүйцэтгэх засаглалын бүрэлдэхүүнд багтдаг бөгөөд прокурор нь шүүгчийн зэрэглэлд хамаарна.

2.Прокурорын байгууллага нь шүүх засаглалын бүрэлдэхүүнд багтаж, шүүхэд харъяаллагддаг буюу шүүх эрх мэдлийн хүрээнд тодорхой хэмжээний бие даасан байдлыг эдлэнэ.

3.Прокурорын байгууллага харьцангуй биеэ даасан тогтолцоотой, хууль тогтоох байгууллага, эсвэл төрийн тэргүүний өмнө тайлагнаж, хариуцлагыг хүлээдэг.

4.Мөн зарим орнуудад прокурорын байгууллага жинхэнэ утгаараа байдаггүй бөгөөд прокурорын эрх хэмжээ, чиг үүргийг хууль зүйн өөр албан тушаалтан эрхлэн гүйцэтгэдэг хэмээн ангилж болох юм.

Прокурорын хяналт нь нэг талаас төрийн хяналт, нөгөө талаас эрүүгийн процессын буюу мэргэжлийн хяналт юм. Төрийн хяналт нь тухайн улс орны төрийн үйл ажиллагаа хэвийн явагдах нөхцөл бололцоог хангах үүднээс хууль, эрх зүйн нэгдмэл байдал, хууль ёсыг улс даяар нэг мөр ойлгон хэрэгжүүлэхэд тус дөхөм болох үүднээс төрийн байгууллагын эрх бүхий албан тушаалтны гаргаж буй шийдвэр, үйл ажиллагаа нь хуульд нийцэж буй эсэхэд хяналт тавина. Харин эрүүгийн процессын буюу мэргэжлийн хяналт нь улс орны шүүн таслах үйл ажиллагаа болон түүнтэй холбоотойгоор эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны бүхий л үе шатанд хууль сахиулах байгууллагаас явуулж буй хүний эрх, эрх чөлөөг хангах, хязгаарлах үйл явцад цаг үргэлж хяналт тавьж байх эрх, үүрэг юм.

Прокурорын хяналтыг постсоциалсит зарим орнуудад /БНХАУ, БНАСАУ, ОХУ г.м/ хууль, тогтоомжид тавих дээд хяналт буюу ерөнхий хяналт болгон энэ хяналтын объектод улс орны хууль тогтоох болон гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагууд, түүний харъяанд орох бүх яам, тусгай газар, тэдгээрийн байгууллагууд, орон нутгийн өөрөө удирдах байгууллагын болон засаг захиргааны нэгжийн байгууллагууд, түүнчлэн төрийн албадлага хэрэгжүүлэгч захиргааны хэрэг бүртгэх байгууллагууд, албан тушаалтан, иргэдээс тус улсын хуулийг нарийн чанд сахин биелүүлэх үйл явц ордог.

Прокурорын хяналтын чиг үүргийг хэрэгжүүлэгч байгууллагын бүтэц, тогтолцоог үйл ажиллагаатай нь уялдуулан авч үзэх нь зүй ёсны асуудал. Энэ ч утгаараа өмнөх хэсэгт прокурорын байгууллагын тогтолцоо болон хяналтын тухайн ойлголт, онцлогийг хамтатган авч үзсэн болно.

Харин эрүүгийн хэргийн мөрдөн байцаалтын ажиллагаанд тавих хяналт нь эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд буюу эрүүгийн мөрдөн байцаах байгууллагын үйл ажиллагаа хуульд заасан үндэслэл журмын дагуу явагдаж буй эсэхийг хянах чиг үүрэгтэй. Прокурор хэдийгээр мөрдөн байцаах ажиллагааг хянана гэж хуульчлагдсан ч олон улсын жишгээр мөрдөн байцаалтын ажиллагааг удирдан явуулдаг. Тухайлбал, 1998 онд

Ромд баталсан “Олон улсын эрүүгийн шүүхийн дүрэм”-ийн 53 дугаар зүйлд прокурорын газарт ирсэн мэдээллийг үнэлж үзээд мөрдөн мөшгих ажиллагаа явуулна⁸⁹ гэжээ.

Мөрдөн мөшгих ажиллагааг ихэнх улс оронд прокурор удирдан хэрэгжүүлж, бас хяналт тавьж ажилладаг. Прокурор эрүүгийн мөрдөн байцаалтыг эхлүүлж мөрдөн байцаалтыг явуулах эрх бүхий байгууллагын үйл ажиллагааг удирдан чиглүүлдэг.

Тухайлбал: ХБНГУ, БНСУ, Япон зэрэг орнуудад прокурор нь мөрдөн байцаах байгууллагыг мэргэжлийн удирдлагаар ханган хяналт тавьж ажиллах ба мөрдөн байцаах байгууллагыг, тэр тусмаа цагдаагийн байгууллагыг прокурорын туслах⁹⁰ хэмээн нэрлэдэг.

Прокурорын байгууллага эрүүгийн мөрдөн байцаах ажиллагааг эхнээс нь гардан удирдан хяналт тавин ажиллах нь прокурорын хяналтын үндсэн чиг үүрэг юм. Гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийг хүлээн авсан, өөрсдөө илрүүлсэн үеэс эхлэн мөрдөн байцаах байгууллага, тэр дундаа цагдаагийн байгууллага 24 цагийн турш шалган тогтоох ажиллагаа явуулдаг тул гэмт хэрэг гарсан тухай мэдээллийг хамгийн түрүүнд хүлээн авч буй хэдий ч тодорхой хугацаанд прокурорт энэ тухай заавал мэдэгдэн прокурорын хяналтын бүртгэлт авагдан хянуулдаг практик дэлхийн олон оронд нэгэнт тогтжээ.

5.3. АВЛИГЫН ГЭМТ ХЭРГИЙГ ШҮҮХЭЭР ХЯНАН ШИЙДВЭРЛЭХЭД ПРОКУРОРЫН ОРОЛЦОО, МЭТГЭЛЦЭХ ЗАРЧМЫН ХЭРЭГЖИЛТ

Прокурор эрүүгийн хэрэг үүсгэх шатнаас эхлэн гэмт хэрэгт холбогдсон этгээдийг гэм буруутай хэмээн шүүхээс ял ногдуулах, уг ногдуулсан ялыг биелүүлэх болон тухайн этгээд ял шийтгэлгүйд тооцох хүртэлх бүхий л үе шатанд прокурорын хяналт тасралтгүй хэрэгждэг тул мөрдөн байцаах ажиллагаа хууль, тогтоомжийн дагуу явагдаж буй эсэхэд хяналт тавих нь прокурорын үндсэн үүрэг мөн.

Монгол Улсын Үндсэн хууль болон Прокурорын байгууллагын тухай хуульд зааснаар прокурор шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс оролцох үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэхдээ Эрүүгийн хууль, Эрүүгийн байцаан шийтгэх хууль болон түүнд нийцүүлэн гаргасан удирдамжийн бичиг баримтыг удирдлага болгон ажилладаг.

Прокурор нь анхан шатны эрүүгийн шүүх хуралдаанд улсын яллагчаар оролцож, шүүх хуралдааны явцад шүүгдэгчийн гэм бурууг нотлох, улмаар яллах чиг үүргийг гүйцэтгэхдээ Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн мэтгэлцэх зарчмыг хэрэгжүүлэгч нэг тал байна. УЕП-с баталсан аргачилсан зааварт прокурор нь шүүх хуралдаанд оролцохоос өмнө зохих бэлтгэлийг хангасан байна гэжээ. Тухайлбал,

Нэг. Улсын яллагч нь төрийн өндөр албан тушаалтан болон дипломат дархан эрх ямба эдэлж байгаа этгээд, шүүгч, прокурор, төрийн захиргаа,

⁸⁹Rome statute of the international criminal court Rom 1998, 53-р зүйлд

⁹⁰Б.Шюнеманн “Цагдаа ба прокурорын байгууллага” Төр эрх зүйн хуудас-Эргэцүүлэл” сэтгүүл УБ 2001 он, 187-р талд

хил, тагнуул, цагдаагийн байгууллагын удирдах албан тушаалтнуудын үйлдсэн гэмт хэрэг, хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлэгдсэн, олон нийтийн анхаарал татсан, түүнчлэн ээдрээ төвөгтэй гэж үзсэн хэргүүдийн ялын саналын талаар дээд шатны прокурорт танилцуулж санал солилцох;

Хоёр. Шүүх хуралдаанд шүүгдэгч, хохирогч, гэрч, шинжээчээс асуух асуултууд, шүүмжлэлийн шатанд хэлэх ялын шүүмж зэргийг урьдчилсан байдлаар бэлтгэсэн байх;

Гурав. Прокуророос хэрэг шүүхэд шилжсэнээс хойшхи хугацаанд яллагдагч, хохирогч, тэдгээрийн өмгөөлөгч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч нараас шинээр нотлох баримт шүүхэд гарган өгч, тусгайлан хүсэлт гаргасан эсэх, хэрэв шинэ нотлох баримт гаргаж, тусгайлсан хүсэлт гаргасан бол хууль ёсны үндэслэлтэй эсэхэд дүгнэлт хийх;

Дөрөв. Прокуророос шүүх хуралдаанд хохирогч, гэрч, шинжээчийг зайлшгүй оролцуулахаар болон бусад асуудлаар гаргасан хүсэлтийг шүүх хүлээн авч тодорхой арга хэмжээ авсан эсэх; Шүүх хуралдаан эхлэхээс 3 хоногийн өмнө яллагдагчаар татсан тогтоол, яллах дүгнэлтийн хуулбарыг зарлан дуудах хуудасны хамт шүүгдэгчид гардуулан өгсөн эсэх;

Тав. Шүүх бүрэлдэхүүн Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 32 дугаар зүйлийн 32.1, 32.6 дахь хэсэгт зааснаар томилогдсон эсэх, тэдгээрийг татгалзан гарах хууль зүйн үндэслэл байгаа эсэх зэргийг анхаарсан байвал зохино.

Анхан шатны эрүүгийн шүүх хуралдаанд прокурор оролцох:

- Улсын яллагч нь анхан шатны шүүх хуралдаанд шүүгдэгчид сонсгосон ялыг нотлох үүргийг хүлээж оролцоно.

- Улсын яллагчийн дотоод итгэл нь хууль болон прокурорын ёс зүйд нийцсэн байна.

- Улсын яллагч нь анхан шатны шүүх хуралдаанд баримталсан байр сууриа дээд шатны прокурорын өмнө тухайн хэргийн нотлох баримтаар нотлох үүрэгтэй. Хэрвээ нотлож чадаагүй бол хариуцлага хүлээх үндэслэл болно.

- Хэрэгт 2 буюу түүнээс дээш прокурор зэрэгцэн хяналт тавьсан эсхүл хэрэг ээдрээ төвөгтэй, олон шүүгдэгчтэй бол шүүх хуралдаанд хэд хэдэн улсын яллагч оролцож болно.

- Улсын яллагч нь онцгой тохиолдолд хуульд заасны дагуу тухайн зүйл, хэсэгт заасан ялын доод хэмжээнээс хөнгөн ял оногдуулахаар санал тавьж болно. Харин үндэслэлгүйгээр яллахаас татгалзах, хэрэгт өмгөөлөгчийн байр сууринаас хандах явдлыг гаргаж болохгүй.

Прокурор нь анхан шатны эрүүгийн шүүх хуралдаанд улсын яллагчаар яллах тал болж оролцохдоо: Шүүх хуралдаанд хэд хэдэн шүүгдэгч, яллах талын гэрчүүд оролцож байгаа тохиолдолд хэн алинаас нь эхэлж мэдүүлэг авах, шаардлагатай гэж үзвэл яллах дүгнэлт, яллагдагчаар татах тухай тогтоолын хавсралтад зааснаас өөр гэрч, шинжээч дуудах, шинээр нотлох баримт гаргах болон бусад оролцогч нараас шинээр гаргасан нотлох

баримтыг үнэлж дүгнэх, эд мөрийн баримтад үзлэг хийх, шүүх хуралдааны явцад туршилт хийлгэх зэрэг асуудлуудын талаар өөрийн саналыг хэлэх;

Яллагдагчаар татах тухай тогтоол, прокурорын яллах дүгнэлтийг уншин сонсгож, хэрэв шүүгдэгч яллагдагчаар татах тухай тогтоол, прокурорын яллах дүгнэлтийг ойлгоогүй бол утгыг тайлбарлаж өгөх; Шүүхийн хэлэлцүүлгийн явцад шүүгдэгч, хохирогч нарын мэдүүлгийг сонсох, хохирогч, гэрч, шинжээч, шүүгдэгч нараас хэрэгт ач холбогдол бүхий яллах талын асуулт тавих, өмгөөлөгч болон бусад оролцогч нараас асуусан хууль бус асуултыг хүчингүй болгуулахаар санал гаргах;

Мэдүүлгээс бусад нотлох баримтыг шинжлэн судлахдаа мэдүүлгээр хэлэлцэгдээгүй, зайлшгүй хэлэлцэгдвэл зохих яллах талын нотлох баримтуудыг хавтаст хэргийн материалаас уншин сонсгох бөгөөд нотлох баримтуудад үнэлэлт, дүгнэлт өгөх хэлбэрээр хэлэх; Шүүгдэгчийн гэм бурууг хавтаст хэргийн материалд тулгуурлан хэргийн сэдэлт, зорилго, цаг хугацаа, үйлдлийн арга хэлбэр, онцлог, шууд буюу шууд бус нотлох баримт, хэрэг гарах болсон шалтгаан нөхцөл, шүүгдэгч болон хохирогчийн хувийн байдал, учирсан хохирлын шинж чанар, хэр хэмжээ зэргийг бодитойгоор үнэлж шүүгдэгчийн гэм бурууг нотлох замаар ялын шүүмжлэл явуулна.

Ялын шүүмжлэл дараах бүтэцтэй байвал зохино.

а/ удиртгал /хэнд холбогдох ямар гэмт үйлдлийг яллах гэж байгаа/

б/ хэргийн байдал /гэмт хэрэг гарах болсон шалтгаан нөхцөл, үйлдлийн арга, сэдэлт, гэм буруугийн хэлбэр болон учруулсан хор уршиг, гэмт хэргийн бүрэлдэхүүнийг агуулсан байдлын талаар/

в/ нотолгоо /хавтаст хэрэгт цугларсан болон шүүхийн хэлэлцүүлгийн үед авагдсан нотлох баримтуудаар хэрхэн нотлогдож байгаа талаар/

г/ яллах хэсэг /шүүгдэгчийн үйлдсэн гэмт хэрэгт Эрүүгийн хуулийн ямар зүйл хэсэгт заасан, ямар ял шийтгэлийг хир хэмжээтэй оногдуулах талаар өөрийн дотоод итгэлийг удирдлага болгон ялын талаарх дүгнэлт хэлнэ. Энэ хэсэгт ялыг хүндрүүлэх нөхцөл байдал, хорих ял эдлүүлэх дэглэм, хохирлын асуудал, эд мөрийн баримтыг хэрхэх болон таслан сэргийлэх арга хэмжээ хэрэглэх эсэх зэргийг дурьдсан байвал зохино/

д/ нэмэлт тайлбарын хэсэг /улсын яллагчийн шүүмжлэлийг эсрэг тал няцаасан тохиолдолд улсын яллагчаас нэмэлт тайлбар заавал хэлнэ/

Улсын яллагчаас ялын төрөл, хэмжээ дэглэм зэргийг үндэслэлтэй зөв тогтоохын тулд гэм буруугийн хэлбэр, гэмт хэрэг үйлдэгдсэн арга, хор уршиг, хувийн байдал зэргээс гадна тухайн төрлийн хэрэгт шүүхээс оногдуулж буй ялын бодлогыг судалсан судалгааны дүнг харгалзан үзсэн байвал зохино.

Улсын яллагч нь шүүгдэгч гэм буруугүй, эсхүл хэргийн талаар нэмэлт ажиллагаа хийх шаардлагатай гэж үзвэл Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 239 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн 1, 2-т зааснаар шүүх бүрэлдэхүүн зөвлөлдөх тасалгаанд орохоос өмнө яллахаас татгалзаж, үндэслэлээ бичгээр гарган хэргийн материалд хавсаргасан байна.

Яллагч нь шаардлагатай гэж үзвэл шүүх хуралдааны тэмдэглэлд хурал даргалагч, нарийн бичгийн дарга гарын үсэг зурснаас хойш 3 хоногийн

дотор тэмдэглэлтэй танилцаж засвар оруулахаар бол энэ талаар саналаа гаргана.

Шүүхээс ирүүлсэн шийтгэх ба цагаатгах тогтоолын хувийг туслах ажилтан бүртгэлд авч шүүх хуралдаанд оролцсон улсын яллагчид хүлээлгэн өгөх ба улсын яллагч нь тухайн тогтоол хууль ёсны, үндэслэлтэй эсэхийг хянана.

Давж заалдах шатны эрүүгийн шүүх хуралдаанд прокурор оролцох:

Эрүүгийн давж заалдах шатны шүүх хуралдаанд прокурор оролцох эрхтэй. Харин шүүхээс цагаатгах тогтоол гарсан, эсэргүүцэл бичигдсэн, онц хүнд гэмт хэрэг, төрийн өндөр албан тушаалтан болон дипломат дархан эрх ямба эдэлж байгаа этгээд, шүүгч, прокурор, төрийн захиргаа, хил, тагнуул, цагдаагийн байгууллагын удирдах албан тушаалтнуудын үйлдсэн гэмт хэрэг, хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлэгдсэн, олон нийтийн анхаарал татсан, түүнчлэн ээдрээ төвөгтэй гэж үзсэн хэргүүдийн давж заалдах шатны шүүх хуралдаанд заавал оролцоно.

Давж заалдах шатны шүүх хуралдаанд анхан шатны шүүх хуралдаанд оролцсон улсын яллагч оролцох боломжгүй тохиолдолд дээд шатны прокурор өөр прокурорыг томилно. Ийнхүү томилогдсон прокурор нь хэргийн материалтай танилцсаны үндсэн дээр шүүх хуралдаанд оролцоно.

Улсын яллагч эсхүл дээд шатны прокурор нь шүүхийн шийтгэх, цагаатгах тогтоолыг үндэслэлгүй гэж үзсэн тохиолдолд ЭБШ хуулийн 304 дүгээр зүйлийн 304.1 дэх хэсэгт заасны дагуу шүүхийн тогтоолыг гардуулснаас хойш 14 хоногийн дотор улсын яллагчийн болон дээд шатны прокурорын эсэргүүцэл бичнэ.

Шүүх ЭБШ хуулийн 230 дугаар зүйлийн 230.1, 225 дугаар зүйлийн 225.1.2-ыг удирдлага болгон нэмэлт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа хийлгэхээр хэргийг прокурорт буцаасан шүүгчийн захирамж, шүүхийн тогтоолыг прокурор үндэслэлгүй гэж үзвэл уг шийдвэрийг хүлээн авснаас хойш ажлын 5 хоногт багтаан эсэргүүцэл бичнэ.

Эсэргүүцэл нь дараах шаардлагыг хангасан байвал зохино.⁹¹

Шүүх хуралдаанд улсын яллагчаар орсон хэргийн тогтоол, магадлалд эсэргүүцэл бичиж байгаа бол “Улсын яллагчийн эсэргүүцэл”, улсын яллагчаар ороогүй буюу яллагдагчийг шүүхэд шилжүүлэхээс өмнө хэргийг буцаасан шүүгчийн захирамжид эсэргүүцэл бичиж байгаа бол “Прокурорын эсэргүүцэл”, Аймаг, Нийслэл, тээвэр, дүүргийн прокуророос шүүхийн тогтоол, магадлалыг эс зөвшөөрч эсэргүүцэл бичиж байгаа бол “Дээд шатны прокурорын эсэргүүцэл” гэсэн нэртэйгээр бичнэ.

Эсэргүүцэл бүр биелэгдэх шаардлагатай гэдэг зарчмыг баримталж түүний хууль зүйн үндэслэлийг зөв тодорхойлох нь зүйтэй. Ялангуяа шүүхийн тогтоол, магадлал, захирамжийн аль хэсгийг ямар үндэслэлээр хүлээн авах боломжгүй байгааг эсэргүүцэлд тодорхой дурьдана. Дээд шатны прокурор нь прокурорын буюу улсын яллагчийн эсэргүүцлийг үндэслэлгүй гэж үзвэл шүүх хуралдаанаас өмнө буцаан авч болно.

⁹¹УЕП-ын тушаал. Аргачилсан заавар, 2011 он.

Улсын яллагч давж заалдах шатны шүүх хуралдаанд оролцох шаардлагагүй гэж үзсэн бөгөөд ялтан, хохирогч, тэдгээрийн өмгөөлөгч, хууль ёсны төлөөлөгч нараас шүүхийн шийдвэрт гомдол гаргасан тохиолдолд прокурорын тайлбарыг бичнэ. Тайлбар бичихдээ: Шүүхэд давж заалдах хугацаанд гомдол гаргасан эсэх;

Шүүхийн шийдвэрт гаргасан гомдол нь хууль зүйн үндэслэлтэй эсэх, гомдолд дурьдсан зүйл нь хавтаст хэрэгт авагдсан ямар нотлох баримтуудаар үгүйсгэгдсэн, нотлогдсон болохыг прокурорын тайлбарт тодорхой дурьдсан байна.

Давж заалдах шатны шүүх хуралдаанд оролцож буй прокурор нь хуралдаан эхэлмэгц тусгайлан гаргах хүсэлт байвал танилцуулж, хэргийн талаарх шүүгчийн илтгэл, давж заалдсан гомдол, эсэргүүцлийн үндэслэл болон хэргийн талаар бүхэлд нь дүгнэлт гаргана. Дүгнэлтийг УЕП-с баталсан загварын дагуу 2 хувь үйлдэж нэг хувийг нь хэрэгт хавсаргаж, нөгөө хувийг нь орлогч, туслах прокурорт танилцуулсны үндсэн дээр дотоодын албан хэрэгт хадгалуулна.

Шүүх хуралдаанд оролцсон прокурор нь хуралдааны тэмдэглэлтэй шүүгч гарын үсэг зурснаас хойш 3 хоногийн дотор танилцах эрхтэй ба тэмдэглэлд засвар өөрчлөлт оруулах үндэслэл байвал саналаа гаргана.

Хяналтын шатны эрүүгийн шүүх хуралдаанд прокурор оролцох:

Давж заалдах шатны шүүх ял оногдуулсан, эсхүл цагаатгагдсан этгээдийн гэм буруутай эсэх асуудлыг шийдвэрлэхдээ ЭБШХ-г ноцтой зөрчсөн, эсхүл Эрүүгийн хуулийг буруу хэрэглэсэн гэж үзвэл магадлалыг гардуулснаас хойш 14 хоногийн дотор улсын яллагч, эсхүл дээд шатны прокурор хяналтын шатны шүүхэд эсэргүүцэл бичнэ.

Хяналтын шатны шүүхэд бичсэн эсэргүүцлийг анхан шатны шүүхээр дамжуулан хүргүүлнэ. Улсын яллагч нь шүүгдэгч, цагаатгагдсан этгээд, хохирогчийн өмгөөлөгчийн магадлалд гаргасан гомдолд прокурорын тайлбарыг бичих эрхтэй. Харин төрийн өндөр албан тушаалтан болон дипломат дархан эрх ямба эдэлж байгаа этгээд, шүүгч, прокурор, төрийн захиргаа, хил, тагнуул, цагдаагийн байгууллагын удирдах албан тушаалтнуудын үйлдсэн гэмт хэрэг, хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлэгдсэн, олон нийтийн анхаарал татсан, түүнчлэн ээдрээ төвөгтэй гэж үзсэн хэргүүдийн магадлалд гаргасан гомдолд заавал тайлбар бичнэ.

Мөрдөн шалгах ажиллагаанд тавих хяналт хариуцсан УЕП-ын туслах болон хяналтын прокурорууд нь УДШ-ийн хяналтын шатны эрүүгийн шүүх хуралдаанаар хэлэлцэгдэх хүнд, онц хүнд хэрэг, прокурорын эсэргүүцэл, дүгнэлт бичигдсэн хэрэг, өмгөөлөгч оролцож байгаа болон шүүхээс шүүгдэгчийг гэм буруугүй гэж хэргийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн хэргүүдийн шүүх хуралдаанд оролцож, дүгнэлтээ бичгээр гаргана.

Хяналтын шатны шүүх хуралдаанд прокурор оролцохдоо Эрүүгийн хууль буруу хэрэглэсэн, Эрүүгийн байцаан шийтгэх хууль ноцтой зөрчсөн аливаа зөрчлийг тухай бүр нь зөвтгүүлэх, хяналтын шатны шүүх хуралдааны тогтоол хуульд харшилсан гэж үзвэл УЕП эсэргүүцэл бичих эсэхийг дээд шатны прокурорт танилцуулж шийдвэрлүүлж байвал зохино.

УДШ-ийн хяналтын шатны шүүхийн тогтоол хуульд харшилсан гэж УЕП үзвэл тогтоол гарснаас хойш 30 хоногийн дотор эсэргүүцэл бичнэ. Мөрдөн шалгах ажиллагаанд тавих хяналт хариуцсан УЕП-ын туслах, Аймаг, Нийслэл, Тээвэр, дүүргийн прокурор нь ийнхүү эсэргүүцэл бичүүлэх саналаа УЕП-ын шийдвэрлэх боломжит хугацаанд гаргасан байвал зохино.

Аймаг, нийслэл, тээврийн прокурор нь дээрх саналаа УЕПГ-т бичгээр ирүүлэх бөгөөд хариуцуулсан прокурор нь хэрэгтэй танилцсаны үндсэн дээр УЕП, түүний орлогчид хэргийг танилцуулж эсэргүүцэл бичих эсэхийг шийдвэрлүүлнэ.

УЕП болон Ерөнхий шүүгчийн дүгнэлтээр хэргийг хэлэлцэж буй нийт шүүгчдийн хуралдаанд УЕП, түүний орлогч оролцож дүгнэлт гаргана. Улсын Дээд Шүүхийн нийт шүүгчдийн хуралдаанд УЕП, түүний орлогчийг оролцуулах бэлтгэл ажлыг мөрдөн шалгах ажиллагаанд тавих хяналт хариуцсан прокурорууд хийнэ.

Эрүүгийн хэргийн холбогдогчдыг нэг бүрчлэн нарийн сайн тогтоох, хохирлын хэмжээг нарийвчлан тодорхойлох, таслан сэргийлэх арга хэмжээг үнэн зөв, хуульд заасан үндэслэл, журмын дагуу бодитой хэрэглэж буй эсэх, сэжигтнээр тооцох, ял сонсгох зэрэг байцаан шийтгэх ажиллагааны үед оролцогчдын эрхийг хэрхэн хангаж байгааг прокурор цаг алдалгүй хяналт тавих нь мөрдөн байцаах ажиллагаанд тавих прокурорын хяналтын үндсэн чиг үүргийн нэг мөн.

Мөрдөн байцаах ажиллагаанд тавих прокурорын хяналтын эрх зүйн хэлбэрт тогтоол, зөвшөөрөл, даалгавар, мэдэгдэл, шаардлага, эсэргүүцэл багтах ба мөрдөн шалгах ажиллагаа явуулж буй тохиолдолд эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд оролцогчдыг байцаасан тэмдэглэл нь прокурорын үйл ажиллагааны эрх зүйн хэлбэрт тооцогддог.

Прокурор мөрдөн байцаах ажиллагааг удирдан хянах явцдаа эрүүгийн хэрэг үүсгэсэн тогтоолыг хүчингүй болгох, эрүүгийн хэрэг үүсгэх, таслан сэргийлэх арга хэмжээг өөрчлөх, эрүүгийн хэргийг түдгэлзүүлэх, хэрэгсэхгүй болгох зэрэг тодорхой асуудлыг шийдвэрлэхийн тулд эрх хэмжээнийхээ хүрээнд тогтоол үйлдэнэ.

Харин мөрдөн байцаах ажиллагааны үед хүний эрх, эрх чөлөө, хувийн болон гэр бүл, захидал харилцааны нууц, орон байр, өмчийн халдашгүй байдлыг хөндсөн ажиллагааг явуулах үед тогтоолыг батламжлах хэлбэрээр бичгээр зөвшөөрөл өгдөг. Мөн эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзсан, хэргийг хэрэгсэхгүй болгосон, түдгэлзүүлсэн, ял сонсгон яллагдагчаар татсан тогтоолыг дээрхийн адил батламжлах хэлбэрээр прокурор уг ажиллагааг зөвшөөрдөг юм.

Прокурор мөрдөн байцаах ажиллагаанд хуулийн заалтыг хангуулах, хуулийг зөв хэрэглэх, мөрдөн байцаалтыг цаг тухайд нь бүрэн бодитой явуулах арга хэмжээний талаар мөрдөн байцаагчид бичгээр даалгавар өгдөг байна.

Мөрдөн байцаах байгууллагаас хууль зөрчсөн үйл ажиллагаа явуулсан тохиолдолд прокурор өөрөө тогтоол, даалгавраар уг хууль бус ажиллагааг арилгахаас гадна дээрх үйлдэл болон түүнд шууд нөлөөлсөн

шалтгаан нөхцлийг арилгуулахаар өөрийн эрх хэмжээний хүрээнд мэдэгдэл гаргадаг.

Прокуророос мөрдөн байцаах ажиллагааг хянах явцад уг ажиллагааны талаар гаргасан хууль бус шийдвэрийг хүчингүй болгуулах, зөвтгүүлэхээр мөрдөн байцаах байгууллагын захиргаанаас гаргасан хууль зөрчсөн тушаал, шийдвэрт эсэргүүцэл бичих нь прокурор хяналтын чиг үүргээ хэрэгжүүлэх үндсэн хэлбэр болж өгдөг. Учир нь мөрдөн байцаах байгууллагаас гаргаж буй энэ шийдвэр ихэвчлэн эцсийн шийдвэр байдаг тул хуулийн заалтыг хангуулах, хуулийг нэг мөр зөв хэрэглэхэд ихээхэн ач холбогдолтой.

Прокурор өөрийн эрх хэмжээнийхээ хүрээнд мөрдөн шалгах ажиллагаа явуулж буй тохиолдолд прокурорын тогтоолоор аливаа асуудлыг шийдвэрлэдэг боловч эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд оролцогчдыг байцаасан тэмдэглэл нь прокурорын үйл ажиллагааны эрх зүйн хэлбэр болохоос хяналтын эрх зүйн хэлбэрт тооцогддоггүй байна. Учир нь байцаалтын тэмдэглэлийг мөрдөн шалгах ажиллагааны явцад үйлддэг болохоос төрийн хяналтын чиг үүргийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны эрх зүйн хэлбэрт ордоггүй. Гэхдээ зарим эрдэмтэд эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд оролцогчдийг байцаасан байцаалтын тэмдэглэлийг эрх зүйн хэлбэр бус нотлох баримтын эх сурвалжийн нэг төрөлд хамааруулдаг.⁹²

Авлигын эсрэг хуулийн 26 дугаар зүйлийн 26.3 дахь хэсэгт зааснаар прокурорын байгууллага цаашид ч АТГ-ын гүйцэтгэх болон хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаанд Гүйцэтгэх ажлын тухай хууль, ЭБШХ, Прокурорын байгууллагын тухай хуульд заасан үндэслэл журмын дагуу хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Авлигын хэргийг илрүүлэх, шалгаж шийдвэрлэх ажиллагаанд прокурорын үүрэг оролцоо чухал байр суурийг эзэлдэг бөгөөд үүнтэй холбоотойгоор прокурорууд мэргэжлийн өндөр төвшинд, хараат бусаар үйл ажиллагаагаа явуулах нийгэм, эдийн засаг, улс төр, эрх зүйн боломжийг бүхий л талаар хангах явдал цаашид ч төрийн бодлогын хэмжээнд байх ёстой асуудлын нэг юм.

Авлигын эсрэг хуулийн дагуу авлигын хэрэгт мөрдөн байцаалтын ажиллагааг дагнасан мөрдөн байцаагчид харъяалуулсан нь оновчтой шийдэл болсон бөгөөд үүний нэгэн адилаар авлигын хэрэгт хийгдэж буй хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, гүйцэтгэх ажилд тавих хяналтыг тусгайлан эрх олгосон буюу дагнасан прокурор хэрэгжүүлэх нь энэ төрлийн гэмт хэргийг мэргэжлийн өндөр төвшинд шалгаж шийдвэрлэх боломжийг нэмэгдүүлнэ.

Эдгээр мэргэшсэн прокуроруудыг сонгохдоо ажлын туршлага, нас тогтсон байдал, мэдлэг мэргэжил, ёс зүйн шаардлага хангаж байгаа эсэхийг нарийвчлан хянасаны үндсэн дээр сонгох төдийгүй тэдний мэдлэг, мэргэшлийг байнга дээшлүүлж байх, сэтгэлзүйн хувьд ч бэлтгэх шаардлагатай.

Авлигын хэргийг шалган шийдвэрлэж буй мөрдөн байцаагч, прокурор,

⁹² Б.Бат-Эрдэнэ, Г.Баясгалан Монгол улсын эрүүгийн байцаан шийтгэх эрх зүй УБ 1996 он, /ерөнхий анги/ 133 дахь талд

шүүгчийн мэргэшлийн ур чадварыг дээшлүүлэх үүднээс тэдгээрийг тусгай хөтөлбөрийн дагуу системчилсэн сургалтанд тогтмол хамруулж авлигын хэргийг мөрдөхтэй холбоотой нарийн арга техник эзэмшүүлэх нь нэн чухал.

Тухайлбал, төрийн удирдлагын болон санхүүгийн менежмент, өмч хувьчлал, бараа үйлчилгээ худалдан авах журмаас авхуулаад нуугдмал хөрөнгө илрүүлэх, нотлох баримт цуглуулах, бэхжүүлэх ажиллагааг хэрхэн гүйцэтгэх, гэрч хохирогчийг хэрхэн хамгаалалтанд авах арга барилыг ч нэг бүрчлэн зааж сургах;

Гэмт этгээдүүд хууль бус аргаар олж авсан эд хөрөнгөө нуун дарагдуулах зорилгоор гадаадад гуйвуулан байршуулах аргыг өргөнөөр хэрэглэх болсон өнөө үед гадаад улсын холбогдох байгууллагуудтай нягт хамтран ажиллаж, тэдгээр хууль бус өмч хөрөнгийг илрүүлэхэд чиглэсэн эрх зүйн харилцан туслалцааг цаг алдалгүй шуурхай үзүүлэх;

Үүнтэй холбоотойгоор эрх зүйн туслалцаа үзүүлэх болон олон улсын гэрээ конвенцүүдийг хэрэгжүүлэхэд чиглэсэн сургалтыг зохион байгуулах, ялангуяа эрх зүйн туслалцаа үзүүлэх чиглэлээр ажиллаж буй холбогдох ажилтнуудын мэргэшлийн ур чадвар болон гадаад хэлний мэдлэгийг сайжруулахад онцгой анхаарах;

Түүнчлэн дээрх байгуулллагуудын авлигын эсрэг бодлого боловсруулах чадавхийг нэмэгдүүлэхэд анхаарч үүнд чиглэсэн сургалт зохион байгуулах, бусад оронд мэргэжил дээшлүүлэх, туршлага судлуулах явдлыг төрийн зүгээс бодлогоор дэмжих шаардлага байх шаардлагатай.

Авлигатай тэмцэх Хонгконгийн жишээнээс үзэхэд мөрдөн байцаагч, прокурорын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх зорилгоор гадаад улсад туршлага судлуулах, сургалтанд хамруулсан зардал нь жилд 4,7 сая ам доллар болж байгаа нь сургалтанд ямар ач холбогдол өгдөгийн бодит жишээ юм.

Авлигын хэргийг хянан шийдвэрлэж буй хуулийн байгууллагын ажилтнууд нь зөвхөн мэргэжлийн хувьд биеэ авч явах ёс зүйн шаардлагыг хангаад зогсохгүй хувь хүний хувьд ч ёс зүйн өндөр шаардлагыг хангасан байх ёстой.

Иймээс цаашид боловсон хүчнийг сонгон шалгаруулах журмыг боловсронгуй, ил тод, нээлттэй болгох, Хуульчдын холбооны мэргэжлийн хариуцлагын хорооны үйл ажиллагааг сайжруулахын зэрэгцээ хуульчдад зориулсан авлигын эсрэг хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах нь хуулийн байгууллагуудын үйл ажиллагааны ил тод байдлыг нэмэгдүүлэх, авлигаас урьдчилан сэргийлэхэд чиглэсэн үр нөлөөтэй арга хэмжээ байх боломжтой. Авлигын хэргийг шалгаж шийдвэрлэхтэй холбоотой эрх зүйн зохицуулалтыг хуульд нарийвчлан тусгах хэрэгцээ шаардлага байсаар байна.

Авлигын гэмт хэрэг нь ихэвчлэн хаалттай хаалганы цаана үйлдэгдэж, гэрч баримт цуглуулахад нэн төвөгтэй байдаг учир уг гэмт хэргийг илрүүлэхэд онцлог арга барил шаардлагатай нь тодорхой. Өөрөөр хэлбэл энэ төрлийн гэмт хэргийг илрүүлэхэд гүйцэтгэх ажлын шугамаар нотлох

баримт цуглуулах аргыг өргөн хэмжээгээр хэрэглэх шаардлагатай юм.

ЭБШХ-ийн 79 дүгээр зүйлд “...эрүүгийн хэргийн талаар хуульд заасан үндэслэл, журмын дагуу прокурорын зөвшөөрлөөр явуулсан гүйцэтгэх ажлын шугамаар авагдсан баримт сэлтийг нотлох баримтын хэмжээнд үнэлж болох ба ингэхдээ нотлох баримт цуглуулах, бэхжүүлэх үйл ажиллагааны эх сурвалжийг нууцална” гэж заасан энэ ерөнхий заалтыг цаашид нарийвчлан зохицуулж гүйцэтгэх ажлын шугамаар авагдсан нотлох баримтуудыг хавтаст хэрэгт баримтжуулах журмыг тодорхой болгох зайлшгүй шаардлага бий болно.

Үүнээс гадна мэдээллийн нууцыг хадгалах, авлигын гэмт хэргийн талаар мэдээлэл өгсөн этгээд, гэрч шинжээч, хохирогчийн аюулгүй байдлыг хангах, уг гэмт хэргийн улмаас материаллаг болон материаллаг бус хэлбэрээр хохирсон бусад этгээдийн хохирлыг бүрэн хэмжээгээр нөхөн гаргуулах, хувь хүнээс гадна хуулийн этгээд авлигын төлөө хариуцлага хүлээх зэрэг Авлигын эсрэг НҮБ-ын конвенцид заасан тодорхой асуудлуудыг өөрийн хууль тогтоомждоо суулгаж, эрх зүйн зохицуулалт хийх шаардлагатай.

Авлигын үзэгдлийг таслан зогсооход зөвхөн хэргийг мөрдөж шалгах ажиллагааг урьдал болгох бус харин түүнээс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагаанд түлхүү анхаарч, авлигын тохиолдол бүрийг мэдээлдэг эрүүл тогтолцоог нийгэмд бий болгох нь юу юунаас чухал.

Үүний тулд хамгийн түрүүнд хийх ёстой зүйл нь хууль эрх зүйн орчныг өөрчлөхөөс эхлэх ёстой бөгөөд хээл хахууль өгсөн этгээд өөрийгөө сайн дураараа илчлэн ирсэн тохиолдолд эрүүгийн хариуцлагаас чөлөөлдөг байх урамшууллын тогтолцоог хэрэглэхгүйгээр амжилт гарах боломжгүй учир шинэ хуулийн төсөлд энэ талаар тусгасан байгаа нь сайшаалтай.

Улс орны хэмжээнд авлигатай хийх тэмцэл нь зөвхөн АТГ, шүүх, прокурорын байгууллагын үйл ажилагаагаар хязгаарлах боломжгүй нь ойлгомжтой бөгөөд авлигатай тэмцэх ажлыг тодорхой үр дүнд хүргэх нөхцөлийг бүрдүүлэхэд нийт төрийн болон иргэний нийгмийн байгууллагуудын хамтын ажиллагаа, хүчин чармайлт чухал бөгөөд ялангуяа авлигатай тэмцэх явдлыг бүхий л талаар хөхүүлэн дэмжих төрийн бодлогыг цаашид улам боловсронгуй болгох шаардлагатай.

5.4. АВЛИГЫН ГЭМТ ХЭРГИЙГ ШҮҮН ТАСЛАХ АЖИЛЛАГААНЫ ОНЦЛОГ

Шүүхийн хараат бус байдал, авлигын эсрэг тэмцэл дэх түүний шийдвэрлэх үүргийг санан, оролцогч улс бүр эрх зүйн тогтолцооныхоо тулгуур зарчимд нийцүүлэн, шүүхийн хараат бус байдалд хохирол учруулахгүйгээр шүүхийн байгууллагад ажиллагсдын шударга байдлыг бэхжүүлэх, тэдгээрийн дунд авлигад автагдах боломж бий болохоос урьдчилан сэргийлэх арга хэмжээ авна.

Эдгээр арга хэмжээ нь шүүхийн байгууллагад ажиллагсдын үйл ажиллагааны дүрмийг багтааж болно. Адил үр нөлөөтэй арга хэмжээг шүүхийн тогтолцоонд хамрагддаггүй атлаа шүүхийн байгууллагатай адил

хараат бус байдалтай прокурорын байгууллага бүхий оролцогч улсын прокурорын байгууллагад нэвтрүүлж, хэрэглэж болно.

Монголд Прокурор нь зөвхөн яллах чиг үүргийг хэрэгжүүлээд зогсохгүй хэрэг бүртгэлт, мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавьж, шүүхийн өмнөх процесст удирдан чиглүүлэгчийн үүрэг гүйцэтгэдэг атал шүүх хуралдааны үед адил эрхтэй мэтгэлцэгч талын нэг нь болдог нь тэнцвэргүй байдлыг үүсгэж байна.

Процесс гэдэг нь /procedure/ буюу латины хөдлөх, ахих гэсэн утгыг илэрхийлдэг. Эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаа нь хуулинд тодорхойлон заагласан олон үе шат, хэсгүүдийг туулж гарсаны эцэст хэргийг шийдвэрлэх боломжтой болдог.

Прокурор нь ЭБШ ажиллагааны хөдөлгөгч хүч бөгөөд бүхий л үе шатанд тасралтгүй оролцдог цорын ганц субъект юм.

Монгол Улсын Үндсэн хуулийн 56 дугаар зүйлд зааснаар Прокурор нь хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавьж, төрийн нэрийн өмнөөс шүүх хуралдаанд улсын яллагчаар оролцох үндсэн 4 чиг үүрэгтэй байгууллага юм. Прокурор шүүх хуралдаанд улсын яллагчаар оролцож, нотлох баримтыг шинжлэх, шүүх хуралдааны явцад гарсан асуудлын талаар санал гаргах, шүүгдэгчид ял оногдуулахад баримтлах Эрүүгийн хуулийн зүйл, хэсэг, ялын төрөл, хэмжээ, хорих ял эдлүүлэх дэглэмийн болон бусад асуудлын талаархи дүгнэлтээ шүүхэд гаргана.

Шүүн таслах ажиллагаанд прокурор улсын яллагчаар оролцоно, Прокурор нь шүүгдэгчийн гэм бурууг шүүхийн өмнө нотлох баримтаар батлаж, ямар төрөл, хэмжээний ял оногдуулах талаар саналаа гаргана. Хэрэв прокурор яллахаас татгалзвал уг хэргийг шүүх хэрэгсэхгүй болгодог ба шүүхэд хэрэг хэлэлцэх ажиллагаа зөвхөн Прокуророос шүүхэд шилжүүлсэн яллах дүгнэлтийн хүрээнд л явагдана.

Шүүхийн өмнөх шатанд Прокурор өргөн эрхийг эдлэж байгаа бөгөөд таслан сэргийлэх арга хэмжээ авах, хэргийг хэрэгсэхгүй болгох, түдгэлзүүлэх зэрэг эрхийг зөвхөн прокурор эдэлдэг бол хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч нь зөвхөн санал гаргах эрхтэй байна.

Монголд ихэвчлэн хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтанд хяналт тавьж байсан прокурор тухайн хэрэгт яллах дүгнэлт үйлдэн шүүх хуралдаандаа өөрөө улсын яллагчаар оролцдог.

Монголын ЭБШ хуульд мэтгэлцэх зарчмыг тусгасан боловч бодит байдал дээр мэтгэлцээн сонгодог утгаараа хэрэгжихгүй байгаа. Өөрөөр хэлбэл шүүхийн өмнөх яллагдагч болон түүний өмгөөлөгчийн эрхийг хязгаарлаж хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт дуусах хүртэл хавтаст хэрэгтэй танилцах ч эрхгүй, зөвхөн хүсэлт, гомдол гаргах эрхтэй байдаг бол прокурор өөрийн үзэмжээр мөрдөн байцаалтыг чиглүүлэх, хэргийг явцын дунд нь татаж хянах, даалгавар өгөх, шаардлагатай бол өөрөө ч тодорхой ажиллагаа хийдэг.

Мөрдөн байцаалтын ажиллагаанд хэр зэрэг хяналт тавьж, хэргийн нөхцөл байдлыг хэр зэрэг мэдэрч, хавтаст хэрэгт авагдсан нотлох баримтыг хэрхэн судалж, үнэлж чадсанаараа улсын яллагчийн үүргийг чадварлаг

гүйцэтгэж, шүүх хуралдааны мэтгэлцээнд яллах нотлох баримтыг үндэслэлтэй зөв гаргаж, шүүгдэгчид ял, хариуцлага хүлээлгэх нь зайлшгүй юм байна гэсэн итгэл үнэмшлийг шүүхэд төрүүлж чадна.

Прокурор бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ гадны нөлөөнд үл автан гагцхүү хууль, Улсын ерөнхий прокурорын шийдвэрийг удирдлага болгоно.

Шүүн эрх мэдэл нь гэмт хэрэг үйлдсэн этгээдийн гэм бурууг нотлон тогтоож ял шийтгэх /цагаатгах/, засаг төр, хуулийн этгээд, хувь хүний хооронд үүссэн эрх зүйн элдэв маргаан, сөргөлдөөнийг эцэслэн шийдвэрлэж зөрчигдсөн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг сэргээн хангах явдал мөн. Сөргөлдөөнт байдалд хуулийг зөв тайлбарлаж, шударгаар хэрэглэх нь шүүхийн социал үүрэг юм. Энэ ажлыг бүх төрлийн, бүх шатны шүүх зөвхөн хуульд захирагдан эцэслэн шийдвэрлэдэг.

Чухамхүү эцэслэн шийдвэрлэдэг тэр чанараар нь шүүх эрх мэдлийг шүүх хэрэгжүүлнэ гэж Үндсэн хуульд заасан нь бүгдийг шүүх ганцаар хийдэг гэсэн үг биш бөгөөд элдэв хэрэг, маргааныг үүсэхээс нь өмнө эцэслэн шийдвэрлэх хүртэл, их ажил ундардаг. “Гурил хийхийн тулд буудай тарьдаг, буудай ургуулахын тулд газар боловсруулдаг” гэхчлэн яриад байвал нэг ажлын гинжин холбоо цааш үргэлжилнэ. Түүн лугаа адил шүүхээс эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэхийн өмнө хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд хууль ёсыг сахин биелүүлж байгаа эсэхийг хянаж, гажуудлыг арилгуулах зэргийн нарийн түвэгтэй их ажил ундардгийг бид мэднэ.

Шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр үйлчилж эхэлсний дараа түүнийг биелүүлэх (эрүүгийн хэргийн хувьд ял эдлүүлэх) ажиллагааг залгаж түүнд бас хуулийг сахиж байна уу гэж хяналт тавих шаардлага гарна. Тэр бүхнийг прокурор хянаж, “зөвшөөрөл олгож”, “татгалзаж”, “гажуудлыг арилгуулж”, бас шүүхэд “яллаж” буюу “яллагааг дэмжиж байгаагаараа шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэхэд амин чухал бөгөөд үлэмжхэн үүрэг гүйцэтгэж буй хэрэг. Гэхдээ эцсийн шийдвэр гаргадаггүй учир “оролцогчийн” статустай гэсэн үг. Бас прокурорын үйл ажиллагаа өөрөө шүүхийн хяналтад байдаг.

Чухам ийм учраас л шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэхэд оролцогч гээд байгаа бөгөөд яллагчийн хувьд энэ нь шүүх хуралдаанд мэтгэлцэгч тал болон оролцоно гэдгээс хавьгүй өргөн ойлголт билээ.

Прокурор бол харьцангуй бие даасан тогтолцоо мөн боловч эцсийн дүндээ шүүхийн тогтолцоонд түшиглэсэн байгууллага юм. Түүний үндсэн тогтолцоо ямар байх нь шүүхийн тогтолцооноос шууд хамааралтай байна. Монгол Улсын прокурорын байгууллагын тогтолцоо нь УЕПГ, аймаг, нийслэлийн прокурорын газар, сум, сум дундын болон дүүргийн прокурорын газруудаас бүрэлдэж буй нь шүүхийн үндсэн тогтолцоог санагдуулж байгаа биз дээ. Мөн хуульд “дагнасан прокурор байж болно” гэсэн нь дагнасан шүүхийн тухай Үндсэн хуулийн заалттай холбоотой юм. Гагцхүү тэр тогтолцооны зарчмын үндэс нь шүүх шиг тус тусдаа бие даасан бус, доод шатных нь дээд шатныхаа прокурорт шатлан захирагдах төвлөрсөн удирдлагатайд оршино.

Төвлөрөл, хууль ёс, гадны нөлөөнд үл автах энэ гурав бол прокурорын зохион байгуулалт, үйл ажиллагааны тухайлсан зарчим мөн⁹³.

⁹³ www.legalinfo.mn. Прокурорын байгууллагын тухай хууль. 4 дүгээр зүйл.

Прокурорын шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс оролцох” чиг үүргийн агуулгыг зөв тайлбарлаж, зохицуулах явдал нэн чухал. Үндсэн хуульд “Төрийн нэрийн өмнөөс ...” гэсэн нь юутай ч төр нийгмийн хууль ёсны ашиг сонирхлыг илэрхийлж хамгаалах утгатай байна. Эл оролцооны цар хэмжээг Прокурорын байгууллагын тухай хуульд:

1/ Эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх шүүх хуралдаанд Улсын яллагчаар:

2/ Бусад (иргэн, захиргааны зэрэг) төрлийн хэргийг хянан шийдвэрлэхэд хуульд заасан журмын дагуу төрийг төлөөлөн тус тус оролцохоор тодруулан заажээ.

Ялангуяа “мөрдөн байцаалт явуулсан хэргийг хянан шийдвэрлэхэд Улсын яллагч заавал оролцоно” гэсэн нь хэрэв мэтгэлцэх зарчмын үүднээс үзвэл прокурор эрүүгийн хэргийн шүүх хуралдаанд төрийн ашиг сонирхлыг хамгаалагч тал болохыг харуулж байна. Үүгээр шүүгдэгчийн эсрэг сөрөн зогсож буй мэт. Энд л прокурор нийгэм ба хүний эрх, ашиг сонирхлыг хамгаалах эсэхийн зөрчил үүсч байгаа юм. Үүнийг яаж шийдвэрлэх вэ? гэдгийг сайтар судалж зөв голдиролд оруулах хэрэгтэй.

“Төрийн нэрийн өмнөөс “Улсын яллагчаар” гэсэн нь өнгөц бодоход хэдийгээр гэмт явдлаас төр нийгмийн ашиг сонирхлыг хамгаалах шууд хандлагатай боловч нэг талаар яллахын шууд зорилт нь “шүүгдэгчийн гэм бурууг шүүхийн өмнө нотлон тогтоох” явдал мөн гэдэгтэй холбон үзвэл өрөөсгөл талтай биш.

Эрүүгийн шүүх хуралдаанд прокурор оролцоно гэдэг нь нэг ёсондоо тухайн хэргийг мөрдөн шалгах явцад хуулийг хэрхэн биелүүлж байгаад хяналт тавьж зөрчил гажуудал, түүний дотор хүний эрх зөрчигдөхөөс сэргийлсэн ажлынхаа дүнг шүүлгэж дэнслүүлж байна гэсэн үг. Иймд дээр дурьдсан “нотлох үүрэг” нь “буруутгах” “ял шийтгэх” гэсэн ганц талыг барих, урьдчилсан таавартаа итгэх буюу түүнийгээ зүтгүүлэхээс ангид байх ёстой.

Шүүн таслах ажилд аюултай, суудал дор чинь нуусан дэлбэрэх бодис бол таамагтаа итгэх явдал мөн гэж Жан Жак Руссо хэлсэн байдаг. Хуульд “хангалттай” гэж хэлдэг, эргэлзээгүй, нэг нь нөгөөг “гэрчилсэн” нотлох баримтуудын бодит бүрдэл бол гэм бурууг тогтоох хөдөлшгүй, шалгуур бөгөөд прокурор түүнд л тулгуурлаж мэдээжийн үг хэллэг болсон “яллах, цагаатгах, хүндрүүлэх, хөнгөрүүлэх” дөрвөн талаас нь цэгнэж байж ам ангайх учиртай. Ингэж хандвал яллагч гагцхүү хатуу ял ногдуулах, хүндрүүлэх талыг барих юм шиг ойлголт тохирохгүй. Нэгэнт яллагаа нь хуулийн бодлого юм бол нөгөө хоёрыг (цагаатгах, хөнгөрүүлэх) ч бодолцох ёстой.

Прокурорын байгууллагын тухай хуульд шүүгдэгч гэм буруугүй нь шүүх хурал дээр тогтоогдвол прокурор яллахаас татгалзана гэсэн нь сая дурьдсаныг нотлох бөгөөд “Гэм буруугүй нь” тогтоогдсон төдийд ч бус” гэм буруутай нь тогтоогдоогүй” бол яллаж болохгүй. Шүүхэд хэргийг шилжүүлэхийн өмнө мөн үндэслэлээр “хэрэгсэхгүй болгох” эрх бий бөгөөд мэтгэлцэгч талууд (эсрэг сонирхол төлөөлсөн өмгөөлөгчид зэрэг)-ын аль нэг нь “яллах” нөхцөлд шүүгдэгч гэм буруугүй гэж прокурор үзэх ахул “дуугүй”

өнгөрөх үү, эсвэл хүний эрхийг нь хамгаалах уу? гэх маягийн олон асуулт байж болох ба энэ бүгдийг хуульд тодруулах, ганц тал барьсан заалтуудыг эргэж харах хэрэгтэй мэт.

Прокурор бол эрх хэмжээнийхээ хүрээнд хууль ёс сахиулахдаа ёс зүйг чанд баримтлагч байх учиртай. Энэ нь түүний бүрэн эрхийн агуулга чанараас шалтгаална.

Хуулиудад прокурорын бүрэн эрхийг тодорхойлохдоо “хяналт тавих”, “танилцах”, “байцаах”, “шалгаж шийдвэрлэх”, “зөвшөөрөл олгох”, хэнээс ч болов “тайлбар мэдүүлэг гаргуулах” албадан ирүүлэх”, “мөрдөн байцаахад болон шүүхэд шилжүүлэх” зэрэг албадах, засаглах агуулгатай нэр томъёог голчлон хэрэглэсэн байдаг. Тэр бүхэн хүн, түүний хувь заяа хууль ёсны ашиг сонирхолтой шууд холбоотой. Өөрөөр хэлбэл прокурорын үйл ажиллагааны үзүүрт “хавтаст хэрэг” биш хүн тээглэдэг.

Энэ нь прокурор нэн эмзэг, ихээхэн хариуцлагатай, өөрийн бус хүний төлөө ажил эрхэлдгийг илэрхийлж байгаа учир хүмүүст хүн ёсоор хандах явдал хүмүүнлэг ардчилсан төрийн хууль сахиулагчийн ёс зүйн үндсэн шаардлага гэлтэй. “Сэжигтэн, яллагдагч, ялтан” хэмээн прокурорын хяналтын дундуур дамждаг хүн, хохирогч, нэхэмжлэгч, хариуцагч гээд шүүх дээр мэтгэлцэгчид эрх, эрх чөлөө, өөрийн гэсэн ашиг сонирхол, амьдрал, эрмэлзэл, хүн чанар бий.

Хуулиар хоосон сүр далайлгах, “барьж л авбал баалах ёстой” мэт мөсгүйтэх, “надад эрх нь байна” гэж эрдэж дур зоргоор хандах, хувийн сонирхол, таамагт дөргүй хөтлөгдөх, улс төрийн өнгө аясыг дагах зэргийн цээртэй хандлагаас зайлсхийж явбал шударга болно. Эцсийн дүнд зөвхөн хөдөлшгүй нотлох баримт, түүнийг зөв үнэлэх таны чадавхи хоёр л аварна. “Төр нүдтэй” гэдэг нь шударга хууль, мэргэн ухаан хоёрыг зөв авцалдуулж, өнгө бүрийн хэрэг явдлыг олон хуулийн заалтын аль илүү тохирохыг онолын хувьд дүгнэх онцгой чадавхи шүүх эрх мэдлийнхэнд, тэр дундаа төрийн өмнөөс дуугарахад онц чухал нь ойлгомжтой буй за.

ЭБШ хуулийн 17 дугаар зүйлд “шүүн таслах ажиллагааг талуудын эрх тэгш байдал, мэтгэлцээний үндсэн дээр явуулна” гэж заасан. Мэтгэлцэх зарчмын агуулга нь шүүх хөндлөнгийн, ажиглах байр сууринаас хурлыг удирдах, яллах, өмгөөлөх талууд идэвхтэй байр суурьтай оролцох ёстой. Манайд болохоор шүүгч нэн идэвхтэйгээр хурлыг удирдан явуулж, шүүх хуралдааныг нээхээс эхлээд оролцогчдын эрх үүргийг тайлбарлах, өөрсдөө хүссэн үедээ асуулт тавих, үзэл бодлоо илэрхийлэх, нотлох баримтыг шинжлэн судлах, оролцогчдын шүүмжлэлийн үгийг хязгаарлах зэргээр шүүх хуралдааныг явуулж байгаа нь мэтгэлцэх зарчим хэрэгжиж чадахгүй байгааг харуулж байна.

Мэтгэлцэх зарчмыг зөрчиж байгаа нэг заалт нь ЭБШ хуулийн 279.6-р зүйлийн “...Шүүх хуралдааны шүүмжлэлд оролцогчид үг хэлж дууссаны дараа тэд шүүмжлэлд яригдсан зүйлийн талаар тус бүр нэг удаа тайлбар хэлж болох” эрхтэй гэж заасан нь буруу байна. Өөрөөр хэлбэл прокурор, өмгөөлөгч нар нь 2 удаа л үг хэлэх эрхтэй байгаа нь мэтгэлцээнийг бодитой байхад саад учруулж байгаа тул тоогоор хязгаарлах учиргүй. Иймд дээрх заалтыг нэн даруй өөрчлөн найруулах шаардлагатай байна.

Өнөөдөр Монгол Улсад авлигатай тэмцэх асуудалд хойрго хандаж байгаа учир авлигатай тэмцэж байгаа туршлага, түүний дотор баримталж байгаа зарчмын асуудалд анхаарал хандуулах нь зүйтэй. Авлигатай тэмцэх ажлыг зохион байгуулахад дараах зарчмыг баримталж ажиллах нь чухал.

Нэг. Авлигыг хүчээр бүрэн төгс шийдвэрлэх боломжгүй. Харин нийгэм, албан тушаалтнаас төрийн хууль дээдэлсэн шударга үйл ажиллагаа нь авлигын хөрсийг устгах үндэс болгох нь юу юунаас чухал. Авлигыг нэг удаагийн компанит ажлаар хязгаарлаж болохгүй бөгөөд компанит ажил болгоны дараа авлигын илүү сөрөг, аюултай, шинэ эргүүлэг гарч ирдэг байна.

Хоёр. Авлигын эсрэг хөтөлбөр нь иргэний нийгмийн институциудын оролцоотойгоор улс төрийн удирдлагын дээд шатнаас эхлэх хэрэгтэй. Авлигатай хийх тэмцэл нь бүх нийтийг хамарсан, иж бүрэн цогцолбор, байнга тасралтгүй, ард иргэдийн хараа хяналтын дор байж төр засаг, нийгмийн бүхий л хүчин чармайлтыг энэ зүг чиглүүлэхэд илүү үр дүнтэй болно.

Гурав. Авлигатай тэмцэхэд зарцуулсан төр, нийгмийн хөрөнгө нь авлигын гэмт явдлын нийгэмд учруулсан хөрөнгөөс ямагт бага байдаг, авлигатай тэмцэх явцад хүний эрх, эрх чөлөөг хамгаалахын тулд шүүхийн хамгаалалтыг дээд зэргээр хангах нь хамгийн чухалд тооцогддог. Авлигын эсрэг бодлогын хүрээнд дараахь зорилтуудыг шийдвэрлэх ёстой гэж үзэж байна. Үүнд:

- Авлигатай тэмцэх тэмцлийг бүх шатанд зэрэг эхлэж, өрнүүлэх;
- Авлигад таатай нөлөө үзүүлж байгаа тэр орчин, хүнд суртал, нөхцөл байдлуудыг юуны өмнө өөрчлөх;
- Авлигын хэлцэлд оролцож байгаа талуудын ашиг орлогыг бууруулах;
- Авлигын үйл ажиллагааг илрүүлэх, ял шийтгэл хүлээх магадлалыг нэмэгдүүлэх;
- Авлигын сэдэлтэнд нөлөөлөх, авлигад дургүйцэх нийгмийн уур амьсгалын орчин бүрдүүлэх;
- Авлигатай тэмцэх явцад хүний эрх, эрх чөлөөг хамгаалах зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлэх нь зүйтэй.

Манай улс Авлигын эсрэг хууль батлаж холбогдох олон улсын гэрээ, конвенцэд нэгдэн орсон, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг баталсан, АТГ байгуулсан зэрэг олон үр нөлөөтэй арга хэмжээ авч байгаа боловч авлигын түвшин төдийлөн буурахгүй байгаа нь нууц биш.

Иймээс авлигын эсрэг эрх зүй, зохион байгуулалт, санхүүгийн арга хэрэгслийг улам боловсронгуй болгох асуудал чухлаар тавигдаж байгаа бөгөөд авлигатай тэмцэхэд хүний эрх, эрх чөлөө ноцтой зөрчигдөхөөс хамгаалах, гэм бурууг зөв тогтоож, шударга ял зэмлэл хүлээлгэх үүрэг шүүх эрх мэдлийн байгууллагуудад оногдож байна.

Орчин үед шүүхийг авлигын эсрэг ажиллагаанаас хамгаалахад төр дараах 2 чиглэлийг баримтлах нь зүйтэй. Үүнд: 1/ Шүүхийг гадны нөлөө,

сүрдүүлэлтээс хамгаалах; 2/ Авлигатай тэмцэх, энэ явцад хүний эрх, эрх чөлөөг хамгаалах шүүхийн байгууллагын бүтэц, чадавхийг дээд зэргээр ашиглах явдал юм.

Нэгдүгээрт: шүүхийг авлигаас хамгаалах явдал хамгийн тулгамдсан асуудал болж байна. Доктор, профессор Б. Чимэд "...Ардчилал өөрийгөө хамгаалах чадвартай, тийм зэмсэгтэй байх ёстой. Элдэв явуулгаас ардчилал, ардчилсан тогтолцоог хамгаалах араа шүдэт арслан нь бие даасан, хараат бус, шударга шүүх юм"⁹⁴ гэжээ.

Ардчиллыг хамгаалах зэвсгийн хувьд шүүхийн хараат бус байдлыг хангах, зөвхөн хуульд захирагдах зарчмаар л хэрэгжинэ. Өнөөгийн шүүхийн тогтолцоо нь засгийн ижил төвшиний нөгөө хоёр салаанаас /УИХ болон Засгийн газар/ үлэмж хоцорч байгаа нь нууц биш бөгөөд шүүхийн бие даасан байдлыг хангах, шүүгчдийн цалин хангамжийг нэмэгдүүлэх талаар ШЕЗ-с тодорхой алхамуудыг хийж байгаа нь сайшаалтай.

Орчин цагт Дани, Швед, Финлянд зэрэг улсуудын шүүхийн тогтолцоо авлигад хамгийн баг өртдөг гэсэн судалгаа гарсан, тухайлбал, Дани улсын иргэдээс авсан судалгаагаар оролцогчдын 81 хувь нь шүүх эрх мэдлийн байгууллагуудад авлига огт байхгүй гэж үзсэн байна. Гэтэл Монголд шүүхийн тогтолцоо шударга бус гэж иргэдийн 76 хувь үзсэн⁹⁵ шинжээчдийн дүгнэлтээр шүүх авлигын түвшингээр эхний 5 байгууллагын нэгд тогтмол шалгарч байгаа нь авлигатай хийх тэмцэл ямар их тулгамдаж байгааг бэлхэнээ харуулна.

Дээр дурьдагдсан орнуудын туршлагаас үзэхэд шүүгч хараат бус байх хамгийн гол үндэс нь хууль зүй, нийгэм, эдийн засаг, аюулгүй байдлын баталгаагаар найдвартай хангагдсан явдал байна. Өнөө үед хэргийн зарим оролцогчид, албан тушаалтан, тэдний өмгөөлөгчид шүүх, шүүгчийн шийдвэрт нөлөөлөх, хууль бус шийдвэр гаргуулахын тулд танил тал харах, зарим хууль бус арга хэрэгсэл хэрэглэж байгааг үгүйсгэх боломжгүй.

Тухайлбал, хээл хахууль өгөхийг оролдох, янз бүрийн эд материалын болон бусад үйлчилгээ үзүүлэхийг санал болгох, найз нөхөд, хамаатан садан, танил талаар дамжуулан дарамт шахалт үзүүлэх, шүүгчийн амин хувийн болон бусад эмзэг мэдээллийг захиалгаар, нийтэд задруулахаар айлган сүрдүүлэх, худал гүтгэх, нэр төрийг нь гутаах, хэрэг шийдвэрлэх ажиллагаанд зориуд саад учруулж, сунжруулж, шүүхийн бүхий л шийдвэр, үйл ажиллагааг үл хүндэтгэн, гомдол гаргах зэргийг дурьдаж болно.

Гадаад улс оронд гэмт бүлэглэлийн хамгийн аюултай хэлбэр нь "авлигад автагдсан шүүгч", түүний халаасны өмгөөлөгчийг хамтад нь элсүүлэх явдал гэж үзэж түүнээс урьдчилан сэргийлэх бүхий л арга хэмжээг авч хэрэгжүүлж байна. Иймд шүүхээс авлигатай тэмцэх нэг нөхцөл бол шүүхийн хараат бус байдлыг хангахад гол ач холбогдол өгөх ёстой.

Хоёрдугаарт: авлигатай тэмцэх ажиллагаанд тагнуулын ба гүйцэтгэх ажлын эрэн сурвалжлах ажиллагааг ашиглах нь зайлшгүйг дээр тэмдэглэсэн.

Хөгжингүй орнуудын практикаас харахад Үндсэн хуулиар хамгаалагдсан

⁹⁴ "Авлигагүй нийгэм-тогтвортой хөгжлийн гарц" үндэсний бага хуралд тавьсан илтгэл. 2007.06.04

⁹⁵ Азийн сан. Авлигын талаарх олон нийтийн ойлголт, мэдлэг тогтоох судалгаа. 2013 оны 09 сар.

хүний эрх, эрх чөлөөг хязгаарлахад ихэнх тохиолдолд шүүхээс энэ асуудал дээр зөвшөөрөл өгч хянадаг ба үүний үр дүнд хүний эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхол шүүхийн хамгаалалтанд орох боломжтой гэж үздэг.

Мөн авлигатай тэмцэж байгаа эрх бүхий этгээдүүдээс гадна тухайн хэргийг шүүн таслаж байгаа шүүгчдийн аюулгүй байдлыг хангах асуудал чухлаар тавигдах ёстой. Түүнээс гадна гэрч, хохирогч, мэдээлэгчдийн аюулгүй байдлыг хангах, гэмт этгээдүүдээс өөрийн бурууг хүлээж хуулийн байгууллагатай хамтран ажилласан тохиолдолд тухайн этгээдийн ял шийтгэлийн хөнгөрүүлэх, ялаас чөлөөлөх асуудлыг зайлшгүй хөндөх ёстой.

Авлигатай тэмцэх ажилд иргэдийг өргөнөөр татан оролцуулах, олон нийтийн хяналтыг дээд зэргээр хангах, иргэдийн өргөдөл, гомдол, санал хүсэлтийг хүлээн авах, шалгах, хариу өгөх тогтолцоог бий болгох, энэ ажилд хуулийн байгууллагуудын ахмадын хороод чухал үүрэгтэйг анхаарлын гадна үлдээх учиргүй. Мөн итгэлийн утас, олон нийтийн хүлээн авах байр, өргөдөл, гомдол, мэдээлэл авах тогтолцоог цоо шинээр бий болгох шаардлагатай.

Авлигатай тэмцэх үндсэн зорилтын нэг бол төрийн удирдлагын үр нөлөөг дээшлүүлэх, төрийн үйлчилгээг иргэдэд ойртуулах, төрийн мэдээллийг олон нийтэд хүртээмжтэй болгох, төрийн албан хаагчдын ёс зүйн хатуу дэглэм тогтоох, нөгөө талаас албан тушаалтны гүйцэтгэвэл зохих үүрэг, тэдгээрийн бодит үйл ажиллагааны зөрөөг ихэсгэж, авлигын гол үндэс суурь нь болсон ашиг сонирхлын сөргөлдөөнийг арилгах явдал байдаг.

5.5. АВЛИГЫН ХЭРГИЙГ МӨРДӨН ШАЛГАХ, ТҮҮНД ПРОКУРОРЫН ХЯНАЛТ ТАВИХ ҮР ДҮНТЭЙ АРГА ХЭРЭГСЭЛ ⁹⁶

Мөрдөн байцаагч хээл хахуулийн хэргийн мөрдөн шалгалтыг дэмжихийн тулд юу хийх хэрэгтэй вэ?

1. Худалдааны бүртгэл, Хөрөнгийн биржийн талаарх компаний албан ёсны бүх мэдээллийг олж авах

2. Хангалттай хугацаанд зохион байгуулагдаж төлөвлөгдсөн төлөвлөгөөг олж авах

- Худалдаа /маркетингийн тасгийн байрлал/
- Тухайн асуудлыг шийдвэрлэх хугацааны туршид гарсан, уг асуудлын хүрээнд хамаарах компани дахь ажлын тодорхойлолт, хариуцлага болон гүйцэтгэх хүчин чадал
- Компаний хариуцлага.

Ялангуяа сэжигтний банкны баталгааг гаргах /компанийг оролцуулан/

- Маркетингийн тасгаас боломжит хувилбараар гаргасан худалдааны гэрээ, хэлэлцээр байгуулах

⁹⁶ www. corruption index.com. Финляндын мөрдөн шалгах Үндэсний товчоо, Финляндын цагдаагийн хэлтэс, Мөрдөн байцаах хэлтсийн дарга Жуузо Ойлинки

- Их хэмжээний худалдааны орлого болон их хэмжээний маркетингийн зардлыг эрүүл бус ажлын арга гэж тооцох
- Бизнесийн дүн шинжилгээ
- Компаний маркетингийн худалдааны зардлууд нь хэр тэнцүү байгааг тооцох.

Данс тооцоог авах, хураах - Тусгай мөрдөн байцаагч эсхүл нягтлан бодогч

- Маркетингийн зардлыг оруулан тооцсон ач холбогдолтой зөвлөгөөний төлбөрийг илтгэх баримтыг мөрдөн байцаагч олж авах замаар маркетингийн тасгийн бүхий л баримтуудыг шалгах.

Данс тооцоонд мөрдөн шалгах ажиллагааг үргэлжлүүлэх

- Худалдааны болон маркетингийн албан хаагчдын гүйцэтгэлд доорхи зардлуудыг онцгойлон тусгадаг:

- o Илгээсэн урилга

- o Данс тооцоонд оруулсан зочид буудлын төлбөр, машин зогсоолын газрын төлбөр, өдрийн хоолны баримт, онгоцны билет эсхүл автобусны билетны төлбөр

- Сайн нотлох баримтаар нотлох боломжтой төлөөлөгчид болон бусад сэжигтнүүдийн баримтуудыг шалгах
- Санхүүгийн гэмт хэрэгт дүн шинжилгээ хийх.

Компаниуд хэзээ зуучлагч, төлөөлөгчдийг ашигладаг болохыг харгалзан үзэх

- Олонх компанийн нээлттэй тайланд компаниуд эсхүл хувь хүмүүсийн аль алиных нь ашигласан төлөөлөгчдийн нөхцөл байдал тодорхой тусгагдсан байдаг.
- Зуучлалын гэрээн дэх огноо болон талууд нь сэжигтэн байх боломжтой этгээдийг болон талуудын боловсруулсан мэдээллийг мэдэхэд туслаж болох юм.
- Зарим тохиолдолд нэг ажил дээр нэг төлөөлөгчтэй 2 гэрээ боловсруулсан байдаг. Нэг нь нээлттэй, нөгөө нь нууц гэрээ байдаг. Нууц гэрээ байгуулах шалтгаан нь тухайн төлөөлөх ажилд үйлчлүүлэгчийн төлөөлөгч эсхүл мөнгийг нууцлах зорилготой юм.
- Гэрээний хугацааг хойшлуулах.

Төлөөлөгч ашиглаж байгааг илтгэх тэмдгүүд:

- Компани төлөөллийн харилцааг нууцалж байх
- Төлөөлөгч бүтээгдэхүүний улсад үйл ажиллагаа явуулахгүй, гуравдагч улсад явуулж байх
- Төлөөлөгч бусад компаниас төлсөн төлбөрийг шаардах
- Төлөөлөгчийн төлбөр нь харьцангуй өндөр байх

- Төлөөлөгчийн төлбөрийн талаар албан ёсны бичилт байхгүй эсхүл төлбөрийн хэмжээ нь маш бага байх. Жишээ нь: сар бүрийн төлбөр г.м /хээл хахуульд тооцогдох бодит төлбөрийг нууц гэрээнд тусгадаг/.

Мөрдөн шалгах хамтын баг гэж юу вэ?

- Хууль хэрэгжүүлэх эрх бүхий албан тушаалтанууд /цагдаа, гааль, хилийн хамгаалалт/ нь өөр улсын эрх бүхий албан тушаалтнуудтай хамтарч тусгай хэргүүд дээр мөрдөн шалгах ажиллагааг хийж эхэлсэн;
- Энэ нь шүүхийн өмнөх шатны мөрдөн шалгах ажиллагаанд хамтран ажиллах явдлыг дээшлүүлэх, олон улсын байгууллагуудын хамтын ажиллагааг дэмжих болон цөөн тооны улс орнуудад нөлөөлж буй гэмт хэргийг хил дамнан илрүүлэх зорилготой;
- Мөрдөн байцаах баг хамтран ажиллах дүрэм нь зөвхөн Европын улс орнуудаар хязгаарлагдахгүй, гуравдагч улс орнуудад хандсанаар хэрэгжих боломжтой.

Хэзээ хамтын багийг бүрдүүлэх вэ?

- Бусад улс орнууд мөрдөн шалгах нийтлэг сонирхолтой байгаа эсэх;
- Хамтын ажиллагаа явуулах эсхүл нэгээс дээш улс орны нутаг дэвсгэр дээр үйлдэгдсэн мөрдөн шалгахыг шаардаж буй бусад ноцтой эрүүгийн үйлдлүүд;
- Дотоодын болон гадаадын боломжтой бол Европол /Европын цагдаагийн байгууллага/ болон Еврожаст /Европын шүүхийн байгууллага/-ыг хамааруулан мөрдөн шалгалтын хангалттай эх сурвалжийг бүрдүүлэх шаардлагатай болсон бол хамтын багийг бүрдүүлнэ.

Мөрдөн шалгах хамтын багийн үйл ажиллагаа

- Мөрдөн шалгах үйл ажиллагаанд оролцох эрхтэй;
- Байцаагдаж байгаа хүнээс асуулт асуух эрхтэй;
- Байшинд үзлэг хийх;
- Мөрдөн шалгах ажиллагааны дагуу офицерийн зааварчилгаан дор хувийн баримт бичгийг /хулгайлагдсан захидал г.м/ шалгах, унших;
- Офицерийн зааварчилгаан дор мөрдөн шалгах ажиллагааны хяналт болон хуулийн дагуу байцаалт явуулах.

Эхний туршлагууд

- Хуулийн уламжлалт хэлбэрээр хэрэгжүүлэх хамтын ажиллагаанаас зардал багатай;
- Эрүүгийн мөрдөн шалгах ажиллагаанд бодитоор хамтран ажиллах нь илүү хурдан;
- Харилцан үзүүлэх хууль зүйн туслалцаанд шаардлагатай хүсэлтийг

багасгах явдал илүү хурдан;

- Эрүүгийн үйл ажиллагаанд хандсан албадлагын арга хэмжээний хэрэглээ, зохицуулалтыг дөхөм болгосон;
- Гадаадын мөрдөн шалгалтыг үзэж ашиглах боломж илүү амар болсоноор орчуулга, тайлбарлалтын зардал гарахгүй болсон;
- Мөрдөн байцаах хамтын багийг офицерийн дэмжлэгээр хангаснаар ихээхэн ач холбогдолтой байгаа ба илүү мэдээлэлтэй болсон;
- Мөрдөн шалгах хамтын багийн талууд нь уг ажиллагаанд тэгш оролцохыг шаарддаг;
- Мөрдөн шалгах бодит хугацаанд маш сайн хэрэглэгдэхүүн шаардлагатай
- Мөрдөн шалгах хамтын ажиллагааны хэрэгсэлүүдийг /эдийн засгийн үйл ажиллагаа г.м/ авч үзэх шаардлагатай.

АВЛИГЫН ГЭМТ ХЭРГИЙГ ҮР ДҮНТЭЙГЭЭР ИЛРҮҮЛЭХ, МӨРДӨН ШАЛГАХ⁹⁷

Хамгийн их авлигад автсан хэсгүүд

- Нийтийн ханган нийлүүлэх хэсэг, үйлдвэрийн газрууд болон Эрүүл мэндийн салбар

Илрүүлэлт

- Мэдээлэл эсхүл албан ёсны тайлбар;
- Бусад гэмт хэргүүдийн мөрдөн шалгалт;
- Нууц зөвлөгөө;
- Цагдаагийн ажлын мэргэжлийн үйлдэл;
- Хууль сахиулах байгууллагын семинарууд, сургалтууд;
- ТББ/Засгийн газрын агентлагуудын хамтын ажиллагаа;
- Нийтийн мэдээлэл, хэвлэл мэдээллийн хэрэгсэл;
- Шинж тэмдгүүд;
- Үнэлгээ, дүн шинжилгээ;
- Прокурорын байгууллага дахь шийдвэр, тэмдэглэл

Зарим шинж тэмдэг

- Нэгдмэл компани;
- Шаардлагатай тодорхойлолт байхгүй;
- Байгуулсан гэрээнүүд улсын төсөвт орохгүй;

⁹⁷ www.corruptionindex.com. Словени улсын мөрдөн шалгах үндэсний товчоо, Мөрдөн шалгах газрын дарга Ноён Жупе Рус

- Өндөр захиалгатай /данс хуваах/;
- Үнэ өссөн, гуравдагч талын хүсэлтээр төлбөр нэмэгдсэн;
- Үндэслэлгүй шалтгаанаар нэхэмжлэлийг хүлээн зөвшөөрсөн
- Гэрээлэгчийн түр зуурын үйл ажиллагаа
- Сүүлийн сунгалт

Шүүхийн өмнөх шатны мөрдөн шалгалт

Прокуророос явуулсан шүүхээс өмнөх шатны үйл ажиллагаа:

- Хүч хэрэглэх / мөрдөн шалгах хамтын ажиллагааны зорилт/
- Өөрчлөгдсөн эрүүгийн үйл ажиллагааны дүрэм
- Уулзалтын мэдээлэл болон нотлох баримт
- Нээлттэй болон нууц арга хэмжээ
- Байцаалт, банкны мэдээлэл, гадаадад илэрсэн ул мөр, холбоотой /нэгдмэл хувь хүмүүс болон /эсхүл компани, хувьцаа, үл хөдлөх хөрөнгө
- Хяналт, ажиглалт, утсан холбоо, мөнгөний урсгалын хяналт, нэр төдийн худалдах худалдан авах замаар хээл хахууль өгөх /UCO/
- Санхүүгийн мөрдөн шалгалт /эх сурвалжаас гадна шинжээчид.../
- Байршилыг эрэн сурвалжлах, байцаалт
- Дүн шинжилгээ хийх /мэдээлэл, мөнгөний урсгал, утасны бичлэг.../
- Баривчлах, түр зуур үйл ажиллагааг нь зогсоох
- Прокурорын байгууллагын эрүүгийн гэмт хэргийн тайлан.

Хамгаалах арга хэмжээ . Мэдээлэгч / CHIS / UCA= Гэрч

- Эрүүгийн хэргийн материалаас бүх эсхүл тодорхой мэдээллийг устгах
- Албан ёсны нууц бүхий болж өнгөрсөн үйл явдлаас бүх эсхүл зарим мэдээллийг тэмдэглэх
- Хариуцагч, түүний өмгөөлөгч болон хохирогч тал, түүнний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчийн хүслэтийг шийдвэрлэж, тодорхой үйл явдал эсхүл нууц мэдээллийг хадгалах
- Гэрчид хуурамч нэр олгох
- Техникийн тоног төхөөрөмж/хамгаалах шил, дуу хоолой хувиргах тоног төхөөрөмж, тусдаа нөхцөл байдлаас дуу хоолойг шилжүүлэх болон бусад үүнтэй ижил техникийн тоног төхөөрөмжүүд/ ашиглан тангараг өргүүлэх.

**ХҮНИЙ ЭРХИЙН ЕВРОПЫН КОНВЕНЦ: АВЛИГЫН
ГЭМТ ХЭРГИЙН МӨРДӨН ШАЛГАХ СТАНДАРТУУД⁹⁸**

1. Хувийн эрх: Мөрдөн шалгах тусгай аргууд
2. Хууран мэхлэлт
3. Баталгааны дарамт болон хэрэгт холбогдох
4. Нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслийн нөлөө

1. Тусгай мөрдөн шалгах арга болон хүний эрхийн стандартууд
 - Мөрдөн шалгах тусгай арга
 - Харилцаа холбоог тогтоох, сонсох тоног төхөөрөмж, мөшгих тоног төхөөрөмж, биеийн ажиглалт, видео ажиглалт, банкны дансны хяналт, компьютерийн үйл ажиллагааны хяналт гэх мэт.
 - Үйл ажиллагааны дор, дууриамал гэмт хэргүүд
 - Тусгай мөрдөн шалгах арга нь шударга шүүгдэх хүний эрхийг зөрчиж болохгүй. Эдгээр аргыг тодорхой хязгаартай хэрэглэх ёстой.
 - Ардчилсан нийгэмд шударгаар шүүгдэх хүний эрх нь их ач холбогдолтой бөгөөд зохистой байдлын төлөө золиослогдох ёсгүй.

Хуулийн дагуу:

- Хөндлөнгийн оролцоо нь хуульд үндэслэсэн, зөвшөөрөгдхүйц байх
- Тухайн асуудлаар хууль нь хангалттай тодорхой, оновчтой байх
- Зохицуулах дэглэм нь зөвлөлдөх эрх мэдлийн дур зоргын эсрэг баталгаатай хамгаалагдах
- Харилцаа холбоог хянасаны хариуцлагыг хүлээх хүмүүсийн ангиллын тодорхойлолт
- Өсөж байгаа зөрчлийн мөн чанарыг тогтоох
- Хяналтын хугацааг хязгаарлах
- Олж авсан мэдээллийн шалгалт, хэрэглээ болон хадгалалтын үйл ажиллагаа
- Бүрэн бүтэн эмхтгэл болон шүүгч, хамгаалалтын бүрэн бүтэн үзлэг шалгалтыг өгөхөөс сэрэмжлэх
- Үйлдсэн /буруугүй гэж үзсэн үйл явдлын тухай мэдээллийн эмхтгэлийг устгах, алга болгох тухай заалт/
- Бие даасан шүүхийн санамсаргүй байдал
- Хамгаалалтын нягт судалгаа.

Ардчилсан нийгмийн хэрэгцээ:

- Улс нь нийтийн тодорхой ашиг сонирхолд хөндлөнгөөс оролцдог нийгмийн хэрэгцээг хуваарилах хэрэгтэй.

- Зорилгын тодорхой хувьд хөндлөнгөөс оролцох /хуулийн дагуу хүрэх зорилгод хэрэглэхээс илүү байх ёсгүй/
- Хувь хүний эрхийн хамгаалалт болон дараахь нийгмийн ашиг сонирхол нь хоорондоо тэнцвэртэй байх ёстой.
- Холбогдох хангалттай шалтгаанууд нь нууц арга хэмжээг дэмжих явдлыг нэмэгдүүлсэн
- Хязгаарлагдаагүй сонголт нь хүчин төгөлдөр
- Шийдвэр гаргах үйл ажиллагаан дахь шударга үйл ажиллагаа юм
- Зүй бус байдлын эсрэг хангалттай хамгаалалт
- Хөндлөнгийн оролцоо конвенцийн эрхийн мөн чанарыг устгадаг.

2. Зөвшөөрөгдсөн харилцаа холбооноос ангилах

а. Өдөөн хатгалгын бодит шалгуур – Зөрчил нь эрх мэдэл бүхий албан тушаалтнуудын хөндлөнгийн оролцооноос ангид үйлдэгддэг.

Шалтгаан нь нууц үйл ажиллагаа болон эрх мэдэлтнүүдийн харилцаа холбоонд үндэслэдэг. Сэжиглэхийн зорилго нь өргөдөл гаргагч нь эрүүгийн үйл ажиллагаа эсхүл эрүүгийн зөрчил үйлдэх шалтгаан болсонтой хамааруулдаг. Тухайн үед эрх мэдэл бүхий албан тушаалтнууд нууц үйл ажиллагааг илрүүлдэг. Нууц төлөөлөгч нь эрүүгийн үйлдэлтэй холбогдож, түүнийг хатгаж өгдөг. Өргөдөл гаргагч нь зөрчил үйлдэх дарамтанд өртөгдсөн байдаг.

б. Өдөөн хатгалгын мэдэгдлийг харгалзан үзэх ажиллагаа.

Хангалттай хамгаалалт:

Тодорхой журам, горимыг зөрчихгүй байх дараах хангалттай үндэслэл, нөхцөл бүрдсэн тохиолдолд далд буюу нууц арга техник хүлээн зөвшөөрөгдөнө. Үүнд:

1. Зөвшөөрөл
2. Хэрэгжүүлэлт
3. Тухайн асуудлаарх мөрдөн шалгах арга хэмжээний хяналт
3. Баталгааны дарамт болон хэрэгт холбогдох

Шударга шүүгдэх эрх /6-р зүйл/. Үүнд эрүүгийн хэрэг дээр хэрэгт холбогдохоос чөлөөтэй байх эрх хамаарна. Энэ нь туйлын шинжтэй биш – зүй бус албадлагыг хориглоно.

Хэрэв эрхийн мөн чанар нь хохирсон хэн нэгнийг хэрэгт холбогдуулах бол албадлага нь зүй бус байна. Харин эсрэгээрээ энэ эрх нь яллагдагчийг үг хэлээгүйгээс нь болж дангаар нь яллах яллагаанд үндэслэн хэрэгт холбогдуулахгүй. Хамгаалалт хүсэх явдлыг хангасан тайлбарыг тодорхой хэлэх нөхцөл байдлыг тооцоолж үг хэлэхгүй байхаас урьдчилан сэргийлэх шаардлагагүй.

Яллагдагчийн эсрэг “prima facie” зарчмыг баримтлах хэрэгтэй. Яллагдагчийн тайлбар байхгүй тохиолдолд нийтлэг хандлагын дагуу

хөндлөнгөөс оролцож шийдвэрлэдэг.

Яллагдагч нь хамгаалалтын үндэслэлийг хайж байх үед баталгааны дарамт нь яллагдагчид шилждэг. Хэрэв хамгаалалтын эрхийг ажиглах, хэвээр үлдээхийн ач холбогдлыг тооцоолж шалтгаан бүхий хязгаарлалтыг хоривол үйл явдлын таамаглал болон хууль нь яллагдагчийн эсрэг хэрэглэгддэг.

4. Нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслийн нөлөө

Тодорхой хэргүүддээр хортой шахалтын үйл ажиллагаа нь олон нийтийн санаа бодол болон яллагдагчийг буруутай гэж шийдсэн тангарагтаны шүүгч нарын нэрсийн дараалал зэргээс шалтгаалан шүүхийн шударга байдалд сөргөөр нөлөөлдөг.

Хэрэв шүүхээс тогтоогоогүй байхад хэн нэгнийг эрүүгийн хэрэг үйлдсэн гэж зарлавал нийтийн зүгээс 6.2-р зүйлийг зөрчсөн гэж үзнэ. Мэдээж хэрэг энэ бол арга биш, эрүүгийн мөрдөн шалгалтын талаар эрх мэдэл бүхий албан тушаалтанууд нь нийтэд мэдээлэхгүй. Хэрэв тухайн хүмүүс баривчлагдсан, гэмээ хүлээсэн гэх мэтээр тэдэнд сэжиг төрсөн байвал 6.2-р зүйлийг зөрчсөн гэж үзэхгүй. Гэхдээ хэн нэгнийг буруутай гэсэн албан ёсны зарлал нь үүнд хамаарахгүй.

Тухайн хүнийг буруутай гэсэн зарлал нь эхлээд нийтэд тухайн хүнийг буруутай гэсэн итгэлийг төрүүлдэг бөгөөд хоёрдугаарт шүүхийн эрх мэдэл бүхий албан тушаалтануудын эрх мэдлийн үйл ажиллагаанд урьдчилан үнэлгээ өгч эхлэдэг.

МӨРДӨН ШАЛГАХ ХАМТЫН БАГ: АВЛИГЫН ГЭМТ ХЭРГИЙГ МӨРДӨН ШАЛГАХ АМЖИЛТТАЙ АРГА ХЭРЭГСЛҮҮД

Албани улсын Ерөнхий Прокурорын газар, Тирана дахь мөрдөн шалгах хамтын хэсгийн дарга Ноён Дритан Ррешка

Зорилго:

- Авлигын гэмт хэргийг хамтран илрүүлэх ялгаатай хууль хэрэгжүүлэх төлөөлөгч нарын хоорондын хамтын ажиллагааг нэмэгдүүлэх
- Илрүүлсэн болон мөрдөн шалгасан санхүүгийн гэмт хэрэг, авлигын хэргүүдийн тоог нэмэгдүүлэх
- Мөрдөн шалгах болон яллах ажиллагааны чанарыг дээшлүүлэх
- Мөрдөн шалгасан болон ялагдсан хариуцагчийн тоог нэмэгдүүлэх
- Хөрөнгө нь хураагдаж байгаа болон хураагдсан үйл ажиллагаа явуулах гэмт хэргүүдийн тоог нэмэгдүүлэх.

Мөрдөн шалгах хамтын хэсгийн гишүүдийг шинээр элсүүлэн авах:

- Хүний хүчин зүйл – маш чухал /Хамгийн сайн хуулиудтай байх ёстой. Гэхдээ илүү чухал нь хамгийн сайн хүмүүстэй байх ёстой./
- Санхүүгийн гэмт хэрэг болон авлигын гэмт хэргийг мөрдөн шалгах, яллах туршлага бүхий прокурорууд, шүүхийн цагдаагийн ажилтнууд

- Өндөр боловсрол, ёс суртахуун, ёс зүйтэй хүмүүс /тэдгээр нь бүгд эмнэлгийн бүрэн шинжилгээнд орсон байх/
- Ихэнхидээ шүүгчийн сургуулиас ирсэн прокурорууд /тэдгээрийн зарим нь эдийн засгийн бакалавр/

Мөрдөн шалгах хамтын хэсгийн мөрдөн шалгалтын онцлог шинж:

- Мөрдөн шалгах тусгай аргын хэрэглээг өргөжүүлсэн /электрон ажиглалт, чагнах хэрэгсэл, ажиглалт, нууц үйл ажиллагаа, хариуцагчийн хамтын ажиллагаа гэх мэт/
- Мөрдөн шалгах post-factum зарчимаас илүү мэргэжлийн үйлдэл хэрэглэх
- Ерөнхий авлигын хэрэг дээр SIS болон FIU хоёулангаас нь нууц мэдээлэл олж авах /нууц мэдээлэгчээс цагдаагийн мэдээлэл рүү мэдээлэл шилжүүлэх/
- Мөрдөн шалгах эхний үе шатуудад хийх прокурорын тохиролцоо
- Нийтэд мэдээлэл өгөх хэвлэл мэдээллийн хэрэгслийн хамтын ажиллагаа

Бэрхшээл:

- Улс төрийн мөрдөн шалгах ажиллагаанд нөлөөлөх гэсэн дарамт /хүчин чармайлт
- Ерөнхий Прокурорын байгууллага болон Мөрдөн шалгах хамтын хэсэгт чиглэсэн улс төрийн дэмжлэг
- Авлигын хохирогчийн хамгаалалт, халдашгүй байдлаа олж авах хэрэгцээ
- Халдашгүй асуудал буюу улс төрийн болон өндөр зэрэглэлийн авлигын халдашгүй байдлыг алга болгох хэрэгцээ
- Прокурор болон санхүүгийн гэмт хэрэг, авлигын гэмт хэргийг шийдвэрлэх шүүгчийн сургалтын хэрэгцээ
- Хууль хэрэгжүүлэх итгэл нэмэгдүүлэх хэвлэл мэдээллийн хэрэгсэл, нийтийн болон ТББ-ын хамтын ажиллагааг илүү ойр болгох.

АВЛИГЫН ГЭМТ ХЭРГИЙГ МӨРДӨН ШАЛГАХ АЖИЛЛАГАА: THE BADEN WURTTENBERG /ГЕРМАНЫ/ ЖИШЭЭ

Германы эдийн засгийн гэмт хэргийн тасгийн Фрейбург дахь прокурорын байгууллагын прокурор Рэйнер Хорнунг

1. Авлигын гэмт хэргийг шийдвэрлэх, мөрдөн шалгах Baden Wurttemberg-ийн жишээ

А.Шүүхийн болон цагдаагийн байгууллага

1)Өндөр түвшний авлигын тусгайлсан шүүх ажиллагаа

Германы Авлигатай тэмцэх процессийн бичгэн хэлбэртэй хуулийн

нэг онцлог нь бодитоор оршдоггүй явдал юм. Шүүхийн үйл ажиллагааны актын 74-р хэсгийн 1-ийн 5, 6-р заалтад нэг зохицуулалт байдаг ба Baden Wurttemberg-ийн 17 дүүргийн шүүхээс Маннхейм болон Стутгарт дахь 2 шүүхэд л өндөр түвшний авлигын хэргийг шийдвэрлэсэн.

2)Авлигын гэмт хэргийг мөрдөн шалгах нийтлэг шүүх ажиллагаа. Бусад 15 Прокурорын байгууллага бүр нь эдийн засгийн гэмт хэргийг хариуцдаг тусгайлсан прокурортой бөгөөд эдийн засгийн гэмт хэргийн тасагт бүр илүү олон прокурор ажилладаг. Сар бүр эдгээр прокурор нь дунджаар эдийн засгийн гэмт хэргийн 35-40 шинэ материал хүлээж авдаг.

3)Авлигын хэргийг мөрдөн шалгах эрүүгийн хэлтэс

Орон нутгийн мөрдөн шалгах хэлтэс бүрт тусгайлсан эдийн засгийн гэмт хэргийн мөрдөн байцаагч байдаг ба Германы мөрдөн шалгах холбооны товчоо нь өндөр түвшний авлигын гэмт хэрэгтэй тэмцэхэд харьцангуй үүрэг багатай оролцдог.

B.Baden Wurttemberg-ийн ердийн авлигын гэмт хэргийг мөрдөн шалгах ажиллагаа

1.Мөрдөн шалгах эхний ажиллагаа - Германд прокурорын байгууллагад материал нь бүрэн эхээрээ ирэхээс өмнө нийтлэг эрүүгийн зөрчлийн ихэнхи төрлүүдийг цагдаа хэдэн долоо эсхүл хэдэн сарын туршид мөрдөн шалгадаг. Гэхдээ цагдаагийн байгууллагад биш Прокурорын байгууллагад авлигын гэмт хэрэг нь шалгагдаж эхлэдэг. Германы эрүүгийн мөрдөн шалгах ажиллагааны арга нь зөрчлийг мөрдөн шалгах заавал биелэгдэх шинжтэй зарчмын дагуу явагддаг.

2.Батлагдсан эхний сэжгийг мөрдөн шалгах арга хэмжээ – Хэрэв урьдчилан шалгах ажиллагаанд илэрсэн үндэслэл бүхий сэжиг байвал эсхүл гомдол гаргагчийн мэдээлэл нь нарийвчилсан, үндэслэлтэй байвал мөрдөн байцаагчийн хамгийн эхэнд хийх ажил бол шүүгчээс сэжигтэн /авлига өгөгч, авагч/, авлига өгөгчийн ажилладаг байгууллага, авлига авагчийн ажилладаг байгууллагын удирдлага зэргийг хайж, оршин байгаа газраасаа явахгүй гэсэн баталгаа гаргуулж авах зөвшөөрөл авах, сэжигтэний дансны мэдээллийг банкнаас авах явдал юм.

3.Авлигын гэмт хэргийн материал болон нөхцөл байдлын нотлох баримтын ач холбогдол – Авлигын гэмт хэргийн мөрдөн шалгах ажиллагаа бүрт тулгарах томоохон асуудал нь авлига өгөгч болон олон нийтийн алба хоорондын ёс суртахуунгүй үйл баримтыг батлах явдал байдаг. Хэрэгтэй гэрчийг олоход хүндрэлтэй байдаг нь холбогдох гэрчүүд нь эрх мэдэл бүхий албан тушаалтануудтай холбоотой байдаг тул ирээдүйн мэргэжлийн амьдралд нь муу зүйл тохиолдох вий гэхээс айдагтай холбоотой юм.

4.Авлигын хэрэг дээр тулгасан ялын төлөвлөгөө – Германы эрүүгийн шүүхийн тогтолцооны байдал. Германы прокурорын байгууллага нь Авлигын хэргийн тодорхой хувьд ял оноодог.

2.Авлигын гэмт хэргийн талбар дээрх томоохон эрүүгийн зөрчлүүдийн хууль зүйн тодорхойлолтууд

А. 2 онцгой дүрэм: Парламентын болон олон нийтийн бус байгууллагын

хээл хахууль

1. Парламентын гишүүдийн хээл хахууль – Хээл хахуулийн болон авлигын ерөнхий дүрэм нь хэрэглэж болохуйц биш байдаг. Учир нь Германы гэмт хэргийн хуульд нийтийн байгууллага болон парламентын буюу захиргааны байгууллагыг ялгаатайгаар хуульчилсан байдаг. Европын зөвлөл нь Германыг парламентын гишүүдийн хээл хахууль авсан гэмт хэргийн зохицуулалтыг хангалттай бус гэж шүүмжилсэн. Европын залуу гишүүдийн зөвлөл нь энэ талбар дээр илүү үр дүнтэй дүрмийг батладаг.

2. Нийтийн бус байгууллагын хээл хахууль – Үүнийг зохицуулсан зохицуулалт нь дараахь 2 харилцан үйлчлэл үзүүлдэг. Үүнд нь: Нийтийн дэд бүтцийн ач холбогдолтой хэсгийг хувьчлах үйл ажиллагааг үргэлжлүүлэх, нийтийн тендерийн үйл ажиллагаа явуулаагүйгээс хохирсон оролцогч нарыг илрүүлэх. Нийтийн бус байгууллагын ажилтан нь гуравдагч этгээдээс бусад өрсөлдөгчдөөс илүү давуу тал бий болгохын тулд ашиг хүлээж авсанаар торгуулах болон гурван жилээс дээш хугацаагаар хоригдох эрсдэл хүлээдэг.

В. Хээл хахууль болон авлига өгөх, авах

1. Нийтийн албан хаагчдын тухай ойлголт – Германы эрүүгийн хуулийн ерөнхий хэсгийн 11.1.2-т нийтийн байгууллага гэдэг нь иргэний үйлчилгээ болон шүүгчээс томилогддоггүй боловч тэдгээр нь аливаа арга замаар нийтийн захиргааны үйл ажиллагаа явуулдаг хүмүүс юм.

2. Хээл хахууль болон авлига – Олонхи бусад үндэсний хууль зүйн тогтолцоо болон Германы хуулинд хээл хахууль болон авлига өгч, авсан гэмт хэргийг ялгасан байдаг. Эрүүгийн яллаагааг зөвхөн батлагдсан ёс суртахуунгүй пакт дээр хэрэглэдэг. Мөн нийтийн албан хаагчдын хууль бус үйлдэл болох хээл хахууль болон авлига өгч авах үйлдэлийг хийсэн байх буюу хийхээр амласан байх шаардлагатай. Хийхээр амласан байх гэдэг нь заавал тусгай мэргэжлийн хүн ашиг авсан байхыг шаарддаггүй боловч тухайн үйлдэл нь мэргэжлийн үүргээ зөрчсөн байдаг. Германы Эрүүгийн хуулийн 332-р зүйлд зааснаар авлига авсан нийтийн албан хаагчид нь 6 сараас 5 жилийн хугацаагаар хоригдох ял авдаг. Хэрэв авсан авлигын хэмжээ нь их эсхүл нийтийн албан хаагчид нь үүргээ зөрчиж авлига авсан хэргээр өмнө нь яллагдаж байсан бол 10 жилийн хугацаагаар хоригдох ял онооно.

3. Ашиг өгөх, авах – Хандивлагч болон нийтийн албан хаагч хоорондын ёс суртахуунгүй үйлдлийг үүргийн тусгай зөрчил гэж үзэхгүй бөгөөд Германы Эрүүгийн хуулийн 332, 334, 335-р зүйлд зааснаар торгох, 3 жилээс дээш хугацаагаар хорих ял онооно.

Дүгнэлт

Авлигын гэмт хэргийг мөрдөн шалгах Германы тогтолцоо болон Германы практикт сул болон давуу тал байна. Жишээ нь: авлига өгөх, авах үйлдэл нь Зүүн Европ болон Төв Азийн авлигын эсрэг сүлжээний гишүүн улс орнуудын авлигын үйлдлээс ялгаатай байгаа ба Германы авлигын гэмт хэргүүд нь илүү өргөн хүрээтэй байна. Гэхдээ нэг зорилготой байдаг нь нийтийн албан хаагчдын бүхий л түвшинд авлига өгч, авахгүй байх явдлыг хангах юм.

ХОРВАТ ДАХЬ АВЛИГЫН ГЭМТ ХЭРГИЙГ ШИЙДВЭРЛЭХ, МӨРДӨН ШАЛГАХ АЖИЛЛАГААН ДАХЬ USKOK-ИЙН ҮҮРЭГ

Хорватын прокурор Хатагтай Диана Перван

USKOK /Авлигын болон зохион байгуулалттай гэмт хэргийг шийдвэрлэх байгууллага/-ын дүрэм нь 2001 оны 10 сард батлагдаж, 2001 оны 12 сард хүчин төгөлдөр болсон. USKOK нь улсын хуулийн байгууллагаас үндэслэгдэн байгуулагдсан нь эрүүгийн зөрчлийг илрүүлэх үр дүнтэй шийдэл болсон юм. USKOK нь Эрүүгийн хуулийн конвенц болон НҮБ-ын хил дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг конвенцийн дагуу үйл ажиллагаа явуулдаг.

USKOK-ийн зохион байгуулалт – USKOK нь Улсын хуулийн тусгай байгууллага бөгөөд Нэгдсэн Кротагийн газар нутагт оршдог. USKOK-ийн удирдлага нь Загребт байрладаг. USKOK нь судалгаа, баримт бичгийн тасаг, авлигын эсрэг болон нийтийн харилцаа холбооны тасаг, прокурорын тасаг, олон улсын хамтын ажиллагаа болон хамтын мөрдөн шалгах тасаг, нарийн бичгийн дарга нарын газар болон дэмжих үйлчилгээ гэсэн тасгуудаас бүрдэнэ.

Албан хаагчид – Байгууллагын дарга нь Хууль зүйн сайд, Улсын хуулийн байгууллагын тэргүүний санаачилсанаар Улсын ерөнхий хуулийн байгууллагаас 4 жилийн хугацаагаар томилогддог. Нийт 28 дэд дарга, 51 ажилтантай.

USKOK-ийн үндсэн үүргүүд –

1. Гэмт хэргийн үйлдлийг илрүүлэх цагдаа болон бусад байгууллагын ажилд зааварчилгаа өгөх, тэдгээр зөрчлүүдтэй холбоотой мэдээлэл цуглуулах,

2. Гэмт хэргийг илрүүлэх явцад олдсон хэрэгсэл, орлого, хөрөнгийг хураах хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэх санал оруулах,

3. Байгууллагын хуваарьт ажлын дагуу явуулах үйл ажиллагааг гүйцэтгэх.

Байгууллагын шүүхийн харьяалал:

• Авлигын гэмт хэрэг – Дараахь эрүүгийн зөрчлүүдийг илрүүлэх үйл ажиллагаа явуулна.

- Дампуурлын хууль бус үйлдэл

-Гадаадын худалдааны үйл ажиллагааны шударга бус өрсөлдөөн

-Улсын үүрэг гүйцэтгэх журам зөрчих

-Хууль бус өмгөөлөл

-Хээл хахууль авах

-Эдийн засгийн бизнесийн үйл ажиллагаанд хээл хахууль авах

-Хээл хахууль амлах

-Эдийн засгийн бизнесийн үйл ажиллагаанд хээл хахууль амлах

-Алба хаагчаас байгууллагын болон байгууллагын албан хаагчийн журмыг зөрчих

- Зохион байгуулалттай гэмт хэрэг – Эрүүгийн байгууллага, бүлгийн гишүүний үйлдсэн дараахь эрүүгийн зөрчлүүдийг илрүүлэх үйл ажиллагааг явуулна.

Үүнд: Эрх чөлөөг хууль бусаар хязгаарлах, хүн хулгайлах, хүн худалдаалах, боолчлол, хүнийг хил дамнуулан хууль бусаар шилжүүлэх, дээрэмдэх, сүрдүүлэх, айлган сүрдүүлэх, мөнгө угаах, хууль бусаар өр цуглуулах, мансууруулах бодис хэрэглэх журам зөрчих, зэвсэглэсэн дайралт, 2 буюу түүнээс дээш улс орнуудын хил дамнасан эсхүл өөр улсын нутаг дэвсгэр дээр төлөвлөгдсөн эрүүгийн зөрчил.

Хэрэгсэл, орлого болон хөрөнгө хураах арга хэмжээ – Уг арга хэмжээг явуулахдаа дараахь байдлыг тодруулна.

Үүнд: гэмт хэрэг үйлдсэн сэжигтэний хэрэгсэл, орлого, хөрөнгөний талаарх үндэслэл, хэрэгсэл, орлого, хөрөнгөний нийт үнэ, нийт үнэ нь 100 000 HRK-аас хэтэрсэн хэрэгсэл, орлого, хөрөнгөний үнэ, гэмт хэрэгтэн гэж үзэх үндэслэл.

Мөрдөн шалгах ажиллагаа – Мөрдөн шалгах ажиллагааг Монгол Улсын хуулийн байгууллагатай хамтарч явуулна. Урт хугацааны шоронд хоригдох ял бүхий эрүүгийн зөрчилтэй холбогдсон мөрдөн шалгах ажиллагааг явуулдаг. Мөрдөн шалгах ажиллагааг хүний эрхийг ханган тухайн хэрэг илэрсэн өдрөөс хойш 8 хоногийн дотор явуулна. Мөрдөн шалгах ажиллагаа нь нууц явагддаг бөгөөд бусад хүмүүс нотлох баримт цуглуулах ажиллагаанд оролцож байгаа тохиолдолд хэргийн нууц задрахаас урьлчилан сэргийлдэг.

USKOK нь зохион байгуулалттай гэмт хэрэг болон авлигын гэмт хэрэг дээр эрх мэдлээ хэрэгжүүлдэг. Эдгээр хоёр гэмт хэрэг дээр ялгаатай байдлаар ажилладаг. Зохион байгуулалттай гэмт хэрэг дээр цагдаа эрүүгийн материал цуглуулах, прокурор нь хэргийг мөрдөх, болон яллагааг хэрэгжүүлэх үүрэгтэй. USKOK нь авлигын гэмт хэргийн талбар дээр авлига өгсөн, авсан хүний болон авлигад өртсөн өөр өөр газар нутаг дээр эрүүгийн мөрдөн шалгах ажиллагааг явуулдаг.

USKOK нь авлигын гэмт хэргийн эсрэг тэмцдэг төрийн бус байгууллагатай хамтран ажиллах ажиллагаанд ихээхэн анхаарал хандуулдаг бөгөөд хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй хамтарч ажилладаг. USKOK нь үргэлжлүүлэн ажиллаж байгаа илүү ач холбогдолтой бүх хэргүүдийн талаарх нийтэд мэдээллэж болох мэдээлэл бүхий веб сайттай.

ГАДААДЫН ХЭЭЛ ХАХУУЛИЙГ МӨРДӨН ШАЛГАХ, ТҮҮНД ПРОКУРОРЫН ХЯНАЛТ ТАВИХ НЬ

Прокурор Fabio de Pasquale, Итали улс, Милан хотын Шүүх

Нэг. Гадаадын хээл хахууль гэж юу вэ?

Авлигын гэмт хэргийн бүтэц анх үүссэн нөхцөл байдлаасаа цоо шинээр өөрчлөгдсөн зүйлгүй бөгөөд төрөл, хэлбэр нь олон янз болсон байна. Олон улсын авлигыг тодорхойлох нь маш чухал зүйл. Хууль тогтоомжид энэ талаар хэрхэн тодорхойлсонтой танилцъя.

Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын /OECD/ 1997 оны Хээл хахуулийн эсрэг конвенцийн⁹⁹ 1-р зүйлд тодорхойлсоноор “олон улсын бизнесийн хэлцэл дэх гадаадын төрийн албан хаагчийн хахууль”-ийг “олон улсын бизнесийн харилцаанд зүй бус давуу тал олж авах зорилгоор гадаадын төрийн албан хаагчаар захиргааны шийдвэр гаргуулах, хууль ёсны албан үүргээ гүйцэтгэхээс нь татгалзуулахын тулд мөнгө, санхүүжилтыг шууд болон шууд бусаар өгөх буюу тийнхүү өгөхөөр санал болгох, амлах, үйлдэл” гэжээ.

Гадаадын хээл хахуулийн хэрэг нь ихэвчлэн томоохон авлигын хэрэг байдаг. Энэ нь маш өндөр түвшний, улс төрийн томоохон албан тушаалтнуудтай холбоотой авлигын нэг онцгой хэлбэр. Үүнтэй холбоотой тус авлигын хэргийг мөрдөн шалгах албан тушаалтнууд, мөрдөн байцаагчдын албаны үйл ажиллагаанд улс төрийн хөндлөнгийн нөлөө их байдаг.

Хоёр. Гадаадын хээл хахуулийг мөрдөн шалгах нь – олон улсын хээл хахуулийн хэргийн хоёр тал

Олон улсын хээл хахуулийн хэргийг хоёроос доошгүй улс харьяалан шийдвэрлэх эрх хэмжээтэй байдаг. Үүнд:

- авлига өгсөн этгээдийн улс /жишээ нь: АНУ, ИБУИНВУ, Франц, ХБНГУ гэх мэт/;
- авлига авсан этгээдийн улс /жишээ нь: Нигери, Пакистан, Өмнөд Африк/.

Хэргийн гол этгээд болохын хувьд авлига авсан этгээдийн тал ийм хэрэгт маш чухал байдаг. Авлига өгсөн этгээдийн хувьд зөвхөн хууль бус төлбөр тооцооны асуудал байдаг. Хөгжиж буй болон хөгжингүй орны мөрдөн байцаагч нар хамтран ажиллахгүйгээр авлигын хэргийг илрүүлэх боломж багатай ч практик дээр ийм хамтын ажиллагаа байдаггүй. Үүний шалтгааныг хоёр ангилан авч үзье.

Авлига авсан этгээдийн тал

Хөгжиж буй орнуудын эрх мэдэлтнүүд голдуу авлига авагч байдаг бөгөөд ийм оронд авлигатай тэмцэх нь тун хүнд. Энэ нь зөвхөн цагдаа, мөрдөн байцаагч нарын ур чадвар, үр дүнтэй технологийн асуудал биш юм.

⁹⁹www.oecd.org/corruption

Хамгийн том бэрхшээл бол прокурорын хяналт хараат бус, бие даасан биш байх явдал юм. Прокурорын хяналт босоо удирдлагатай, Ерөнхий прокурор нь Засгийн газрын гишүүн буюу түүнтэй адилтгах албан тушаалтан бөгөөд тухайн хэргийг шүүхэд шилжүүлэх эсэхийг дангаар шийдэх эрхтэй бол том авлигын хэргийг мөрдөн шалгах, түүнд прокурорын хяналт тавих аливаа үр дүн тун бага байдаг.

Авлига өгсөн этгээдийн тал

Өндөр түвшний эрх мэдэлтнүүдтэй харилцдаг том түншлэгч нар цөөхөн салбарын төлөөлөл байдаг бөгөөд ихэнхдээ том компаниуд байдаг. Эрх мэдэлтнүүд хууль зөрчсөн ул мөрөө үлдээдэггүй бөгөөд зөвхөн дараах бүтцээр гадаадын хахуулийг илрүүлэх боломжтой. Үүнд: корпорацийн данс, тооцоо болон мөнгөний урсгал.

Гурав. Мөрдөн шалгалт явуулх практик эх сурвалж

Корпорацийн данс

Авлига өгөгчийн талаас нь үзвэл, олон улсын авлигыг мөрдөн шалгах нь ерөнхийдөө корпорацийн зөрчил, олон улсын санхүүгийн хэлцлийг мөрдөн шалгахад тулгуурладаг. Корпорацийн дансыг мөрдөн шалгах нь хууль бус мөнгөний урсгалыг илрүүлэхэд гол үүрэг гүйцэтгэдэг. Энэ талаар Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын 1997 оны Хээл хахуулийн эсрэг конвенцийн 8-р зүйлд тусгасан.

Санхүүгийн мэдээлэл

Санхүүгийн мэдээллийг хянан шалгах нэгж ажиллах бөгөөд энэхүү төрийн агентлаг нь санхүүгийн мэдээллийг хүлээн авах, түүнд дүн шинжилгээ хийх, ийм мэдээллийг эрх бүхий байгууллагад нууцын зэрэглэлтэйгээр шилжүүлэх асуудлыг хариуцдаг. Энэ нэгж нь гадаадын хээл хахуульд зориулагдсан хууль бус санхүүжилтын ул мөрийг илрүүлэхэд чухал үүрэгтэй. Санхүүгийн мэдээллийг нотлох баримтаар ашиглахад хүндрэлтэй асуудал гардаг.

Харилцан туслалцаа

Гадаадын авлига нь олон янзын хууль зүйн тогтолцоог хамрах өвөрмөц онцлогтой байдаг учраас дотоодын мөрдөн шалгалт нь ийм хэргийг дангаар илрүүлэхэд хүчин мөхөсддөг. Харилцан туслалцаа нь дараах бүрдэлтэй байдаг. Үүнд:

- мөрдөн шалгалтын стратегийг харилцан зөвшөөрөх
- өдөр тутмын гэрээ, хэлэлцээ
- гэрчийг харилцан зөвшөөрөх
- хамтарсан судалгаа хийх.

Гэхдээ хэд хэдэн шалтгаанаар улс, орнууд харилцан туслалцаанаас зайлсхийдэг. Үүнд: туслалцаа нь удаан, эрх бүхий байгууллага хоорондын харилцаа нь зөвхөн албан ёсных байдаг, мөрдөн шалгах стратегийг зөвшөөрөхгүй байх, зөвхөн нотлох баримттай ажиллагаан дээр туслалцаа үзүүлдэг. Харилцан туслалцааны талаар Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын 1997 оны Хээл хахуулийн эсрэг конвенцийн 9-р зүйлд тусгасан.

Дөрөв. Прокурорын хяналт

Эрх мэдлийн хязгаарлалт

Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын 1997 оны Хээл хахуулийн эсрэг конвенцийн 6-р зүйлд зааснаар мэргэжлийн үйл ажиллагааны аливаа хязгаарлалт нь гадаадын албан тушаалтны авлигын хэргийг мөрдөн шалгах, түүнд хяналт тавих тохиромжтой цаг хугацааг хязгаарлах ёсгүй.

Практик зөвлөгөө

- Мөрдөн шалгалтын үйл ажиллагааны үеэр зайлшгүй шаардлага тохиолдолд хүч хэрэглэнэ. Ийм хүч нь баривчлах, утас чагнах зэрэгт хамааралтай байх нь зохистой. Учир нь хүч хэрэглэсэн нотлох баримтууд шүүх хурал дээр тун амархан нотлох баримтаас хасагддаг.

- Санхүү, нягтлан бодох бүртгэлийн шинжээчдийг ашигла. Тэдний ажилд хүч бүү хэрэглэ.

- Мөрдөн шалгалтын үеэр гэрчид ямар нэг дарамт, шахалт хэзээ ч бүү үзүүл. Эс тэгвэр шүүх хурал дээр мөрдөн шалгалтын үед цуглуулсан нотлох баримт нотлох чадвараа алдах буюу мөрдөн шалгалт үр дүнгүй болдог.

Эцэст нь дүгнэхэд, луйварчин, зальтай этгээдүүд эрх мэдэлтэй байх үед прокурорууд чадварлаг байх ёстой. Хүч хэрэглэх тухай бүү бод, оюун ухаанаа ашиглах, гэхдээ хэзээ ч бүү бууж өг.

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАР ДАХЬ АВЛИГЫГ МӨРДӨН ШАЛГАХ, ТҮҮНД ПРОКУРОРЫН ХЯНАЛТ ТАВИХ НЬ

*Прокурор Marcello Paranhos de Oliveira Miller,
Бразил улс, Рио-де-Жанейро, Төрийн прокурорын газар*

Бразилд шилжүүлэн суулгах мэс заслыг холбооны хуулиар зохицуулдаг. Тодруулбал, “Эд эрхтнийг шилжүүлэн суулгах акт”-аар төрийн болон хувийн салбар дахь энэ талын харилцааг бүхэлд нь зохицуулдаг. Бразилын эрх зүйн тогтолцоонд гэмт хэрэгт хамаарахгүй тодорхой зөрчилд “иргэний прокурорын хяналт” хэрэгждэг. Энэ нь торгох, албан тушаалаас нь чөлөөлөх, улс төрийн эрхийг нь хязгаарлах байдлаар иргэний эрх зүйн хариуцлага хүлээлгэх зарчмаар ажилладаг бөгөөд шалгах явцад гэмт хэргийн шинжтэй үйлдлийг прокурорт шууд шилжүүлдэг.

Бүх эд эрхтэн шилжүүлэн суулгах мэс заслын үндэсний жагсаалтыг Эрүүл мэндийн яаманд тайлагнадаг бөгөөд уг жагсаалтыг эрүүл мэндийн төвийн тэргүүн Х эмч үйлддэг байсан. Гэнэт Х эмч шилжүүлэн суулгах мэс заслыг холбооны өөр эмнэлэгт тусдаа хийх болсон бөгөөд уг эмнэлэг хамгийн өндөр үнэтэй хувийн эмнэлэг болсон.

Энэ болон эд эрхтэн шилжүүлэн суулгах мэс заслын үндэсний жагсаалтын эргэлзээтэй байдлын үндсэн дээр Х эмчийг шалгах ажлын хэсэг байгуулагдан ажилласан.

Х эмчийн хоёр хамаатан нь Рио-де-Жанейро хотын шүүгч нар байсан бөгөөд Х эмч олон шүүгчтэй найз байсан. Энэ мэт олон шалтгаан, нөхцлийг нягтлан шалгасан бөгөөд Х эмчийн багийн 4 гишүүнийг хэрэгт татсан. Энэ 4 гишүүнд холбогдох хэргийг Рио-де-Жанейро хотын анхан шатны шүүхээс хэрэгсэхгүй болгосон бөгөөд Х эмчийг баривчлах бидний хүсэлтийг нотлох баримт хангалтгүй шалтгаанаар хангахгүй орхисон. Х эмч 8 жил хоригдох ялаас мултарсан.

Энэ хэргийг Холбооны давж заалдах шатны шүүхэд хэлэлцэж байгаа бөгөөд хянан шийдвэрлэх ажиллагаа дуусаагүй, үргэлжилж байгаа. Одоо энэ хэрэг дээр миний бие прокуроруудыг ахлахаа больж, санхүүгийн гэмт хэрэг, мөнгө угаах гэмт хэргийг харьяалан шийдвэрлэдэг өөр шүүхэд хуваарилагдсан.

Авлигын эсрэг хууль тогтоомжоор прокурор нь мэргэжлийн үйл ажиллагаагаараа сайн засаглалыг бэхжүүлэх, засаглалыг шинэчлэхэд хувь нэмрээ оруулдаг. Миний итгэлтэй байгаа зүйл бол дунд болон дээд түвшний эрх мэдэл бүхий албан тушаалтнууд бараг бүгдээрээ авлигын хор хохирлын талаар зохих боловсролтой болсон.

ЛАТВИ УЛСАД ДЭЭД ТҮВШНИЙ АВЛИГЫГ МӨРДӨН ШАЛГАЖ БУЙ ТУРШЛАГА

Мөрдөн байцаагч Rimants Kuzma, Латви улсын Авлигаас урьдчилан сэргийлэх, авлигатай тэмцэх товчоо


Авлигаас урьдчилан сэргийлэх, авлигатай тэмцэх товчоо /KNAB/

Үйл ажиллагааны үндсэн хүрээ:

- Эрүүгийн хуульд заасан авлигатай холбоотой гэмт хэргүүдийг илрүүлэх, тийм гэмт хэргээс урьдчилан сэргийлэх
- Авлигатай холбоотой эрүүгийн хэрэгт шүүхийн өмнөх шатанд мөрдөн шалгалт явуулах, эрүүгийн хэргийн прокурорын хяналтанд дэмжлэг үзүүлэх
- Төрийн албан хаагчийн үйл ажиллагаанд тавигдах хязгаарлалтанд хяналт тавих
- “Төрийн албан хаагчийн үйл ажиллагаанд ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль”-д заасан зөрчил үйлдсэн төрийн албан хаагчид захиргааны хариуцлага хүлээлгэх санал гаргах

- Улс төрийн намуудын санхүүжилтын үйл ажиллагаанд хяналт тавих
- Авлигын эсрэг стратеги болон авлигатай тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх төрийн хөтөлбөрийг хөгжүүлэх, түүний хэрэгжилтэнд хяналт тавих.

Авлигаас урьдчилан сэргийлэх, авлигатай тэмцэх товчооны бүтэц




Хахууль авах, тийнхүү авахаар сүрдүүлэхтэй холбоотой эрүүгийн хэрэг

- Хахууль авахаар шаардсан хэмжээ 1,900,000 евро /дөрвөн тохиолдолд/
- Хэрэгт холбогдсон хүний тоо 5
- Моторт завь болон бэлэн мөнгийг оруулаад царцсан хөрөнгө 345,000 еврогоос багагүй

Гэмт хэргийн схем

Гэмт хэргийн схем



Мөрдөн шалгах үйл ажиллагаанд учирч буй сорилт

- Мөрдөн байцаагч нар олон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгслийн дарамт, шахалтанд байх
- Хууль сахиулах бусад байгууллагатай сөргөлдөх.

Сэдэв 4. Цагдаа, прокурорын бие даасан, мэргэшсэн байдал

**АВЛИГЫГ МӨРДӨН ШАЛГАХ, ИЛРҮҮЛЭХЭД АВЛИГЫН ЭСРЭГ БИЕ
ДААСАН, МЭРГЭШСЭН БАЙГУУЛЛАГА ҮР ДҮНТЭЙ БАЙХ ТУХАЙ**

*Мөрдөн байцаах албаны дарга Daumantas Polius,
Литва улс, Мөрдөн шалгах тусгай алба, шүүхийн өмнөх шатанд
мөрдөн шалгах хэлтэс*

Авлигын эсрэг бие даасан байгууллагын бага зэргийн ялгаатай хоёр загвар байдаг. Үүнд:

1. Бусад хууль сахиулах болон засгийн газрын байгууллагын хамтын ажиллагааны нөөц дээр үндэслэн ажилладаг харьцангуй бага бие даасан байдалтай авлигын эсрэг байгууллага.

2. Бусад байгууллагатай харилцах, хамтран ажиллагаа хэрэгцээ маш багатай авлигын эсрэг бие даасан, өөрийгөө дэмжих хараат бус байгууллага.

Энд дурьдаж буй бие даасан, хараат бус байгууллага хэрхэн ажиллах ёстой вэ?

Авлигын эсрэг үр дүнтэй тэмцэл нь засгийн газрын байгууллагууд, хууль сахиулах тусгай байгууллагуудын хэвтээ чиглэлийн харилцаанд тулгуурлана.

- Авлигын эсрэг шүүхийн өмнөх мөрдөн шалгалт, ажиглалт явуулж буй тухай мэдээллийг бусад байгууллагад өгөх нь авлигаас урьдчилан сэргийлэх чухал үр дүнтэй. Авлигын эсрэг байгууллага нь бусад хууль сахиулах, хяналтын байгууллагууд итгэх ёстой. Гэхдээ зарим тохиолдолд тэдгээр байгууллагын ажилтны мэдээлэл, ажил үүргийн байдлыг нягтлах шаардлагатай.
- Авлигын эсрэг байгууллагын үйл ажиллагааны талаарх зохих мэдээлэл буюу өндөр албан тушаалтныг саатуулсан эсэх тухай, шүүхийн өмнөх мөрдөн шалгалтын явцын мэдээллийг олон нийтийн мэдээллийн хэрэгсэлд танилцуулах нь авлигын эсрэг байгууллагын хэрэгжүүлж буй үйл ажиллагааг буруу ойлгох, дүгнэхээс урьдчилан сэргийлэхэд тустай.

Сэдэв 5. Үр дүнтэйгээр эд хөрөнгө хураах, албан тушаалаас чөлөөлөх нь

ЭД ХӨРӨНГИЙГ МӨРДӨН ШАЛГАХ, ОЛЖ АВАХ ҮР ДҮН БА ХУУЛЬ ЗҮЙН ХАРИЛЦАН ТУСЛАЛЦААНЫ ПРАКТИК ХЭРЭГЛЭЭ

Сургалтын төвийн тэргүүн Phyllis Atkinson, Швейцар улсын Базел хүрээлэн

Эд хөрөнгийг мөрдөн шалгах зорилго юу вэ?

Санхүүгийн мөрдөн шалгалт явуулах нь гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох аливаа стратегийн гол бүрэлдэхүүн болдог. Мөрдөн байцаагчийн хувьд салангид, ялгаатай мөрдөн шалгалт байх ёсгүй бөгөөд санхүүгийн мөрдөн шалгалт нь дараах олон зорилгыг агуулдаг. Үүнд:

- Нэгдүгээрт, эд хөрөнгө нь хууль бус үйл ажиллагаа, авлигатай холбогдоно. Энэ нь нотлох баримт цуглуулах, эд хөрөнгө хураах эсэхийг шийдвэрлэх гол үндэс болдог.
- Хоёрдугаарт, мөрдөн шалгалт нь авлига, мөнгө угаах хэрэгт холбогдсон албан тушаалтанд прокурорын хяналт тавихад шаардлагатай хангалттай нотлох баримтыг тогтоодог.
- Гуравдугаарт, нотлох баримт цуглуулах замаар тухайн эд хөрөнгө хулгайлагдсан, хууль бус эзэмшилд байгаа эсэхийг илрүүлэх, тогтооно.

Тиймээс эд хөрөнгийг илрүүлэх, мөнгө угаах хэргийг мөрдөн шалгах нь авлигын хэрэгт холбогдох эд хөрөнгийг хураан авах буюу битүүмжлэх үндэслэл болдог.

Энд дурдсан үйл явц дараах үндсэн алхамаас бүрдэнэ. Үүнд:

- Хардалт, сэжиг бүхий үйл баримтыг шалгах
- Дээр дурдсаныг батлах буюу үгүйсгэх нотлох баримтыг бүрдүүлэх
- Хууль бус үйл ажиллагааг ажиглах, тандах
- Тухайн эд хөрөнгийг хураах, үйл ажиллагааг сэргээн баримтжуулах.

Бидний мэдэх нийтлэг зүйл бол эрүүгийн хэрэгт прокурорын хяналт тавих үйл явцын анхдагч зорилго нь эд хөрөнгийг хураах, битүүмжлэх биш бөгөөд энэ нь прокурорын хяналтын ажлын нэг хэсэгт хамаарна. Эрүүгийн процесс нь үндсэндээ дараах хоёр чулах зорилгод үйлчилдэг. Үүнд:

- Гэмт этгээдэд хариуцлага хүлээлгэх
- Алдагдсан эд хөрөнгийг буцаан олохын тулд нотлох баримт цуглуулах.

Мөрдөн шалгах ажлын бүтэц

Тухайн хэргийн нөхцөл байдлаас хамаараад санхүүгийн хэргийг мөрдөн шалгах олон арга зам байх хэдий ч дараах үндсэн стратегитай. Үүнд:

- Тодорхой хэрэгт шууд нотлох баримтыг ашиглах
- Аудио болон видео бичлэгийг хээл хахуулийг шууд нотлоход ашиглах
- Шууд бус аргаар орлогын мэдээллийг тодорхой нөхцөл байдалд нотлох баримт болгон үнэлэх
- Залилан мэхлэсэн шинжтэй хэлцэл, үйлдлийн далд зорилгыг мэдээллийг тодорхой нөхцөл байдалд нотлох, баримт болгон үнэлэх.

Туслалцааны төрөл

Албан бус хамтын ажиллагаа нь мөрдөн байцаагчид авлига, санхүүгийн гэмт хэргийн цогцыг илрүүлэхэд албан ёсны хамтын ажиллагаанд нэмэлт хүч болдог. Гэхдээ албан бус хамтын ажиллагаанаас татгалзах шаардлагагүй. Үүний гол шалтгаан нь хилийн чанад дахь шүүх дээр албан ёсны хүсэлт бүхий албан бичгийг л нотлох баримт гэж үнэлдэгтэй холбоотой.

Олон оронд эрүүгийн мөрдөн шалгалтын анхдагч зорилго нь нууц далд гэмт үйлдлийг мөрдөн шалгахад чиглэдэг. Гэхдээ мөнгө, эд хөрөнгийн урсгалыг шалгах, шинжлэх нь авлига зэрэг гэмт хэргүүдтэй тэмцэхэд мөрдөн байцаагч, прокурор нарт үнэлж баршгүй чухал арга хэрэгсэл болдог.

Орчин үеийн бизнест интернэт болон цахим хэлбэрээр хил дамжуулан үйл ажиллагаа явуулж буй үед гадаад улсуудын туслалцаа тун чухал болж байгаа бөгөөд гэмт хэрэгтэн хаанаас ч зорилгоо биелүүлэх болж байгаа нь бид бүхний хувьд шинэ сорилт болж байна. Зохион байгуулалттай гэмт хэргүүд нь нотлох баримтыг хамгаалах ажлыг санхүүгийн цогц мөрдөн шалгалт явуулах шаардлагыг улам бүр нөхцөлдүүлж байна.

**ШВЕЙЦАР УЛСАД АВЛИГЫН ХЭРГИЙН МӨРДӨН ШАЛГАХ ЭРҮҮГИЙН
БАЙЦААН ШИЙТГЭХ АЖИЛЛАГАА ДАХЬ ЭД ХӨРӨНГИЙГ ХАЙХ,
БИТҮҮМЖЛЭХ, ХУРААН АВАХ НЬ**

Jean-Bernard Schmid, Швейцар улсын шүүх, санхүүгийн хэлтэс, мөрдөн шалгах магистрат

Эд хөрөнгийг хайх, таньж олох

Энд зөвхөн хууль бус үйл ажиллагааны буюу сэжиг бүхий хөрөнгийн хувьд яригдаж байгаа бөгөөд эхлээд эрүүгийн хэрэгт сэжиглэгдэж буй этгээдийн хөрөнгийн хувьд яригдана. Швейцар улсын хуулийн дагуу эд хөрөнгө болон гэмт үйлдлийн хооронд шууд болон шууд бусад холбоо байдаг.

Мэдээллийн эх сурвалж: Мөрдөн шалгах үйл ажиллагааг анхлан явуулахад туслах мэдээллийн хэд хэдэн төрлийн эх сурвалж байдаг. Үүнд:

- Цагдаагийн цуглуулсан өдөр тутмын мэдээ, рапорт
- Санхүү, үл хөдлөх хөрөнгийн хэлцэл зэрэг асуудал хариуцсан эрх бүхий захиргааны байгууллагын өдөр тутмын мэдээ, мэдээллийн сан
- Банк, итгэмжлэгдсэн этгээд, бизнесийн хуульч зэрэг хуулийн дагуу үйлчлүүлэгчийнхээ хувийн болон эдийн засгийн үндсэн мэдээллийг шалгаж санхүүгийн үйл ажиллагаанд оролцдог санхүүгийн зуучлагчдын бэлтгэсэн мэргэжлийн ёс зүйн дүрмийн дагуу цагдаад мэдээлсэн сэжиг бүхий хэлцлийн мэдээ
- Сэжиг бүхий үйл ажиллагааны мэдээллийг тайлагнах үүрэг бүхий аудиторууд
- Санхүүгийн мөрдөн шалгах албаны гүйцэтгэх ажлын шугмаар цуглуулсан мэдээлэл
- Цуу тараагч буюу түүнтэй төстэй этгээдүүд
- Мөнгө угаах, бичиг баримт хуурамчаар үйлдэх, итгэл эвдэх, залилах зэрэг хууль бус үйл ажиллагааны асуудлаарх Гадаад улсаас ирүүлсэн харилцаа туслалцааны хүсэлт
- Төрийн албан хаагчийн хөрөнгө орлогын мэдүүлэг
- Олон улсын зах зээл дэх банк, корпорацийн үйл ажиллагааны талаарх хэвлэл мэдээллийн хэрэгсэл, интернэт дэх нийтийн мэдээлэл

Эдгээр мэдээллийн эх сурвалжийг дотоодод болон олон улсын түвшингээр нь хэрхэн ашиглахаас гол үр дүн хамаарна.

Техникийн зарим асуудал

Мөрдөн шалгах үйл ажиллагааг эхлэхийн өмнө дараах хууль зүйн чадвар бий эсэхийг нотлох нь маш чухал зүйл байдаг. Үүнд:

- Эд хөрөнгө хураах зэрэг шаардлагатай арга хэмжээ авах
- Тухайн ажиллагаанд татан оролцуулах байгууллага, хүмүүсээс нууцлалын баталгаа гаргуулах буюу тухайн ажлыг нууцлалыг задруулахгүй байх үүрэг хүлээлгэх. Швейцар улсын хуулиар ийм үүргийг ихэвчлэн банк, санхүүгийн зуучлагч нарт хүлээлгэдэг.
- Хэвлэл мэдээллийн хэрэгслээр цацагдахаас зайлсхийх.

Практикт нууцлалыг хангах үүргийг урт хугацаанд хүлээлгэх боломжгүй байдаг. Хэрэв хадгаламжийн дансыг битүүмжилвэл, энэ талын нууцыг урт хугацаагаар хадгалах боломж бага байдаг. Иймд хэрэг тус бүрийн онцлогт тохирсон хойшлуулашгүй арга хэмжээг авах шаардлагатай.

Дипломат эрх дарх, хуульч, нотариатч, аудиторчуудын мэргэжлийн нууц, битүүмжилсэн хөрөнгийг зохицуулах, цахим хэлбэртэй мэдээллийг шинжлэхийн тулд мэдээллийн технологийн асуудал хариуцсан цагдааг ажиллуулах, түүний шинжилгээг бусад эрх бүхий этгээдээр зөвшөөрүүлэх асуудал хүндрэлтэй байдаг.

Банкны бичиг баримтыг олж авах

Швейцар улсын хуулийн дагуу банк, санхүүгийн зуучлагч нар үйлчлүүлэгчийнхээ тухай болон тэдний санхүүгийн үйл ажиллагааны мэдээлэл, эд хөрөнгийн гарал үүслийн мэдээллийг нягтлан шалгах, хадгалах үүрэгтэй. Ингэж нягтлан шалгасан мэдээллийг олж авах нь цаг хугацаа хэмнэх давуу талтай байдаг.

УКРАЙН УЛСАД АВЛИГААР ОЛЖ АВСАН ЭД ХӨРӨНГӨ ХУРААН АВАХ АСУУДАЛ

Станислав Туровски, Украин улсын Ерөнхий прокурорын газрын прокурор

Украин улс “Авлигатай тэмцэх үйл ажиллагааны төлөвлөгөө”-г дэмжиж 2003 онд Истанбул хотод түүнийг батласан. Үүний үр дүнд манай улс НҮБ-ын Авлигын эсрэг конвенцид гарын үсэг зурж, нэгдэн орсон дагуу Украин улсын Ерөнхий прокурорын газар олон орон, олон улсын байгууллагатай хамтран ажилладаг.

Одоогийн хууль тогтоомжоор Украин улсын прокуроруудад зарим бэрхшээлтэй асуудал байдаг ба энэ нь авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтэнд хяналт тавих эрхийг хууль сахиулах болон бусад эрх бүхий байгууллага хэрэгжүүлдэг. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн дагуу прокурор, мөрдөн байцаагч нар авлига, хээл хахуультай холбоотой эрүүгийн хэргийг мөрдөн шалгах эрхтэй.

Украин улсын Үндсэн хуулийн 41-р зүйлийн 6 дахь хэсэгт зааснаар эд хөрөнгө хураан авах, өмчийг хязгаарлах асуудлыг хуульд заасан хэмжээгээр зөвхөн шүүхийн шийдвэрээр зохицуулдаг. “Авлигатай тэмцэх тухай хууль”-иар прокурорууд удирдлага-захиргааны авлигын зөрчлийг тогтоох эрхтэй

бөгөөд шүүхийн өмнө зохисгүй зан үйл, материалыг тодорхойлох, зөвлөмж өгөх эрхтэй.

Жилд дунджаар шүүхэд шилжүүлсэн авлигын гэмт хэрэг 15000 буюу нийт хэргийн 12.6 %-ийг эзэлдэг, үүнээс 1.7 сая хүн эрүүгийн хэргийн оролцогч болсон байна.

Прокурорын газрын мөрдөн байцаагч нарын мөрдөн шалгасан авлигын гэмт хэргийн хохирлын хэмжээ 12 сая ам.доллараас багагүй байсан бөгөөд шүүх хурлын өмнөх шатанд тал хувь нь нөхөн төлөгдсөн байна. Хураасан эд хөрөнгийн 96.7 хувь нь гэмт хэрэг үйлдэхэд ашиглагдсан болохыг шүүхийн шийдвэрүүдээр тогтоосон.

Ойролцоогоор 381 га газар буюу зах зээлийн үнэлгээгээр 25 сая ам.долларын хөрөнгийг гэмт бүлэглэл буюу Хууль зүйн яамны аюулгүйн албаны ажилтан, өмгөөлөгч, шүүгчдийн бүлэглэлээс хураасан байна.

Энэ нь зохион байгуулалттай бүлэг, эрүүгийн бүлэглэлүүдийн үйлдсэн авлигын гэмт хэргийг илрүүлэх, мөрдөн шалгахад хууль сахиулах байгууллагууд онцгой анхаарал хандуулах шаардлагатай болсоныг харуулж байна.

Хууль сахиулах байгууллагуудын зохион байгуулсан ажиллагааны хүрээнд авлигын гэмт хэрэг үйлдсэн эрүүгийн 33 бүлэг, холбоог илрүүлж, тэдний үйлдийг таслан зогсоосон байна. Энэ жилд прокурорын газраас шүүгч нарын үйлдсэн нотлох баримтаар тогтоогдсон авлигын 27 хэргийн мөрдөн шалгалтанд хяналт тавьж шүүхэд шилжүүллээ.

Львов бүсийн Захиргааны хэргийн давж заалдах шатны ерөнхий шүүгч, бусад найман шүүгчийн авлигын хэргийг Ерөнхий прокурорын газраас шүүхэд шилжүүлсэн бөгөөд эдгээр шүүгч нийтдээ 100,000 ам.доллараас багагүй хэмжээний авлига авсан байна. Энэ хэргийг шүүх хянан шийдвэрлэх ажиллагаа үргэлжилж байгаа.

Шүүгч нар авлигын хэрэгт холбогдож, эрүүгийн хариуцлага хүлээж байгаа нь анхаарал татаж байгаа бөгөөд авлигатай тэмцэх үйл ажиллагаанд гол бэрхшээл болж байна.

1.1.Авлигын хэмт хэргүүд

1.1.1.Олон улсын стандартууд

Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага, Европын зөвлөл, НҮБ зэрэг олон улсын байгууллагуудаас гаргасан авлигын гэмт хэрэг дээрх олон улсын стандартад “авлига” гэдэг нэр томъёог тодорхойлоогүй бөгөөд оронд нь авлигын гэмт хэрэг гэж тооцож болох үйлдлүүдийг тусгаж өгсөн.

Авлигын гэмт хэргийн олон улсын үндсэн стандартад дараах тусгай гэмт хэргүүдийг тодорхойлсон¹⁰⁰:

НҮБ-ын Авлигын эсрэг конвенцид албадлагын гэмт хэргүүдийг зааж

¹⁰⁰Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын Авлигын эсрэг олон улсын стандартын тайлбар, 2008, 30-р хуудас.

өгсөн. Үүнд нь: Төрийн албан хаагчийн хээл хахуулийн гэмт хэрэг, гадаадын төрийн албан хаагч болон олон улсын байгууллагын албан хаагчийн хээл хахуулийн гэмт хэрэг, хууль бус аргаар мөнгө олох гэмт хэрэг, төрийн албан хаагч эд хөрөнгө шамшигдуулах, завших, шүүн таслах ажиллагаанд саад учруулах, шахалт үзүүлэн худалдаа хийх, түүнтэй төстэй гэмт хэргүүд, үүрэг зөрчих, хууль бусаар хөрөнгөжих, хувийн сектор дахь хээл хахуулийн гэмт хэрэг гэх мэт.

Европын зөвлөлийн авлигын гэмт хэргийн эрүүгийн конвенцид гэмт хэргийн хүрээ хязгаарыг зааж өгсөн. Уг конвенцийн 2-р бүлэгт дотоод болон гадаадын төрийн албан хаагчийн идэхитэй, идэвхигүй хээл хахуулийн гэмт хэрэг, хувийн сектор дахь хээл хахуулийн гэмт хэрэг болон шахалт үзүүлэн худалдаа хийх гэмт хэргүүдийг тусгасан. Европын зөвлөлийн конвенцид заасан бүх гэмт хэргүүд нь албадлагын гэмт хэргүүд юм.

Гадаадын төрийн албан хаагчдын олон улсын бизнесийн хэлцэл дэх хээл хахуулийн гэмт хэрэгтэй тэмцэх тухай Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын конвенц /Хээл хахуулийн эсрэг Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын конвенц/-ийн 1-р зүйлд гадаадын төрийн албан хаагчдын олон улсын бизнесийн хэлцэл дэх хээл хахуулийн гэмт хэргүүдийг зааж өгсөн.

Дээр дурьдсан конвенцууд нь өөрөө шууд хэрэгжих шинж багатай бөгөөд конвенцуудад заасан шаардлагуудыг тусгасан дотоодын хууль тогтоомжийг батлахыг шаарддаг.

Өөрөөр хэлбэл эдгээр конвенцуудыг хэрэгжүүлэхийн тулд улс нь нэн тэргүүнд хууль тогтоомжиндоо хэрхэн тухайн стандартуудыг тусгах вэ гэдгийг тодорхойлох ёстой.

1.1.2.Украин улс дахь авлигын гэмт хэргийн хариуцлага

Украин улс нь НҮБ-ын Авлигын эсрэг конвенцид 2003 онд гарын үсэг зурж, 2006 онд соёрхон батласан ба 2010 онд уг конвенцийн гишүүн орон болсон.

Мөн Европын зөвлөлийн авлигын гэмт хэргийн эрүүгийн хуулийн конвенцид 1999 онд гарын үсэг зурж, 2006 онд соёрхон батласан бөгөөд уг конвенц нь 2010 оны 3 дугаар сараас Украин улсад хүчин төгөлдөр үйлчилж эхлэсэн.

Украин улс нь Хээл хахуулийн эсрэг Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын конвенцийн гишүүн биш боловч Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын байгуулсан Зүүн Европ болон Төв Азийн Авлигын эсрэг сүлжээнд оролцдог бөгөөд Хээл хахуулийн эсрэг Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын конвенц зэрэг олон улсын стандартуудад үндэслэсэн Истанбулын Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөнд хяналт тавьдаг улс юм.

1.1.2.1. Эрүүгийн хариуцлага

Украин улсын хууль тогтоомжид авлигын гэмт хэргийг өргөн хүрээтэйгээр тусгасан нь Украин улс дахь авлигын гэмт хэрэг болон олон улсын стандартуудыг зөрүүтэй болгосон томоохон дутагдалтай юм.

Авлигын эсрэг улсуудын нийгэмлэг болон Авлигын эсрэг сүлжээ нь уг асуудлыг хянаад дараах дутагдлуудыг илрүүлсэн:

Украин улсын нийт хууль тогтоомжинд заасан авлигын гэмт хэргүүд	Украин улсын нийт хууль тогтоомжоос илэрсэн дутагдлууд
Хээл хахуулийн гэмт хэргүүд	
- Идэвхигүй хээл хахууль /Эрүүгийн хуулийн 368, 368.3.3, 368.4.3-р зүйл/ - Идэвхитэй хээл хахууль /Эрүүгийн хуулийн 368.3, 368.4, 369-р зүйл/	- Хээл хахууль өгөх, авахаар амлах, шаардах, хээл хахууль өгөх, авах санал эсхүл амлалтыг хүлээж авах нь төгссөн гэмт хэрэг - Эд хөрөнгийн бус ашигтай талууд - Гуравдагч этгээдээс хээл хахууль өгөх, авах болон гуравдагч этгээдийн ашиг - Хээл хахуулийн гэмт хэргийн хариуцлагын үр нөлөө, тэгш байдал болон хориглох шинж - Хуулийн этгээдийн хариуцлага

Бусад авлигын гэмт хэргүүд	
- Мөнгө угаах гэмт хэрэг /Эрүүгийн хуулийн 209, 209.1-р зүйл/ - Хууль бус аргаар мөнгө олох гэмт хэрэг, мөрийн болон хувийн секторын эд хөрөнгө шамшигдуулах, завших гэмт хэрэг /Эрүүгийн хуулийн 191-р зүйл/ - Шахалт үзүүлэн худалдаа хийх /Эрүүгийн хуулийн 369.2-р зүйл/ - Шүүн таслах ажиллагаанд саад учруулах /Эрүүгийн хуулийн 376-р зүйл/ - Байгууллагын журам зөрчих, албан тушаалын эрх мэдлээ хэтрүүлэх /Эрүүгийн хуулийн 364, 364.1, 365, 365.1, 365.2-р зүйл/ - Санаатайгаар нуун дарагдуулах /Эрүүгийн хуулийн 396-р зүйл/ - Хууль бусаар хөрөнгөжих /Эрүүгийн хуулийн 368.2-р зүйл/	- Мөнгө угаах гэмт хэрэг үйлдсэн хуулийн этгээдийн хариуцлага - Хууль бусаар хөрөнгөжих /Энэ гэмт хэрэг нь НҮБ-ын Авлигын эсрэг конвенцийн 20-р зүйлд байхгүй./ - Байгууллагын журам зөрчих гэмт хэрэг /Энэ гэмт хэрэг нь хувь хүн ашиг олох гэсэн шинжийг агуулаагүй бөгөөд үл ялгагдах байдлаар илэрхийлсэн/

1.1.2.1. Захиргааны хариуцлага

Олон улсын арга хэрэгслүүд нь авлигын үйлдэлд эрүүгийн гэмт хэргийн нэгэн адил прокурорын хяналт тавихыг шаарддаг тул 1995 оноос хойш Украин улс нь хуучнаар ЗХУ байсан зарим улсууд шиг авлигын гэмт хэргийн захиргааны болон эрүүгийн хариуцлагын зэрэгцээ тогтолцоотой болсон.

Мөн Эрүүгийн хуулиндаа тухайн гэмт хэргүүдийг тусгасан бөгөөд Украин улсын авлигын гэмт хэрэгтэй тэмцэх хуулинд захиргааны болон засан хүмүүжүүлэх ял шийтгэл бүхий “Төрийн үүрэг гүйцэтгэх эрх бүхий албан тушаалтан ... материаллаг ашиг, үйлчилгээ, эрх мэдэл, бусад давуу талыг ... хууль бусаар олж авах” гэмт хэргийг оруулсан.

Авлигын эрүүгийн болон захиргааны гэмт хэргийн хоорондын ялгарах гол шинж нь тухайн гэмт хэргүүдийн нийгэмд учруулах аюулын хэр хэмжээ боловч практикт үүнийг тодорхойлоход хүндрэлтэй байдаг. Эрүүгийн үйл ажиллагаа нь баталгааны өндөр түвшин болон илүү төвөгтэй үйл ажиллагааг шаарддаг бөгөөд гэмт хэрэгтэнд хүнд хариуцлага оногдуулдаг тул хууль хэрэгжүүлэгч эсхүл дотоодын мөрдөн шалгах эрх бүхий албан тушаалтанууд илүү хөнгөн захиргааны хариуцлагыг оногдуулах хандлагатай байдаг.

2011 онд Авлигын гэмт хэргийн хариуцлагатай холбоотойгоор хууль тогтоомжид шинэчлэлт хийсний дараа одоог хүртэл Украин улсын хуулиар авлигын гэмт хэрэг дээр захиргааны болон эрүүгийн зэрэгцээ хариуцлага оногдуулдаг болсон. Жишээ нь: Захиргааны гэмт хэргийн хуулийн 172.3-р зүйлд “Давуу тал бий болгох тухай санал болгох , өгөх” гэж заасан бол Эрүүгийн хуулийн 369-р зүйлд “Хээл хахууль санал болгох, өгөх” гэж заасан байна.

1.1.2.2. Хариуцлага, хураан авах болон халдашгүй байдал

Оногдуулах хариуцлагын хувьд олон улсын авлигын эсрэг конвенцуудад тухайн хариуцлага үр дүнтэй, тэгш болон хориглох шинж бүхий байхыг шаардсан ерөнхий стандартыг тусгасан. Украин улсын тодорхой дутагдлуудыг илрүүлсэн Авлигын эсрэг сүлжээний хяналт нь хээл хахуулийн гэмт хэргийн хариуцлага нь хэтэрхий сул байгааг онцолсон¹⁰¹.

2011 онд танилцуулагдсан нэмэлтүүд нь энд хамаарахгүй бөгөөд эсрэгээрээ тэдгээр нэмэлтүүдээр хээл хахуулийн зарим гэмт хэргүүдийн хариуцлагыг багасгасан. Идэвхитэй болон идэвхигүй хээл хахуулийн үндсэн гэмт хэргүүдэд шоронд хоригдох ял шийтгэл байхгүй /368.1, 369.1, 2-р зүйлүүд/. Энэ нь Европын зөвлөлийн конвенцийн 19-р зүйлд “хариуцлага нь үр дүнтэй, тэгш, хориглох шинж бүхий байна, үүнд эрх чөлөөг хасах төрлийн ял шийтгэлтэй байх бөгөөд тухайн улсын хуулийг зөрчсөн гэмт хэрэгтнийг шилжүүлэн өгөх явдлыг нэмэгдүүлэх зорилготой байна” гэсэн заалтыг зөрчдөг. Үүнээс гадна зарим авлигын гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааны хязгаарлалт нь – идэвхигүй хээл хахуулийн үндсэн гэмт хэргийнх 2 жил /368.1-р зүйл/, идэвхитэй хээл хахуулийн үндсэн гэмт хэргийнх 3 жил /369.1-р зүйл/ - үлдсэн гэмт хэргийнх хэтэрхий бага байдаг.

¹⁰¹Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага /Авлигын эсрэг сүлжээ, Истанбулын үйл ажиллагааны төлөвлөгөөнөөс 2010 оны 12 дугаар сард батласан Украин улсын хяналтын тайлангийн 2-р үе шат, хуудас 33.

Олон улсын бүхий л конвенцууд тэдгээрт нэгдэж орсон улсуудыг хээл хахууль, хээл хахуулийн үйл ажиллагаа болон тухайн үйл ажиллагаанд тохирох хөрөнгийн үнийг хураан авах чадвартай байхыг шаарддаг. Украин улсын хураан авах хүчин төгөлдөр арга ажиллагаа нь хязгаарлагдмал бөгөөд бүх авлигын гэмт хэрэг дээр болон авлигатай холбогдох гэмт хэргүүд дээр хураан авах үйл ажиллагааг хэрэгжүүлэх боломжоор хангаагүй байдаг. Уг боломж нь хэдийгээр “Хураан авах үйл ажиллагааг явуулах процесс ажиллагааг сайжруулах эрүүгийн болон эрүүгийн процессийн хуулийн нэмэлт” хуулийн төсөлд тусгагдсан боловч уг төслийг 2009 оноос хойш парламент хойшлуулсаар байна.

Халдашгүй байдлын хувьд Авлигын эсрэг НҮБ-ын конвенц нь халдашгүй байдал болон шалгагдах шаардлагатай авлигын гэмт хэргийг үр дүнтэйгээр мөрдөн шалгах, прокурорын хяналт тавих болон шүүхээр шийдвэрлэх боломжийг тэнцвэртэйгээр хангадаг.

Хамгийн сайн практик нь эдгээр олон улсын стандартууд, төрөлхийн шинжээр үүрэгжсэн халдашгүй байдалд нийцүүлэх, зөвхөн албан хаагчийн хүлээсэн үүргээ хэрэгжүүлэх үйлдэлд нь хандах болон хөөн хэлэлцэх хугацааг хязгаарлах, зайлшгүй шалтгаанаар халдашгүй байдалд халдах үйл ажиллагааг үр дүнтэй байлгахыг зөвлөдөг. Хөөн хэлэлцэх хугацааны тухай хуулинд халдашгүй байдлын тухай заагаагүй.

Украинд халдашгүй байдлыг баталгаажуулах ямар ч арга хэмжээ авагдаагүйг тэмдэглэх хэрэгтэй бөгөөд төрийн дээд түвшний албан хаагчийн хэргийг мөрдөн шалгах, прокурорын хяналт тавих үйл ажиллагаанд халдашгүй байдлыг урьдчилан хамгаалдаггүй, бусад халдашгүй байдал туйлын бөгөөд үүрэгжээгүй байдаг ба халдашгүй байдалд халдах үйл ажиллагаа нь хангалттай үр дүнтэй, тодорхой биш байдаг.

1.1.2.3. Хуулийн шинэтгэлийг үргэлжлүүлэх

2011 оны 4 сарын 7-нд 3206-6 дугаартай “Авлигын эсрэг, авлигаас урьдчилан сэргийлэх зарчим” болон 3207-6 дугаартай “Авлигын гэмт хэргийн хариуцлагатай холбогдох хэд хэдэн хууль тогтоомжийн актуудын нэмэлт”-ийг батласан бөгөөд эдгээр нь 2011 оны 7 сарын 1-нд хүчин төгөлдөр болсон.

Тэдгээр эрх зүйн актууд нь Украин дахь эрүүгийн хууль тогтоомжийн хэд хэдэн чухал өөрчлөлтүүдийг танилцуулсан юм.

Үүнд нь: шахалт үзүүлэн худалдаа хийх, хууль бусаар хөрөнгөжих гэмт хэрэг, идэвхитэй болон идэвхигүй хээл хахуулийн гэмт хэргийн хариуцлагын өөрчлөлтүүд г.м. Эдгээр өөрчлөлтүүдэд олон улсын стандартуудыг бүтнээр нь тусгасан.

Гэхдээ Украины авлигын гэмт хэрэгт хууль зүйн дутагдлууд үлдэж байгаа учраас улс нь эцсийн эцэст хууль тогтоомжоо шинэчлэх, олон улсын стандартуудыг дагаж мөрдөх шаардлагатай.

Энэ нь Украины хууль тогтоомжийн хэм хэмжээ болгох ёстой, бусад улс орнуудын дагаж мөрддөг, хуулийн хяналтын байгууллага /MLA/ болон

олон улсын хамтын ажиллагааны бусад хүсэлтүүдийн үндэслэл болгон хэрэглэдэг олон улсын стандартуудыг ухамсарлаж ойлгосон мөрдөн байцаагч болон прокуроруудад ихээхэн ач холбогдолтой юм.

1.2. Авлигын хэргийг мөрдөн шалгах, түүнд прокурорын хяналт тавих зарчим

Авлигын хэргийг мөрдөн шалгах, түүнд прокурорын хяналт тавихтай холбоотой прокурор, мөрдөн байцаагч нарын чиг үүргийн талаарх олон улсын нэгдсэн стандарт байдаггүй.

Авлигын эсрэг НҮБ-ын конвенц, Авлигын асуудлаарх Европын Зөвлөлийн конвенц зэрэг олон улсын зарим баримт бичгүүд авлигын хэргийг мөрдөн шалгах, түүнд прокурорын хяналт тавихтай холбоотой зарим заалтыг тусгасан байдаг.

Дэлхий даяар хөгжсөн улс орнуудад сайн туршлага бий болгосон байгууллагууд байгаа бөгөөд эдгээр байгууллага нь заавал дагаж мөрдөх шинжтэй олон улсын стандартыг бий болгохгүй ч үндэсний түвшинд шинэчлэл хийхэд хэрэг болохуйц жишиг болж байна.

1.2.1. Прокурорын чиг үүрэг

Шууд болон мөрдөн байцаагчаар дамжуулан авлигын хэргийг мөрдөн шалгах, түүнд хяналт тавих, мэдээлэл солилцох, хамтын ажиллагаа өрнүүлэхэд прокурор тэргүүлэх үүрэгтэй болохыг олон улсын стандартууд, сайн туршлагауудад тодорхойлсон байдаг.

Украины прокурорын албаны чиг үүрэг нь төрийн удирдлагын хууль ёсны байдалд хяналт тавихад давамгайл оролцоотойгоороо Зүүн Европ, Төв Азийн зарим улсынхтай адил Зөвлөлтийн прокурорын газрын хэв маягийг санагдуулам бөгөөд

“Ерөнхий хяналт”-аар төрийн байгууллага, орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага, тэдгээрийн албан тушаалтнуудаас хүний эрх, эрх чөлөөг хангасан хуулийг хэрхэн хэрэгжүүлж байгаад хяналт тавих бүрэн эрхтэй.

Үүнээс гадна төрийн прокурор нь төрийн байгууллага, иргэн, холбоо, аж ахуйн нэгж, байгууллагад саадгүй нэвтрэх, тэдгээрийн бичиг баримтыг шалгах бүрэн эрхтэй. Прокурор нь хяналт тавих, шалгалт хийх эрхийн хүрээнд шийдвэр, зааварчилгаа, захирамж, эрх зүйн бусад акт гаргахыг даалгаж болно. Энэхүү олгогдсон эрх хэмжээний мөн чанар нь хуулийн хэрэгжилтэнд хяналт тавих бүрэн эрх юм.

Украин зэрэг Зүүн Европ, Төв Азийн зарим улсад олон улсын стандарт, сайн туршлага нь прокурорын үүрэгт үндсэн шинэчлэл хийх шаардлагыг бий болгож байна. Ийм шинэчлэлийн гол зорилго нь хүний эрхийг хамгаалах, төрийн алба дахь сонирхлын зөрчлийг арилгахад прокурорын чиг үүргийг тогтооход чиглэнэ.

Энэхүү шинэчлэл нь авлигын хэргийг мөрдөн шалгах, түүнд хяналт тавихад прокурор тэргүүлэх үүрэгтэй оролцохын тулд түүнд зохих ёсны шаардлагатай эрх, хангамж олгохыг дэмжинэ.

1.2.2. Бүрэн эрхтэй болон сонголттой прокурорын хяналт

Дэлхийн эрх зүйн олон тогтолцоонд прокурорын хяналтын талаар үндсэн хоёр хандлага байдаг. Эхнийх нь, тухайн хэрэг, зөрчилд прокурорын хяналт тавих эсэхийг прокурор өөрөө шийднэ гэх англи-саксоны эрх зүйн тогтолцоотой АНУ, Англи зэрэг улсад байдаг хандлага. Хоёрдахь нь бүрэн эрхтэй прокурорын хяналт бөгөөд эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны бүх үе шатанд хяналт тавина гэх Европын холбооны улсууд зэрэг иргэний эрх зүйн тогтолцоотой улсад байдаг хандлага¹⁰². Энэ хоёр тогтолцоо нь давуу болон сул талуудтай. Сонголттой прокурорын хяналтын гол давуу тал нь прокурорын нөөц, чадварыг олон тооны жижиг хэрэгт бус хамгийн чухал хэргүүд дээр төвлөрүүлж эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд эрх зүйн үр нөлөөг дээшлүүлэх юм. Гэхдээ энэ нь тодорхой зохицуулалтгүй тул прокурорууд дураараа байх, прокуророос татгалзах гэсэн хандлага бий болгодог. Бүрэн эрхтэй прокурорын хяналтын гол давуу тал нь бүх эрүүгийн хэрэгт улс төрийн нам, хүчний сонирхлоос үл хамааран тэгш хандах боломж олгодог байдал юм. Гэхдээ энэ нь маш олон хэрэгт хяналт тавих, эрүүгийн процессын эрх зүйд ачаалал үүсгэх зэргээр прокурорын нөөц, чадварыг үргүй зардаг. Ийм тогтолцоотой Европын зарим оронд прокурор нь бүх хэрэгт хяналт тавьдаггүй. Тухайлбал, ХБНГУ, Австри улсад прокурорын хяналт тавих үйл ажиллагаанд хязгаарлалт байдаг¹⁰³. ХБНГУ-д 1-ээс бага жилээ хорих ялтай хэргийг “хөнгөн хэрэг” гэх бөгөөд ийм хэрэгт прокурор хяналт тавихаас түдгэлздэг.¹⁰⁴

Авлигын эсрэг сүлжээний бусад орнуудын адил Украин улсад прокурорын хяналтыг хуульчилсан бөгөөд түүнийг хязгаарлах нөхцөл тусгагдаагүй. Гэхдээ практикт хязгаарлагдмал нөөц, бололцоотой холбоотойгоор бүх хэрэгт хяналт тавьж чаддаггүй байна. Гэхдээ Авлигын эсрэг сүлжээний тайланд дурдсанаар Украин улс нь авлигатай холбоотой бүх хэрэгт прокурорын хяналтыг хэрэгжүүлэх шаардлагатай байна. Энэ хязгаарлагдмал нөөц, бололцоог гол, чухал хэргүүдэд хандуулах үр ашигтай.

Эцэст нь хэлэхэд Украин улсын эрх бүхий байгууллага, албан тушаалтнууд авлигын ямар хэрэг, зөрчилд мөрдөн байцаалт явуулах, түүнд прокурорын хяналт тавих шалгуурыг батлана.

1.2.3. Хараат бус байдал

Авлигатайтэмцэхэдпрокурорынүүргийнталаархолонулсынстандартууд буюу НҮБ, Европын зөвлөлийн баримт бичгүүдэд зааснаар прокурор нь мэргэжлийн үйл ажиллагаандаа хараат бус, бие даасан байх шаардлагатай. Оролцогч, гуравдагч этгээдийн зүгээс хууль бусаар хөндлөнгөөс нөлөөлөх бол түүнийг нотлох шаардлагатай. Олон улсын стандартуудад улс төрийн болон бусад нөлөөлөлд прокурорын байгууллагууд хэрэхэн бие даасан, хараат бус байх талаар тусгайлан заагаагүй.

¹⁰²Европын Зөвлөлийн сайд нарын хорооны зөвлөмж 2000(19) нь бүрэн эрхтэй болон сонголттой прокурорын хяналтын талаар нарийвчилсан дүн шинжилгээг агуулсан.

¹⁰³ХБНГУ-ын Эрүүгийн байцаан шийтгэх хууль (StPO), para 154; Австрийн Эрүүгийн байцаан шийтгэх хууль (StPO), para 34.

¹⁰⁴ХБНГУ-ын Эрүүгийн байцаан шийтгэх хууль (StPO), para 153

Энэхүү бие даасан, хараат бус байдалд байгууллагын эрх зүйн байдал, Ерөнхий прокурор, түүний орлогчийг томилох, эгүүлэн татах, прокурорыг томилох, дэвшүүлэх, байгууллагын төсөв батлах үйл явц шууд хамааралтай.

Прокурорын байгууллага, прокурорын бие даасан, хараат бус байдлыг хангахын тулд хуульд дараах зүйлийг тусгах шаардлагатай. Үүнд:

- Прокурорыг дур зоргоор эгүүлэн татахын эсрэг хамгаалалт, прокурорыг томилох, дэвшүүлэх шударга, оновчтой механизм,
- Хэргийг шилжүүлэхтэй холбоотой дээд шатны прокурорын бүрэн эрхийн талаарх хоёрдмол утгаггүй, ойлгомжтой тодорхойлолт,
- Дээд шатны удирдлагаас тухай прокурорын ажлыг үнэлэх, тайлагнахтай холбоотой тодорхой бөгөөд зохистой механизм.

1.2.4. Мэргэшил

Авлигын эсрэг НҮБ-ын конвенц, Европын зөвлөлийн авлигын гэмт хэргийн эрүүгийн конвенцид мэргэшилтэй холбоотой стандартыг тогтоосон. Авлигын эсрэг НҮБ-ын конвенцоор түүний оролцогч талуудад авлигаас урьдчилан сэргийлэх, авлигатай тэмцэх үүрэгтэй хууль сахиулах байгууллага байгуулах, албан тушаалтан ажиллуулах шаардлага тавьсан.

Авлигатай тэмцэх байгууллагын мэргэшсэн байдал гэдэгт мэргэшсэн албан тушаалтнууд, тэдгээрийн тусгай чадвар, авлигатай тэмцэх тусгай эрх, үүргийг ойлгоно.¹⁰⁵ Үүнтэй холбоотой олон тооны төрөл бий.

Украин улсад авлигатай тэмцэхийн тулд прокурорын байгууллага дараах үүргийг хэрэгжүүлдэг. Үүнд:

- Гэмт хэрэг, үүнд авлигын гэмт хэргийг мөрдөн шалгах
- Мөрдөн байцаах байгууллагуудын ажилд хяналт тавих
- Шүүх дээр төрийн нэрийн өмнөөс ял төлөвлөх.

Иймээс, Украин улс дахь прокурорууд мөрдөн байцаалт, прокурорын хяналтын өөр өөр түвшинд гэмт хэргийн төрлүүд, ялангуяа авлигын гэмт хэргээр мэргэшэх бололцоогүй.

“Авлигын эсрэг сүлжээ”-ний тандалтын тайлангийн дагуу Украин улсад прокурорын алба авлигын эсрэг үйл ажиллагаа мэргэшээгүй байгаа нь авлигатай тэмцэх хуулийн хэрэгжилтийн үр нөлөөг бууруулж байгаа бөгөөд хууль зүйн, байгууллагын шинэчлэл хийх шаардлагыг бүрдүүлж байна.

1.2.5. Нөөц, бололцоо

Олон улсын стандартуудад авлигын гэмт хэргийн эсрэг үр дүнтэй арга хэмжээ авахын тулд мэргэшсэн албан тушаалтан ажиллуулах, түүнтэй холбоотой зохих нөөц, бололцоог бүрдүүлэх шаардлага тавьсан. Материалын нөөц гэдэгт цалин хөлс, үл хөдлөх хөрөнгө, тоног төхөөрөмж болон шаардлагатай бусад нөөц хамаарна.

¹⁰⁵ Авлигын эсрэг байгууллагын мэргэшсэн байдал: Загвар, туршлага, OECD 2007, х6.

Хүний нөөц гэдэгт прокурорын албанд дадлагажсан, холбогдох сургалтанд хамрагдсан мэргэжилтэн, мэргэшсэн ажилтнууд хамаарна. Украин улсад хүний нөөцтэй холбоотой зарим бэрхшээл бий. Үүнд: авлига, эдийн засгийн гэмт хэргийг мөрдөн шалгахад шаардлагатай санхүү, банк, нягтлан бодох бүртгэлийн шинжилгээ, мэдээллийн технологи, худалдан авалт, инженеринг болон орчин үеийн бизнесийн технологитой холбоотой цогц мэдлэг дутагдалтай бөгөөд ийм нарийн мэдлэгийг тусгайлан эзэмшүүлэх шаардлага тулгарч байна. Мэргэшсэн ажилтан бэлтгэх сургалт нь хүний нөөцийн хөгжлийн чухал бүрдэл хэсэг юм.

Украин улсын Прокурорын газрын харьяа Үндэсний академи нь мэргэшсэн алба хаагч бэлтгэх, прокуроруудыг хөгжүүлэх асуудлыг хариуцсан үндсэн байгууллага юм. Үүнээс өөр авлигатай тэмцэх зориулсан албан ёсны хичээл заах, сургалт явуулах байгууллага байхгүй.

ХБНГУ ДАХЬ АВЛИГЫН ЭСРЭГ ТЭМЦЭЛД ПРОКУРОРЫН ГҮЙЦЭТГЭХ ҮҮРЭГ¹⁰⁶

Энэхүү судалгаагаар “Германы транспэренси интернэшнл” ТББ-аас 2009 онд гаргасан эмхэтгэлийг шинэчлэх зорилт тавьсан бөгөөд муж улсуудын Дотоод хэргийн болон Хууль зүйн яамдуудаас бичгээр асуулга тавьж, мэдээллүүдийг авсан юм.

Асуулгын хариултуудаар ХБНГУ дахь авлигын эсрэг тэмцэл нь товчхондоо дараах институционал бүтэц, нөөцөөр хэрэгжиж байна. Үүнд:

- Одоогийн байдлаар Нийдерсахсен, Бранденбург, 2012 оны 9 дүгээр сараас Баден-Вюртемберг муж улсууд авлигын талаар мэдээлэл өгөх цахим системийг ашиглаж байна. Берлин муж улсад энэ ажил төлөвлөлтийн шатанд байна. Таван муж улсад хэрэгцээтэй тохиолдолд ийм мэдээллийг нэр, хаяггүйгээр авах Итгэлт-прокуроруудыг томилон ажиллуулж байна. Мөн зарим муж улсуудад байнгын ажиллагаатай тусгай утсан холбоог ажиллуулж байна.
- Бүтэцжсэн авлигатай Цагдаагийн зүгээс тэмцэхийн тулд одоогоор дийлэнх муж улсуудад төвлөрсөн мөрдөх нэгжийг муж улсын гэмт хэрэгтэй тэмцэх албан дээр юмуу Авлигын гэмт хэрэгтэй тэмцэх төв нэгж болгон зохих мэргэшсэн албан хаагчдын бүрэлдэхүүнтэйгээр байгуулаад байна.
- “Эдийн засгийн гэмт хэрэг ба авлигатай тэмцэх нэгдсэн үзэл баримтлал” нэртэй Холбоо ба муж улсуудын хамтарсан гэмт хэрэгтэй тэмцэх цагдаагийн төслийн багийн зөвлөмж болгосон “Хууль зүйн болон цагдаагийн байгууллагын авлигын хэргийг мөрдөх хамтарсан бүлэг” хэмээх бүтэц зөвхөн Шлесвиг-Холштайн, Бранденбург муж улсуудад байгуулагджээ.

¹⁰⁶ “Германы транспэренси интернэшнл” ТББ-аас 2012 оны 12 дугаар сард гаргасан “ХБНГУ дахь авилгын эсрэг тэмцэл: Институцуудын нөөц боломжийг Холбооны муж улсуудаар харьцуулсан нь” сэдэвт эмхэтгэлээс хэсэгчлэн орчуулав. http://www.transparency.de/fileadmin/pdfs/Themen/Justiz/Korruption/bekaempfung_web.pdf, 2013.11.04-ний өдрийн байдлаар.

- Хамбургийн Дотоод мөрдөлтийн хэлтэс ба Бремений Авлигийн эсрэг төв нэгж зэргийн авлигын хэргийг мөрдөх ажиллагаа нь зохион байгуулалтын хувьд цагдаагийн байгууллагад бус шууд Дотоод хэргийн яаманд харъяалагддаг болжээ.
- Нилээд олон цагдаагийн байгууллагууд урьдчилан сэргийлэх арга хэмжээг илүү хүчтэй явуулах болжээ. Жишээ нь Баден-Вюртемберг муж улсад бүх тойргуудын цагдаагийн албад дээр авлигыг хариуцсан ажилтантай болсон. Мөн Хамбургийн Дотоод мөрдөлтийн хэлтэст нь авлигаас урьдчилан сэргийлэх нэгжийг байгуулсан байна.
- Нэг сайшаалтай зүйл нь дийлэнх муж улсуудад авлигын төрөлжсөн прокурорын нэгжийг байгуулсан бөгөөд ийм нэгж байгуулаагүй бусад муж улсууд нь уг асуудлыг эдийн засгийн гэмт хэрэгтэй тэмцэх гэх мэт хэлтэс, нэгжүүддээ хариуцуулсан байна.
- Онцгойлон дурдууштай нэг зүйл бол Франкфурт дахь Хессен муж улсын Ерөнхий прокурорын газарт “Эрүүл мэндийн салбар дахь эд хөрөнгийн болон авлигын гэмт хэрэгтэй тэмцэх төв нэгж”-ийг байгуулсан явдал юм.
- Хамбургийн Дотоод мөрдөлтийн хэлтэст болон Нордрайн-Вестфален муж улсын Мөрдөх албаны 15-р хэлтэст авлигын хэргийг мөрдөхөд татвартай болон татварын гэмт хэрэгтэй холбоотой илэрсэн асуудлыг шалгах, шаардлагатай тохиолдолд хяналтын мэдээллүүдийг Санхүүгийн захиргаанд дамжуулах, Санхүүгийн захиргаатай хамтран ажиллах үйл ажиллагааг зохион байгуулах чиг үүрэг бүхий байнгын санхүүгийн албан хаагчийг ажиллуулж байна.
- Байерн муж улсын Татварын мөрдөх албанд “Мөнгө угаах ба зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх” хоёр тусгай бүлгийг байгуулсан. Тэдний нэг үндсэн чиг үүрэг нь авлигатай тэмцэх юм.
- Зарим муж улсуудад гадуур ажилладаг аж ахуйн шалгагчид ба татварын мөрдөгчдөд зориулсан авлига ба түүний татварын нөлөөлөл, татвар төлөгчийн мэдээллэх үүрэгтэй холбогдсон өргөн цар хүрээтэй мэдээлэл бүхий “Хахууль” нэртэй гарын авлагыг хэрэглүүлдэг.
- Олон муж улсуудад янз бүрийн нэршилтэй салбар дамнасан хамтын ажиллагааны хэлбэрүүд үүсжээ. Тухайлбал, Зохицуулах бүлэг /Баден-Вюртемберг/, Авлигын эсрэг Штабын нэгж /Бранденбург/, Авлигын эсрэг зөвлөл /Бремен/ гэх мэт. Олон салбарын мэргэжилтнүүдээс бүрддэг эдгээр нэгжүүдийн зарим нь урьдчилан сэргийлэх чиглэлээр ажилладаг бол зарим нь Мөрдөх албадад чанарын удирдлагын чиглэлээр шахалт үзүүлэх байдлаар ажилладаг байна.
- Бараг бүх муж улсуудад нийтийн захиргаанд авлигаас урьдчилан сэргийлэхэд зориулагдсан захиргааны журмууд үйлчилж байна.
- Ийм захиргааны журмуудын нилээд нь төрийн байгууллагууд, салбарын яамдуудад дотоод хяналтын болон авлигын эсрэг шалгах бүлгүүдийг байгуулахыг, зарим нь бүр заавал байгуулахыг шаардсан агуулгатай байна.

- Байерн муж улсад “Авлигаас урьчилан сэргийлэх нь” нэртэй цахим сургалтын программыг ажилтнуудаа сургахад зориулан авчээ.
- Авлигад өртөмхий аж ахуйн нэгжүүдийг бүртгэдэг Авлигын бүртгэлийн асуудал тийм ч сайн хөгжихгүй байна. Зөвхөн Баден-Вюртемберг, Байерн, Бремен, Хессен, Нордрин-Вестфален муж улсуудад найдваргүй аж ахуйн нэгжүүдийг өрсөлдөөнд оролцуулах, өөрөөр хэлбэл тендер гэх мэтэд оруулахыг хязгаарлах зорилгоор бүртгэдэг нэгдсэн бүртгэл хөтлөж байна. Энэхүү бүртгэлээс лавлагаа заавал авах шаардлагыг үүсгэх хэмжээг Бременд 10000 евро, Баден-Вюртембергт 50000 евроноос дээш байхаар тогтоожээ. Бремен, Нордрин-Вестфален муж улсуудад ийм лавлагааг мөн мөрдөх албад авах боломжтой байна. Гэвч энэ бүртгэлийн мэдээлэл хангалттай, найдвартай бус байна. Ихэнх муж улсууд өөрийн эрх мэдлээ хадгалахын тулд холбооны хэмжээний ийм бүртгэл бий болгохын эсрэг байна.
- Олон муж улсуудад нилээд сайн боловсруулагдсан, олон тулгуурт суурилсан Авлигаас сэргийлэх, тэмцэх нэгдсэн стратегитай байна.

Муж улсуудын прокурорын үүрэг, оролцоо

ХБНГУ нь холбооны улс болохоор муж улс бүр өөрийн гэсэн гэмт хэрэгтэй тэмцэх бүтэц, зохион байгуулалттай байдаг бөгөөд авлигын гэмт хэрэгтэй тэмцэхэд муж улс бүрийн прокурорын байгууллагын оролцоо, бүтэц мөн адил харилцан адилгүй байна. Ингээд зарим муж улсуудын авлигын эсрэг тэмцэлд прокурорын байгууллагын гүйцэтгэх үүрэг, оролцооны талаарх зохицуулалтыг муж улс бүрээр авч үзье.

Баден-Вюртемберг

Авлигын талаарх мэдээллийг бүх прокурор хүлээн авна. Авлигын хэргийг хариуцан төрөлжсөн Прокурорын бүтэц байхгүй боловч энэ төрлийн гэмт хэргийг тухайлсан асуудал хариуцсан хэлтэс, тасгуудад хуваарилсан байдаг. Тус муж улсын хамгийн том прокурорын газар болох Штуттгартын прокурорын газарт энэ асуудлаарх тухайлсан хэлтсийг хэлтсийн дарга, дөрвөн ажилтантайгаар байгуулсан байна. Энэ хэлтэс нь авлигын хэргээс гадна эдийн засгийн гэмт хэргийг хариуцдаг.

1996 оны 11 сард байгуулагдсан муж улсын Мөрдөх албанд байрладаг Авлигын эсрэг тэмцлийг зохицуулах бүлэгт Штуттгарт, Карлсруэгийн прокурорын төлөөлөл багтдаг байна.

2003 онд тус муж улс дахь Ерөнхий прокурорын газрууд муж улсын Санхүүгийн дээд байгууллагатай зөвшилцөн тогтоол гаргаж, бүх прокурорын газруудын удирдлагуудад Орлогын албан татварын хуулийн 4-р зүйлийн 5 дахь хэсгийн 10 дугаард заагдсан прокурорын Санхүүгийн албадад мэдээллэх үүргийн талаар зааварчилгаа өгсөн нь эдүгээ ч үйлчилж байна.

Байерн

Прокурорууд нь ноцтой, анхаарал татсан авлигын хэргийн талаар цагдаагийн уг асуудлыг хариуцсан хэлтэст Дотоод хэргийн яам, Шүүхийн адил чиглэл өгөх эрхтэй.

Байерн муж улсын хүн ам төвлөрсөн тойргуудын прокурорын газруудад найман эдийн засгийн гэмт хэргээр төрөлжсөн прокурорууд буюу хэлтэсүүд байдаг. Мюнхений 1-р прокурорын газрын хувьд тухайлсан авлигын хэлтэстэй. Авлигын гэмт хэрэг нь үндсэн шинжээрээ итгэл эвдэх, татварын гэм үйлдэлтэй холбоотой байдаг тул ихэнхдээ эдийн засгийн гэмт хэрэгтэй тэмцэх хэлтэст энэ төрлийн гэмт хэргийг мөрдүүлэхээр хариуцуулсан байдаг. Эдгээр төрөлжсөн прокурорын газрууд нь ахлах прокурорууд болон олон тооны мэргэшсэн прокуроруудаас бүрдсэн бүлгүүдийн удирдагчидтай байгуулагдсан байдаг. Ийнхүү төрөлжсөн шинжээрээ цагдаагийн холбогдох мөрдөх албадтай байнгын холбоотой ажилладаг байна. Мөн албан хаагчдыг сонгохдоо нэмэлт мэргэшлийн шаардлага хангасан, тусгай мэдлэгтэй байхыг шаарддаг.

Зарим учир холбогдол ихтэй, нарийн төвөгтэй хэргүүдийг шалгахад нэмэлт хүний нөөц шаардагдсан тохиолдолд бусад прокуроруудыг нэмэгдүүлэн ажиллуулах зохицуулалттай. Түүнээс гадна цагдаа, бусад төрийн байгууллагуудаас ирүүлсэн авлигын сэдвээрх асуултад хариулах асуудлыг хариуцсан ажилтныг прокурорын газар бүрт томилон ажиллуулж байна. Энэ төрлийн гэмт хэргийг мөрдөх ажиллагааны нэг гол зорилго нь тухайн гэм буруутай этгээдэд ял ногдуулахаас гадна гол нь гэмт хэргийн замаар олсон эд хөрөнгийг үр нөлөөтэй хураан авах, ийм замаар хөрөнгөжих боломжийг хаах явдал байдаг. Мюнхений 1-р прокурорын газар сүүлийн 6 сарын хугацаанд гэмт хэргийн замаар олсон хөрөнгийг хураан авах болон торгууль ногдуулах замаар тэрбум гаруй еврог төвлөрүүлсэн.

Татварын мөрдөх албаны “Мөнгө угаах ба зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх” тусгай бүлэг нь авлигын хэргийн сэжиг илэрвэл дээрх төрөлжсөн прокуроруудад мэдээллэдэг. Прокурорын зүгээс ч авлигын хэргийг мөрдөх явцад илэрсэн татварын зөрчлийн талаар дээрх тусгай бүлгүүдэд мэдээллэдэг байна.

Берлин

Тус муж улсын Ерөнхий прокурорын газар дээр Авлигатай тэмцэх төв алба байрладаг бөгөөд иргэн, аж ахуйн нэгж, төрийн байгууллагууд, албан хаагчид авлигаас сэргийлэх, тэмцэх асуудлаар зөвлөгөө авахаар тэдэнд хандах боломжтой. Түүнээс гадна авлигын талаарх мэдээллийг цагдаа, прокурорт гаргахаас гадна дээрх албанд болон 2011.10.01-ний өдрөөс томилогдсон Итгэлт-Прокурорт өгч болно. Ийм мэдээллийг нэр, хаяггүй өгч болох бөгөөд Итгэлт-Прокурор нь мэдээллийн нууцлалыг хамгаалдаг тул зөвхөн мэдээллэгч зөвшөөрвөл түүнтэй нэр, хаягаар нь холбоо тогтоож болдог.

Энэхүү төв алба нь дээрх байдлаар мэдээлэл авах, зөвлөгөө өгөхөөс гадна шалгалтын бүлгүүд, нийтийн захиргааны дотоод хяналтын болон

авлигын эсрэг ажлын бүлгүүдэд зориулсан зөвлөмж боловсруулах, сургалт явуулах ажлыг эрхэлдэг байна. Мөн Санхүүгийн хяналтын байгууллага (Rechnungshof), Хотын сенатын захиргаа, Муж улсын картелийн эсрэг газар, төрийн захиргааны байгууллагуудын Авлигын эсрэг албан тушаалтантай байнгын харилцаа холбоотой ажилладаг.

Берлин мужийн прокурорын газрын 243-р хэлтэс нь 8 прокурор, нэг ахлах прокурор буюу хэлтсийн даргатайгаар авлигатай тэмцэх асуудлыг хариуцан ажиллаж байна.

Хотын сенатын хууль зүйн ба хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах захиргааны дэргэд байгуулагдсан салбар дамнасан Авлигын эсрэг ажлын бүлэг байдаг. Энд мөн прокурорын төлөөлөл ордог.

Берлин муж улс нь авлигын эсрэг нэгдсэн стратегитай муж улсуудын нэг нь бөгөөд энэ нь дөрвөн тулгуурт үндэслэдэг байна. Нэгдүгээр багана нь Прокурорын авлигын эсрэг тусгай хэлтэс юм. Хоёр дахь нь Ерөнхий прокурорын дэргэдэх Авлигатай тэмцэх төв нэгж, гурав дахь нь Хотын сенатын хууль зүйн ба хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах захиргааны дэргэд байгуулагдсан салбар дамнасан Авлигын эсрэг ажлын бүлэг, дөрөв дэх нь авлигатай тэмцэх Итгэлт-Прокурор юм.

Бранденбург

2005 оноос хойш салбар дамнасан Нойруппин дахь Прокурорын газар ба муж улсын Мөрдөх албаны авлигын хэргийг мөрдөх хамтарсан бүлэг ажиллаж байна. Ийнхүү хүний нөөцийг нэгтгэж, хэргийг мөрдөн шалгах үйл явцыг төвлөрүүлж байна.

Нойруппин дахь Прокурорын газар нь 2000 оноос хойш авлигын хэргийн төрөлжсөн прокурорын газар болсон бөгөөд нэг ахлах прокурор, таван прокурор, нэг эдийн засгийн мэргэжилтэнтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна.

Энэхүү прокурорын газар нь Бранденбург муж улс дахь авлигын хэргийг мөрдөх, хянан шийдвэрлэх, шүүхийн шийдвэрийг биелүүлэх үйл явцыг бүхэлд нь хариуцан оролцдог. Өөр нэг чиг үүрэг нь муж улсынхаа санхүүгийн хяналтын байгууллагын жилийн тайлан болон бусад мэдээллэлд гэмт үйлдлийн талаарх хангалттай, бодит сэжүүр байгаа эсэх тухайд бүхэлд нь шалгах юм.

Төрөлжсөн прокурорын газар болон авлигын хэргийг мөрдөх хамтарсан бүлэг нь Дотоод хэргийн яамны “Авлигаас урьдчилан сэргийлэх штабын нэгж”-тэй холбоотой ажиллах бөгөөд мөрдөх ажиллагааны туршлага болон тухайн үеийн авлигын илрэх хэлбэрүүдийн талаар мэдээлэл солилцдог байна.

Түүнчлэн энэхүү прокурорын газар нь Татварын мөрдөх алба, санхүүгийн захиргаатай хамтран авлигын сэдвээр мэдээллийн арга хэмжээ болон семинаруудыг зохион байгуулдаг. Мөн Сангийн яамны 35-р Реферат нь хамтын ажиллагааг сайжруулахын тулд уг төрөлжсөн прокурорын газартай авлигын хэргийн талаар мэдээллэх үүргийн биелэлтийг хангуулах,

мэдээлэл харилцан солилцох байдлаар байнгын холбоотой ажилладаг байна.

Бремен: Аль ч прокурор бусад гэмт хэргийг мөрдөх чиг үүргийн байгууллагуудын адил авлигын хэргийн талаарх мэдээллийг нэр, хаяггүйгээр авч болох ба эргээд мэдээллэгчтэй холбогдох боломжгүй.

Төрийн албаны авлигын хэргийг мөрдөх чиг үүргийг 3-р хэлтэс (Зохион байгуулалттай гэмт хэрэг), эдийн засгийн авлигын хэргийг мөрдөх чиг үүргийг 7-р хэлтэс (Эдийн засгийн гэмт хэрэг)-т хариуцуулсан байна.

Бремен дэх авлигын эсрэг ажлын шинэчилсэн зохион байгуулалтын хүрээнд Авлигын эсрэг зөвлөлийг байгуулсан бөгөөд 3 сар тутамд хуралддаг энэхүү зөвлөлд Сенатын салбар хариуцсан байгууллагуудын Авлигын асуудал хариуцсан албан тушаалтнууд, Дотоод хэрэг, спортын асуудал эрхэлсэн Сенаторын харъяаны Авлигын эсрэг төв нэгжийн төлөөллөөс гадна Прокурорын төлөөлөл ордог байна.

Хамбург: Хамбургийн прокурорын газрын 57-р хэлтэс нь таван орон тоотойгоор авлигын асуудлаар төрөлжин ажилладаг.

Дотоод мөрдөлтийн хэлтэсийн дэргэд 1999 онд байгуулагдсан, улирал тутам болон ажлын шаардлагаар хуралдаж авлигын хэргийн мөрдөх ажиллагааны туршлага, мөрдөх үйл ажиллагааны чанарын удирдлагын асуудлыг хэлэлцдэг “Авлигын асуудлаарх ярилцлага”-д прокурорын газрын дээрх төрөлжсөн 57-р хэлтэсийн төлөөлөл ордог.

Прокурорын газар Санхүүгийн албатай татварын хууль тогтоомжийн дагуу мэдээллэх үүргийн хэрэгжилтийг хангах хүрээнд нягт хамтран ажиллаж, сургалт, идэвхижүүлэх арга хэмжээг зохион байгуулдаг. Санхүүгийн албанаас прокурорын байгууллагатай нягт хамтран ажиллаж, татварын хэргийг шалгах явцад илэрсэн авлигын хэргийн талаарх мэдээллийг өгдөг байна. 1997 оноос хойш “Хамбургийн авлигатай тэмцэх үзэл баримтлал” гэсэн нэгдсэн стратегийг батлан хэрэгжүүлж байгаа бөгөөд энэ гурван тулгуурт үндэслэдэг.

Эдгээр нь, нэгд нийтийн захиргааг авлигаас урьдчилан сэргийлэх дотоод хяналт, эрсдлийн дүн шинжилгээ, хянан шалгалтын бүтэц, хоёрт төрийн захиргааны албан хаагчдын мэргэжлийн болон үргэлжилсэн сургалт, түүнчлэн олон нийтийг интернетээр соён гэгээрүүлэх зэрэг ажил, гуравт Дотоод мөрдөлтийн хэлтэс ба Прокурорын авлигын эсрэг хэлтэсийн “үр нөлөөтэй гэмт хэргийн мөрдөлт, байгууллагуудын хоорондын мэдээллийн солилцооны ажил юм.

Энэхүү үзэл баримтлалын хэрэгжилтийг хянах, зохицуулах ажлыг Авлигын эсрэг коференц гэх байгууллага Дотоод мөрдөлтийн хэлтэсийн удирдлага дор эрхэлж байна. Энэхүү коференц нь прокурорын байгууллага, Муж улсын мөрдөх албаны Эдийн засгийн гэмт хэргийг мөрдөх нэгж, Санхүүгийн хяналтын байгууллага, Хүний нөөцийн алба, Санхүүгийн албадын төлөөллөөс гадна Худалдаа, аж үйлдвэрийн танхим гэх мэт бусад байгууллагуудын төлөөллөөс бүрддэг байна.

Хессен: 2008 оноос хойш улс дамнасан болон онцгой учир холбогдолтой авлигын хэргийг Франкфурт дах прокурорын газар хянан шалгадаг болжээ.

2009 оны бүтэцийн өөрчлөлтийн дараа ч Франкфуртын Прокурорын газрын гол хэлтэс нь Хессен муж улсын эдийн засгийн болон байгаль орчны эсрэг гэмт явдлын төрөлжсөн прокурорын газар болсноор мөн авлигын хэргийг хариуцсан энэ чиг үүрэг нь хэвээр үлдсэн юм. Энэхүү прокурорын газар нь найман хэлтэстэй бөгөөд үүнээс хоёр нь авлигын хэргийг өөрийн тойрогтоо болон муж улс даяр хариуцан ажилладаг. Энэ хэлтэс нь хэлтсийн дарга, долоон прокурортой ажиллах ба хэргийг мөрдөх явцад нэг референт, зургаан ажилтан бүхий эдийн засгийн шалгах бүлгийг татан оролцуулах боломжтой байдаг. Түүнээс гадна энэхүү төрөлжсөн прокурорын газарт өөр нэг эдийн засгийн хэлтэс байх ба түүнийг Ерөнхий прокурорын даалгавраар өөр хэлбэрийн авлигын хэрэг болон мөнгө угаах асуудалтай холбоотой тохиолдолд оролцуулан ажиллуулж болдог.

Эрүүл мэндийн салбар дахь авлигын болон эд хөрөнгийн гэмт хэрэгтэй тэмцэх асуудлыг муж улсын хэмжээнд хариуцан шалгадаг төв нэгжийг Ерөнхий прокурорын газрын Бэлэн байдлын нөөцийндэргэд төв нэгжийн дарга, гурван ажилтантайгаар нилээд хэдэн жилийн өмнөөс байгуулан ажиллуулж байна. Мөн Бэлэн байдлын нөөцийн эдийн засгийн мэргэжилтнүүдийг тодорхой тохиолдлууд дээр татан оролцуулж болдог.

Улс дамнасан бус болон учир холбогдол багатай авлигын хэргүүдийг тухайн тойргийн прокурорын газрууд хариуцан шалгадаг. Дармштадтийн прокурорын газар авлигын хэргийг тухайлан хариуцсан прокурортой. Бусад прокурорын газруудад эдийн засгийн гэмт явдлыг хариуцсан прокурор хянан шалгадаг. Хессен мужийн бүх прокурорын газруудад авлигын тухай мэдээллийг нэр, хаяггүйгээр авах эрх бүхий орон нутгийн захиргааг хариуцсан прокурортой юм.

Дээрх төрөлжсөн прокурорын хэлтэс болон цагдаагийн мэргэшсэн нэгж, муж улсын мөрдөх албаны хооронд тогтмол зөвлөлдөх уулзалтууд явагддаг ба үүгээр шалгагдаж байгаа хэргүүдийг эрэмбэлэх, авлигатай тэмцэх ажлын хүрээнд стратегийн хувьд юунд ач холбогдол өгөх хэрэгтэй байгаа талаар хэлэлцдэг.

Мөн дээрх төрөлжсөн прокурорууд олон улсын байгууллагуудаас зохион байгуулдаг арга хэмжээнүүдэд тогтмол оролцож, олон улсын туршлагаас суралцах, туршлага солилцох байдлаар үйл ажиллагаагаа сайжруулдаг.

Эрүүл мэндийн салбар дахь авлигын болон эд хөрөнгийн гэмт хэрэгтэй тэмцэх төв нэгж нь мөн эмч нарын ТББ-ууд, холбоод, эрүүл мэндийн даатгалын байгууллагууд, бусад эрүүл мэндийн салбарын институцуудтай нягт холбоотой ажиллаж, зөвлөлдөх уулзалтуудыг зохион байгуулдаг.

Авлигад өртөмтгий байж болох найдваргүй аж ахуйн нэгжүүд, байгууллагуудыг нийтийн ажил, үйлчилгээний сонгон шалгаруултад оруулахгүй байх Авлигын бүртгэл 1997 оноос хойш хөтлөгдөж байгаа бөгөөд энэхүү тогтоолын дагуу Франкфуртын Санхүүгийн дээд байгууллага дээр Төв мэдээллэх болон мэдээллийн нэгжийг байгуулсан. Энэхүү нэгжтэй авлигын гэмт явдалтэй тэмцэх төрөлжсөн прокурорын газраас тогтмол зөвлөлдөх уулзалтыг зохион байгуулдаг байна.

Мекленбург-Форпоммерн: Энэ муж улсад төрөлжсөн прокурорын газар байдаггүй бөгөөд прокурорын газар бүрт энэ төрлийн гэмт хэргийг

мөрдөх тусгай хэлтсүүд ажилладаг байна. Хэрэв авлигын хэрэг нь эдийн засгийн гэмт хэрэгтэй холбоотой гарсан байвал тухайн хэргийг прокурорын газруудын эдийн засгийн гэмт хэрэгтэй тэмцэх хэлтэс нь шалгадаг.

Нийдерсахсен: 2007 онд бүх нутаг дэвсгэрийг хамарсан авлигын гэмт хэргээр төрөлжсөн прокурорын газруудын сүлжээг бүрдүүлсэн бөгөөд Брауншвайг, Ханнофер, Оснабрюк, Ферден зэрэг хотуудад байрлах эдгээр төрөлжсөн прокурорын газрууд нь хэд хэдэн шүүхийн тойргуудийг хариуцан ажилладаг. Тэдний үйл ажиллагааг Селле дэх Ерөнхий прокурорын газрын дэргэдэх Зохион байгуулалттай гэмт хэрэг болон авлигатай тэмцэх төв нэгж уялдуулан зохицуулж, зөвлөдөг байна. Прокуроруудын бүсийн хэмжээний сүлжээ үүсгэх боломжийг хангахын тулд тус муж улсад муж улсын хэмжээний төв нэгж байгуулахаас зориуд татгалзсан байна. Эдгээр төрөлжсөн прокурорын газрууд нь тус бүр дөрвөн прокурор, нэмэлт эдийн засгийн мэргэжилтэн, үйлчилгээний ажилтнуудын бүрэлдэхүүнтэйгээр үйл ажиллагаагаа явуулдаг.

Селле дэх Ерөнхий прокурорын газрын дэргэдэх Зохион байгуулалттай гэмт хэрэг болон авлигатай тэмцэх төв нэгж нь 1996 онд байгуулагдсан. Энэ байгууллага өөрөө бие даан хэргийг мөрдөх ажиллагаа явуулдаггүй. Гол чиг үүрэг нь эрхэлсэн асуудлаараа төрийн байгууллагуудад зөвлөгөө өгөх, муж улсынхаа прокурорын газрууд болон бусад муж улсуудын адил чиг үүрэгтэй төв нэгжүүдийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, түүнчлэн үргэлжилсэн сургалтыг зохион байгуулж явуулах юм. Үүний зэрэгцээ европын хууль зүйн сүлжээний хоорондоо холбогдох төвийн үүргийг гүйцэтгэдэг ба энэ хүрээндээ хил дамнасан мөрдөх ажиллагаанд үр нөлөөтэй дэмжлэг үзүүлж чаддаг юм. Мөн гэмт хэргийг мөрдөх чиг үүргийн төрийн байгууллагууд мэдээлэл солилцох боломжийг хангах үүднээс жилд нэг удаа ажил хэргийн чуулганыг зохион байгуулдаг. Үүнээс гадна муж улсын мөрдөх албатай хамтран жил бүр “Нийдерсахсен дахь авлигын гэмт явдал” гэсэн нөхцөл байдлын дүр зургийг гаргадаг байна.

Нордрайн-Вестфален: 1999 оноос Бийлефелд ба Бохумийн прокурорын газруудад */Хамм дахь Муж улсын дээд шүүхийн тойргийг хариуцсан/*, Көлнийн прокурорын газарт */Көлнийн тойргийг хариуцсан/*, Вупперталын прокурорын газарт */Дюсселдорфийн тойргийг хариуцсан/* авлигын хэргийг мөрдөх дөрвөн төрөлжсөн прокурорын газруудыг байгуулан ажиллуулжээ. Ийнхүү эдгээр прокурорын газрууд нь муж улсын нийт нутаг дэвсгэрийг хамран ажиллах боломжтой болсон.

Хүний нөөцийн хувьд дараах бүтэцтэй ажилладаг. Үүнд:

- Бийлефелд: 3 орон тоотой
- Бохум: 24 орон тооны прокурор, зургаан эдийн засгийн мэргэжилтэн, нэг мэдээллийн технологийн мэргэжилтэн, долоон нягтлан бодогчтой */Гэхдээ Эдийн засгийн болонавлигын хэргийг хариуцсан нэгдсэн хэлтэст хамаарна./*
- Көлн: 13 орон тооны прокурор, дөрвөн эдийн засгийн мэргэжилтэнтэй.
- Вуппертал: 8 орон тооны прокурор, нэг эдийн засгийн мэргэжилтэнтэй.

Эдгээр төрөлжсөн прокурорын газруудаас гадна тэднийг зарим өргөн цар хүрээг хамарсан, ээдрээ төвөгтэй авлигын хэргийг шалгах ажлын хэрэгцээ шаардлагын үүднээс өргөтгөн ажиллуулах зорилгоор тус муж улсын прокурорын газар бүрт наад зах нь нэг мэргэшсэн прокурор ажилладаг байна.

Авлигын эсрэг тэмцлийг эрчимжүүлэх ба Тендерийн бүртгэлийг үүсгэх болон хөтлөх тухай хуулийн дагуу авлигад өртөмхий аж ахуйн нэгжүүдийн мэдээллийг хадгалдаг нийтэд нээлттэй бус бүртгэлийг бий болгосон юм. Энэхүү бүртгэлээс мэдээлэл авах эрх нь нийтийн болон орон нутгийн ажил, үйлчилгээг захиалагчид болон прокуроруудад хадгалагддаг байна. Сангийн яаман дээр хөтлөгддөг энэхүү бүртгэлээс мэдээлэл авах хүсэлт өдөрт 200 орчим ирж, ажиллагаа хийгддэг байна.

Райнланд-Пфалц: Энэ муж улсад авлигын хэргээр төрөлжсөн прокурорын газар байдаггүй бөгөөд энэ төрлийн гэмт үйлдлийг шинж байдлаас нь хамааруулан Кобленцийн болон Кайзерслаутерний прокурорын газруудын дэргэд байгуулагдсан Эдийн засгийн гэмт хэрэг хариуцсан төв нэгж мөрддөг. Бусад авлигын гэмт үйлдлүүдийг тухайн орон нутгийн хариуцсан прокурорын байгууллагууд мөрддөг.

Заарланд: муж улсад мөн төрөлжсөн прокурорын газар байдаггүй. Авлигын гэмт үйлдлүүдийг мөрдөх ажиллагааг 2000 оноос хойш дан ганц Заарбрюкен дэх прокурорын газрын “Эдийн засгийн, Авлигын, Зохион байгуулалттай, Санхүүгийн болон Эд хөрөнгийн гэмт хэрэг”-ийг мөрдөн шалгах тусгай хэлтэс эрхэлж байна. Энэхүү тусгай хэлтэс нь нэг ахлах прокурор, таван прокурорын бүрэлдэхүүнтэй ажилладаг ба эдгээрийн хоёр нь авлигын гэмт хэргийг хариуцдаг байна.

Захсен: Тус муж улсын ерөнхий болон бүх прокурорын газрууд авлигын хэргийн талаарх мэдээллийг иргэдээс авдаг. Захсен муж улсад авлигын хэргээр төрөлжсөн прокурорын газар байхгүй. 2009.05.01-ний өдрөөс Сахсений нэгдсэн мөрдөх нэгжийн чиг үүргийг бүх төрлийн гэмт явдлуудын өндөр түвшний болон онцгой учир холбогдол бүхий хэргүүдийг нь мөрдөх ажиллагааг хариуцуулахаар өргөтгөсний дотор мөн авлигын шинж бүхий гэмт үйлдлүүд хамаарч байгаа юм. Бүтэцийн хувьд энэхүү нэгж нь Дрездений прокурорын газраас салгаж, Дрезден дэх Ерөнхий прокурорын газрын 3-р хэлтэс болон нэгтгэгдсэн байна. Бүрэлдэхүүний хувьд ахлах прокурор, долоон мэргэшсэн прокурор, нэг эдийн засгийн мэргэжилтэнтэйгээр ажилладаг. Энэхүү тусгай нэгж нь муж улсын хэмжээнд үйл ажиллагаагаа явуулах бөгөөд тухайн авлигын хэрэг нь өндөр түвшний болон онцгой учир холбогдолтой байх тусгай шинжээрээ энэхүү нэгжийн хариуцан мөрдөх хэрэг биш бол тухайн орон нутгийн прокурорын газрын прокурорууд мөрддөг.

Сахсений бүх прокурорын газруудад авлигын гэмт хэргүүд нь тухайлсан нэг прокурор дээр төвлөрдөг боловч эдгээр прокурорын газар бүрт Авлигын, албан тушаалын, эдийн засгийн гэмт хэргийн ангилал нь нэгдсэн бус байдалтай байна.

Энэхүү нэгжид цагдаагийн ажилтнууд мөн ажиллах бөгөөд гол нь гэмт явдалтай тэмцэх байгууллагууд болох Муж улсын мөрдөх алба, Татварын

мөрдөх алба, Гаалийн байгууллага, Холбооны цагдаагийн байгууллага гэх мэт авлигатай тэмцэх үйл ажиллагааг муж улсын хэмжээнд уялдуулан зохицуулах чиг үүргийг хэрэгжүүлдэг байна.

Захсен-Анхальт: Авлигын гэмт явдлыг мөрдөх төрөлжсөн прокурорын газар байдаггүй. Эн төрлийн гэмт хэргийг мөрдөх ажиллагааг орон нутгийн прокурорын газрууд болон тэр дундаа Халле болон Магдебургийн Эдийн засгийн гэмт хэргийн төрөлжсөн прокурорын газар мөрддөг.

Шлесвиг-Холштайн: Муж улсын дөрвөн прокурорын газрын хоёрт нь буюу Киел, Любек дахь прокурорын газруудын дэргэд Эдийн засгийн гэмт явдлыг хариуцсан төрөлжсөн прокурорын газрууд ажилладаг. Бүтэцжисэн авлигын тохиолдлуудыг зөвхөн Киел дэх прокурорын газарт мөрддөг байна.

Эдгээрээс гадна 1996.09.10-наас хойш Шлесвиг дэх Ерөнхий прокурорын газрын дэргэд “Авлигын хэргийг мөрдөх төв нэгж”-ийг байгуулан ажиллуулж байна. Энэ байгууллага нь авлигын хэргийг мөрдөн шалгах, хянан шийдвэрлэх үйд ажиллагааны туршлагыг хуримтлуулах, гэмт хэргийг мөрдөх болон төрийн захиргааны байгууллагуудад зөвлөгөө өгөх, үргэлжилсэн сургалтыг зохион байгуулах ажлыг эрхэлдэг байна.

1999.06.01-ний өдөр прокурорын болон цагдаагийн байгууллагын оролцоотой “Авлигын хэргийг мөрдөх хамтарсан бүлэг”-ийг үүсгэн байгуулсан.

Энэ бүтэц нь урьд нь зөвхөн Киел-ийн прокурорын газарт үйлчилдэг байсан бол 2002.08.01-нээс нийт Шлесвиг-Холштайны нутаг дэвсгэрийг хамарсан үйл ажиллагаа явуулдаг болжээ. Энэ бүтэц нь бүтэцжисэн авлигын гэмт явдалтай тэмцэх үндсэн чиг үүрэгтэй бөгөөд тэдний үйл ажиллагааг муж улсын мөрдөх алба болон Киелийн прокурорын газар хариуцдаг.

Хүний нөөцийн хувьд энэхүү бүлэг нь прокурорын талаас нэг ахлах прокурор, 8,5 прокурорын орон тоотойн дээр, хоёр хууль зүйн ажилтан, нэг барилгын инженер, нэг нягтлан бодогчийг тогтмол ажиллуулдаг бол муж улсын мөрдөх албаны зүгээс нэг хэлтсийн дарга, 22 ажилтан, тэдгээрийн найм нь эдийн засгийн криминалистууд, нэг санхүүгийн хяналтын мэргэжилтэн, нэг нягтлан бодогчийн бүрэлдэхүүнтэйгээр оролцон ажилладаг байна.

Муж улсын Засгийн газрын салбарын яам бүрт ажилтнууддаа зөвлөгөө өгөх, авлигатай холбоотой асуудлыг эрхлэх “Авлигын асуудлаар зөвлөх нэгжүүд”-ийг мөн байгуулсан. Эдгээр нэгжүүд нь Ерөнхий прокурорын дэргэдэх “Авлигын хэргийг мөрдөх төв нэгж”-тэй жил бүр туршлага солилцох уулзалтыг зохион байгуулдаг байна.

Тюринген: 1998 онд Эрфурт дахь прокурорын газрын дэргэд байгуулагдсан авлигын хэргийг мөрдөх төрөлжсөн прокурорын байгууллага нь дөрвөн прокурорын бүрэлдэхүүнтэй үйл ажиллагаагаа явуулж байна. Ажлын хэрэгцээ шаардлагаар санхүүгийн мөрдөх ажилтнууд болон нягтлан бодох бүртгэлийн шалгагч нарыг татан оролцуулж болдог.

НОМ ЗҮЙ
Нэг. Хууль, тогтоомж

1. Монгол Улсын Үндсэн хууль. 1992 он
2. БНМАУ-ын прокурорын хяналтын тухай хууль. 1976 он
3. Монгол Улсын прокурорын байгууллагын тухай хууль 1993, 2002 он
4. Олон улсын эрүүгийн шүүхийн Ромын Дүрэм. 1998 он
5. ХБНГУ-ын эрүүгийн байцаан шийтгэх хууль. 1877 он
6. Эрүүгийн байцаан шийтгэх хууль. 1963 он, 2002 он
7. Авлигын эсрэг хууль. 2006 он.
8. Монгол Улсын Эрүүгийн хууль. 2002, 2008 он.

Монгол хэл дээрх ном зохиол

9. Дэлхий нийтийн авлигын тайлан. 2007 он. Шүүхийн тогтолцоон дахь авлига. Transparency international.
10. Азийн сан. Авлигын талаарх олон нийтийн ойлголт мэдлэг тогтоох судалгаа. 2013 оны 09 сар. УБ хот
11. Азийн сан. Бизнес эхрлэлтийн орчин дахь авлигын нөхцөл байдал. 2013 оны 09 сар. УБ хот.
12. Азийн сан. Авлига, албан тушаалын гэмт хэргийг мөрдөн шалгах, хянан шийдвэрлэх ажиллагаанд эрүүгийн хууль тогтоомжийг хэрэглэж байгаа байдлыг судалсан судалгааны ажил. 2013 оны 10 сар.
13. Ж. Бямбаа. Г. Баясгалан. “Эрүүгийн байцаан шийтгэх эрх зүйн үндсэн асуудлууд” УБ., 1998 он
14. Прокурорын байгууллагын тухай хуулийн тайлбар. Г. Баясгалан, Н. Туяа.
15. Прокурорын ном. Гарын авлага 2002 он.
16. Баттогтох.Б., “Латин хэл хууль зүйд” УБ 2001 он, 182-р талд
17. “БНМАУ-ын прокурорын хяналт” /эмхэтгэл/ УБ 1966 он
18. “БНМАУ-ын прокурорын хяналт” /эмхэтгэл/ УБ 1974 он
19. БНМАУ-ын хуулиуд /эмхэтгэл/ УБ 1980 он
20. Бүдханд.Ц., “Прокурорын түүхэн замналаас” УБ 2000 он
21. Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар 2000 он
22. Монгол улсын ЭБШЭЗ-н хичээлээр судлах тушаал, заавар тогтоолуудын эмхтгэл УБ. 2000 он
23. Монгол Улсын эрүүгийн хууль, эрүүгийн байцаан шийтгэх хууль, тэдгээрийн тайлбарууд 1995 он
24. Нарангэрэл.С., “Монголын ба дэлхийн эрх зүйн тогтолцоо” УБ 2001
25. Отгончимэг.Н., “Харьцуулсан эрх зүй” УБ 2001
26. Прокурорын ном /эмхэтгэл/ УБ 2001 он
27. “Төр эрх зүйн хуудас-Эргэцүүлэл” сэтгүүл № 12, 13 УБ 2001 он
28. “Үнэн” сонин УБ 1973.04.
29. Олон улсын эрүүгийн шүүхийн Ромын дүрэм. 2002 он

Ашигласан бусад материал

30. Авлигын хэрэг мөрдөх аргачлал /Ерөнхий редактор Б.Батзориг/, УБ., 2011 он
31. Авхиа.Ж “Хүний амины гэмт хэргийг илрүүлэх, мөрдөн байцаах арга зүй” УБ., 1987.
32. Амгаланбаяр “Байцаалтанд нотлох баримтыг ашиглах нь” УБ., 1989.
33. Амгаланбаяр.Ц., Орон байрны хулгайн гэмт хэргийг илрүүлэх, мөрдөн байцаах арга зүйн зарим асуудлууд, УБ., 1994.
34. Балжинням.А., Мөрдөн байцаалтын үзлэг, УБ., 1984.
35. Батзориг.Б. “Гэмт хэргийн нотолгооны ерөнхий онол” УБ., 2002.

36. Батзориг.Б., Зүмбэрэлхам.Д. “Сэжигтэн, яллагдагч, гэрчийн мэдүүлэг нотлох баримт болох нь” УБ., 2006.
37. Батзориг.Б., Бямбаа.Ж, Сүхбаатар.Т., “Эд мөрийн баримт” УБ., 2006.
38. Бат-Эрдэнэ.Б. “Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх эрх зүй” УБ., 2009.
39. Бат-Эрдэнэ.Б., Байцаалт түүний онцлог, УБ., 1994.
40. Бат-Эрдэнэ.Бө. “Криминалистик” УБ., 2003.
41. Бүдрагчаа С., Комиссаров.В.И., Урьдчилсан мөрдөн байцаалтын шинжлэх ухааны үндэс, УБ., 1987.
42. Галдаа.Б., “Монгол улсын нотолгооны эрх зүйн үндсэн асуудал” УБ., 2001.
43. Глазырин.Ф.В., Мөрдөн байцаалтын сэтгэл зүй, УБ., 1987.
44. Зүмбэрэлхам. Д., Мөрдөн байцаалтын туршилт, УБ., 1997
45. Зүмбэрэлхам.Д., Таньж олуулах ажиллагаа, УБ., 1994.
46. Мягмарцэрэн.Ш.,Цог.Д., “Эдийн засгийн гэмт хэрэгтэй тэмцэх эрүүгийн тагнуулын ажлын тактик”УБ, 2008.
47. Кушниренко.С.П Особенности расследования взяточничества, Санкт-Петербург 2002.
48. Хүний амины гэмт хэргийг илрүүлэх, мөрдөн байцаах аргачилал, УБ., 1984.

Гадаад хэл дээрх ном зохиол

49. В. И. Рохлин. Прокурорский надзор и государственный контроль Санкт- Петербург 2003 г
50. Басков В. И. “Прокурорский наздор” Москва 1996г
51. Басков В. И. Курс прокурорского надзора, М., 19 98 г
52. Ведомости Верховного Совета СССР. 1956г
53. Веретенников В.И. Очерки истории генеральной прокуратуры России доекатерининского времени. Харьков 1915г
54. Винокуров.Ю.Е., “Прокурорский наздор” Москва 2001г
55. Муравьев Н.В. Прокурорский надзор в его устройстве и деятельности.
56. Парамонов.В., Судебная защита протеста прокурора 1995 г
57. Полное собрание законов Российской империи
58. Правовые системы стран мира М 2001г
59. Прокуратура на Западе и в России Москва 1889г.
60. Рене Давид; Камила Жоффре-Спинози “Основные правовые системы современности” 1999
61. Российской Федерации о прокуратуре М 1992г
62. Собрание Законодательства 1933г
63. Чувилов.В., “Прокурорский наздор” Москва 2000г

Интернетийн хаягууд

64. <http://criminal-procedure.da.ru>
65. <http://eng.sppo.go.kr>
66. <http://icpo.at.tut.by/crimeru.html>
67. www.aalreg.ru
68. www.alltest.ru
69. www.austlii.edu.au/links
70. www.catalog.alledu.ru
71. www.chuvashia.uka.ru
72. www.eduworld.ru
73. www.elcommerce.wallts.ru